



**МЕРСИ КОРЫН
САЙН ТУРШЛАГУУД**



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС	4
ӨМНӨХ ҮГ	6
МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫГ ДЭМЖИХ ДЭД ТЭТГЭЛГҮҮД	8
Махны зах зээл	
1. Орон нутагт мал нядалгааны цех байгуулсан нь (Занаду Разорбак)	9
2. Чанартай мах- найдвартай нийлүүлэлт (Минжийн Бор Өтөг)	14
3. Малын дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлсэн нь (Мон Мийт Трэйд)	19
4. Махны зах зээлийг малчдад ойртуулах нь (Дээдсийн Сүрэг)	23
Малын эрүүл мэнд	
1. Мал эмнэлгийн нэг цэгийн лаборатори (Сац Манал)	30
2. Мал эмнэлгийн лабораторийн анхан шатны сургалт	40
3. Мал аж ахуйн салбар дахь залуусын оролцоо (Элит Хүнс)	45
4. Мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь (Юмтгэгээ)	50
5. Залуусын удирдан ажиллуулдаг мал эмнэлгийн лаборатори (Мандалхаан Сүрэг)	55
6. Хувийн мал эмнэлгийн чадавхийг бэхжүүлсэн нь (Дэвжих Дөл)	63
7. “Мал эмнэлгийн бизнес хөгжил” цахим сургалт	69
Мал үржил	
1. Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг суманд нэвтрүүлсэн нь (Төгс Ген)	76
2. Хутаг-Өндөр сумын мал үржлийн төсөл	81
3. Казахын цагаан толгойт үхрийн чанар, үр шим, борлуулалтыг сайжруулсан нь (Хушаатын хамтын хүч хоршоо)	89
Малын тэжээл	
1. Малын тэжээл үйлдвэрлэл (Мөнх Түрүү ХХК)	101
2. Ногоон тэжээл үйлдвэрлэл (Арт Маргад)	106
3. Чанартай дарш үйлдвэрлэл (Ар Сэвд Могойт)	112
4. Ногоон тэжээл, даршны үйлдвэрлэл (Сэтэби)	118
5. Баяжуулсан арвайн тэжээл (Гурванборхууд)	124
Бэлчээрийн менежмент	
1. Бэлчээр сайжруулах туршилтын талбай	130
2. Бэлчээрийн менежментийн бүсчилсэн сургалт	136
Залуучууд, санхүүгийн хүртээмж	
1. Ногоон Бэлчээр төсөл	145
2. Залуучуудын хөдөлмөр эрхлэх үр чадвар төсөл	164
3. Орон нутгийн бизнес клиник төсөл	172
Гамшгийн эрсдэл бууруулах	
1. Бэлчээрийн дэд бүтцийг сайжруулах төслүүд	186
2. “Гамшгаас хамгаалах сумын төлөвлөгөөг сайжруулах” сургалт	194
3. “Бэлэн Бай” сургагч багш бэлтгэх сургалт	199
4. Гамшгийн эрсдэлийг бууруулах хэрэгсэл тоног төхөөрөмжийг гардуулсан нь	203
5. PDS аргачлалыг Монголд нутагшуулах сургалтууд	211

ТОВЧИЛСОН ҮГС

БМТ	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ГХТ	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө
ДБХС	Дэлхийн Байгаль Хамгаалах Сан
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн газар
КЦТ	Казахын цагаан толгойт үхэр
МАЗС	Мал аж ахуйн эрсдэлийн сан
МАЗШХ	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн
МБАХ	Монголын бэлчээр ашиглагчдын холбоо
МБАНХ	Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МҮМЭХ	Монголын үндэсний мал эмнэлгийн холбоо
МЧХБЦ	Малын чанарыг хянан баталгаажуулах цэг
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МЭС	Мал эмнэлгийн сургууль
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТББ	Төрийн бус байгууллага
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
LEGS	Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар стандарт
LTS	“Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь” төсөл
PDS	Оролцооны аргаар өвчнийг тандан судлах аргачлал
PENAPH	Мал амьтан, нийтийн эрүүл мэндийн оролцоот эпидемиологийн сүлжээ
SNAPP	Шинжлэх ухаанд суурилсан байгаль орчин ба хүний харилцаа
YESP	“Залуучуудын хөдөлмөр эрхлэх үр чадвар” төсөл
WCS	Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг

ӨМНӨХ ҮГ

Эрхэм хүндэт харилцагч, түншүүд, найз нөхөд өө.

Мерси Кор нь 40 гаруй улс оронд үйл ажиллагаа явуулдаг олон улсын ТББ. Бид 20 гаруй жил Монголд төр, хувийн хэвшил, иргэний нийгэмтэй хамтран ажиллаж, хөдөө орон нутгийн иргэдийн орлого, даван туулах чадварыг бэхжүүлэхэд анхаарч ирсэн.

Мерси Кор нь Монгол улсын төр, иргэний нийгэмтэй 20 жил хамтран мал аж ахуй, боловсрол, засаглалын салбарт үр нөлөө ихтэй төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн. Бид төрийн яам, агенлагуудтай бараг аймагт бүрт төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлж, нийт 60 гаруй сая долларын тусламж хүргэсэн.

2015-2020 оны хооронд Мерси Кор “Гамшгийн Эрсдэлийг Бууруулахад Уламжлалт Болон Шинжлэх Ухааны Аргыг Ашиглах нь” (LTS) хөтөлбөрийн гурван үе шатыг амжилттай хэрэгжүүлж дууссан. Энэхүү хөтөлбөрийг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн Гамшигт Нэрвэгдсэн Гадаад Орнуудад Тусламж Үзүүлэх Газар (USAID/OFDA) санхүүжүүлсэн бөгөөд гол зорилго нь гамшгийн эрсдэлийн бэлэн байдал, бэлчээрийн менежментийг сайжруулснаар малчин өрхүүдийн эмзэг байдлыг бууруулахад оршиж байсан.

Мөн бид “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” (RCP) хөтөлбөрийг 2021 оны 3 сар хүртэл амжилттай хэрэгжүүлж дууссан. Үг хөтөлбөр нь мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, зах зээлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд анхаарлаа хандуулсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд Мерси Кор мал аж ахуйн салбарын гол оролцогчидтой хамтран ажилласан.

Монгол улсыг төр, хувийн хэвшлийн манлайлал дор монголын иргэд л зөвхөн хөгжүүлж чадна гэдэгт манай байгууллага гүн итгэж байгаа. Тиймээс бид Монгол дахь үйл ажиллагаагаа өндөрлөж, 5-р сарын 30-нд дуусгахаар шийдсэн. Энэ бол жам ёсны үзэгдэл юм. Бид 20 гаруй жил хэрэгжүүлсэн шинэлэг, үр өгөөжтэй бүх төсөл хөтөлбөр, оруулсан хувь нэмрээрээ бахархдаг.

Энэ номонд LTS, RCP хөтөлбөрүүдийн цөөн хэдэн сайн туршлагаудыг оруулсан. Гэхдээ энэ бол зүгээр нэг амжилтын түүх биш – энэ бол бидний төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түүншүүдтэй хамтран хэрэгжүүлсэн ажлын үр дүн, үр нөлөө юм. Эдгээр амжилтууд нь зөвхөн Мерси Корын гавья биш, энэ бол бидний хамтран ажилласан бүх байгууллагууд, иргэд, бизнес эрхлэгчдийн амжилт- малчид, эрчимжсэн фермерийн аж ахуй, малын эмч, малын тэжээл үйлдвэрлэгчид, мал үржлийн мэргэжилтнүүд, мал нядлах, мах боловсруулах үйлдвэрүүд, санхүүгийн байгууллагууд, төрийн албан хаагчид.

Та бүхэнд бидэнтэй хамтран ажиллаж, дэмжиж байсанд талархлаа илэрхийлье. Монголд ажиллах нь бидний нэр төрийн хэрэг байлаа.

Венди Гайэт
Суурин төлөөлөгч
Мерси Кор Монгол ОУБ
2021 оны 5 сар

“Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд хөтөлбөр”

Мал аж ахуйн салбарыг дэмжих дэд тэтгэлгүүд

Төслийн байршил: Хэнтий, Булган, Сэлэнгэ аймгууд

Төслийн хугацаа: I үе: 2019 оны 8-р сар- 2020 оны 6-р сар

II үе: 2020 оны 4-р сар- 2020 оны 10-р сар

Мерси Корын хөрөнгө оруулалт: 1 273 929 356 төгрөг

Түншлэгчдийн зардал хуваалт: 31%-77%

Мерси Корын 2017-2021 оны хооронд хэрэгжүүлсэн “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн гол зорилго нь МАА-н салбарын үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, зах зээлийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломжуудыг бий болгох замаар хөдөө, орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, даван туулах, дасан зохицох чадварыг бэхжүүлэхэд оршиж байсан.

Энэхүү зорилгынхоо хүрээнд Мерси Кор 2019 болон 2020 онд хоёр удаагийн нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, МАА-н салбарын 14 бизнесийг сонгон, хамтран ажилласан. Үүнд: малын тэжээл үйлдвэрлэлийн 5, малын үржлийн 1, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 4, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэгч 4 хувийн мал эмнэлэг багтсан. Эдгээр 14 төсөл нь амжилттай хэрэгжиж, тухайн бизнест төдийгүй мал аж ахуйн салбарт олон үр дүн, эерэг өөрчлөлт авчирсныг танилцуулж байна.

 <p>ШИНЭ БОЛОН ЗАСВАРЛАЖ САЙЖРУУЛСАН АЖЛЫН БАЙР, БАЙГУУЛАМЖТАЙ БОЛОВ</p> <p>Бүх түншлэгчдийн бизнесийн цар хүрээ, хүчин чадал нь 2-3 дахин өргөжлөө</p>	 <p>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО ДУНДЖААР 80%-ААР ӨССӨН</p> <p>Бизнес нь өргөжихийн хэрээр борлуулалтын орлого мөн өссөн</p>
 <p>42 ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛСЭН</p> <p>Шинэ төрлийн малын тэжээл, махан болон дайвар бүтээгдэхүүн, мал эмнэлгийн лабораторийн үйлчилгээ, мал аж ахуйг хөнгөвчлөх тоног төхөөрөмж зэргийг нийлүүлээ</p>	 <p>ЗОРИЛТОТ АЙМГУУДАД 74 ШИНЭ АЖЛЫН БАЙР БИЙ БОЛГОВ</p> <p>Түншлэгч компаниуд орон нутгийн иргэдийг сурган, ажлын байраар хангав</p>
 <p>МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ТОГТМОЛ АВАДАГ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО 2 ДАХИН ӨССӨН</p> <p>Өмнө нь 3,720 байсан бол одоо 6,614 малчин өрх энэ үйлчилгээг авч байна</p>	 <p>МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ 2 ДАХИН ИХ МАЛД ҮЗҮҮЛЭВ</p> <p>Өмнө нь 420,000 байсан бол одоо 931,213 толгой малд үйлчилгээ үзүүлж байна</p>
 <p>ТЭЖЭЭЛ ТАРИАЛАЛТЫН ТАЛБАЙГ 3 ДАХИН НЭМЭГДҮҮЛЭВ</p> <p>Өмнө нь 260 га газарт тариалж байсан бол одоо 777 га газарт арвай, овъёос, вандуй, царгас зэрэг олон төрлийн тэжээлийн ургамал тариалдаг болов</p>	 <p>ТЭЖЭЭЛИЙН УРГАЦЫН ХЭМЖЭЭ 5.4 ДАХИН НЭМЭГДСЭН</p> <p>234-өөс 1,273 тонн болж нэмэгдсэн</p>
 <p>ЧАНАРТАЙ МАХ БОЛОН ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ 3 ДАХИН ӨССӨН</p> <p>Нийлүүлэлтийн хэмжээ 131-ээс 417.5 тонн болж өссөн</p>	 <p>ТӨСЛИЙН ҮР ДҮНД 1,508 ЗАХ ЗЭЭЛИЙН ХОЛБОЛТ БИЙ БОЛСОН</p> <p>Энэхүү холболтоор дамжуулан 165,041 ширхэг малын дайвар, 4,017 толгой мал, 1,340 тонн малын тэжээл, 27 ширхэг мал аж ахуйн хөдөлмөр хөнгөвчлөх тоног төхөөрөмж зарагдлаа</p>
 <p>4,113 МАЛЧИНГ МАЛ АЖ АХУЙН СУРГАЛТАНД ХАМРУУЛАВ</p> <p>16,200 ширхэг сургалт, сурталчилгааны нугалбарыг малчид, иргэдэд түгээв</p>	 <p>341 ҮХЭРТ ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭВ</p> <p>Хээл авалт 60%-аас 81.5%-болж, үйлчилгээний чанар 21.5%-аар өссөн</p>

1 тонн = 1,000 кг



Амжилтын түүх

ОРОН НУТАГТ МАЛ НЯДАЛГААНЫ ЦЕХ БАЙГУУЛСАН НЬ

Түншлэгчийн нэр: Занаду Разорбак ХХК

Төслийн байршил: Булган аймгийн Хутаг-Өндөр сум

Хугацаа: 2019 оны 8 сар – 2020 оны 6 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Мерси Корын хэрэгжүүлж буй “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” (RCP) хөтөлбөр нь Занаду Разорбак ХХК-тай хамтран мах боловсруулах болон жижиглэн худалдаалах хүчин чадлыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Занаду Разорбак нь мал бордох цэг болон мах боловсруулах цех ажиллуулдаг бөгөөд 2009 оноос хойш Улаанбаатарын өндөр зэрэглэлийн ресторанууд, сүлжээ дэлгүүрүүдэд сайн чанарын мах нийлүүлж байна. Занаду Разорбакийн бизнес загварын нь нутгийн малчдаас нас залуу, тугал, бяруу худалдан авч, улмаар нядалгааны насанд хүртэл нь бордон тарга авахуулахад оршдог. Улмаар Занаду Разорбак нь үхрийг нядалгаанд оруулан, боловсруулалт хийж, борлуулалтад зориулан махаа савладаг. Богино хугацаанд үр ашгийг нэмэгдүүлэх, махны чанарыг сайжруулахын тулд Занаду Разорбак нь эрчимжүүлсэн тэжээлийн горим ашигладаг ба үүнд хадлан

өвс, дарш, овъёос, улаан буудай бүхий шимт чанар өндөртэй тэжээлээр тэжээдэг.

Өмнө нь Занаду Разорбак нь үхрээ сумын төв дээрх нядалгааны цехээр нядлуудлаг байжээ. Энэхүү цех хаагдсаны дараа Занаду Разорбак гар аргаар нядлахаас өөр сонголтгүй болжээ. Занаду Разорбак нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэхийн тулд аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан нядалгааны арга замыг олж тогтоох шаардлагатай болсон байна. Мерси Кор нь Занаду Разорбак ХХК-тай түншлэн ажиллаж зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлсэн ба ингэснээр орон нутгийн зах зээлийн эрэлтийг хангахын тулд сайн чанарын махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжтой болно. Энэхүү зорилтын хүрээнд гурван гол үр дүнг тодорхойлсон ба эдгээр нь; (1) дотоодын зах зээлд зориулсан сайн чанарын махны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх; (2) зах зээлийн холбоосыг бэхжүүлэх; (3) бордох аж ахуйд үхэр нийлүүлж буй малчдын тоог нэмэгдүүлэх зэрэг болно.

Үр дүн 1: Бизнесийн өсөлт, ашиг орлогыг нэмэгдүүлсэн нь

Занаду Разорбак нь Булган аймгийн Хутаг-Өндөр суманд Европын Холбооны стандартад нийцсэн бага оврын нядалгааны цехийг байгуулсан. Ийм стандартыг хангасан нядалгааны цех хөдөө суманд байх нь ховор бөгөөд энэ нь тус төслийн өвөрмөц онцлог байсан юм. Үүгээр ч зогсохгүй, зөвхөн тухайн бизнесийн байгууллагад ч бус орон нутгийн иргэдэд ч өгөөжтэй болсон юм. Занаду Разорбак ХХК-ийн захиралын хувьд орчин үеийн технологи нэвтрүүлэх нь эцсийн бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлыг баталгаажуулж, улмаар хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлдэг болохыг онцлон тэмдэглэж байна. Ийнхүү зах зээлд гарч буй бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг ханган итгэлцлийг нэмэгдүүлж байгаа нь бизнесийн өрсөлдөх чадавхид ч дэм болох юм.

Шинээр байгуулагдсан нядалгааны цэг нь компанийн үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөж өгчээ. Нядалгааны хүчин чадал өмнө нь өдөрт 7 үхэр нядалдаг байсан бол одоо 10-12 болж нэмэгдэн, сардаа нийт 220 үхэр нядлан боловсруулах боломжтой болжээ. Үүний үр дүнд зах зээлд нийлүүлсэн махны хэмжээ 21% нэмэгдэж, 36 тонноос 43.6 тонн болж нэмэгдэн, төсөл хэрэгжсэн 10 сарын хугацаанд Занаду Разорбакын орлого 20% өссөн. Одоогоор Занаду Разорбак нь Монгол улсын хүнсний аюулгүй байдлын стандартад нийцсэн 35 төрлөөр бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангаж байна.

Үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэх хэрээр даган өссөн ажлын ачааллаас үүдэн нэмэлтээр ажилтан авах шаардлага гарсан. Зургаан шинэ ажилтан авснаас 2 нь Улаанбаатар дахь захиргааны албанд, 4 нь Хутаг-Өндөр суман дахь нядалгааны цех дээр ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлсний дүнд гарсан бас нэгэн үр нөлөө нь Булган аймаг дахь Занаду Разорбакын ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа сайжирсан явдал байв. Хөдөлмөрийн аюулгүй байдлын хуулийн дагуу нядалгааны цехэд ажиллах шинэ ажилтнуудад аюулгүй ажиллагаа, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааны журмыг таниулан сургасан. Үүний үр дүнд орчин

үеийн тоног төхөөрөмж дээр аюулгүй нөхцөлд ажиллаж буй ажилтнуудын ажлын орчин дахь сэтгэл ханамж өндөр, улам их хүсэл тэмүүлэлтэйгээр ажиллах болжээ.

Тийссений хэлж буйгаар “Хэрэв бидэнд эдгээр (Монгол Улсын) стандартад нийцсэн нядалгааны цех байхгүй бол мэргэжлийн хяналтын зүгээс Занаду Разорбакт ажлаа үргэлжлүүлэх зөвшөөрөл өгөхгүй хаагдах эрсдэл байсан. Өмнө нь төрийн байгууллагуудаас тавьсан олон тооны шаардлагуудыг бид хангаж чаддаггүй байсан. Бид энэхүү хөрөнгө оруулалт дээр Мерси Кортой түншлэн ажиллаагүй бол юу болох байсныг төсөөлөхөд ч бэрх. Миний бодлоор Мерси Кор байгаагүй бол бид энэ үнэтэй, өндөр чанартай, дотоодын болон олон улсын шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжийг худалдан авахын тулд 4 жил илүү ажиллах шаардлагатай байсан. Энэ нь (нядалгааны цехээ өргөтгөх) миний мөрөөдөл байсан, бас махан бүтээгдэхүүн экспортлох гол шаардлага юм.”

Үр дүн 2: Зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлсэн

Компани нь өөрийн вэбсайт болон Фэйсбүүк хуудсыг илүүтэй ашиглан өөрийн махан бүтээгдэхүүнийг идэвхтэй сурталчилдаг. Эдгээр цахим зах зээлийг ашигласны дүнд компани нь энгийн дэлгүүрээс өргөжин, томоохон ресторан, жуулчны бааз, амралт болон Монгол дахь хамгийн том уул уурхайн компани болох Оюу Толгойд ханган нийлүүлэлт хийж байна. Төслийг эхлүүлснээс хойш Занаду нь дахин хоёр ресторан, гурван амралтын газар, жуулчны баазтай гэрээ байгуулахын зэрэгцээ хувь хүмүүсийн захиалгыг нийлүүлэх хүчин чадлаа нэмэгдүүлжээ.

КОВИД-19 халдвараас үүдэлтэй хязгаарлалтаас шалтгаалан хил хаасан нь экспортыг удаашруулж, эдийн засаг болон олон нийтийн худалдан авалтад сөргөөр нөлөөлж байна. Хэрэглэгчдийн мөнгөн урсгал удааширч, өндөр үнэтэй мах худалдан авах нь буурчээ. Олон тооны ресторанууд үйл ажиллагаагаа зогсоож эсвэл эрэлт буурснаас үүдэн хэвийн үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулснаас үүдэн өмнөхийн адил Занаду Разорбакаас байнгын худалдан авалт хийхээ больжээ. Компанийн өсөлтөд тулгарсан өөр нэгэн саад тотгор нь жуулчны бааз, амралтын газар зэрэг аялал жуулчлалын бизнес эрхлэгчдээс ирэх захиалга тасарсан явдал байв. 2020 оны зун гадаадын жуулчид Монголд ирэх боломжгүй байнаас үүдэн тухайн бизнес эрхлэгчид өмнөх жилтэй ижил хэмжээний мах худалдан авах хэрэгцээ шаардлага хумигдсан байв. Эдгээр нөхцөл байдал нь Занадуг худалдан авах үхрийн тоог цөөрүүлэхэд хүргээд зогсохгүй үйл ажиллагаагаа хумихад хүргэжээ.

Гэхдээ эдгээр хүндрэл дундаас инновац төрөн гарчээ! Занаду Разорбак нь зах зээл дээр гарсан өөрчлөлтөд нийцүүлэн гэрээр мах хүргэх үйлчилгээг нэвтрүүлсэн. Энэхүү үйлчилгээ нь хувь хүмүүсээс ирэх захиалгыг 70% нэмэгдүүлсэн бөгөөд Хутаг-Өндөр сумын болон Улаанбаатар хотын хэрэглэгчдэд энэ үйлчилгээ хүрч байна. Хэрэглэгчдийг гэртээ хүргүүлэн авахад нь идэвхжүүлэх зорилгоор Занаду Разорбак нь шинэ бүтээгдэхүүн болох татсан мах, хавирга, шөлний хөрөөдсөн яс, савласан өөх, чөмөг зэргийг санал болгож эхэлсэн. Занаду нь эдгээр бүтээгдэхүүнийг гэрээр

хүргүүлэн авдаг дундаж худалдан авагчийн сонголт, үнэтэй нийцүүлэн санал болгож байна.

Үр дүн 3: Малчид зах зээлээ өргөжүүлсэн

Бизнесийнхээ үндсэн үйл ажиллагааны хүрээнд Занаду нь жил тойрон малчдаас үхэр худалдан авч тэжээн, нядлан борлуулдаг. Нядалгааны цехийн төсөл хэрэгжүүлэн үйлдвэрлэлийн хүчин чадлаа сайжруулсны дүнд үхэр худалдан авдаг байсан малчдын тоо хоёр дахин нэмэгдэн, 20-иос 40 болон өссөн. Түүнчлэн 2019 оны 10-р сараас хойш Занаду Разорбак нь нийт 289 үхэр худалдан авсан нь өмнөх жилээс 5% өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өссөн нь тухайн бизнес эдийн засгийн хувьд дасан зохицсон, эдийн засгийн байдлаас шалтгаалан борлуулалтын хэмжээ, орлого ихээр буурсан ч өсөлт гаргах боломжтой буйг илтгэн харуулж байна!

Занаду Разорбак нь өөрсдөд нь үхэр нийлүүлдэг орон нутгийн малчдыг бизнесийн амжилтынх нь бүрдүүлэгч чухал оролцогч тал хэмээн үздэг. Захирал Тийссений зүгээс малчдад орон нутгийн зах зээл, худалдан авагчийн стандарт, шаардлагууд, компанийн цаашдын төлөвлөгөө, зорилтын талаар байнга шинэ соргог мэдээлэл өгч байхад түлхүү анхаарал хандуулдаг. Занаду нь үхэр худалдан авахад баримтлах өөрийн стандартыг гарган, малчдад мэдээлсэн ба нас, эрүүл мэнд, вакцинжуулалт, мөшгөх тогтолцоо зэргийг үүнд харгалзан, малчид сайн чанарын мал нийлүүлэхийг нь дэмжих үүднээс стандарт хангасан малыг худалдан авахдаа нэмэлт үнэ төлдөг.

Хутаг-Өндөр сумын засаг дарга Занаду Разорбакын төсөл нь мал маллагааны шинэ арга барилд шилжих малчдын сэтгэлгээнд өөрчлөлт оруулсан болохыг цохон тэмдэглэж байв. Занадугийн мал бордох цехийг загвар хэмээн харж, малчид малын тэжээлд хөрөнгө оруулж, жилийн туршид тэжээх аргачлалыг хэрэгжүүлэхийн үнэ цэнийг ойлгожээ. Залуусын хувьд үхэр өсгөх арга ажиллагааны талаар илүү их мэдэх болж, зах зээлд борлуулах сайн чанарын махны гарцыг нэмэгдүүлж байна. Жишээ нь орон нутгийн гурван фермер Занадугийн мал бордох загварыг ашиглан өөрийн мал сүргээ илүү сайжруулж, чанарыг нэмэгдүүлж, улмаар Занадуд мал нийлүүлэх болсон байна.

Үр дүн 4: Бизнесийн чадамжийг сайжруулсан

Мерси Корын дэмжлэгтэйгээр Занаду Разорбак нь олон улсын зах зээлд өөрийн бүтээгдэхүүнийг борлуулах зорилго бүхий 4 жилийн хугацаанд хэрэгжих бизнесийн төлөвлөгөөг боловсруулан гаргасан. Энэхүү зорилгод хүрэх гол бүрэлдэхүүн хэсэг нь Европын холбооны стандартад нийцсэн нядалгааны цех байгуулан, чанар болон эрүүл ахуйн шаардлагыг хангах явдал байсан. 4 жилийн бизнес төлөвлөгөө нь цаашид өсөлтөө хангах, үйл ажиллагаагаа сайжруулахад нь хөтөч болно. Төлөвлөлтийг 4 жилээр хийсэн тухайгаа Тийссен “Хөдөө аж ахуйн салбарын инновацид цаг хугацаа шаардлагатай бөгөөд хөгжүүлэхэд хамгийн багадаа 4 жил шаардлагатай. Эхлээд их хэмжээний хөрөнгө оруулалт хийх ч ашиг нь эхний 1-2

жилд бага байх тул ямар нэгэн харагдахуйц үр дүн гарахгүй. Гэхдээ суурь нь ийнхүү сайн тавигдсанаар 3 болон 4 дэх жилд ашиг олно” хэмээн тайлбарлаж байна. Занаду Разорбак компанийн Мерси Кортой тогтоосон түншлэл нь компанийн шинэлэг, инновац бүхий үйл явцад эргэлт хийж, бизнесийн үйл ажиллагааны хүчин чадлаа сайжруулахад нь шаардлагатай дэмжлэг болжээ.

Мөн бизнесийн цар хүрээ өргөжин тэлэхийн хэрээр Занаду хүний нөөцөө улам бэхжүүлэх хэрэгцээ өсөн нэмэгдэж буйг тогтоосон. Тэдний хувьд ажилтан олох, тогтвортой ажиллуулахад багагүй саад бэрхшээл учирч байв. Энэхүү сорилтыг анхааран Занаду нь Мерси Корын ханган нийлүүлсэн үйлчилгээний хүрээнд зөвлөх үйлчилгээний компанитай хамтран ажилтан авах үйл явц, хүний нөөцийн бодлогоо сайжруулжээ. Эдгээр бүтцийн чиглэлийн сайжруулалтыг хийж, үйл ажиллагаанд нэвтрүүлснээр Занаду нь фермийн менежер, нядалгааны менежер ойрын үед авч ажиллуулахаар төлөвлөж байна.

Цаашдын үйл ажиллагаа

Занаду Разорбак ХХК нь ирэх 4 жилийн хугацаанд олон улсын экспортын зах зээлд нэгдэхээр төлөвлөж байна. Үүний тулд сар тутмын махны үйлдвэрлэлээ 2021 он гэхэд 20%-иар нэмэгдүүлэх, 2023 он гэхэд дахин 63%-иар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Компани нь нядалгааны үйл ажиллагаагаа өргөжүүлэн, бог мал (хонь, ямаа) нядлахаар төлөвлөж буй бөгөөд тухайн үйл ажиллагаа явуулж буй газарт нь бог мал ихтэй, зах зээлийн эрэлт ч өндөр буй юм. Үйлдвэрлэлээ нэмэгдүүлснээр нядалгааны цех нь цаашид 7 хоногийн 5 өдөр бүрэн хүчин чадлаараа ажиллах юм. Түүнчлэн Занаду Разорбак нь, талуудын үүрэг хариуцлагыг тогтоосон албан ёсны гэрээгээр дамжуулан малчидтай бизнесийн харилцаа тогтоож, улмаар цаашид орон нутгийн түншлэгч малчдад санхүүгийн баталгаатай эх үүсвэр гарган өгөхөөр төлөвлөж байна.



Амжилтын түүх

ЧАНАРТАЙ МАХ- НАЙДВАРТАЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Түншлэгчийн нэр: Минжийн Бор Өтөг ХХК

Төслийн байршил: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум

Хугацаа: 2019 оны 8 сар – 2020 оны 6 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Минжийн Бор Өтөг нь Сэлэнгэ аймгийн төвд үйл ажиллагаа явуулж, орон нутгийн хэрэглэгчдэд өөрийн нэрийн хүнсний дэлгүүрээр дамжуулан шинэ мах, гэдэс дотор, шийр, царцаамаг зэрэг дайвар бүтээгдэхүүн борлуулдаг. Аймгийн төвд байрладаг давуу талаа ашиглан тус компани нь махны жижиглэн худалдааны дэлгүүр байхгүй хөрш гурван сумын иргэдэд үйлчилдэг. Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” (RCP) хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр тус компани нь “Чанартай мах-Найдвартай нийлүүлэлт” хэмээх төслийг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд 2019 оны 8-р сараас 2020 оны 6-р сарын хооронд хэрэгжүүлсэн.

Энэхүү төсөл нь зах зээлийн эрэлтийг хангахын тулд сайн чанарын мах үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилготой. Төслөөс хүлээгдэж буй дүнг 1) мах боловсруулах

хүчин чадлыг сайжруулсан байх (үүнд бизнес удирдлага, боловсруулалт болон борлуулалтыг сайжруулах), 2) Минжийн Бор Өтөг ХХК-д мал нийлүүлэх малчин өрхийн тоо өссөн байх, 3) орон нутгийн зах зээлд нийлүүлж буй мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдсэн байх хэмээн тодорхойлжээ.

Энэхүү төслийн хүрээнд компани нь боловсруулах цех, вакуум савлагааны дамжлага, 20 тонн мах нөөцлөх хүйтэн зоорь зэргийг байгуулан үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмж, үүний үр дүнд зах зээлд нийлүүлэх сайн чанарын махны хэмжээг нэмэгдүүлсэн. Түүнчлэн Минжийн Бор Өтөг нь махны хомсдол үүсдэг хаврын улиралд сайн чанарын махны тогтвортой нийлүүлэлтийг хангах зорилгоор 20 толгой үхэр бордох хүчин чадалтай байгууламж барьж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Үр дүн 1: Бизнесийн өсөлт, ашиг орлогыг нэмэгдүүлсэн нь

Төслийн хэрэгжилтээс гарсан үр нөлөө нь өмнө нь мах боловсруулах үйл ажиллагаа зөвхөн намар, өвөл хийгддэг байсантай харьцуулбал одоо бүтэн жилийн туршид тасралтгүй үйл ажиллагаа явуулж буйгаас илэрхий харагдаж байна. Жилийн турш үйлдвэрлэл явуулах боломжтой болж, хүйтэн зоорьтой болсноор үйлдвэрлэж буй махны хэмжээг хоёр дахин, дайвар бүтээгдэхүүний хэмжээг гурав дахин нэмэгдүүлжээ. Минжийн Бор Өтөг нь төсөл хэрэгжсэн 10 сарын хугацаанд нийт 100.6 тонн мах, 15.8 тонн дайвар бүтээгдэхүүнийг орон нутгийн зах зээлд нийлүүлжээ. Энэ нь өнгөрсөн жилтэй харьцуулбал хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлт юм. Компанийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдсэн нь борлуулалтын орлого 71% өсөхөд хүргэж, зах зээлд эзлэх хувь нь 15%-иас 30% болж хоёр дахин өсчээ.

Хөргүүртэй зоорьтой болсны өөр нэгэн давуу тал нь махыг аюулгүй, цэвэр орчинд хадгалснаар хэрэглэгчдийг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах боломжтой болсон байна. Дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадлаа нэмэгдүүлснээс хойш компани нь шинээр 10 төрлийн нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлжээ. Эдгээрийн тоонд төрөл бүрийн мах болон царцаамаг, савласан элэг, банш, толгой, шийр зэрэг багтна. Минжийн Бор Өтөг ХХК-ийн захирал хэлэхдээ чанар сайн, үнэ хямд учир дайвар бүтээгдэхүүн маш сайн зарагддаг гэжээ. Өмнө нь хадгалах, боловсруулалт хийх боломж байхгүйн улмаас дайвар бүтээгдэхүүн хаягддаг байв. Гэвч төслийн хүрээнд хадгалах тоног төхөөрөмж авч, суурилуулсны үр дүнд дайвар бүтээгдэхүүн нь одоо бизнесийн өсөлтийн гол нөөц болжээ. Компани нь дайвар бүтээгдэхүүний хаягдлыг бууруулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, шинэ орлогын эх үүсвэр бий болгосон.

Түүнчлэн Минжийн Бор Өтөг нь дэлгүүрийнхээ махны лангуунд хөлдөөгч авч тоногловсон. Хэрэглэгчдийн зүгээс чанар болон аюулгүй байдлын чиглэлээр илүү их шаардлага тавих болсон тул компани нь дэлгүүр дээр аюулгүй хадгалах тоног төхөөрөмж байх шаардлагатай хэмээн үзсэн байна. Байнгын үйлчлүүлэгчдийн нэг нь “Би бусад дэлгүүрээс илүү энэ дэлгүүрт илүү дуртай. Учир нь мал нядалгааг зөвшөөрөлтэй газарт хийдэг тул махны чанар, эрүүл ахуйд итгэлтэй байдаг. Бусад

дэлгүүртэй харьцуулбал мах нь шинэ, үнэ нь хямд байдаг. Түүнчлэн дэлгүүрийн орчин нь тав тухтай, аюулгүй, манай энэ хавийн мах жижиглэнгээр борлуулдаг бараг бүх газруудад зориулалтын хөргөгч байдаггүй” хэмээн хэлж байв. Компанийн захирал мөн дэлгүүрийн үнийн бодлогын талаар “Бид 2016 оноос хойш тусгайлсан хямд үнийн бодлого хэрэгжүүлж байгаа. Манай үнэ гэхэд бусад дэлгүүрээс кг тутамдаа 500 төгрөгөөр хямд тул үйлчлүүлэгчид хямд үнэд татагдаж манайхаар үйлчлүүлдэг нь бидэнд зах заалд өрсөлдөх давуу тал болдог. Үүний үр дүнд бид илүү их хэмжээний борлуулалт, хурдан хугацаанд хийдэг” хэмээн тайлбарлаж байв.

Бизнесийн үйл ажиллагаа нь өсөн нэмэгдэхийн хэрээр Минжийн Бор Өтөг 4 байнгын ажилтан шинээр авч ажиллуулсан. Мерси Кортой түншлэн тус компани нь ажилчдынхаа зөөлөн үр чадвар болох үйлчлүүлэгчтэй харилцах зэрэг үр чадварыг хөгжүүлж, борлуулалтын хяналтын системийн нэвтрүүлсэн. Мерси Корын орон нутгийн ажилтан нь нийлүүлэгчийн бүртгэл, борлуулалтын хяналт, нягтлан бодох бүртгэл хийх компьютерын систем хэрхэн ашиглах зэргийг зааж, зөвлөж компанид дэмжлэг үзүүлсэн. Өмнө нь компани ажилчин авч ажиллуулахад бичгээр гэрээ хийдэггүй байсан бол одоо хөдөлмөрийн гэрээ боловсруулах, хувийн хэрэг бүрдүүлэх, гэрээ болон бусад баримт бичгийг аюулгүй хадгалах үр чадвартай болжээ. Энэ талаар компанийн захирал “Мерси Корын дэмжлэггүйгээр бид өнөөгийн байдалдаа хүрэхийн тулд 4-5 жил зарцуулах байсан. Нэг жилийн өмнө манай бизнес нь жижигхэн махны дэлгүүр байсан бол одоо орон нутгийн махны зах зээлийн найдвартай оролцогч болоод байна. Энэхүү төсөл нь зөвхөн санхүүгийн тусламж ч бус мөн бид бүгдэд сурч мэдэх их боломжийг олгосон төсөл байлаа” хэмээн хэлж байна.

Үр дүн 2: Малчин өрхүүдэд зах зээлийн боломж нээж өгсөн

Төсөл хэрэгжихээс өмнө Минжийн Бор Өтөг нь тогтмол 100 малчин өрхөөс мал худалдан авдаг байв. Компанийн бизнесийн цар хүрээ өргөжих тусам илүү олон тооны малчдаас ахиу хэмжээгээр мал худалдан авах боломжтой болж иржээ. Одоогоор нийт 240 малчин Минжийн Бор Өтөг ХХК-д мал нийлүүлж байна. Сүүлийн 10 сарын хугацаанд нийт 2300 толгой малыг эдгээр малчдаас худалдан авсан нь өмнөх жилд худалдан авсан малын тооноос хоёр дахин илүү байна.

Шинээр өөр малчидтай холбоо тогтоон, байнгын ханган нийлүүлэгч болгохын тулд Минжийн Бор Өтөг нь нийлүүлж буй малын нас, эрүүл мэнд, амьдын жин зэрэг дээр үндэслэн урамшуулал олгох болсон. Малчид ч малаа ченжүүдэд зарснаас илүү ашигтай учраас Минжийн Бор Өтөгт борлуулах хүсэлтэй болжээ. Ченжүүдийн худалдан авч буй үнэтэй харьцуулбал Минжийн Бор Өтөг нь бог малд 14-20 мянган төгрөг, бод малд 70-85 мянган төгрөгийн илүү үнэ санал болгож байна. Бизнесийн үйл ажиллагаа өсөх тусам компанийг сумын болон хөрш зэргэлдээ сумын малчид илүүтэй хүлээн зөвшөөрөх болжээ. Өндөр үнийн бодлого баримталсны үр дүнд малчид ч тус компанид малаа нийлүүлэх сонирхол нэмэгдсэн. Түүнчлэн малын гаралтай түүхий эд худалдан авдаг бусад талуудаас ялгаатай нь Минжийн Бор

Өтөг нь өөрийн машиныг явуулан малаа сумын төв хүртэл тээвэрлэдэг нь малчдын хувьд тээврийн зардал хэмнэх болжээ. Энэ нь Минжийн Бор Өтөг компанийн зүгээс алслагдмал нутагт амьдарч буй малчдын зах зээлийг өргөжүүлэх, мөнгөний хэрэгцээтэй болох үед малаа борлуулах боломж олгох хүсэл эрмэлзэлтэйг нь харуулж байна.

Үр дүн 3: Мал аж ахуйн шинэ арга ажиллагааг нэвтрүүлсэн

Занаду Разорбак ХХК-ийн мал бордох цэгийг үзсэний дараа Минжийн Бор Өтөг ХХК-ийн захиралд өөрийн ажиллуулж буй мал бордох цэгийн үйл ажиллагааг өргөжүүлэх сэдэл төржээ. Минжийн Бор Өтөг нь 20 үхэр худалдан авч, өвлийн туршид бордож тарга авахуулсан ба нэг бүр нь ойролцоогоор 10 кг жин нэмсэн байна. Хангалтай хэмжээнд жин нэмсний дараа компани нь үхрийг нядалгаанд оруулж, махыг нь борлуулдаг. Улмаар Минжийн Бор Өтөг нь дахин 20 үхэр худалдан авчээ. Өвөл, хаврын улиралд Минжийн Бор Өтөг нь нийт 40 үхэр бордон тэжээж 8.3 тонн мах үйлдвэрлэсэн нь анхлан төлөвлөсөн 1.3 тонноос давжээ.



Компанийн захирал үхэр бордохын ач холбогдлын талаар “Өвөл, хавар эрт цагаар үхэр бордох нь чанартай махны нийлүүлэлтийг тасралтгүй байлгахад их тустай. Малыг хувьд өвөл, хавар жингээ ихээр алддаг хамгийн хүнд цаг үе байдаг. Энэ үеэр малчид малаа бараг нядалдаггүй. Харин эсрэгээр энэ хомсдолын үед хэрэглэгчид шинэ, сайн чанартай мах шаарддаг. Тиймээс бордох цэг байгуулах нь үхрийн махны зах зээлийн эрэлтийг хангах хамгийн сайн арга зам” хэмээн хэлж байв. Махны хомсдол үүсдэг цагаар өөрийн дэлгүүрийн хангамжийг тасралтгүй байлгах боломж бүрдснээс гадна энэхүү үйл ажиллагаа нь зах зээл дээр хомсдол үүсэх үед ханган нийлүүлэлтийн сүлжээг нь тогтворжуулж өгдөг байна. Жишээ нь КОВИД-19 халдварын үеэр Минжийн Бор Өтөг нь малчдаас мал худалдан авах боломжгүй байсан ч өөрийн малаа нядлан борлуулах замаар нийлүүлэлтээ хадгалж чаджээ. Энэ нь тухайн компанийн нөхцөл байдалд дасан зохицох чадварыг нэмэгдүүлжээ.

Үр дүн 4: Зах зээлийн талуудын оролцоог нэмэгдүүлсэн

Минжийн Бор Өтөг компанийн үйл ажиллагаа явуулж буй суманд нядалгааны газар байдаг. Гэхдээ үйлчлүүлэгчийн тоо бага байдгаас үүдэн дөнгөж хүчин чадлынхаа 30%-ийг л ашигладаг. Төсөл хэрэгжих хугацаанд Минжийн Бор Өтөг нь тэрхүү нядалгааны газартай ойр хамтран ажиллаж, 2300 гаруй мал нядлуулж, нядалгаанаас гарсан мах, дайвар бүтээгдэхүүнийг өөрсдөө боловсруулалт хийн борлуулсан. Нядалгааны газрын менежер энэ талаар “Минжийн Бор Өтөг компанийн зүгээс үйлчилгээ үзүүлэх хүсэлт нэмэгдсэн нь манай бизнесийн үйл ажиллагаа, орлогод

ээрэг нөлөө үзүүлсэн” гэж хэлжээ. Минжийн Бор Өтөг компанийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдсэний үр дүнд тус нядалгааны газрын нядалж буй малын тоо хоёр дахин нэмэгдэж, орлого нь өнгөрсөн жилтэй харьцуулбал 5 дахин өссөн байна.

Минжийн Бор Өтөг компанийн үйлдвэрлэл, боловсруулалтын хүчин чадал нэмэгдэхийн хэрээр түгээлтийн сувгуудаа олшруулан, төрөлжүүлжээ. Өмнө нь Минжийн Бор Өтөг махаа зөвхөн өөрийн дэлгүүрээр дамжуулан зардаг байсан бол одоо компани нь 10 гаруй орон нутгийн дэлгүүрээр махаа борлуулж, 6 зоогийн газарт ханган нийлүүлэх гэрээг байгуулаад байна. Мөн Минжийн Бор Өтөг компанийн бизнесийн өсөлт нь бусад бизнес эрхлэгчтэй зах зээлийн харилцаанд орох замыг нээж, улмаар өртгийн сүлжээнд харилцан ашигтай байх үр өгөөжийг бий болгожээ. Харилцан хамаарал бүхий бизнесүүд өөр хоорондоо хамтын ажиллагаатай болсон нь тогтвортой зах зээлийн тогтолцоо руу явж буйн нэг илрэл юм.

Хүлээгдээгүй өөрчлөлт ба дасан зохицох менежмент

2020 оны 1-р сараас хойш дэлхий дахин КОВИД-19 халдварын цар тахлын нөлөөнд амьдарч байна. Жижиг бизнесүүд үйлдвэрлэлээ үргэлжлүүлэх чиглэлээр сорилтуудтай тулгарч, борлуулалт болон захиалга буурсаар байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй хязгаарлалтын хүрээнд ресторан, хоолны газрууд хаагдсан нь Минжийн Бор Өтөг компанийн борлуулалтыг хоёр дахин бууруулсан. Түүнчлэн хил хаасан явдал нь мөнгөний эргэлтийн удаашруулж байна. Гэсэн ч Минжийн Бор Өтөг нь бордох цехдээ өөрийн малтай, хөргүүртэй зоориндоо нөөцөлсөн махтай тул махны ханган нийлүүлэлтийг тасралтгүй хангажээ.

Бизнесийн тогтвортой байдал болон ойрын ирээдүйн хэтийн төлөв

Минжийн Бор Өтөг ХХК нь одоогийн зах зээлд эзлэх хувиа (30%) нэмэгдүүлж Сүхбаатар сумын зах зээлийн талаас илүүг (50-60%) болгон өсгөх алсын хараатай. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд үхрийн үүлдэр угсааг сайжруулан, бордох аж ахуйгаа өргөжүүлэх нь компанийн цаашдын хөгжлийн гол чиглэл болно. Түүнчлэн компанийн бизнесийн хамрах хүрээг өргөжүүлэхийн тулд компани нь өөрийн нягтлан бодох бүртгэл болон бизнесийн удирдлагын дотоод хүчин чадлаа сайжруулах шаардлагатай. Компанийн захирлын хэлсэнчлэн энэ нь бизнесийг цаашид хөгжүүлэх суурь хөшүүрэг байх юм.



Амжилтын түүх

МАЛЫН ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛСЭН НЬ

Түншлэгчийн нэр: Мон Мийт Трейд ХХК

Төслийн байршил: Хэнтий аймгийн Хэрлэн сум

Хугацаа: 2019 оны 8 сар – 2020 оны 6 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Мон Мийт Трейд ХХК нь 2007 оноос хойш мах боловсруулах үйл ажиллагаа эрхлэн явуулж байна. Хэнтий аймагт нядалгааны газар, боловсруулах цехтэй тус компани нь Улаанбаатар хотын гэр хорооллын хоёр цэгт махны дэлгүүр ажиллуулж байнгын үйлчлүүлэгчидтэй болсон. Мах боловсруулах ажиллагаанаас гарах хаягдлыг бууруулах буюу дайвар бүтээгдэхүүнийг шууд хаяхын оронд худалдан авч, хадгалж, улмаар толгой, шийр, гэдэс дотрыг нь боловсруулан Улаанбаатар хотын захын дүүргүүдээр өндөр чанартай, хямд үнэтэй бүтээгдэхүүнийг борлуулах хандлага баримталдаг аж ахуйн нэгж юм.

“Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан тэтгэлэгт төслийн хүрээнд Мерси Корын дэмжлэгтэйгээр өөрийн

Үйлдвэрлэлээ өргөжүүлж, хүйтэн зоорийн хүчин чадлаа дээшлүүлснээр жилийн туршид сайн чанартай дайвар бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэх боломжтой болжээ. Төсөл нь зах зээлийн эрэлтийг хангахын тулд сайн чанарын махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжсэн. Энэхүү зорилтын хүрээнд гурван гол үр дүнд хүрэхээр төлөвлөсөн нь: (1) үйлдвэрлэл болон нөөц хадгалах хүчин чадал нэмэгдсэн байх, (2) малын дайвар бүтээгдэхүүн ашигласан шинэлэг, үр ашигтай бүтээгдэхүүний хэрэглээ өссөн байх, (3) зах зээлийн холбоос бэхэжсэн байх зэрэг юм. Мерси Корын дэмжлэгтэйгээр Мон Мийт Трейд нь нийт 216 м² талбайтай боловсруулах үйлдвэрийн байраа шинэчилж, 300 тонн багтаамжтай хүйтэн зоорь барьж, боловсруулах болон хөргөх тоног төхөөрөмж худалдан авсан.

Үр дүн 1: Бизнесийн чадамж нэмэгдсэн

Компани нь өөрийн эрхэлж байсан дайвар бүтээгдэхүүн боловсруулах жижиг хэмжээний үйл ажиллагааг мах боловсруулах бизнесийн нэгэн томоохон, бие даасан салбар болгон хөгжүүлсэн. Одоо бог болон үхрийн толгой, шийр зэрэг дайвар бүтээгдэхүүнийг бүтэн жилийн туршид боловсруулах боломжтой болжээ. Үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн нь хот суурин газрын зах зээл дээрх дайвар бүтээгдэхүүний нийлүүлэлтийг хангахад түлхэц болсон. Компанийн захирал энэ талаар “Өмнө нь манай үйлдвэрлэл түүхий эдийн олдцоос их хамааралтай байсан. Өвөл, хавар дайвар бүтээгдэхүүний нийлүүлэлт хомс, харин зун, намар нь мал нядалгааны хугацаа болохоор их хэмжээний дайвар бүтээгдэхүүн ирдэг байсан. Манай компани ингэж ихээр ирсэн бүтээгдэхүүнийг хадгалах газар байхгүй байсан нь хаягдал болоход хүргэж, ашгаа алдаж байсан. Тиймээс энэхүү төслийг хэрэгжүүлэхдээ Мон Мийт нь 300 тонны багтаамжтай хүйтэн зоорь барихыг зорьсон.”

Хүйтэн зоорьтой болсон нь Мон Мийт Трейдийн бизнес өсөлтөд томоохон нөлөө үзүүлжээ. Нэгдүгээрт, дайвар бүтээгдэхүүнийг өвлийн улиралд муутгалгүйгээр, чанарыг нь алдуулалгүйгээр хадгалах боломжтой болсон. Мон Мийт зун, намрын цагаар буюу дайвар бүтээгдэхүүний үнэ 3-4 дахин хямд байх үед их хэмжээний дайвар бүтээгдэхүүн худалдан авч хадгалах боломжтой болсон. Энэхүү хүйтэн зоорь нь дайвар бүтээгдэхүүнийг зах зээлд шуурхай нийлүүлэх, ашигтай ажиллах боломжийг бүрдүүлж байна. Хоёрдугаарт, боловсруулсан бүтээгдэхүүнийг аюулгүй, найдвартай хадгалах болсноор компанийн үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдсэн. Үйлдвэрлэсэн барааг нэн даруй борлуулах шаардлагагүй тул компани нь хаягдал болгох, ашиг орлогоо алдах эрсдэлгүйгээр их хэмжээгээр үйлдвэрлэл явуулах боломжтой.

Зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн Мон Мийт нь төслийн хугацаанд гэдсэн бууз, хуушуур, хонины толгойн махан банш зэрэг гурван төрлийн шинэ бүтээгдэхүүн гаргасан. Эдгээр бүтээгдэхүүн нь чанартай, үнэ хямд тул хамгийн сайн зарагддаг. Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш боловсруулсан дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл 8 дахин нэмэгдэж, 21 тонноос 258 тонн болсноор орлого нь 10 дахин нэмэгджээ. Компанийн өсөн нэмэгдэж буй үйлдвэрлэлийн хэрэгцээг хангахын тулд Мон Мийт

шинээр 18 ажилчин авч, дайвар бүтээгдэхүүн боловсруулах, аюулгүй ажиллагааны чиглэлээр сурган ажиллуулжээ. Эдний дундаас 6 нь өрх толгойлсон эмэгтэй, 2 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бусад нь 35 хүртэлх насны иргэд байна. Компанийн захирлын зүгээс ажилтнуудаа авч үлдэх, ажлын байран дээр сургах нь ихээхэн сорилттой ажил байсан гэжээ. Ихэнх тохиолдолд шинэ ажилтан авахад анхны цалин авах хүртлээ ажиллачихаад дахин ажилдаа ирдэггүй байна. Компанийн захирлын хувьд үүнийг хүмүүс ажил хийх дургүй байдагтай холбон тайлбарлаж байна. Энэхүү асуудлыг шийдэхийн тулд компани нь хоёр үндсэн өөрчлөлт хийсэн ба үүнд: 1) ажилтнуудтай гэрээ хийх, 2) ажилчдыг сэдэл тэмүүлэлтэй болгох зорилгоор гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоог нэвтрүүлжээ. Ингэснээр ажилчид гүйцэтгэлээ сайжруулах, өдөр тутмын ажлаа сайн хийхэд түлхэц болсон байна.

Үр дүн 2: Малчид, орон нутгийн ханган нийлүүлэгчдийн боломж өргөжсөн

Мон Мийт Трейд түүхий эд худалдан авч, боловсруулалт хийн, нэмүү өртөг шингээн эцсийн хэрэглэгч шууд хэрэглэх бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа юм. Дайвар бүтээгдэхүүн худалдан авч, боловсруулах болсноор ММТ орон нутгийн хогийн цэгүүдэд хаягдаж буй малын гаралтай хог хаягдлыг бууруулахад мөн хувь нэмэр оруулж байна. Компанийн захирал болон Хэнтий аймгийн ХАА-н газрын дарга Энх-Амгалан нар “Өмнө нь Хэнтий аймгийн төвийн хогийн цэг дээр маш их хэмжээний дайвар бүтээгдэхүүн хаягддаг байсан. Харин одоо бид энэ асуудлыг шийдвэрлэж, төслийн үр дүнд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж байна” хэмээн тайландаа дурджээ.

Малчид ч мөн шинээр байгуулагдсан үйлдвэрийн үр шимийг хүртэж буй бөгөөд одоо тэд өөрийн түүхий эд, дайвар бүтээгдэхүүнийг боломжийн үнээр Мон Мийт компанид худалдах болжээ. Төсөл эхэлснээс хойш компани нь нийт 447 малчнаас түүхий эд, материал худалдан авахаар 324 сая төгрөг зарцуулсан. Түүнчлэн Мон Мийт нь орон нутгийн нядалгааны газруудтай гэрээ байгуулан зуны улиралд буюу дайвар бүтээгдэхүүн ихээр гарч буй үед дайвар бүтээгдэхүүнийг худалдан авахаар тохиролцжээ.

Компани нь хиама болон үхрийн шийрэн царцаамаг үйлдвэрлэдэг 4 компанитай гэрээ байгуулсан. Тус цехүүдэд бүтээгдэхүүнээ үйлдвэрлэхэд нь шаардлагатай дайвар бүтээгдэхүүнийг нийлүүлж байна. Борлуулж буй гэдэс дотор, дайвар бүтээгдэхүүнийг шинээр дөрвөн сувгаар нийлүүлэх болсон нь Мон Мийт компанид ч үр ашигтай байна. Мөн өөрийн үйлдвэрлэлд тогтвортой, чанартай орц нийлүүлэх боломжтой болсноор үйлдвэрлэгчдэд ч мөн ашигтай сонголт болжээ.

Үр дүн 3: Үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн эрэлт нэмэгдсэн

Компанийн бүтээгдэхүүний гол хэрэглэгчид нь Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчид бөгөөд тухайн хэрэглэгчид нь орлого багатайн улмаас хямд,

чанартай хүнс худалдан авах сонирхол өндөр байдаг. Төслөөс өмнө Мон Мийт нь Яармаг болон Толгойтын эцэст махны дэлгүүртэй байсан бол сүүлд Хайлаастын эцэст нэрийн дэлгүүрээ нээжээ. Энэ талаар компанийн захирал “хэрэглэгчид одоо манай бүтээгдэхүүний талаар сайн мэддэг, худалдан авах хүсэлтэй болсон тул дайвар бүтээгдэхүүн борлуулахад ямар ч асуудалгүй байгаа” гэв.

Компанийн борлуулалт нэмэгдсэн нь олон тооны хүмүүс үнэ хямд боловч чанар сайтай дайвар бүтээгдэхүүн буюу махнаас хоёр дахин хямд бүтээгдэхүүн худалдан авах сонирхолтой буйг илэрхийлж байна. Эрэлт өсөн нэмэгдэж буй нь КОВИД-19 халдвараас үүдэн өрхүүдийн мөнгөн орлого буурч, энэ төрлийн бүтээгдэхүүнийг түлхүү сонирхох болсонтой холбоотой. Ялангуяа хонины толгойн мах хамгийн түгээмэл бүтээгдэхүүн бөгөөд одоо компани нь өдөртөө нэг дэлгүүрээр 40 кг энэ төрлийн мах худалдааж байна. Хүмүүс дэлгүүр онгойхоос өмнө ирж оочирт зогсож байж өдрийн хэрэгцээт бүтээгдэхүүнээ авдаг тул хурдан зарагддаг. Компанийн захирлын зүгээс “Миний санаа зовоох гол зүйл бол яаж энэ эрэлтийг хангах гэдэг асуудал байна” хэмээн хэлж байна.

Компани нь мөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг олон улсын халуун тогооны сүлжээ ресторанд нийлүүлдэг дайвар бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлээд байна. Өмнө нь тус ресторанд 2 тонн үхрийн хэл жилд нийлүүлж байсан бол одоо 8 тонн хонины толгойн мах нийлүүлэхээр гэрээ байгуулаад байна.

Бизнесийн тогтвортой байдал болон ойрын ирээдүйн төлөвлөгөө

Мон Мийт компанийн захирал “Малын дайвар бүтээгдэхүүний бизнес нь энгийн боловч ихээхэн ашигтай бизнес юм. Гэхдээ ихэнх хүмүүс энэ бизнесийг их ажиллагаатай гэж боддог тул ашгийг нь үзэж чаддаггүй” хэмээн хэлж байна. Мон Мийт нь бүрэн хүчин чадлаараа ажиллаж, Хэнтий аймгийн төвөөс гарч буй малын бүх дайвар бүтээгдэхүүнд боловсруулалт хийнэ хэмээн тооцож байна. Компанийн захирал энэ талаар “заавал шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх шаардлага байхгүй, учир нь компанид хэрэгтэй зүйл нь энэхүү өндөр эрэлтийг хангахын тулд малын дайвар бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх арга зам олох л явдал” гэж үзэж байна.

Түүнчлэн компани нь Улаанбаатар хотод байрладаг нохой үржүүлгийн газруудыг шинэ зах зээл гэж харжээ. Дайвар бүтээгдэхүүний боловсруулалтаас үлдсэн материал нь маш өндөр тэжээллэг чанартай нохойн хоол болдог. Эдгээр нохой үржүүлгийн газруудад ойролцоогоор өдөрт 1 тонн нохойн хоол шаардлагатай бөгөөд сайн чанарын хоолны эрэлт өндөр байна. Мон Мийт нь хонины толгой боловсруулахад ойролцоогоор 100 кг орчим үлдэгдэл гарах тул ирээдүйтэй гэж үзжээ. Зах зээл дээр борлуулагдаж буй ихэнх нохойн хоол нь хадгалалтын горим алдагдаж, аюулгүй байдлын шаардлага хангадаггүй тул нохой үржүүлгийн газруудын зүгээс Мон Мийт компанитай шууд хамтран ажиллах сонирхлоо илэрхийлжээ.



Амжилтын түүх

МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙГ МАЛЧДАД ОЙРТУУЛАХ НЬ

Түншлэгчийн нэр: Дээдсийн Сүрэг ХХК

Төслийн байршил: Хэнтий аймгийн Норовлин сум

Хугацаа: 2020 оны 4 сар- 10 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Мах борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг Дээдсийн Сүрэг ХХК нь Хэнтий аймгийн Норовлин суманд үйл ажиллагаа явуулдаг. 2007 онд байгуулагдсан тус компани нь үхэр мал өсгөж, Улаанбаатар хотын хамгийн том захуудын нэг болох Хархорин зах дээр махны 2 лангуу ажиллуулдаг. Энэхүү борлуулалтын хоёр цэгээс гадна Чингис Хаан олон улсын нисэх буудал болон мах экспортлогч компаниуд гээд бусад харилцагч нарт мах нийлүүлж байна.

Дээдсийн Сүрэг нь өөрийн сумын малчдын хэрэгцээнд үйл ажиллагаагаа илүү сайн нийцүүлэхийн тулд махны бизнесээ өргөжүүлэх хүсэлтэй байжээ. Норовлин сум нь нийт 2400 оршин суугчтай бөгөөд эдгээрийн 60% нь малчид юм. Малчдын орлогын цөөн эх үүсвэрийн нэг нь нядалгааны улирлаар (9-12 сард) мал борлуулах явдал

байдаг. Малчдын хувьд суманд мах борлуулах нэгдсэн цэг байхгүй тул Улаанбаатар хотын зах зээлд мал борлуулахаар ихээхэн мөнгө зарцуулан, тээвэрлэдэг. Эсвэл малчид махаа ченжүүдэд зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулж тээврийн зардлаа хэмнэдэг. Түүнчлэн зориулалтын хүйтэн зоорь байхгүй тул их хэмжээний дайвар бүтээгдэхүүн болон гэдэс дотор, толгой, шийр зэрэг нь хаягддаг байсан.

Өөрийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэн, орон нутагт дайвар бүтээгдэхүүн боловсруулах цех болон гүн хөлдөөх, хүйтэн зоорь байгуулахын тулд Дээдсийн Сүрэг нь Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөртэй хамтран ажилласан. Тэдний зорилго нь “Зах зээлийн эрэлтийг хангахын тулд чанартай махны хэмжээг нэмэгдүүлэх” байжээ. Энэ зорилгоо хангахын тулд гурван зорилгыг дэвшүүлсэн нь; (1) Хүчин чадлаа нэмэгдүүлснээр зах зээлд (сум болон Улаанбаатар хотод) мах болон дайвар бүтээгдэхүүн жилийн турш нийлүүлэх; (2) Компани болон орон нутгийн малчид, аж ахуй нэгж хоорондын хамтын ажиллагаа, зах зээлийн холбоо бэхжих; (3) Махын эрүүл ахуй, чанарт тавигдах зах зээлийн шаардлагын тухай малчдын ойлголт, мэдлэг нэмэгдсэн байх зэрэг байна.

Үр дүн 1: Бизнесийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн

Дээдсийн Сүрэг ХХК нь Мерси Корын дэмжлэгтэйгээр дайвар бүтээгдэхүүн боловсруулах цех болон хүйтэн зоорийг сумын хэмжээнд анх удаа байгуулсан. Энэхүү төсөл эхлэхээс өмнө компани нь мал худалдан авч, Улаанбаатар хотын зах зээлд борлуулж байсан ч дайвар бүтээгдэхүүнийг ашиглалгүй хаяж байжээ. Харин одоо компани нь дайвар бүтээгдэхүүнийг орон нутагтаа боловсруулж, аюулгүй хадгалж, мах болон нэмүү өртөг шингээсэн дайвар бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотын зах зээлд шууд нийлүүлж байна. Үүний үр дүнд малчид малаа зах зээлийн, боломжийн үнээр борлуулж, Дээдсийн Сүрэг нь Норовлин сумын махны нэмүү өртгийн сүлжээнд дундын зууч ченжүүдийг халснаар малчдад очих ёстой орлого буурдаг явдлыг арилгажээ.

Түүнчлэн орон нутгийн төрийн ажилтнуудын зүгээс Дээдсийн Сүрэг компани махны зах зээлийн системийг орон нутагт бий болгож буйн ач холбогдлыг цохон дурдсан. Норовлин сумын ХАА-н тасгийн дарга “Аймгийн төвөөс 210 км, Улаанбаатар хотоос 540 км зайтай орших манай суманд зах зээлийн хүртээмж бий болгох нь манай сумын нэн тэргүүн шаардлагатай асуудал. Хэрэв малчид нэг үхэр борлуулахын тулд аймгийн төв рүү явбал тээврийн зардал нь 100 мянган төгрөг болно. Дээдсийн Сүрэг малчдаас мал худалдан авах, удаан хугацаанд хадгалах боломжтой болсноор хөрш Дадал, Баян-Уул, Баян-Овоо сумдын малчид одоо Улаанбаатар явах шаардлагагүй болсон. Хувь хүн дангаараа явахад тээврийн зардал өндөр гардаг тул орон нутгийн малчдын ихэнх нь малаа ченжүүдэд борлуулж, тэд цааш нь тээвэрлэдэг байсан ч худалдан авч буй үнэ нь бага байдаг. Харин одоо Дээдсийн Сүрэг нь энэ асуудлыг шийдэж нутгийн малчид Улаанбаатар хоттой ойролцоо үнээр малаа жингээр нь шууд бэлэн мөнгөөр борлуулах боломжтой болсон” гэж үзэж байна.

Монгол улсад мал нядалгаа улирлын чанартай явагдаж, ихэнх нядалгааны ажил 8-р сарын дундаас 11-р сарын хооронд мал зун бэлчээрээр тарга хүч авсны дараа хийгддэг. Үүнийг дагаад махны үнэ улирлаас хамааран хэлбэлздэг. Нядалгааны үеэр зах зээл дээр нийлүүлэлт нэмэгдэх тул махны үнэ буурч харин хавар болон зуны эхэнд нийлүүлэлт буурснаас үүдэн үнэ нь өсдөг.



Суманд ажиллаж буй мал аж ахуйн бизнесүүд нь хүйтэн хадгалах тоног төхөөрөмжгүй тул мал нядалсны дараа махаа аль болох хурдан хугацаанд борлуулах шаардлагатай болдог.

Харин Дээдсийн Сүрэг ХХК нь хүйтэн зоорьтой болсноор махаа нядалснаас хойш хавар хүртэл хадгалах боломжтой болсон. Ингэснээр махны үнийг тогтвортой байлгаж, зах зээлийн нийлүүлэлтийг хангах юм. Тиймээс Дээдсийн Сүрэг нь бүтэн жилийн туршид мах, махан бүтээгдэхүүний тогтвортой нийлүүлэлтийг бий болгохын зэрэгцээ улирлаас хамааралтай байдлыг бууруулж байна. Ийнхүү хүчин чадлаа шинээр үүсгэсэн нь тухайн байгууллагад бүтэн жил үйл ажиллагаа явуулах боломжийг олгож, тогтвортой мөнгөн урсгал бий болгож, ажилчдыг ч байнгын ажлын байртай байлгах болжээ. Хөргүүрт их хэмжээний мах, дайвар бүтээгдэхүүнийг чанар, эрүүл ахуйг ханган хадгалж, хэрэглэгчдэд хүргэдэг.

Норовлин сумын Засаг даргын орлогч “Малчид өмнө нь малын дайвар бүтээгдэхүүн болон толгой, шийрийг зүгээр л хаядаг байсан бол одоо эдгээрийг хаялгүйгээр, цехэд нийлүүлж, нэмэлт орлого олох боломжтой болсон. Хэрэв дайвар бүтээгдэхүүнийг цэвэрхэн, зөв цэвэрлэж боловсруулбал Улаанбаатар дахь өндөр үнэтэй ресторанууд болон бусад зах зээлд нийлүүлэх боломжтой” хэмээн хэлж байна.


Мерси Кортой түншлэн ажиллаж, Дээдсийн Сүрэг нь одоо сар тутамд хамгийн багадаа 300 гэдэс дотор боловсруулах хүчин чадал бүхий бага оврын дайвар бүтээгдэхүүн боловсруулах цехтэй болсон. 2020 оны 11-р сард компани нь Хэнтий аймгийн Мэргэжлийн хяналтын газраас шинээр үйлдвэрлэл эрхлэхийг зөвшөөрсөн албан ёсны зөвшөөрөл авсан. Улмаар үйл ажиллагаагаа өргөтгөн явуулсан эхний сард Дээдсийн Сүрэг нь 68 малчнаас 1419 толгой мал худалдан авсан ба махыг эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын өндөр түвшинд бэлтгэжээ. Бүх дайвар бүтээгдэхүүнийг ангилан, цэвэрлэж, хэрэглэгчдэд хүргэхэд бэлэн байдлаар савлажээ. Гулуузыг гялгар уутаар ороон жин алдахаас сэргийлэн, хөргүүрт хадгалсан.

Цех байгуулагдсанаас хойш өмнө нь хаягдал болж байсан дайвар бүтээгдэхүүн нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болсноор малчдын орлогод ч эерэг нөлөөлөл үзүүлж эхэлсэн. Компани нь гурван төрлийн шинэ бүтээгдэхүүн болох цэвэрлэж, вакум савласан үхрийн гэдэс, хонины гэдэс болон шийр зэргийг зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөсөн.

Компанийн захирал “Өөрийн төрсөн нутагтаа энэ байгууламж барих нь миний мөрөөдөл байсан. Мөрөөдөл маань биелсэнд би маш их баяртай байна. Ялангуяа суманд хүйтэн зоорь байх нь маш ховор байдаг. Бид орон нутгийн аж ахуйн

нэгжүүдтэй тогтоосон түншлэлээ энэхүү шинэ байгууламжаар дамжуулан бэхжүүлнэ хэмээн найдаж байна. Гэхдээ энэ бүх ажил анх бодсоноос хэцүү байсан” хэмээн хэлсэн.

Барилгын ажлын үеэр төлөвлөж байгаагүй саатал гарсан ба сумын эрчим хүчний чадал нь хөргөх тоног төхөөрөмж ажиллуулахад хүрэхгүй байсан тул цахилгаан тоног төхөөрөмжийн суурилуулалт дээр ихээхэн хүндрэл учирчээ. Түүнчлэн КОВИД-19 халдвартай холбоотойгоор хил хаагдсанаас үүдэн барилгын материалын үнэ нэмэгдсэн. Гэсэн ч компани нь тухайн сорилтуудыг даван туулахын тулд шургуу ажиллаж анхлан төлөвлөөгүй байсан 80 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг нэмэлтээр хийжээ. Энэхүү нэмэлт хөрөнгө оруулалт хийснээр компани нь хүйтэн зоорины хөргөх тоног төхөөрөмжийг заасан хүчдэл бүхий цахилгаан эрчим хүчинд холбож, дотоодын үйлдвэрийн барилгын материал ашиглан бүтээн байгуулалтын ажлаа дуусгажээ.




Сумын засаг даргын орлогч энэхүү шинэ байгууламж нь сумын мал ахуйд цаашид урт хугацааны нөлөөтэй байна хэмээн үзжээ. Энэхүү шинэ дэд бүтэц нь орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах төрийн бодлогод ч мөн

нийцсэн аж. Шинээр байгуулсан боловсруулах үйлдвэр нь нутгийн иргэдэд зориулан ажлын байр шинээр бий болгожээ. Компани сумаас өмнө нь хөдөлмөр эрхлээгүй байсан 3 шинэ ажилчныг байнгын ажилчнаар авахын зэрэгцээ салбараар мэргэшсэн үйл ажиллагаа хариуцсан менежерийг Улаанбаатар хотоос авч ажиллуулжээ. Шинэ менежерийн гэр бүл нь Улаанбаатар хотоос Норовлин суманд нүүн ирж суурьшсан. Менежер нь Дээдсийн Сүрэг компанид ажиллаж буйдаа сэтгэл ханамжтай, Дээдсийн Сүрэг нь шинээр авч буй ажилтнууддаа эрүүл мэнд, аюулгүй байдлын сургалт хийдэг тул боловсруулах цехийн үйл ажиллагааны чанарт сэтгэл өндөр буйгаа хэлж байв.

Дээдсийн Сүрэг нь Мерси Корын “Орон нутгийн бизнес клиник” төслийн хүрээнд Кинг Консалтинг компаниас дэмжлэг авчээ. Кинг Консалтингийн хэрэгцээнд нийцсэн, зорилтот дэмжлэгийн үр дүнд Дээдсийн Сүрэг нь өөрийн маркетингийн стратегийг сайжруулж, хүний нөөцийн үйл явцаа сайжруулжээ. Түүнчлэн энэхүү техникийн туслалцааны дүнд Дээдсийн Сүрэг нь бизнес төлөвлөгөө боловсруулж, хүний нөөцийн баримт бичиг, бүртгэлээ сайжруулж, сошиал сүлжээнд идэвхтэй харилцаа болжээ.

Үр дүн 2: Зах зээлийн холбоосыг бэхжүүлсэн

Зах зээлийн холбоосыг өргөжүүлэхийн тулд компани нь зах зээл дээрх шинэ боломжийн талаарх сурталчилгааны тараах материал бэлтгэн, сошиал сүлжээгээр түгээсэн. Дээдсийн Сүрэг нь өөрийн сошиал медиа хуудсыг нээсний дараагаас төсөл дуусах хүртэл хугацаанд 6 мянган гаруй хүмүүс хандсан байна. Үүний үр дүнд үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргах хүмүүсийн тоо ихээр нэмэгдсэний тоонд орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон нутгийн иргэд багтаж байна.



Компани нь мөн сумын ХАА-н тасагтай үр дүнтэй түншлэл үүсгэж, махны зах зээлд хялбар нэвтрэх боломжийг олгож буй шинэ байгууламжийн талаар малчдад хүрч мэдлэг, мэдээллийг нь нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан. Байгууламжийн үйл ажиллагаа эхэлснээс хойш цөөн хэдэн долоо хоногийн хугацаанд компани нь нийт 68 малчинтай шинээр бизнесийн харилцаа үүсгэсэн. Малчид нь компанийн зүгээс мал худалдан авах шалгуурын талаар мэдээлэлтэй болж, үйлдвэрлэлээ чанаржуулах, мөшгөх тогтолцоог хангах талаар ойлголт авчээ.



Засаг даргын орлогчийн зүгээс “Норовлин суманд эмнэлэг, сургууль зэрэг хувь хүмүүсээс байнга мах худалдан авдаг төрийн 5 байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Сургууль л гэхэд сар тутамд 300- 400 кг мах худалдан авах шаардлагатай байдаг. Махны үнэ нь намар 12-р сард болон хавар 3-р сард хэлбэлздэг. Харин одоо зориулалтын хүйтэн зоорьтой болсноор махны үнийг тогтворжуулах боломжтой болж, тэдгээр төрийн байгууллагууд нь Дээдсийн Сүрэг ХХК-тай мах бөөнөөр хямд үнээр худалдан авах болон чанарыг нь алдуулалгүйгээр хадгалах гэрээ хэлцэл байгуулах боломжтой болсон” хэмээн үзэж байв. Жишээ нь үйл ажиллагаа явуулсан цөөхөн сарын хугацаанд компани нь орон нутгийн цэцэрлэгтэй өөрийн хүйтэн зооринд 1.5 тонн мах хадгалах гэрээ байгуулжээ.

Түүнчлэн Норовлин сумын малчид, нутгийн иргэд, зэргэлдээ сумын малчид нь хүйтэн зооринд нь мах хадгалуулах хүсэлт гаргаж буй ч одоогоор албан ёсоор бус харин аман байдлаар л хандаж, сонирхлоо илэрхийлээд байна. Мөн Мерси Кортой хамтран ажиллагч түнш, аймгийн төв дээр мах борлуулдаг Мон Мийт Трейд компанийн зүгээс өвөл болон хавар нөөц нь буурах үед түүхий эд нийлүүлж байх хүсэлт гаргаад байна. Энэхүү үүсэн гарч буй эрэлтэд үндэслэн Дээдсийн Сүргийн захирал нь цаашид түрээслүүлэх гэрээ байгуулах чиглэлээр ажиллаж байна.

Үр дүн 3: Махны зах зээлийн тухай малчдын мэдлэгийг нэмэгдүүлсэн

Дээдсийн Сүрэг ХХК-ийн захирлын хэлж буйгаар өмнө нь маркетингийн чиглэлд анхаарал хандуулдаггүй байжээ. Харин одоо Мерси Короор дамжуулан Кинг Консалтинг компанитай хамтран ажилласны дүнд тэд маркетинг, олон нийттэй харилцахын үр ашгийг мэдэрчээ. Компани нь өөрийн тухай видеог YouTube сувгаар цацахын зэрэгцээ махны аюулгүй байдлын талаарх мессежүүдийг төрөл бүрийн маркетингийн арга замаар хүргэдэг болсны тоонд товхимол, ганцаарчилсан уулзалтууд, нийтийн хурал болон компанийн сошиал медиа хуудас зэрэг багтаж байна. Энэхүү маркетингийн стратеги нь тухайн бизнесийн үзэл баримтлалын талаарх хүмүүсийн ойлголтыг сайжруулахад ихээхэн үр дүнтэй болжээ. Олон нийтэд хандсан мессежээр дамжуулан Дээдсийн Сүрэг нь малын эрүүл мэнд, махны чанарын талаар мэдлэг, ойлголт нэмэгдүүлэхээр хичээн ажиллаж байна. Энэ нь малчид болон бусад ханган нийлүүлэгчдийг мал маллагааны арга ажиллагааны талаар өөрөөр бодож, улмаар мал аж ахуйн салбарын бүтээмж, хүнсний баталгаат байдлыг хангах талаар хандлагаа өөрчлөхөд хүргэнэ.



Одоо компани нь мал худалдан авахад тавигдах стандарт, шаардлагын талаар малчдыг мэдээллээр хангах чиглэлд ажиллаж байна. Үүнд эмийн үлдэгдэл малын биеэс гадагшлах хугацааг нарийн

баримтлах, мал маллагааны сайн арга туршлагыг мөрдөх, малын эрүүл мэндийн үйлчилгээг цаг тухайд нь авах болон бүртгэл хөтлөх зэрэг шаардлагууд багтдаг. Дээдсийн Сүрэг нь эрүү ахуйн шаардлага хангасан нөхцөлд мах боловсруулах, мал болон бүтээгдэхүүний чанар, мөшгөх тогтолцоо зэрэгт тэргүүлэх ач холбогдол өгч байна. Төслийн хэрэгжилтийн хугацаанд Дээдсийн Сүрэг нь компанид мал нийлүүлэх боломж, тавигдах шаардлагын талаар нээлттэй зарлаж, малчин өрхүүдэд зах зээлийн хэрэгцээ, шаардлагын талаарх мэдээлэл өгчээ. Дээдсийн Сүрэгт малаа нийлүүлснээр малчдын амьжиргааг сайжруулж, мал аж ахуйн сайн практикийг нэвтрүүлэх, малаа шууд нэмүү өртгийн сүлжээнд нийлүүлэх, боломжит үнээр борлуулах боломжийг үүсгэсэн.

Цаашдын үйл ажиллагаа

Аймгийн ХАА-н газрын дарга “Бид орон нутгийн брэндийн мах бий болгохоор зорин ажиллаж байна. Дээдсийн Сүрэг зэрэг хувийн компаниуд орон нутгийн мал аж ахуйн зах зээлийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой. Тиймээс орон нутгийн захиргаанаас бид бизнесүүд, мал аж ахуйн ханган нийлүүлэгчид, малчдад харилцан холбоотой байж, нэмүү өртгийн сүлжээг дэмжин ажиллахад нь дэмжлэг үзүүлэх ёстой. Үүний нэг жишээ нь орон нутгийн хувийн мал эмнэлгийн нэгжийг Дээдсийн Сүрэг ХХК-д танилцуулан эдгээр хоёр аж ахуйн нэгж нь цаашид үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж, гарал үүсэл нь тодорхой, вакцин болон эмийн үлдэгдэлгүй сайн найдвартай нийлүүлэлтийг бий болгоно хэмээн үзэж байна” хэмээн хэлж байв.

Дээдсийн Сүрэг ХХК-ийн захирал нь махны салбарын талаарх нарийвчилсан судалгааг үргэлжлүүлэн хийж, боломжит сорилт, эрсдэл болон боломжуудыг судлах хүсэлтэй байна. Цаашдын үйл ажиллагаанд баримтлах тэргүүлэх чиглэлээ “Одоо энэхүү бизнесийг өргөжүүлэх нь миний тэргүүн зорилго. Цаашдаа би өндөр чанартай, аюулгүй махыг идэвхтэй сурталчилна. Чанар болон эрүүл ахуйг хангахад ложистик нь чухал ач холбогдолтой. Ирэх 1- 2 жилийн хугацаанд би хэрэгцээнд суурилсан хүргэлтийн үйлчилгээг хангах замаар бизнесээ өргөжүүлэхэд төвлөрөн ажиллана. Энэ хугацаа дуусахад зах зээл дээр найдвартай ханган нийлүүлэгч хэмээн танигдаж, Дээдсийн Сүргийн нийлүүлсэн мах нь чанартай, найдвартай гэж хүмүүс ярих болно” хэмээн тодорхойлж байна.



Амжилтын түүх

МАЛ ЭМНЭЛГИЙН НЭГ ЦЭГИЙН ЛАБОРАТОРИ

Түншлэгчийн нэр: Сац Манал мал эмнэлэг

Төслийн байршил: Хэнтий аймгийн Баянхутаг сум

Хугацаа: 2020 оны 1 сар- 10 сар

Төслийн үндэслэл

Мерси Кор “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” (RCP) хөтөлбөрийг Булган, Сэлэнгэ, Хэнтий аймагт амжилттай хэрэгжүүлж 2021 оны 3-р сард дуусгасан. Үг хөтөлбөрийн гол зорилтуудын нэг нь мал эмнэлгийн болон лабораторийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, малын эмч нарын мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх, малын эрүүл мэндийн чиглэлээр малчдын мэдлэгийг нэмэгдүүлэх, төр болон хувийн хэвшлийн үр дүнтэй хамтын ажиллагааг дэмжих замаар малын эрүүл мэндийн салбарыг бэхжүүлэхэд оршиж байсан.

Хэнтий аймаг нь малын тоогоор улсад эхний 5-д ордог ч бэлчээрийн доройтлоор сүүл мушгиж байна. Хөрш Дорнод болон Сүхбаатар аймгууд малын өвчний голомтот халдвар бүхий аймагт ордог ба эдгээр аймгаас Улаанбаатар хотод

борлуулах гэж буй бүх мал Хэнтий аймгаар дайран өнгөрдөг. Түүнчлэн Монгол улсын Малын эрүүл мэндийн тухай хуульд 2017 оны 12-р сард томоохон өөрчлөлт оруулаад байна. Шинэчлэн батдагдсан Малын эрүүл мэндийн тухай хуулиар мал болон малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс өмнө лабораторид шинжлүүлэн, хүнсний аюулгүй байдлын гэрчилгээ авсан байхыг шаардах болсон. Энэхүү эрх зүйн шаардлага нь орон нутгийн түвшинд лабораторийн шинжилгээний эрэлт өсөхөд хүргээд байна.

Эдгээр хүчин зүйлсийг харгалзан Хэнтий аймгийн ЗДТГ-ын зүгээс аймгийн хэмжээнд малын эрүүл мэнд, өвчлөлөөс урьдчилсан сэргийлэлт болон илрүүлэлт, өвчний хяналтыг бэхжүүлэх чиглэлээр аймгийн түвшинд анхаарч, сумын түвшинд ажиллаж мал эмнэлгийн нэг цэгийн лабораторийг байгуулахаар болсон. Нэг цэгийн лаборатори нь мал эмнэлгийн үйлчилгээ, лабораторийн шинжилгээг малчид болон бусад хэрэглэгчдэд нэгэн дор үзүүлэх төвлөрсөн цэг юм.

Малын эрүүл мэндийн салбарт аймгийн Мал эмнэлгийн газруудтай урт хугацаагаар хамтран ажилласан бидний туршлага дээр үндэслэн Хэнтий аймгийн ЗДТГ-аас Мерси Кор хандаж тус аймагт “Нэг цэгийн лабораторийг” туршилтаар байгуулан ажиллуулахад дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргасан. Эхний алхам нь Хэнтий аймгийн сумын хэмжээнд түншлэн ажиллах хувийн мал эмнэлгийг олж тодорхойлох явдал байлаа. Төвийн болон орон нутгийн мэргэжилтнүүдтэй хамтран Мерси Кор Хэнтий аймгийн Баянмөнх, Баянхутаг, Баян-Овоо сумдад ажиллаж, сонголтоо хийсэн.

Сонгон шалгаруулалтын нэг гол шалгуур нь тухайн суман дахь лабораторийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ байсан. Түүнчлэн сумын түвшний мал эмнэлгийн лаборатори байгуулах эрх зүйн орчин судалж, шаардлагатай хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны зардлыг түншлэх боломжтой сум нэг бүрээр тооцон гаргаж, одоогийн хүний нөөц, тоног төхөөрөмжийг мал эмнэлэг нэг бүрээр тоолон, үнэлгээ хийсэн.

Сонгон шалгаруулах явцад орон нутагт мал эмнэлгийн лаборатори байгуулахад тулгарч байгаа хэд хэдэн томоохон саад бэрхшээлүүдийг тодорхойлсон. Үүнд: хүний нөөцийн хомсдол, тоног төхөөрөмжийн дутагдал, лабораторийн мэргэжлийн мэдлэг үр чадварын хангалтгүй байдал багтаж байна. Хамгийн чухал нь орон нутагт лабораторийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэх хүртэл бизнесийн ашгийн түвшин доогуур байх нь тогтоогдсон.

Хэдий дээрх сорилтууд байсан ч Баянхутаг сумын Сац Манал хувийн мал эмнэлгийн зүгээс Баянхутаг суманд нэг цэгийн лабораторийг байгуулах сонирхол, энэ чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллахаа илэрхийлсэн. Тус сумын байршил ч шалгуурт нийцсэн ба Баянхутаг сум нь аймгийнхаа хамгийн их малтай суманд тооцогддог тул орон нутагт үйлчилгээний өндөр эрэлтийг бий болгож буй юм. Тиймээс 2020 оны 2-р сард Мерси Кор, аймгийн Мал эмнэлгийн газар, сумын ЗДТГ, Сац Манал хувийн мал эмнэлэг хамтран Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үзэг зурж, хамтын ажиллагаа албан ёсоор эхэлсэн юм.

Сац Санал нь нийт 240 мянган толгой малд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд энэ нь тус сумын нийт малын 70% эзэлж байна. Тус мал эмнэлгийн үзүүлж буй үйлчилгээнд малын өвчлөлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, тандан судалгаа хийх, паразитын эсрэг үйлчилгээ, ариун цэвэр халдваргүйжүүлт, вакцинжуулалт зэрэг багтаж байна. Одоо лабораторийн үйлчилгээтэй болсноор сумын хэмжээний бүх мал, мах, сүүн бүтээгдэхүүнд хүнсний ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээ хийх боломж нээгджээ.

Суман дээр нэг цэгийн лабораторийг байгуулснаар нутгийн малчид болон мал аж ахуйн бизнес эрхлэгчид нь аймгийн төв орохгүйгээр ариун цэврийн гэрчилгээг богино хугацаанд авах боломж бүрдээд байна. Хамгийн чухал нь хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцсэн гэрчилгээтэй бүтээгдэхүүн нийлүүлснээр малчид илүү их ашиг орлого олох боломжтой болж байгаа. Түүнчлэн малчид лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн малын өвчин эрт илрүүлэх, урьдчилан сэргийлж, эрүүл мэнд, үржлийн ашиг шимээр нь ангилан ялгах замаар өөрийн мал сүргээ илүү үр ашигтай өсгөх боломж нээгдэнэ.

Сумын ЗДТГ, Сац Манал мал эмнэлэг, Мерси Кор нь бүгд нэг цэгийн мал эмнэлгийн лабораторийг байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. Мерси Кор лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлж, гурван ажилтныг нь Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори (УМЭАЦТЛ) дээр хоёр долоо хоногийн сургалтад хамруулсан. Сац Манал нь лабораторийн барилга барих, тавилга, урвалж бодис болон бусад хэрэгцээт зүйлсийг худалдан авах болон УМЭАЦТЛ дээр сургалтад хамрагдаж буй ажилтнуудын зам, хоолны зардлыг төлсөн.

Түүнчлэн сумын ЗДТГ болон аймгийн Мал эмнэлгийн газар нь бодлогын дэмжлэг үзүүлж, шинээр батлагдсан Малын эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт хангахад нь манлайлан ажилласан. Тухайн талуудын оруулсан гол хувь нэмэрт ЗДТГ-тай хамтран ажиллаж, лабораторийн шинжилгээнд үндэслэн малын эрүүл мэндийн гэрчилгээ олгох, сургалт семинар, мэдлэг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах замаар малчдад лабораторийн үйлчилгээ авахын давуу талуудыг ойлгуулах зэрэг багтаж байна.

Түүнчлэн УМЭАЦТЛ нь суманд ажиллаж буй мал эмнэлгийн ажилтнуудад зориулсан тусгайлсан хөтөлбөрийг боловсруулах, сургалт зохион байгуулах чиглэлээр ихээхэн чармайлт гаргасан. Жишээ нь сургалтын хүрээнд сумын түвшинд эрэлт хэрэгцээ нь өсч буй лабораторийн шинжилгээ, үйлчилгээг оролцогчид өөрсдийн биеэр, бодит нөхцөлд хийж, туршиж үзсэн. УМЭАЦТЛ нь одоо олон хувилбарт сургалтын хөтөлбөртэй болсноор орон нутгийн нөхцөл байдалд зохицуулан, Монгол улсын сумдад илүү олон тооны мал эмнэлгийн лабораториуд байгуулахад ашиглах боломжтой болжээ.

Арга зүй

RCP хөтөлбөрийн Малын эрүүл мэндийн багтай зөвлөлдсөний үндсэн дээр Мониторинг, үнэлгээний баг нь Сац Санал хувийн мал эмнэлгийн бизнесийн хөгжилд гарч байгаа өөрчлөлтүүдийн тухай мэдээлэл цуглуулахын тулд чанарын судалгааны төлөвлөгөө боловсруулсан. Тиймээс Мерси Кор нь 5 гол мэдээлэгчтэй 2020 оны 10-р сард ярилцлага хийсэн. Үүнд: хувийн мал эмнэлгийн захирал, сумын засаг дарга, мал эмнэлгийн газрын дарга болон лабораторийн үйлчилгээнд хамрагдсан малчдын төлөөлөл багтсан. Цуглуулсан чанарын мэдээллийг төслийн хэрэгжилтийн үеэр цуглуулсан тоон мэдээлэлтэй тулган, дүн шинжилгээ хийн баталгаажуулсан.

Үр дүн 1: Мал эмнэлгийн лабораторийн чадавх нэмэгдсэн нь

Мерси Кортой хамтран Сац Манал мал эмнэлэг нь лабораторийн хоёр өрөөг шинэчлэн засаж, 15 төрлийн лабораторийн тоног төхөөрөмж суурилуулснаар лабораторийн техникийн хүчин чадлыг бүрдүүлж, 2 малын эмчийг лабораторид авч ажиллуулсан. Улмаар компанийн захирал болон лабораторийн шинэ ажилтнууд Улаанбаатар хотод 4 долоо хоногийн лабораторийн сургалтад хамрагджээ. Сургалтын үр дүнд УМЭАЦТС-ын зүгээс Сац Маналын малын эмч нарт лабораторийн мэргэшсэн техникчийн гэрчилгээг олгосон байна. Тус эмнэлгийн малын эмч нар одоо мал эмнэлгийн шинжилгээ хийх, малын өвчин оношлох, ариун цэвэр болон чанарын шинжилгээ хийж мал аж ахуйн бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдлын шаардлагад нийцэж буйг баталгаажуулах боломжтой болоод байна.

Мал эмнэлгийн захирал нь лабораторийн үйлчилгээний ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж байна:



“Сүүлийн үед мал эмнэлгийн шинжлэх ухаан хурдацтай хөгжиж буйн улмаас хувийн мал эмнэлгүүд технологийн дэвшилтэй хөл нийлүүлэх шаардлага үүсэж байна. Зах зээлд нийлүүлэгдэж буй малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарын лабораторийн шинжилгээний хэрэгцээ өндөр байна. Тийм учраас бид энэхүү үйлчилгээг нутгийн иргэддээ зориулан санал болгохоор зорьсон. Аз болж, энэхүү хамтарсан төслийн үр дүнд бид одоо нэн шаардлагатай шинжилгээ тоног төхөөрөмж бүхий шинэ лабораторитой болоод байна. Мерси Корын оролцоогүйгээр бид ижил төстэй лаборатори байгуулахад 6 жил гаруй хугацаа зарцуулах байсан.”

Мал эмнэлгийн лаборатори нь одоо зургаан төрлийн ариун цэврийн шинжилгээг мах, сүүнд хийж тухайн бүтээгдэхүүн нь аюулгүй болохыг хэрэглэгчдэд баталгаажуулж өгч байна. Энэхүү шинжилгээнд маханд хийгдэх рН буюу хүчил шүлтийн шинжилгээ,

антибиотикийн үлдэгдлийн шинжилгээ, сүүн бүтээгдэхүүнд хийгдэх бохирдол, нэмэлт бодис, уураг, нүүрс ус тодорхойлох шинжилгээ зэрэг багтана. Түүнчлэн ийлдэсний шинжилгээг суманд хийх болсноор химийн урвалж ашиглан түргэвчилсэн тест хийж 1) боом, 2) галзуу, 3) цусан халдвар, 4) дотрын халдварт хордлого, 5) бруцеллёз болон 6) сүрьеэ гэсэн 6 төрлийн зооноз болон халдварт өвчнийг илрүүлэх боломжтой болжээ.

Мал эмнэлгийн захирал болон аймгийн Мал эмнэлгийн лабораторийн дарга нар малын өвчнийг илрүүлэх, хянах, урьдчилан сэргийлэхэд шинжилгээ хийх боломжтой байх нь асар өндөр ач холбогдолтой талаар дурдаж байв. Малын өвчнийг эрт илрүүлэх нь цаг алдалгүй шаардлагатай вакцин, эм тариаг захиалж хэрэглэх боломж олгож байгаа бөгөөд мал сүргийг эрүүл, зооноз өвчнөөс ангид байлгах нөхцөлийг бүрдүүлдэг. Түүнчлэн аймгийн Мал эмнэлгийн лабораторийн дарга сумын лабораторийг дэмжиж байгаагаа илэрхийлэн:

“Өөрийн гэсэн лабораторитой болсон нь Сац Манал мал эмнэлэгт шинжилгээнд орсон мал, малын гаралтай бүтээгдэхүүн нь халдваргүй болохыг батлан гэрчилгээ олгох боломжийг нээж, энэ нь борлуулалтад тус дэм болж, сумын мал сүргийг эрүүлжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Одоо тус мал эмнэлэг нь сэжигтэй болон клиникийн тохиолдлыг цаг алдалгүй шинжлэн, эмчлэх боломжтой болсон” хэмээн цохон тэмдэглэж байв.




Лабораторийн үйлчилгээнд хамрагдсан малчид, бизнес эрхлэгчид Мал эмнэлгийн гэрчилгээний нэгдсэн системд холбогдох боломжтой болж байгаа нь тэдэнд ихээхэн давуу талыг олгож байна. Сац Манал нь махны ариун цэврийн болон амьд малын эрүүл мэндийн гэрчилгээг олгох болсон. Олгогдсон бүх гэрчилгээ МЭЭГ-ын Мал эмнэлгийн гэрчилгээний нэгдсэн системд бүртгэгдэж байна. Тухайн систем нь мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдал, ариун цэврийн стандартыг шалган, жижиглэн худалдаачид, эцсийн хэрэглэгч нарт тухайн малыг нядлахаас өмнө ямар үйлчилгээ, эмчилгээ хийсэн болохыг мэдэх боломж олгодогдоороо ихээхэн үр өгөөжтэй юм. Үүний үр дүнд малчид, худалдаачид нь өөрийн бараа, бүтээгдэхүүнийг өрсөлдөхүйц үнээр борлуулах, хэрэглэгчид хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн хувьд баталгаатай, гэрчилгээжсэн бүтээгдэхүүнийг худалдан авах боломжтой болж байгаа юм.

Сац Манал лабораторийн гүйцэтгэсэн анхны ажил нь нийт 3400 хонины бруцеллёзын шинжилгээ байсан. Энэ нь Монгол улсын Засгийн газраас БНХАУ-д хандивласан 30 мянган хонины нэг хэсэг байсан бөгөөд төрийн захиалгаар энэхүү шинжилгээг хийлгэжээ. Аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Сац Маналын ажлын талаар ийнхүү хэлжээ: “Хувийн мал эмнэлэг нь энэхүү ажлыг амжилттай гүйцэтгэж, лабораторийн үйл ажиллагаа явуулах боломжтой болохоо үзүүллээ. Тус мал

эмнэлэг нь аймгийн лабораторийн чиг үүргийг хуваалцан гүйцэтгэх боломжтой болсон байна. Манай аймгаас халдварт өвчингүй 8 мянга гаруй хонийг Засгийн газарт гардуулсан. Энэ ажилд Сац Манал мал эмнэлэг нь чухал үүрэг гүйцэтгэж, нийт шинжилгээний ажлын бараг 43%-ийг хариуцан гүйцэтгэсэн”. Шинжилгээний үйлчилгээг цаг тухайд нь үзүүлсэн нь Сац Маналын лабораторийн хүчин чадал нэмэгдэж байгааг харуулсан.

2020 оны 6-р сард нэг цэгт лабораторийн үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш тус мал эмнэлэг нь нийт 313 малчин өрхийн 10101 толгой малд хүрч үйлчлэн, 189 тонн маханд эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээ хийгээд байна. Лабораторийн өргөтгөл нь орлогын шинэ эх үүсвэрийг нээж, үйл ажиллагаа явуулсан эхний 6 сарын хугацаандаа 10 сая төгрөгийн орлогыг зөвхөн лабораторийн үйлчилгээнээс төвлөрүүлжээ.



Түүнчлэн лабораторийн үйлчилгээний цар хүрээ өргөжих тусам Сац Манал нь бизнесийн тогтвортой үйл ажиллагаа явуулах чадавхаа бэхжүүлэх хэрэгцээ нь тодорхой болсон.

Тиймээс Сац Манал нь Мерси Короос санал болгосон бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг компанитай хамтран ажиллаж, тус мал эмнэлгийн бизнесийн одоогийн нөхцөл байдлыг тодорхойлж, бизнесийн болон маркетингийн төлөвлөгөөг боловсруулан гаргасан. Кинг Консалтинг ХХК-ийн өгсөн зөвлөмжийн дагуу Сац Манал нь өөрийн эрхэм зорилгыг тодорхойлж, лого зохиож, вэбсайт байгуулжээ. Мөн бизнесийн болон маркетингийн төлөвлөгөөг орлогын төсөөлөл, одоогийн эрэлтэд суурилан боловсруулан гаргасан.

Мал эмнэлгийн захирал нь энэхүү зөвлөх үйлчилгээний ач холбогдлыг “Бид зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээ анхааралгүй, зүгээр урсгал даган хөвж явснаа ойлгосон. Бид зөвхөн лаборатори л нээхийг хүсэж байснаас биш тодорхой зорилго, төлөвлөгөө байгаагүй. Сайн дэлгэрэнгүй төлөвлөхийн ач холбогдлыг би одоо л мэдэж авлаа. Энэ нь миний нүдийг нээсэн ажил боллоо” хэмээн үнэлсэн.

Үр дүн 2: Орон нутгийн оролцогч талуудтай түншлэл өргөжин тэлсэн нь



Сац Манал нь лабораторийн үйлчилгээ эрхэлж эхэлснээр орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, зах зээлээ өргөтгөх боломж нь нэмэгдсэн. Сумын засаг дарга болон мал эмнэлгийн мэргэжилтнүүд лабораторийн үйлчилгээг цаг алдахгүй авах боломж нээгдсэн нь малчид, орон нутгийн бизнес эрхлэгчид, төрийн байгууллагуудад цаг, мөнгө хэмнэж буй болохыг цохон дурдаж байв. Албан ёсны гэрчилгээ олгодог нь мал болон бусад бүтээгдэхүүнийг өндөр үнээр борлуулах, бүтээгдэхүүний чанар болон аюулгүй

байдалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, бусад аймаг болон Улаанбаатар хотын бусад бизнесийн байгууллагуудтай түншлэл үүсгэн, өргөжүүлэх боломжийг нээн өгсөн. Жишээ нь өнгөрсөн 6 сарын хугацаанд нэг цэгийн лаборатори нь 70 малчинд үйлчилж, Улаанбаатарын Налайх дүүрэг байрладаг Эрүүл Монгол Мах Эко ХХК-д нийлүүлсэн 6000 хонинд эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээ хийжээ.

Сац Манал мал эмнэлэг нь үйл ажиллагаагаа эхлээд удаагүй ч сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон хоолны газарт үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж чадсан. Сац Манал нь тухайн байгууллагуудын худалдан авч буй мах, сүүн бүтээгдэхүүнд шинжилгээ хийж, чанар болон аюулгүй байдлыг баталгаажуулж байна.

Нутгийн захиргааны зүгээс лабораторийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаа. Суманд нийт 4 мал эмнэлэг үйл ажиллагаа явуулж буй бөгөөд бүгд мах, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээг Сац Маналаар хийлгэж, гэрчилгээ авч байхаар хэлэлцэн тохироод байна. Сумын удирдлага Сац Манал болон бусад байгууллагуудын хооронд зах зээлийн холбоос үүсгэх замаар нэг цэгийн лабораторид дэмжлэг үзүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Сумын захиргаа нядалгааны цех, хоолны газруудад өөрийн хүнсний бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийлгэж байхыг хүсэх болжээ.

Сумын мал эмнэлэгийн мэргэжилтэн “Тус мал эмнэлэг нь өндөр чанартай үйлчилгээг, түргэн хугацаанд үзүүлэх боломжтой болсон тул бидний зүгээс бусад бизнесийн байгууллагад хандаж нэг цэгийн лабораторитой хамтран ажиллахыг уриална” хэмээн хэлж байна. Сумын засаг дарга нь тус мал эмнэлгийг Хэнтий аймгийн урд талын сумдуудтай холбож өгөхөөр төлөвлөж буй бөгөөд учир нь урд сумын малчид Хэнтий аймгийн төв, Улаанбаатар орохдоо Баянхутаг сумаар дайрч өнгөрдөг байна. Эдгээр сумдын малчид Баянхутаг суманд байдаг нядалгааны цехээр ихэвчлэн үйлчлүүлдэг тул нэг цэгийн лабораторид махны шинжилгээ хийх боломжууд нээгдэж байгаа. Мөн шинээр байгуулагдсан хуурай сүүний үйлдвэртэй хамтран ажиллаж, хуурай сүү үйлдвэрлэхэд ашиглаж буй түүхий эд болох сүүнд шинжилгээ хийх боломж мөн нээгджээ. Ярилцсан хүн бүр Монгол улсаас БНХАУ-д хандивласан хонинд лабораторийн шинжилгээ хийсэн нь тус мал эмнэлэг малчид, нутгийн захиргаа, аймгийн лаборатори зэрэг оролцогч талуудтай бат бөх түншлэл тогтоосны тод жишээ хэмээн хэлж байв.

Үр дүн 3: Нэг цэгийн лаборатори нутгийн иргэдэд танигдсан нь

Төсөл хэрэгжсэний үр дүнд Сац Манал мал эмнэлгийн хүчин чадал нэмэгдэж, улмаар олон нийтийн дунд илүү ихээр танигдах болжээ. Төсөл эхэлснээс хойш тус мал эмнэлэг нь мал эмнэлгийн болон лабораторийн үйлчилгээг 595 182 толгой малд үзүүлсэн нь өмнөх жилийн 210 мянган толгойтой харьцуулбал 2.8 дахин нэмэгджээ. Үйлчлүүлэгчдийн (малчид, бизнес эрхлэгчид) тоо мөн 214-аас 1046 болж 4.9 дахин өссөн. Эдгээрээс 313 малчин лабораторийн үйлчилгээ авч, 10101 толгой малаас дээж авч, шинжилжээ.

Сумын малчид шинжилгээ гэж юу болох, яагаад чухал ач холбогдолтой болох талаар одоо л мэдэж, мах, сүүн бүтээгдэхүүнд шинжилгээ хийлгэхийн учир утгыг олгосон тухайгаа хэлж байна. “Одоо бид лабораторийн үйлчилгээ авахаар аймаг явах шаардлагагүй болсон. Одоо үйлчилгээ авахад хялбар, аюулгүй болсон. Махаа шинжлүүлээд албан ёсны гэрчилгээ авдаг болсон. Өмнө нь малын эмч нар махыг нэг хараад л гэрчилгээ өгдөг байсан бол одоо шинжилгээний үр дүнд үндэслэн өгдөг болсон. Манай бүтээгдэхүүн аюулгүй гэдгээ мэддэг болсон учир бид махаа зах зээл дээр зарахдаа итгэлтэй болсон” хэмээн нутгийн нэг малчин хэлж байсан.

Сумын Засаг дарга мөн өөрийн нутагт лабораторитой байхын ач холбогдлын ийнхүү үнэлж байна: “Хэнтий аймагт анх удаа суман дээр нэг цэгийн лабораторитой боллоо. Манай суманд нийт 4 мал эмнэлэг үйл ажиллагаа явуулдаг. Бүгд л лабораторийн үйлчилгээний эрэлт өндөр байгааг судлан тогтоосон. Эдгээрээс Сац Манал нь Мерси Корын тусламжтайгаар нэг цэгийн лаборатори байгуулах санаачилга гаргаж, бусад мал эмнэлгүүд тухайн лабораторийн үйлчилгээг төлбөртэй авахаар зөвшөөрсөн. Нэг цэгийн лаборатори нь БНХАУ-д нийлүүлэх хонины шинжилгээнд оролцсон нь сумын иргэдийн дунд нэр хүндийг нь ихээр өргөж, аймгийн лабораторийн зүгээс тус лабораторийг чадамжтай болохыг зарласан тул үйлчилгээ авахдаа итгэлтэй байдаг болсон.”



2020 оны 11-р сард, Сац Манал бусад малын эмч нарыг өөрийн мал эмнэлэгийн үйлчилгээтэй танилцах, туршлага судлах аялалд оролцуулж, туршлага, саналаа хуваалцан бусад газруудад ижил төстэй үйлчилгээ нэвтрүүлэх талаар ярилцсан. Хэнтий аймгийн 9 сумын 15 малын эмч энэхүү арга хэмжээнд хамрагдсан. Оролцогчид лабораторийн ажил хэрхэн явагддаг, чанартай, шуурхай үйлчилгээ хэрхэн үзүүлдэг, ижил төрлийн лабораторийг хэрхэн байгуулж болох талаар мэдлэгээ дээшлүүлсэн үр дүнтэй аялал болсон.

Оролцогчид нь хямд, жижиг оврын тоног төхөөрөмжүүдийг ихээхэн сонирхож байсан. Түүнчлэн оролцогчид тус лабораториос ихээхэн урам авч, зарим нь эрэлт өндөртэй буй газруудад хамтран лаборатори байгуулах сонирхолтой буйгаа илэрхийлсэн.

“Лабораторийн үйл ажиллагаа, баримт бичгүүдээ зочдод танилцуулахад надад маш сайхан сэтгэгдэл төрж байсан. Бид хамтдаа энэ ийм амжилтанд хүрсэн гэдэгт би одоо ч итгэхгүй байсан. Манай мал эмнэлэгт маш сайхан гэрэлт ирээдүй байгаа гэдэгт би итгэлтэй байна” хэмээн Сац Манал мал эмнэлгийн захирал хэлж байв.

Бизнесийн тогтвортой байдал, ойрын ирээдүйн төлөв

Зах зээлийн эрэлт нэмэгдэж буй тул тус мал эмнэлгийн бизнесийн үйл ажиллагаа цаашид тогтвортой үргэлжлэх нь тодорхой байна. Мал эмнэлгийн захирлын хэснээр малчид, лабораторийн үйлчлүүлэгчдийн зүгээс зах зээлийн эрэлтэд хэрэгцээнд нийцүүлэн лабораторийн шинжилгээний тоо, төрөл, цар хүрээг өргөтгөх хүсэлтүүдийг тавьж байгаа ажээ. Жишээ нь адууны худалдаа ихээр хийгдэж буй тул адуунд шинжилгээ хийх нь нэг цэгийн лабораторийн боломжтой бизнес тул энэ чиглэлээр үйлчилгээг нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.

Түүнчлэн мал эмнэлгийн захирлын зүгээс сумын мал сүрэгт буй антибиотикийн үлдэгдлийг хянах тандан судалгаа хэрэгжүүлэх санал гаргажээ. Энэхүү саналыг сумын Мал эмнэлгийн тасагтай хамтран боловсруулж, ИТХ-д өргөн мэдүүлж, шаардлагатай төсвийг хуваарилах хүсэлтийг гаргаад байна. Энэхүү тандан судалгаа нь малчид, аж ахуйн нэгжүүдэд дотоод, гадаад зах зээл дээрх махны нийлүүлэлтээ өргөжүүлэхэд стратегийн ач холбогдолтой юм, шинэлэг арга хэмжээ юм.

Мерси Корын дэмжлэгтэйгээр Сац Манал нь зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Кинг Консалтинг компаниас шаардлагатай зөвлөх үйлчилгээ авсан. Зөвлөх үйлчилгээ нь маркетингээ сайжруулах, хэрэглэгчдэд шинэ үйлчилгээгээ таниулахад гол анхаарлаа хандуулсан. Одоо Сац Манал нь малчидтай хэрхэн үр дүнтэй ажиллах, өөрийн хэрэглэгчдийн тоог хэрхэн нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдэд мэдээлэл хэрхэн өгөх талаар илүү сайн ойлголттой болжээ. Жишээ нь Сац Манал нь өөрийн мал эмнэлэг, лабораторийн үйлчилгээг тайлбарласан товхимол хэвлүүлэн, сумын малчдад түгээжээ.

Эцэст нь Сац Манал мал эмнэлэг нь 2021 онд сумын захиргаа болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, лабораторийн барилгаа төвлөрсөн дулаанд холбож, бизнесээ улам өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа.

Сургамжууд

Энэхүү хэсэгт суманд мал эмнэлэг байгуулах чиглэлээр Мерси Кор болон Сац Манал мал эмнэлгийн авсан зарим “сургамжуудыг” тусгалаа.

- Хөрөнгө оруулалтын зардлыг лабораторийн үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй харьцуулан тооцоолох. Төслийн дэмжлэгтэйгээр Сац Манал нь бусад газруудад хялбархан хуулбарлан хэрэгжүүлж болох загвар лаборатори байгуулсан. Энэхүү төслийн өмнө хийсэн ТЭЗҮ-гээр шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, урвалж бодис худалдан авахад багадаа 30 сая төгрөг шаардлагатайг тогтоосон. Энэ нь хөдөө орон нутгийн хувийн мал эмнэлгүүдийн хувьд өндөр дүн тул суманд лаборатори байгуулахад төр болон олон улсын байгууллагуудын нэмэлт хөрөнгө оруулалт зайлшгүй шаардлагатай юм.

Тиймээс хувийн мал эмнэлгүүд болон сонирхсон бусад аж ахуйн нэгжүүд шинжилгээ хийлгэх нийт малын тоо толгой, малын гаралтай бүтээгдэхүүний тоо хэмжээ зэргийг тооцож, хамгийн боломжит байршлыг тодорхойлох нь ихээхэн чухал юм.

- Мэргэжлийн болон бизнесийн менежментийн чадавхи бэхжүүлэх дээр төвлөрөх. Мэргэжлийн ур чадвар болон бизнесийн менежментийн чадавхи сул байх нь орон нутгийн малын эмч нарт мал эмнэлгээ бизнесийн зарчмаар ажиллуулахад ихээхэн хүндрэл учруулдаг. Түүнчлэн малчид мал эмнэлгээс төлбөрт үйлчилгээ авах сонирхолгүй байдаг учир мал эмнэлэг нь зардлаа нөхөж чадахгүй хүндрэл гарч, төрөөс санхүүжүүлдэг вакцинжуулах ажлаас улам хамааралтай болдог. Амжилттай ажиллахын тулд малын эмч нар мэргэжлийн, бизнесийн, компьютерын мэдлэг, ур чадвараа сайжруулж, өөрийн сум, аймгаас гадуурх мэргэжлийн чадвар, мэдлэг бүхий хувь хүн, байгууллагатай холбоо тогтоохыг эрэлхийлэх шаардлагатай. УМЭАЦТЛ нь одоо нэг цэгийн лаборатори байгуулах хүсэлтэй хувийн мал эмнэлгүүдэд тусгайлан зориулсан сургалтын хөтөлбөртэй болсон. Үүнээс гадна малын эмч нар бизнес/менежментийг дэмжих үйлчилгээ нэмж авах нь суманд лаборатори байгуулах сонирхол бүхий мал эмнэлгүүдэд томоохон дэмжлэг болж чадна.
- Төрөл бүрийн талуудтай хамтран ажилласан нь амжилтын үндэс болно. Сум, аймаг, төр, хувийн хэвшлийн зэрэг олон төрлийн оролцогч талуудтай хамтран ажиллах нь маш чухал юм. Сац Манал мал эмнэлэг нь малчид, бизнес эрхлэгчдэд мал эмнэлгийн болон лабораторийн үйлчилгээг хүргэхийн зэрэгцээ сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг орон нутгийн байгууллагуудтай идэвхтэй ажиллаж, лабораторийн үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулжээ. Ийнхүү бизнесийн холбоос үүсгэсэн нь сумын байгууллагуудтай цаашид тогтвортой түншилж, лабораторийн үйлчилгээний эрэлт хэрэгцээг өндөр байлгахад чухал хувь нэмэр оруулах юм.



Амжилтын түүх

МАЛ ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИЙН АНХАН ШАТНЫ СУРГАЛТ

Түншлэгчийн нэр: Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори

Төслийн байршил: Улаанбаатар хот

Хугацаа: 2020 оны 10 сар

Төслийн үндэслэл

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль 2018 оноос хэрэгжиж Монгол Улсад мал амьтныг хэзээ ямар мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан, ямар вакцин хийлгэсэн, шилжилт хөдөлгөөн зэрэг бүхий л мэдээллийг агуулах тандан мөшгих системийг нэвтрүүлж эхлээд байна. Энэ систем нь малын эмч, малчдад тухайн мал амьтны талаарх бодит, үнэн зөв мэдээллээр хангах боломж олгодог.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас лабораторийн шинжилгээгээр баталгаажсан мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх бодлого, журам гаргасан. Тандан мөшгөх тогтолцоог амжилттай хэрэгжүүлэх нь орон нутгийн хувийн мал эмнэлгүүдийн мал, малын гаралтай бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний чадавхаас ихээхэн хамаардаг.

Гэвч дээрх дүрэм журмыг хэрэгжүүлэх явц нэн удаашралтай байгаа гол шалтгаан нь сумдын мал эмнэлгүүдэд шаардлагатай хөрөнгө, санхүүжилт, мэдлэг, үр чадвар дутмаг байгаатай холбоотой байна. Ихэнх тохиолдолд хувийн мал эмнэлгүүд ямар хууль эрхзүйн бичиг баримтыг мөрдөх, ямар төрлийн шинжилгээ хийх, ямар багаж тоног төхөөрөмж шаардлагатай эсвэл хаанаас худалдан авах талаар ойлголт багатай байдаг.

Иймд Мерси Кор “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” (RCP) хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн малын эмч нарын лабораторийн мэдлэг, үр чадварыг бэхжүүлэх, малын өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, улмаар мал, малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийг өргөжүүлэх зорилгоор Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгийн нийт 15 сумын малын эмч нарт зориулан “Мал эмнэлгийн лабораторийн анхан шатны сургалт” зохион байгууллаа.

Мерси Кор нь 2020 оны 10 сард “Мал эмнэлгийн лабораторийн анхан шатны сургалт”-ыг зохион байгуулахаар Улсын Мал Эмнэлэг, Ариун Цэврийн Төв Лаборатори-(УМЭАЦТЛ)-тай гэрээ байгуулав.

УМЭАЦТЛ нь мал эмнэлгийн био-аюулгүйн зэрэглэл бүхий малын өвчний оношилгоо, шинжилгээний чиглэлийн 18 лабораторитой, орон нутгийн мал эмнэлгийн оношилгоо, шинжилгээний үр дүнг баталгаажуулдаг үндэсний лавлагаа лаборатори тул хувийн мал эмнэлгүүдийн малын эмч нар тус лабораторийн сургалтад хамрагдах, цаашлаад зах зээлийн уялдаа холбоо бий болгох нь чухал ач холбогдолтой байв.

УМЭАЦТЛ-ыг сонгох үндэслэл

Тус сургалтаас өмнө Мерси Кор нь УМЭАЦТЛ-ийг нээлттэй өрсөлдөөнт сонгон шалгаруулсаны үндсэн дээр Хэнтий аймгийн “Сац Манал” ХХК-ын мал эмнэлгийн лабораторийн 3 малын эмчийг УМЭАЦТЛ-д 2020 оны 6-р сард лабораторийн дадлага олгох сургалтад сургасан. “Сац Манал” ХХК-ийн малын эмч нарт лабораторийн сургалтад зориулж Мерси Кор болон УМЭАЦТЛ хамтран сумын түвшинд тохирсон тусгай сургалтын хөтөлбөр боловсруулсан.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдсанаар мал эмнэлгийн стандарт, дүрэм журмууд дагалдан шинэчлэгдэж, улмаар мал эмнэлэг нь мал, амьтны оношилгоо, малын эрүүл мэндийн тандан судалгаа, хүнсний аюулгүй байдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах шаардлагатай болсон. Үүнтэй холбоотойгоор мал эмнэлэг мал, малын гаралтай бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ зэрэг сумын түвшинд хийх боломжтой лабораторийн шинжилгээний үр чадвартай байх хэрэгцээ зүй ёсоор бий болж байна.

Мерси Кор нь 2018 онд “Сумын мал эмнэлгийн нэг цэгийн лабораторид тавигдах техникийн шаардлага, зардал, үр ашгийн тооцоо” хэмээх судалгааг хийлгэсэн бөгөөд үүнд сумын лабораторид хийгдэх ёстой шинжилгээ, шаардлагатай тоног

төхөөрөмж, жижиг хэрэгсэл, эм урвалж (орон нутгийн мал эмнэлгүүдийн судалгаа болон стандарт шаардлагууд дээр үндэслэн) тодорхой тусгагдсан юм. Дээрх мэдээлэлд үндэслэн Мерси Кор нэг цэгийн лабораторийн ажилтанд зориулсан сургалтын хөтөлбөрийг УМЭАЦТЛ-той хамтран боловсруулсан юм.

Ийнхүү төслийн баг өмнөх сургалтын хөтөлбөр, Улсын Мал эмнэлгийн төв лаборатори хамтран ажилласан туршлага зэрэг дээрээ үндэслэн дээрх сургалтын хөтөлбөрийг дахин сайжруулж, зорилтот гурван аймагт сумын мал эмнэлгийн лаборатори ажиллуулах сонирхолтой 15 малын эмчид “Мал эмнэлгийн лабораторийн анхан шатны сургалт” сургалтыг 2020 оны 10-р сарын 21-29-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулав.

Сургалтын хөтөлбөр

МЭАЦЛ нь сумдын малын эмч нарт зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, өмнөх лабораторийн сургалт болон мал эмнэлгийн шинэ стандарт шаардлага дээр үндэслэн “Мал эмнэлгийн лабораторийн анхан шатны сургалт”-ын хүрээнд зааж сургах лабораторийн шинжилгээний аргуудыг Мерси Кортой харилцан ярилцаж сонгосон.

Ингэхдээ Мерси Кор болон УМЭАЦТЛ сургалтын хөтөлбөр боловсруулахад дараах асуудлуудыг харгалзан үзэв. Үүнд:

- Стандартын дагуу сумын мал эмнэлгийн лабораторид хамгийн өргөн хэрэглэгдэх ямар шинжилгээ хийгдэх ёстой вэ?
- Малчид зах зээлд мал, малын гаралтай бүтээгдэхүүнээ борлуулахад ямар лабораторийн шинжилгээ хийлгэх шаардлагатай вэ?
- Сумын мал эмнэлгүүдэд байгаа хамгийн олдоцтой тоног төхөөрөмжийг ашиглан ямар шинжилгээг хийх боломжтой вэ?

Дээрх асуудлуудаас үүдэн илүү практик, гардан дадлага хийх байдлаар УМЭАЦЛ лабораторийн сургалтыг зохион байгуулсан.

Мах, сүүний шинэлэг байдал, хольц илрүүлэх, үхсэн малын махыг ялган оношлох, нянгийн бохирдол тодорхойлох, үлдэгдэл бодис илрүүлэх зэрэг орон нутагт зайлшгүй шаардлагатай анхан шатны лабораторийн шинжилгээ хийх мал эмнэлгийн лабораторийн чадавхыг нэмэгдүүлснээр, малчид дээрх шинжилгээг орон нутагтаа авах, улмаар малчдын малын гаралтай бүтээгдэхүүнээ зах зээлд саадгүй нийлүүлэхэд дэм болох юм.

Сургалтын хөтөлбөрийн хүрээнд оролцогчид Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хувийн мал эмнэлгийн хоёр лабораторитой танилцах аялал хийсэн.



Сургалт

УМЭАЦТЛ нь “Мал эмнэлгийн лабораторийн анхан шатны сургалт”-ыг 7 хоногийн хугацаанд дараах агуулгын хүрээнд зохион байгууллаа.

- 1. Лабораторийн шинжилгээ, холбогдох дүрэм журам, био-аюулгүй байдлын тухай ойлголт, мах, сүүний стандартууд** (0.5 өдөр)- малын эмч нарт мал эмнэлгийн лабораторийн шаардлага, стандарттай танилцуулах зорилготой.
- 2. Лабораторийн дадлага олгох сургалт** (6 өдөр)- Нянгийн шинжилгээ, мах, сүүний шинжилгээ, үлдэгдлийн шинжилгээ зэрэг хамгийн өргөн хэрэглэгддэг анхан шатны шинжилгээнүүдийг багтаасан. Мерси Корын хүсэлтийн дагуу УМЭАЦТЛ нь шинжилгээний арга зүй, арга техникийг хамгийн энгийн, түгээмэл тоног төхөөрөмж ашиглахад анхаарсан. УМЭАЦТЛ нь үндэсний лавлагаа лабораторийн хувьд зарим тоног төхөөрөмж, арга техник нь маш өндөр үзүүлэлттэй, орчин үеийн шинэ тоног төхөөрөмж ашигладаг. Гэвч дөнгөж үйл ажиллагаа эхэлж байгаа мал эмнэлгийн хувьд нарийн, үнэтэй тоног төхөөрөмжөөс илүү хамгийн энгийн, олдоц сайтай тоног төхөөрөмж ашиглан сурах нь зүйтэй гэж үзсэн. Мөн сургалтаар заасан шинжилгээнүүд нь орон нутагт хамгийн эрэлттэй, байнга хийгдэх шинжилгээ юм.
- 3. Мал эмнэлгийн 2 лабораторитой танилцах аялал** (0.5 өдөр). Оролцогчид Улаанбаатарын хүнсний захын дэргэдэх хувийн мал эмнэлгийн хоёр лабораторид зочиллоо. Танилцах аяллын хүрээнд дараах хоёр үр дүн гарав. а) УМЭАЦТЛ нь лабораторийн танилцах аяллыг анх удаа зохион байгуулж тодорхой туршлагатай болов. б) Ихэнх оролцогчдын хувьд (15 оролцогчийн 10 нь) хувийн мал эмнэлгийн лабораторитой анх удаа танилцаж туршлага судлав.

Сургалтын дараах асуулгаар сонгогдсон хоёр лабораторийн хоорондын ялгаа нь оролцогчдод гүн сэтгэгдэл төрүүлжээ. “Экас лаборатори” нь лабораторийн бичиг баримтыг цэгцтэй бүрдүүлсэн, лабораторийн урсгал, зохион байгуулалт маш сайн байсан. “Алтан Үе Буянт” нь энгийн бөгөөд хялбар байдлаар лаборатори байгуулах санааг оролцогчдод төрүүлсэн байна. Энгийн байгаа нь стандартад нийцэхгүй гэсэн үг биш олдоцтой тоног төхөөрөмжөөр шаардлагатай шинжилгээг хийх боломжийг бүрдүүлж чадсан байв.

Сургалтын үр дүн

- Орон нутгийн мал эмнэлгийн лабораторийн үр чадварыг нэмэгдүүлэх, малын өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулах, хүнсний аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ мал, махан бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой сургалт боллоо.
- Ажиглалт, судалгаанаас харахад оролцогчид сургалтын ерөнхий агуулга, хэлбэр, хугацаанд сэтгэл хангалуун байсан бөгөөд өндөр үнэлгээ өгсөн. Энэ нь нөгөө талаас малын эмч нарт зориулсан ижил төстэй сургалт байдаггүйтэй ч холбоотой байж болох юм.
- Оролцогчид мал, малын гаралтай бүтээгдэхүүнээс дээж авах, боловсруулах, шинжилгээ хийх мэдлэг, дадал, үр чадвар эзэмшсэн.
- Түүнчлэн хүнсний захын дэргэдэх мал эмнэлгийн лабораториудад зочилж мал эмнэлгийн жижиг лабораторийн бодит туршлагатай танилцаж, төсөөлөл авсан.
- УМЭАЦТЛ нь сумын малын эмч нарт зориулсан сургалтын хөтөлбөртэй болж энэхүү хөтөлбөрийг бусад малын эмч нар ашиглах боломжтой боллоо. Энэ нь практик дадлага ажилд суурилсан сертификаттай анхны сургалт бөгөөд орон нутагт эрэлт хэрэгцээтэй байх өндөр магадлалтай.
- Сургалтын агуулга, дадлагын хичээлийг флаш диск (USB)-т хуулж сургалтад оролцогчдод өгсөн бөгөөд энэ нь эргээд сумандаа ажиллах явцад лабораторийн шинжилгээнд ашиглагдах болно.

Дараагийн алхмууд

Энэхүү сургалт нь оролцогчдыг сумандаа мал эмнэлгийн лаборатори ажиллуулах чадварыг нэмэгдүүлж, хүнсний захын дэргэдэх лабораторийн бодит туршлагаас суралцахад нь тусалсан.

2018 оны 12-р сард энэхүү сургалтад хамрагдсан таван оролцогч Мерси Корын “Малын эрүүл мэнд- лабораторийн багц” төсөлд хүсэлт гаргаснаас гурав нь дэмжлэг авав. Тэд мал эмнэлгийн лабораторийн үйлчилгээ үзүүлэх бүхий л боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.

УМЭАЦТЛ нь орон нутгийн малын эмч нарт зориулсан сургалтын хөтөлбөртэй болсон бөгөөд үүнийг бусад сумын малын эмч нарыг сургахад ашиглах боломжтой.

Мерси Кортой хамтран дээр дурдсан хоёр сургалтыг зохион байгуулсан УМЭЦТЛ-ийн мэргэжилтнүүд орон нутгийн малын эмч нарт сургалт зохион байгуулах үр чадвараа дээшлүүлжээ.



Амжилтын түүх

МАЛ АЖ АХУЙН САЛБАР ДАХЬ ЗАЛУУСЫН ОРОЛЦОО

Түншлэгчийн нэр: Элит Хүнс ХХК

Төслийн байршил: Хэнтий аймгийн Хэрлэн сум

Хугацаа: 2019 оны 8 сар – 2020 оны 8 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Элит Хүнс ХХК нь Хэнтий аймагт Монголд үйлдвэрлэдэггүй, олдоц ховор мал аж ахуйн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэн борлуулдаг. Энэ бизнесийг 20-30 насны залуус¹ эрхэлдэг бөгөөд үйлдвэрлэдэг бод малын хүзүүвч, малын иж бүрэн зогсоол, зөөврийн хашаа зэрэг тоног төхөөрөмж нь мал эмнэлэг, үржлийн үйлчилгээнд хэрэглэгддэг малын хөдөлгөөнийг хязгаарлах зориулалттай тоног төхөөрөмж юм. Эдгээр тоног төхөөрөмж нь бас малд зохих үйлчилгээ үзүүлж буй хүмүүсийн аюулгүй байлгахын зэрэгцээ малын тавлаг байдлыг хангадаг. Тоног төхөөрөмжийн загвар дизайныг энэ төрлийн бизнес эрхлэхээр олон жил мөрөөдсөн тус компанийн захирал Г. Дүүрэнбилэг төлөвлөн гаргажээ. Төхөөрөмжүүдийн хэлбэр, загвар нь түүний бага наснаасаа мал маллаж, малтай ойр байсан туршлага, орон нутгийн

¹ 35-аас доош насныхныг залуус хэмээн тооцно.

хэрэгцээ, бусад малчид, малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтнүүдийн хэрэгцээнээс үүдэн бий болсон байна.

Мерси Корын “Даван туулах дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөртэй түншлэн тус компани нь энэхүү шинэлэг төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр төсөл хэрэгжүүлж малын эрүүл мэнд, үржлийн үйлчилгээний чанарыг сайжруулахаар ажиллаж байна. Энэхүү зорилгын хүрээнд дараах үр дүнд хүрэхээр зорьжээ: (1) Элит Хүнс компанийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх; (2) Шинэлэг, үр ашигтай мал аж ахуйн хөдөлмөр хөнгөвчлөх тоног төхөөрөмжийг Монголын зах зээлд сурталчлах; (3) Тоног төхөөрөмж ашиглаж буй хүмүүсийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг багтаж байна.

Үр дүн 1: Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн

Элит Хүнс ХХК нь 150м² талбай бүхий цех байгуулан, орчин үеийн гагнуурын тоног төхөөрөмж худалдан авч, үйлвэрлэлийн чанар болон бүтээмжээ сайжруулаад байна. Өмнө нь компанийн ажилчид нь гадаа талбайд цаг уурын байдлаас ихээхэн хамааралтай ажиллаж байжээ. Харин шинээр цехтэй болсноор бүтэн жилийн туршид тасралтгүй үйл ажиллагаа явуулж, цаг агаарын нөхцөл байдлаас үл хамааран ажиллах боломжийг нээсэн бөгөөд цех нь цахилгаан, дулааны эх үүсвэрт холбогджээ. Мөн орчин үеийн тоног төхөөрөмжтэй болсноор гагнуурын ажлыг мэргэжлийн түвшинд хийж, ажилчид нь илүү үр бүтээмжтэй ажиллах боломжтой болсон. Үйлдвэрлэлийн хүчин чадал гурав дахин (3.7 дахин) нэмэгджээ. Төсөл хэрэгжих эхлэхээс өмнө нэг ширхэг бодын иж бүрэн зогсоолыг бүтэн нэг сарын турш хийдэг байсан бол одоо уг тоног төхөөрөмжийг 10 хоногт багтаан үйлдвэрлэж байна.

Мерси Корын дэмжлэгтэйгээр Элит Хүнс нь өөрийн санал болгож буй бүтээгдэхүүнийг төрөлжүүлэн, олшруулж байна. Хэрэглэгчийн хэрэгцээг илүү сайн хангахын тулд шинэ бүтээгдэхүүний загварыг боловсруулан гаргаж байна. Ийнхүү бүтээгдэхүүнээ сайжруулах, шинэчлэх нь зах зээл дээр өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хэрэглэгчдийн тоогоо нэмэгдүүлэхэд тусалж байгаа тухай Элит Хүнс компанийн захирал онцолжээ. Шинээр боловсруулсан тоног төхөөрөмжийн тоонд бог малын хүзүүвч, иж бүрэн зогсоол, зөөврийн хашаа, мэс заслын ширээ, мал жигнэх том оврын жин зэрэг багтаж байна.

Бизнес өргөжсөний үр дүнд Элит Хүнс нь борлуулалтын орлогоо төслийн хугацаанд 6 дахин нэмэгдүүлсэн байна. Тухайлбал компанийн жилд үйлдвэрлэх мал аж ахуйн тоног төхөөрөмжийн тоо нь 7-оос 26 болж нэмэгджээ. Түүнчлэн дээрх байнга үйлдвэрлэдэг тоног төхөөрөмжөөсөө гадна зургаан төрлийн тоног төхөөрөмжийг хэрэглэгчдийн хүсэлтээр тусгайлан үйлдвэрлэдэг болоод байна. Дүүрэнбилэг захирал “Хэрэв бид Мерси Кортой хамтран ажиллаагүй бол өнөөгийн түвшиндээ хүрэхэд бидэнд 4- 5 жил шаардагдах байсан” хэмээжээ.

Үйлдвэрлэлийн эрэлтийг хангахын тулд компани нь үндсэн хоёр ажилтан авахын зэрэгцээ захиалга нэмэгдэхэд дахин 4 ажилтан түр гэрээгээр ажиллуулж байна. Төслийн хүрээнд Элит Хүнс нь хоёр гагнуурчнаа албан ёсны сургалтад хамруулж, улсын стандартын дагуу мэргэжлийн гэрчилгээ авч, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлсэнтэй холбогдуулан аюулгүй ажиллагааны шинэ арга хэмжээг авч хэрэгжүүлэх болжээ. Түүнчлэн Элит Хүнс нь мөн ажилчдынхаа зөөлөн ур чадвар болох харилцаа холбоо, гэрээний харилцааг удирдах, маркетинг, нягтлан бодох бүртгэлийн ур чадваруудыг хөгжүүлэв.

Жишээ нь Мерси Корт ирүүлсэн тайландаа “Элит Хүнс нь гаргаж буй ахиц дэвшлээ баримтжуулах, бүртгэл хөтлөх үйл явцаа сайжруулахын зэрэгцээ үйлдвэрлэлийн хугацааг нарийн баримтлах болжээ. Мөн Элит Хүнс нь бусад компаниудтай тогтоосон харилцаагаа илүү сайн удирдаж байна. Үүний нэгэн жишээ бол Элит Хүнстэй хамтран ажиллаж, маш эерэг сэтгэгдэлтэй үлдсэн Дорнод аймгийн нэгэн аж ахуйн нэгж юм. Элит Хүнс ХХК-ийн захирал “Тухайн компани нь төслийг удирдаж буй байдал, бэлтгэн гаргасан гэрээний төсөлд маш сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн. Мөн бидний баримтжуулалт хийж буй ил тод байдал тэдэнд их таалагдсан” хэмээн дурьджээ. Ийнхүү менежментээ сайжруулснаар Элит Хүнс нь түнш байгууллагуудынхаа дунд хамтран ажиллахад таатай, зохион байгуулалт сайтай, харилцахад хялбар түнш хэмээн үнэлэгдэх болжээ.

Үр дүн 2: Зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлсэн

Элит Хүнс нь шинэ зах зээлд нэвтэрч, бүтээгдэхүүн нь олонд танигдаагүй, эрэлт багатай байсан учраас төслийн хугацаанд өөрийн бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах, эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой тооны бүтээгдэхүүнээ 20-50% хямдралтай үнээр борлуулсан юм. Үүний дүнд компани шинээр 20 үйлчлүүлэгчтэй болсон ба малчид, фермерүүд, мал эмнэлгийн нэгжүүд, хоршоо, бордох аж ахуйн нэгж хямдралтай үнээр үнээр тоног төхөөрөмж худалдан авчээ.

Ашигтай, тогтвортой бизнесийн байгууллага байхын тулд Элит Хүнс нь бизнесийн сайн төлөвлөгөө, ур чадвар, маркетингийн стратеги хэрэгцээтэй болжээ. Тиймээс Мерси Корын зүгээс гэрээт зөвлөх үйлчилгээний компани болох Кинг Консалтинг компаниас зөвлөх үйлчилгээ авах боломжийг Элит Хүнс ХХК-д олгосон юм.

Кинг Консалтинг нь Элит Хүнс компанид маркетингийн төлөвлөгөөгөө сайжруулахад тусалсан ба үүнд олон нийтийн сүлжээнд танигдахад түлхүү анхаарах, тоног төхөөрөмжийн шууд маркетинг хийх зэрэг зөвлөгөө, зааварчилгааг өгсөн байна. Тэдний ашигласан маркетингийн хоёр дахь арга нь хувийн мал эмнэлгийн нэгж болон үржлийн нэгжүүдтэй тоног төхөөрөмжийг богино хугацаанд үнэ төлбөргүйгээр ашиглаж боломж олгосон ба энэ нь зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх үр дүнтэй арга зам хэмээн үзэж байна. Элит Хүнс нь мөн Кинг Консалтинг компанийн зөвлөхүүдтэй

хамтран ажиллаж, ХЗДХЯ-наас ашигтай загварын гэрчилгээ² авахаар ажиллаж байна. Ингэснээр бусад үйлдвэрлэгчид Элит Хүнсний загвар, дизайныг хуулбарлах боломжгүй болох юм.

Энэхүү төслийн хүрээнд компани нь олон нийтийн сүлжээгээр дамжуулан үйлчлүүлэгч нарыг олж тогтоох нь хамгийн үр дүнтэй арга зам болохыг тодорхойлжээ. Компани нь бүтээгдэхүүний каталог, сурталчилгааны видео зэргийг бэлтгэн гаргаж, олон нийтийг сүлжээ, үзэсгэлэн худалдаа, мал эмнэлгийн нэгжүүдээр тараажээ. Мөн хоёр вэб хуудас хөгжүүлсний нэг нь хэрэглэгчдийн боловсролд зориулсан: Элит Хүнсний тоног төхөөрөмжийг үр дүнтэй ашиглаж буй хүмүүсийн тухай, нөгөө нь “NomadTech-Мал аж ахуйн тоног төхөөрөмж” хэмээх нэртэй бөгөөд тоног төхөөрөмжийг сурталчлах, бүтээгдэхүүний каталогийг байршуулах зорилготой. Маркетингийн эдгээр арга замыг ашиглан компани нь 4 төрлийн тоног төхөөрөмж (бодын хүзүүвч, малын иж бүрэн зогсоол, зөөврийн хашаа, хонь жигнэх жин) үйлдвэрлэх гэрээг Дорнод аймгийн нэгэн компанитай хийжээ. Энэхүү гэрээ нь хямдралгүй үнийн дүнгээр хийгдсэн тул компанид томоохон орлогын эх үүсвэр болсон байна. Компанийн өөр нэгэн чухал амжилт нь Мерси Корын хэрэгжүүлж буй АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн харьяа Гамшигт нэрвэгдсэн гадаад орнуудад тусламж үзүүлэх газрын (USAID/OFDA) санхүүжилт бүхий LTS3 хөтөлбөрийн хүрээнд тендерт шалгаран, Хэнтий аймаг дахь 2 горхины эхийг хамгаалахад зориулан төмөр хашаа үйлдвэрлэж, зах зээлийн үнээр нийлүүлжээ.

Үр дүн 3: Тоног төхөөрөмж ашиглаж буй малчид, аж ахуйн нэгжийн бүтээмж нэмэгдсэн

Элит Хүнс компанийн үйлчлүүлэгчдийн нэг нь Хэнтий аймгийн Юмтгэгээ хувийн мал эмнэлгийн нэгж юм. Тус мал эмнэлгийн эмч Элит Хүнс компанийн бүтээгдэхүүний талаар “Энэ тоног төхөөрөмжийн нэг чухал давуу тал нь мал эмнэлгийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлдэг. Өмнө нь энэ тоног төхөөрөмжгүй байхад 4-5 хүн ажиллах шаардлагатай байдаг байсан бол одоо 2 хүн ажиллаад шаардлагатай эмчилгээ, үйлчилгээг хийх боломжтой болсон. Өөр нэгэн давуу тал нь малчин айл дээр очоод угсардаг хашаа байна. Энэ нь мал эмнэлэг болон малчдын тээврийн зардал, цаг хугацааг ихээхэн хэмнэдэг” хэмээн хэлж байв.

Мөн 40 үхэртэй өөр нэг үйлчлүүлэгч иж бүрэн зогсоол төхөөрөмж 20%-ийн хямдралтай үнээр худалдан авчээ. Тэрээр одоо зогсоол ашиглаад бусдын тусламжгүйгээр малдаа өөрөө хөөвөрлөх, эвэр, туурай засах зэрэг үйлчилгээг хийдэг болжээ. Одоо бод малтай ажиллахад хялбар болсон, шаардлагатай эм тариа, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхэд цаг барахгүй хурдан шуурхай хийдэг болжээ.

² Ашигтай загварын гэрчилгээ нь тухайн загварыг өмчлөх эрхийг эзэмшигчийг баталгаажуулан төрөөс олгодог гэрчилгээ бөгөөд патенттай ижил төстэй. “Ашигтай загвар” гэдэг нь үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл эсвэл үйл явцад хамаарах техникийн шийдэл юм.

Элит Хүнс нь зах зээлийн хэрэгцээг тогтоох, бүтээгдэхүүнээ сайжруулах зорилгоор үйлчлүүлэгч нартайгаа эргэх холбоотой ажиллаж, байнга тэдний саналыг нь сонсож байна. Энэ зорилгоор компани санал асуулгын хуудас бэлтгэн хямдралтай үнээр тоног төхөөрөмж худалдан авсан 6 үйлчлүүлэгчээс саналыг нь авчээ. Бүтээгдэхүүний талаарх тэдний санал нь тоног төхөөрөмжийн чанар болон үзүүлэлтийг сайжруулахад тусалж байна.

Бизнесийн тогтвортой байдал болон ойрын ирээдүйн хэтийн төлөв

Өөрийн үйлдвэрлэж буй тоног төхөөрөмж дээр ашигтай загварын гэрчилгээ авах зорилго нь Кинг Консалтанг компанийн тусламжтайгаар бараг биелээд байна. Энэхүү гэрчилгээг авах нь компанийн цаашдын тогтвортой өсөлт, хөгжлийг хангахад чухал алхам болно.

Шинэ зах зээлийг тодорхойлохын тулд Элит Хүнс нь хувийн мал эмнэлгийн нэгжүүдтэй малын иж бүрэн зогсоол, бодын хүзүүвч ашиглах 3 жилийн гэрээ байгуулахаар төлөвлөж байна. Улмаар тухайн хувийн мал эмнэлгийн нэгжүүд нь тоног төхөөрөмж ашигласан туршлагаа үржлийн нэгжүүд, малчид, фермерүүд болон бусад малын эмнэлгүүд зэрэг бусад хэрэглэгчтэй хуваалцах, мэдээлэл өгөх үүргийг хүлээнэ. Элит Хүнс мөн орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдэхүүнээ төрөлжүүлэх төлөвлөгөөтэй байна. Дүүрэнбилэг нь одоо малчдад зориулсан зөөврийн сууц болон тугал засах ширээний загвар гаргахаар ажиллаж байна.

Цаашдаа хэрэглэгчдийнхээ тоог нэмэгдүүлэхийн тулд Элит Хүнс нь бэлэн мөнгөний хомсдолтой байдаг боломжит худалдан авагчид буюу малчид, фермерүүд, мал эмнэлгийн нэгжүүд, хоршоонд төлбөрийн өөр арга замыг санал болгох шаардлагатай байна. Энэхүү сорилт нь Элит Хүнсийг тоног төхөөрөмжөө малаар солилцох бартерын арга замын туршин үзэхэд хүргээд байна.



Амжилтын түүх

МАЛ ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

Түншлэгчийн нэр: Юмтгэгээ хувийн мал эмнэлэг

Төслийн байршил: Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум

Хугацаа: 2019 оны 8 сар - 2020 оны 6 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Юмтгэгээ нь Хэнтий аймгийн хамгийн олон малтай Өмнөдэлгэр суманд үйл ажиллагаа явуулдаг хувийн мал эмнэлэг юм. Тус мал эмнэлэг нь сумын нийт малын 80% болох 420 мянган малд үйлчилгээ үзүүлдэг. Мерси Кортой хамтран хэрэгжүүлсэн төслийг эхлүүлэхээс өмнө Юмтгэгээ нь шаардлага хангаагүй зөвхөн нэг өрөөтэй лаборатори ажиллуудаг байсан тул үндсэндээ лабораторийн шинжилгээ хийх боломжгүй байжээ. Мөн мал эмнэлгийн тоног төхөөрөмж нь хуучирсан, ажилтнууд нь лабораторийн чиглэлээр мэргэшээгүй байв.

Хэдийгээр дээрх сорилтуудтай тулгарч байсан ч тус мал эмнэлэг нь тухайн боломжит нөөц, эх үүсвэрээ ашиглан, мал эмнэлгийн үйлчилгээг үзүүлсээр иржээ. Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээ нь үндсэндээ мэдрэхүйн арга болох

хүрэх, амтлах, үнэрлэх, харах байдлаар л бүтээгдэхүүний чанарыг тодорхойлж байв. Гэвч энэхүү ерөнхий тест нь дангаар чанарын баталгаажуулалтын хүлээн зөвшөөрөгдсөн арга зүй хэмээн тооцогдохоо болиод байна. 2017 оны 12-р сард УИХ-аас Малын эрүүл мэндийн тухай багц хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, мах болон сүүн бүтээгдэхүүнд мал эмнэлдэг, ариун цэврийн гэрчилгээг зөвхөн лабораторийн шинжилгээнд үндэслэн олгож байх заалтыг оруулжээ. Гэвч орон нутгийн мал эмнэлгийн 98% нь шаардлагатай лабораторийн шинжилгээ хийх тоног төхөөрөмжгүй байна. Юмтгэгээ нь өөрийн лабораторийн хүчин чадал сул байгааг тогтоосноос гадна энэ нь бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломж болохыг олж харжээ.

Лабораторийн үйлчилгээ үзүүлэх хүчин чадлаа нэмэгдүүлэх боломжийг олж тогтоохын зэрэгцээ паразитын эсрэг эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх хүчин чадлаа нэмэгдүүлэх нь ч бас нэгэн боломж хэмээн харсан байна. Монголын мал эмнэлгүүдийн нэг үндсэн чиг үүрэг нь мал сүрэгт паразитын эсрэг эмчилгээ хийх үүрэг байдаг. Төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө Юмтгэгээ нь өөрийн хамаарах газар нутаг дахь нийт малын дөнгөж 50%-д л хүрч ажиллаж байжээ. Энэ нь тоног төхөөрөмжийн хангамж муу, ажилчдын тоо хүрэлцэхгүйгээс үүджээ.

Дэд бүтцийн асуудлаа шийдэх, мал эмнэлгийн үйлчилгээний хүчин чадлаа нэмэгдүүлэхийн тулд Юмтгэгээ нь Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөртэй түншлэн орчин үеийн мал эмнэлгийн лаборатори байгуулах, паразит өвчний эмчилгээг эрчимжүүлэх, бүтээгдэхүүний гэрчилгээ болон малын эрүүл мэндийн талаар малчдад мэдлэг олгох чиглэлээр ажиллажээ. Үг төсөл нь малын эрүүл мэндийг сайжруулах арга ажиллагааг хэвшүүлэн, малын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилго тавьсан. Энэхүү зорилгын хүрээнд гурван үр дүнг тодорхойлсон бөгөөд үүнд: (1) сумын мал эмнэлгийн лабораторийн хүчин чадал нэмэгдсэн байх, (2) паразитын эсрэг эмчилгээ, үйлчилгээ өргөжсөн байх, (3) лабораторийн үйлчилгээ болон паразитын эмчилгээ, үйлчилгээний эрэлт нэмэгдсэн байх зэрэг багтжээ.

Үр дүн 1: Мал эмнэлгийн лабораторийн чадамж сайжирсан

Мерси Кортой харилцан түншлэлээр дамжуулан тус мал эмнэлэг нь лабораторийн 2 өрөөг шинэчлэн засаж, орчин үеийн тоног төхөөрөмж суурилуулснаар тухайн сум дахь иж бүрэн тоног төхөөрөмж бүхий эмнэлэг болжээ. Үг нөхцөл байдал нь шинжилгээний тоног төхөөрөмж болон үйлчилгээний чанарыг ихээхэн сайжруулсан байна. Энэхүү лабораторийн шинэ үйлчилгээ нь суманд хийгдэх шинжилгээний тоог хоёр дахин нэмэгдүүлжээ.

Юмтгэгээ нь одоо мэдэрхүйн шинжилгээнээс гадна таван төрлийн хими биологийн шинжилгээ хийж буй бөгөөд үүнд рН, антибиотикийн үлдэгдэл тодорхойлох, эрүүл ахуйн болон нянгийн шинжилгээ багтаж байна. Эдгээр шинжилгээний арга зүй нь шинжилгээний хувь хэмжээг 75%-аар нэмж, өмнө нь 360 тонн маханд

шинжилгээ хийж байсан бол энэ үзүүлэлт 629 тонн болон өсчээ. Сумын түвшинд 10 төрлийн шинжилгээ хийх лабораторитой болсон нь нутгийн малчид мах болон сүүн бүтээгдэхүүндээ найдвартай, өндөр түвшний шинжилгээ хийлгэх хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

Лабораторийн үйл ажиллагаа үр ашигтай болж, олон нийтэд хүртээмж нэмэгдснээр малчдын бэлтгэн худалдаалж буй мах, сүүн бүтээгдэхүүнд ариун цэвэр, эрүүл ахуйн гэрчилгээ олгох болж, энэ нь хэрэглэгчдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахад үр нөлөөтэй болж байна. Тус мал эмнэлэг лабораторийн шинжилгээнийхээ үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ хэрэглэгчдийг тодорхойлсон бөгөөд үүнд сургууль, эмнэлэг, зах, махны дэлгүүр, нядалгааны газрууд, ресторанууд багтжээ. Эдгээр нь бүгд мах, сүүн бүтээгдэхүүн худалдан авч, олон нийтэд үйлчилдэг. Юмтгэгээ нь тэдний худалдан авсан бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээ хийн, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагуудад нийцүүлэх гэрээг тухайн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хийсэн байна.

Лабораторийн үйл ажиллагааны хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд мэргэшсэн ажилтнуудын тоог нэмэгдүүлэх хэрэгцээ байгааг анхааран, Улаанбаатар хотод лабораторийн сургалтад хамрагдаж, мэргэжлийн лабораторийн техникчийн гэрчилгээ авсан хоёр залуу малын эмчийг лабораторийн ажилтнаар ажиллуулах болжээ. Юмтгэгээ нь өөрийн биет дэд бүтэц болон хүний нөөцөд хөрөнгө оруулалт хийсэн нь бизнесийн тогтвортой өсөлтөд хүргэсэн байна. Энэхүү хөрөнгө оруулалтын үр дүнд мал эмнэлгийн лабораторийн орлого нь 56%-аар өссөн нь эдгээр үйлчилгээ өндөр эрэлттэй буй, тус мал эмнэлэг нь хэрэглэгчдийн хэрэгцээг ханган арга замыг нарийн тогтоон тооцсонтой холбоотой.

Мал эмнэлгийн захирал “Саяхан Хэнтий аймгийн хөрш сумдын мал эмнэлэг, төрийн албан хаагчид манай лаборатори дээр ирж, бидний үйл ажиллагаа, лабораторийн протоколын талаар судалсан. Бусад мал эмнэлэг ч ийм ижил төстэй лаборатори байгуулах сонирхолтой байсан бөгөөд манай лабораторийг үзэх түршлага судлах, үйл ажиллагаа, шинжилгээний арга зүйтэй танилцах аялал хийх санал тавьсан юм. Манай лаборатори нь Хэнтий аймаг, бүр Монгол улсын хэмжээнд ч загвар лаборатори болно гэж итгэж байна” гэжээ.

Үр дүн 2: Паразит өвчний эсрэг эмчилгээний чадавхи нэмэгдсэн

Юмтгэгээ нь шинэ тоног төхөөрөмж, материал худалдан авах замаар паразитын эмчилгээний хамрах хүрээгээ сайжруулах хүсэлтэй байв. Мерси Кортой тогтоосон түншлэлийн хүрээнд Юмтгэгээ нь ариутгал, халдваргүйжүүлэлтийн шүршигч, автомашин, хувийн хамгаалах хэрэгсэл, зөөврийн хашаа болон бод мал бэхлэх зогсоол худалдан авсан байна. Худалдан авсан автомашин нь паразитын эсрэг үйлчилгээнд зориулагдсан танктай, өдөрт 2000-3000 бог мал, 200-400 бод малд ариутгал хийх хүчин чадалтай. Ийм үйлчилгээний зориулалттай машинтай болсноор алс суурьших малчдад хүрч, сумын хэмжээнд чөлөөтэй зорчин үйлчилгээ хүргэх

боломжтой болжээ. Тус мал эмнэлэг нь мөн мал хаших зөөврийн хашаа ашиглан, ариутгал, халдваргүйжүүлэлт хийж буй нь эдийн засгийн болон эмчилгээний үр ашгийг ихээхэн нэмэгдүүлжээ.

Төсөл хэрэгжсэн хугацаанд Юмтгэгээ нь паразитын эсрэг эмчилгээгээ бараг хоёр дахин нэмэгдүүлж, 420 мянган толгой малаас 891 мянган толгой болтол өсгөжээ. Үүний үр дүнд 5332 малчин өөрийн мал сүрэгт паразитын үйлчилгээ авсан нь өнгөрсөн жилийн 3520 малчинтай харьцуулбал 51%-ийн өсөлт үзүүлсэн байна. Ийнхүү техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт, сайжруулалт хийж, үр ашигтай байдлаа нэмэгдүүлсний улмаас паразитын эмчилгээ, үйлчилгээний цар хүрээ өргөжснөөр орлогоо нэмэгдүүлж чадсан. Эхлээд орлого дөнгөж 10%-аар нэмэгдэнэ хэмээн хүлээж байсан ч уг эмчилгээ нь тэдний орлогыг 50%-аар нэмэгдүүлснийг тайландаа дурджээ.

Үйлчилгээ хүргэх хүчин чадлаа ийнхүү өргөжүүлэхийн тулд тус мал эмнэлэг нь ажилтныхаа тоог нэмэгдүүлэх хэрэгцээ гарсан бөгөөд лабораторийн ажилтнуудынхаа тоог хоёр лабораторийн малын эмчээр нэмэгдүүлж, паразитын эмчилгээ хийх болжээ. Одоо мал эмнэлэг дээр ажиллаж буй 7 ажилтан үүрэгт ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, нөөц эх үүсвэртэй болжээ. Хэнтий аймгийн ХАА-н газрын дарга энэ талаар “Юмтгэгээ мал эмнэлэг өөрийн үйлчилгээгээ өргөжүүлснээс хоёр чухал үр өгөөж хүртсэн бөгөөд энэ нь нэгдүгээрт, тус мал эмнэлэг тоног төхөөрөмж, хүний нөөцийн хувьд хангалттай болж, паразитын эмчилгээг шаардлагатай хугацаанд нь хийх боломжтой болсон явдал юм. Өмнө нь энэ чиглэлийн эмчилгээг нөөц эх үүсвэр дутмаг учраас байнга хойшлуулж ирсэн. Хоёрдугаарт, энэхүү мал эмнэлэг энд үйл ажиллагаа явуулж, залуу эмч нарт ажлын байр бий болгон, бусад мал эмнэлгээс илүү өндөр цалин олгож буй нь тогтвортой ажиллахад түлхэц болж байна” хэмээн дүгнэсэн байна.

Үр дүн 3: Лабораторийн болон паразит өвчний үйлчилгээний эрэлт нэмэгдсэн

Хүргэж буй үйлчилгээ, хүрч ажиллаж буй малчдын тоо нэмэгдсэнээр Юмтгэгээ мал эмнэлгийн үйлчилгээний эрэлт хэрэгцээ өндөр буй нь тодорхой байна. Гэвч тэд лабораторийн шинжилгээ, паразит өвчний эмчилгээний чиглэлээр малчдын эрэлтийг улам нэмэгдүүлэх боломжуудыг олж тогтоогоод байна. Тус мал эмнэлэг малын эрүүл мэнд, паразитын эмчилгээний ач холбогдлын талаар 2500 товхимол хэвлүүлэн малчдад түгээснээс гадна паразит өвчний эмчилгээний талаар нийт 6 удаагийн мэдээлэл, мэдлэг олгох үйл ажиллагааг зохион байгуулж, эдгээр арга хэмжээнд нийт 220 малчин оролцжээ. Ийнхүү өргөн хүрээг хамран ажиллаж, мал эмнэлгийн үйлчилгээ, паразитын эмчилгээ хэрхэн хийгддэг болохыг харуулсан байна. Түүнчлэн хүнсний аюулгүй байдал, лабораторийн шинжилгээний талаар зурагт хуудас бэлтгэн, эдгээрийг сургууль, эмнэлэг, зах, махны дэлгүүр, ресторан болон олон нийтийн гадруудад байршуулжээ. Эдгээр арга хэмжээ нь малчдад мэдлэг олгохоос гадна мал эмнэлгийн үзүүлж буй үйлчилгээг сурталчилсан ажил боллоо.

Юмтгэгээ нь мөн паразитын эмчилгээ, үйлчилгээ, лабораторийн шинжилгээний чиглэлээр нэг өдрийн сургалтын хөтөлбөр, оролцогчдод зориулсан гарын авлагыг боловсруулж, үүнийгээ 648 малчинд хүргэжээ. Сургалтыг анх малчдад зориулахаар төлөвлөсөн ч КОВИД-19 халдвараас үүдсэн хязгаарлалтын улмаас олон хүн нэг дор цуглуулах боломжгүй болсон юм. Тиймээс сургалтын хэлбэрийг өөрчлөн, малын эмч нар малчин өрх нэг бүрээр орж сургалт хийж, материалыг хүргэжээ. Мал эмнэлгийн захирал “Ийнхүү өөрчлөлт оруулсан нь илүү үр дүнтэй ажил болсон бөгөөд учир нь бид илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгч, асуултуудад шууд хариулан, сургалтын үеэр малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байсан” хэмээн хэлж байна.

Сумын малчид одоо тэрхүү шинжилгээний талаар илүү мэдээлэлтэй болж, шинжилгээ гэж юу болох, яагаад чухал болохыг сайтар ойлгосноо хэлж байна. Шинжилгээ илүү их хийгдэж, улам түгэхийн хэрээр малчид болон худалдан авагчдын хооронд итгэлцэл бий болж, малчид одоо өөрийн мал, махыг өндөр үнээр борлуулах боломжтой боллоо. Үүний үр дүнд малчид Юмтгэгээ мал эмнэлгээр төлбөртэйгөөр шинжилгээ хийлгэхдээ цааргалахгүй болжээ.

Зах зээлийн эрэлтээс үүдэн тус эмнэлэг өөрийн үйлчилгээг өргөжүүлэн, эмнэлэгтээ малын эмийн сан нээж, хавар болон намрын эмийн хэрэгцээг хангаж байна. Мөн энгийн мэс ажиллабар хийдэг байсан бол одоо илүү ахисан түвшний кесарев, ясны хугарал, хавдар зэрэг мэс засал хийх болжээ.

Эцэст нь, уг төслийн урьдчилан хүлээгдээгүй чухал өөр нэгэн нөлөө нь КОВИД-19 халдварын хүрээнд Юмтгэгээ болон нутгийн захиргаа хооронд тогтоосон түншлэл юм. Вируст халдвар тархахаас сэргийлэн, төрийн зүгээс авч буй арга хэмжээнд уг эмнэлэг өөрийн ариутгалын тоног төхөөрөмжийг олон нийтийн газарт ариутгал, халдваргүйжүүлэлт хийхэд зориулан, үнэ төлбөргүй ашиглуулж байна.

Бизнесийн тогтвортой байдал болон ойрын ирээдүйн хэтийн төлөв

Малчид, бизнесүүдийн зүгээс эрэлт хэрэгцээ нэмэгдэж, орлого өссөн болон үйлчилгээ үзүүлэх хүчин чадал өндөр түвшинд хүрсэн зэргээс харвал энэхүү бизнес нь цаашид тогтвортой үргэлжлэх нь тодорхой байна. Юмтгэгээ нь бусад малын эмч нарт сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор өөрийн лабораторийг демо лаборатори болгон хөгжүүлж, малын мэс засал болон эмчилгээний шинэ барилга барихаар төлөвлөн ажиллаж байна.



Амжилтын түүх

ЗАЛУУСЫН УДИРДАН АЖИЛЛУУЛДАГ МАЛ ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИ

Түншлэгчийн нэр: Мандалхаан Сүрэг мал эмнэлэг

Төслийн байршил: Хэнтий аймгийн Биндэр сум

Хугацаа: 2020 оны 4 сар – 10 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Мандалхаан Сүрэг ХХК нь Хэнтий аймгийн Биндэр суманд үйл ажиллагаа явуулдаг хувийн мал эмнэлэг бөгөөд тус суманд Мандалхаан Сүргээс гадна 6 өөр мал эмнэлэг ажиллаж нийт 266.8 мянган толгой малд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж байна. Мандалхаан Сүрэг нь ерөнхий мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг ба үүнд эмчилгээ, тарилга, угаалга, эрүүл мэндийн үзлэг зэрэг үйлчилгээг тус мал эмнэлэгт бүртгэлтэй 60 малчин өрхийн 29 мянган толгой малд хүргэдэг.

Энэхүү хувийн мал эмнэлгийг ажиллуулдаг хоёр залуу малын эмч Мерси Корын “Даван түүлах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөрөөс дэмжлэг хүлээн авчээ. Монгол улсад 15-34 насны залуус хүн амын дийлэнхийг бүрдүүлдэг ба нийт хүн амын бараг 35%-ийг эзэлж буй ч мал аж ахуйн салбарт бизнес

эрхэлж буй залуусын тоо маш доогуур буй юм. Тиймээс Мерси Кор нь дэд тэтгэлэгт хөтөлбөртөө “залуусын удирдаж буй” бизнест түлхүү анхаарал хандуулж, төсөл хэрэгжүүлэхэд нь зориулан 70/30 харьцаатайгаар санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Мерси Корын дэмжлэгтэйгээр Мандалхаан Сүрэг нь мал эмнэлгийн үйлчилгээг өргөжүүлэн хоёр шинэ төрлийн үйл ажиллагаа болох мал аж ахуйн бүтээгдэхүүний ариун цэврийн шинжилгээ болон зооноз өвчний шинжилгээ, мониторингийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Эдгээр үйлчилгээг нутгийн иргэд, мал сүргийн эрүүл мэнд, аюулгүй байдалд чухал үүрэгтэй тул сонгон авчээ. Төслийг хэрэгжүүлэхээс өмнө тухайн суманд дээрх үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай лабораторийн үйлчилгээ хийх байгууламж, тоног төхөөрөмж байдаггүй байв. Энэхүү бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх төсөл нь мөн иргэдэд хүрч ажиллах, мэдээлэл түгээх болон маркетингийн чиглэлийн үйл ажиллагааг багтааж, шинжилгээний хэрэгцээний талаар мэдээлэн, мал эмнэлгийнбизнесийг, ялангуяа шинэ үйлчилгээг сурталчлан түгээжээ.

Төслийн зорилт нь “Мал маллагааны сайн арга ажиллагааг нэвтрүүлэх зорилгоор малчид мал эмнэлгийн чанартай үйлчилгээг ашигладаг болсон байх” явдал бөгөөд үүнийг хангахын тулд гурван гол үр дүнг тогтоон гаргасан нь; (1) Малчид болон бизнес эрхлэгчдэд мал эмнэлгийн лабораторийн үйлчилгээ хүртээмжтэй болсон байх; (2) Зооноз өвчний чиглэлээр нутгийн иргэдийн оролцоо, мэдлэг нэмэгдсэн байх; (3) Зах зээлийн холбоос бэхжиж, боломжит хэрэглэгчид идэвхэжсэн байх зэрэг үр дүнг байна.

Үр дүн 1: Мал эмнэлгийн лабораторийн хүртээмж сайжирсан

Мерси Кортой түншлэн Мандалхаан Сүрэг нь өөрийн барилгын гурван өрөөг шинэчлэн засаж, малын эрүүл ахуй, зооноз өвчний шинжилгээ хийх мал эмнэлгийн лабораторийг байршуулахын зэрэгцээ мөн эмийн санг байгуулан ажиллуулсан. Лаборатори нь шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдож, сумын шинжилгээний хэрэгцээнд нийцэх болсон. Хувийн мал эмнэлгийн хүлээн авах хэсэг болон оффис болгон нэмэлт өрөөг засан тохижуулж, зориулан 10 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалтыг анхны тооцсон төсвөөс гадуур хийсэн. Шинээр тохижуулсан лаборатори нь мал эмнэлгийн лабораторид тавьдаг улсын стандартыг хангажээ.

Мал эмнэлгийн захирал “Мерси Кор нь орон нутгийн залуу бизнес эрхлэгчдийг дэмждэг тул тус байгууллагатай хамтран ажиллахад тун таатай байсан. Одоо маш цөөн тооны залуус хөдөө орон нутагт, мал аж ахуйн бизнес эрхлэх сонирхолтой байна. Их сургууль төгсөөд бид нутагтаа эргэн ирэхээр шийдсэн ба тэр үеэс хойш 4 жилийн турш тасралтгүйгээр мал эмнэлгийн үйлчилгээг малчдад үзүүлж байна. Санхүү, техникийн туслалцаа авснаар манай мал эмнэлгийн үзүүлдэг үйлчилгээний цар хүрээ ихээхэн нэмэгдэж, цаашдын ирээдүйд үргэлжлэн өсөх орлогын шинэ эх үүсвэрийг бий болгосон. Барилга байгууламжаас гадна бид лабораторийн

шинжилгээний техникийн мэдлэг, чадамжаа гүнзгийрүүлсэн. Хэрэв бид зөвхөн өөрийн мөнгөөр санхүүжүүлсэн бол бид үүнтэй ижил төстэй мал эмнэлгийн лабораторийг 3- 4 жилийн дараа л байгуулах боломжтой байсан” хэмээн өгүүлсэн.

Сумын түвшинд лабораторитой болсон нь тус мал эмнэлгийн үйлчилгээг нутгийн малчдад хүргэх боломжийг нээн, мах болон сүүн бүтээгдэхүүний шинжилгээ хийх болжээ. Мал эмнэлгийн түгээмэл үйлчилгээнээс өргөжин шинэ үйлчилгээ нээсэн нь тус хувийн мал эмнэлгийн үйлчлүүлэгчдийн тоог мөн нэмэгдүүлсэн.

Төслийн хүрээнд мал эмнэлгийг эзэмшигч малын эмч 2 залуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори дээр сургалтад хамрагдан, лабораторийн эмчийн гэрчилгээ авсан. Энэхүү сургалтад хамрагдаж, бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлсний дараагаар Мандалхаан Сүрэг нь хоёр ангилалд багтах 8 төрлийн лабораторийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Шинжилгээний эхний ангилалд хүнсний аюулгүй байдал, ариун цэврийн шинжилгээ болох ариун чанарын, PH тодорхойлох, маханд антибиотикийн үлдэгдэл үзэх, бохирдлын, нэмэлт бодисын, эмийн үлдэгдлийн, илчлэг тогтоох болон сүүний бактерийн шинжилгээ багтана. Шинжилгээний хоёр дахь ангилалд зооноз өвчний шинжилгээ орох ба энэ нь сумын нутаг дэвсгэр дэх зооноз өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, эмчлэхэд чухал үүрэгтэй шинжилгээ юм. Тус хувийн мал эмнэлэг нь зооноз өвчний шинжилгээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж, мэдээлэл хүргэх, материал түгээх зэргээр ажиллаж байна.



Төсөл хэрэгжсэн 6 сарын хугацаанд нийт 414 малчин лабораторийн шинэ үйлчилгээг авчээ. Нийтдээ тус мал эмнэлэг нь 8.2 тонн болон 10.4 тонн сүүнд шинжилгээ хийсэн ба өмнө нь тус суманд мал эмнэлгийн лабораторийн шинжилгээ хийх хүчин чадал огт байгаагүй юм. Үр дүнд нь тус хувийн мал эмнэлэг нь орлогын шинэ эх үүсвэртэй болж, нийт орлого нь 56%-иар өссөн байна. Мал эмнэлгийн захирлын хэлснээр Мандалхаан Сүрэг нь өмнө нь тогтвортой мөнгөн орлоготой байгаагүй зөвхөн улирлын чанартай хийгддэг хуваарьт вакцинжуулалт, угаалгын үйлчилгээнээс л орлого олж байв. Одоо тус мал эмнэлэг нь сард нэмэлтээр 500-800 мянган төгрөгийг лабораторийн болон эмийн үйлчилгээнээс олох болжээ. Малын гаралтай бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний эрэлт нэмэгдэхэд орлого нь мөн нэмэгдэхээр тооцож байна. Монголын хувийн мал эмнэлгүүдэд ашигтай ажиллах боломж хомс байдаг ч Мандалхаан Сүрэг нь нутгийн иргэдэд шинэ үйлчилгээ үзүүлэхээс гадна тухайн үйлчилгээгээр ашиг олж болохыг харуулсан.

Лабораторийн хүчин чадал нэмэгдсэнээр Мандалхаан Сүрэг нь малчид, фермерүүдэд малын эрүүл мэндийн гэрчилгээ олгох боломжтой болжээ. Гэрчилгээ нь малын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан болохыг тодорхойлж, мөн малчид малаа дотоодын болон улсын хэмжээний том

зах зээлд борлуулахад нь тусалж буй юм. Эцсийн хэрэглэгчийн үүднээс авч үзвэл сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг төрийн байгууллагууд нь аюулгүй, мөшгөн гарал үүслийг нь тогтоох боломжтой бүтээгдэхүүнийг орон нутгийн зах зээлээс худалдан авч байна. үндсэндээ нийт олон нийт, иргэд энэхүү лабораторийн үйлчилгээний үр шимийг шууд болон шууд бусаар хүртэж байна.

Мал эмнэлгийн захирал мөн “Зах зээл дээр зарагдаж буй олон төрлийн хүнсний бүтээгдэхүүн нь өмнө нь шинжилгээнд хамрагддаггүй байсан. Харин одоо хуулиар заавал шинжилгээнд хамрагдах ёстой болсон. Бид өөрийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд малын бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоог бэхжүүлэх замаар хувь нэмэр оруулж байна” хэмээн хэлж байв.

Төсөл хэрэгжүүлснээр тус мал эмнэлэг нь шинжилгээг баримтжуулах, үйлчилгээ хүргэх, цахим гэрчилгээ олгох, ариутгал халдваргүйжүүлэлт хийх зэрэг үйл ажиллагааг сайжруулсан ба одоо бүртгэл нь илүү сайн зохион байгуулалттай болж, бүртгэлд хөтлөх журмыг стандартын дагуу даган мөрдөж байна. Бүртгэлээ сайжруулснаар сумын захиргаа болон Мал эмнэлгийн ерөнхий газар нь олон нийтэд хандаж малын эрүүл мэндэд хяналт тавих шинжилгээний боломжууд, тархвар судлалын үр дүнг нийтэд мэдээлэхэд ч мөн түлхэц болж байна.

Мал эмнэлгийн улсын байцаагч “Мал, амьтны эрүүл мэндийн тухай шинэ хуулиар малчид борлуулж буй малын гаралтай бүтээгдэхүүн нь хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан болохыг баталсан лабораторийн гэрчилгээ авах ёстой. Гэтэл бодит байдал дээр ихэнх мал эмнэлэгт өөрийн лаборатори байдаггүй учир энэ заалт хэрэгждэггүй. Сумын энэхүү хувийн мал эмнэлэг нь одоо лабораторийн үйлчилгээ үзүүлдэг болсонд бид маш баяртай байна” хэмээн хэлж байв.

Тус хувийн мал эмнэлэг нь дотоодын менежментээ сайжруулахыг зорьсон. Мандалхаан Сүрэг нь Мерси Корын “Орон нутгийн бизнес клиник” төсөлд хамрагдаж, Кинг Консалтинг компанитай хамтран ажиллаж, бизнесийн зөвлөх үйлчилгээг авсны үр дүнд бүртгэлээ сайжруулах, нягтлан бодох бүртгэл болон хүний нөөцөө хөгжүүлэх, маркетингийн болон бизнесийн төлөвлөгөөг боловсруулж чадсан билээ.

Хүний нөөцийн хувьд түр ажилтан авч ажиллуулах журам гаргаж, цалингийн хэмжээг тогтоож, нийгмийн даатгал болон татварыг нь төлөх болжээ. Мал эмнэлэг нь мөн өөрийн ашигладаг хөдөлмөрийн гэрээ, байнгын ажилтан авах журам зэргийг сайжруулжээ. Хүний нөөцийн баримт бичиг бүрийг албан шаардлагын дагуу бүрдүүлж, Монгол улсын Хөдөлмөрийн хуульд нийцүүлжээ. Маркетингийн хувьд Мандалхаан Сүрэг нь шинэ лого бүхий сошиал медиа хуудас хөгжүүлж, малчидтай хэрхэн холбогдон хэрэглэгчийн тоог нэмэх талаар суралцаж, мал эмнэлгийн бизнесийг хэрхэн үр дүнтэй үргэлжлүүлэх талаар суралцсан байна. нягтлан бодох бүртгэл, санхүүгийн удирдлагын хувьд тус мал эмнэлэг нь нягтлан бодох бүртгэлийн үндэс, татварын хөнгөлөлт чөлөөлөлт, тайлагнах, санхүүгийн тайлан бэлтгэх болон баримтжуулалт зэрэг чиглэлээр зөвлөх үйлчилгээ авсан байна.

Үр дүн 2: Зооноз өвчний чиглэлээр мэдлэг, оролцоо нэмэгдсэн

Өөрийн лабораторийн үйлчилгээний зах зээлийн эрэлтийг идэвхжүүлэхийн тулд Мандалхаан Сүрэг нь олон төрлийн үйл ажиллагааг явуулсны тоонд товхимол боловсруулан бэлтгэж, малчид, иргэд болон бусад төр болон хувийн хэвшлийн байгууллагуудад тараах зэрэг багтжээ. Тухайн тараах материалууд нь мал эмнэлгийн лабораторийг сурталчлах, зооноз өвчний талаарх мэдлэгийг бий болгох явдал юм. мал эмнэлэг нь мөн Намрын баяр, Малчдын бага хурал болон Бизнесийн байгууллага хоорондын арга хэмжээнд оролцож ирсэн. Түүнчлэн хувийн мал эмнэлэг нь маркетингийн өөр өөр арга болох сошиал медиа хуудас үүсгэн олон нийтэд хүрэх зэргийг ашигласнаар онлайн болон товхимлоор дамжуулан нийт 1567 хүнд хүрч ажиллажээ.

Нөгөө талаар зооноз өвчний талаарх мэдлэг, тандан судалгаа ерөнхийдөө дутмаг буй нь малчдад өөрийн малын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад хүндрэл учруулдаг байна. Малчин бүхэн тархвар зүйн мэргэжилтэн байх албагүй ч хэрэв мал өвчлөх тохиолдолд ямар арга хэмжээ авах, хэрхэн сэргийлэх, малын байдлыг хэрхэн хянах зэргийг мэдэж байх шаардлагатай.

Энэхүү дутагдлыг арилгахын тулд тус мал эмнэлэг нь сумын 74 малчин өрхийн 2710 толгой малд бруцеллёзын шинжилгээ хийсэн. Шинжилгээгээр бруцеллёзын тохиолдол илрээгүй байна. Гарсан үр дүнгээр тэдний үхэр нь эрүүл, бруцеллёзгүй буйд малчид ихээхэн баяртай буй ажээ. Энэ нь малчдад бусад төрлийн цусны өвчний тест, жишээ нь цусан халдвар, энтеротаксем зэрэг суманд түгээмэл байдаг өвчний шинжилгээ хийлгэх сонирхолтой болгожээ. Нутгийн нэг малчин “Манай бүх үхрийг мал эмнэлэг шинжилж, гарсан дүнг нь эргээд маш хурдан мэдээлсэн. Өмнө нь зөвхөн цөөн тооны үхэр л шинжилдэг байсан. Харин одоо би бүх үхэр бруцеллёзгүй болохыг баталгаажуулах боломжтой болсон нь махаа зах дээр зарахад надад давуу тал болж байна” гэжээ.

Үүн дээр нэмээд Биндэр сумын мал эмнэлгийн улсын байцаагч дараах зүйлийг цохон тэмдэглэсэн: “Мандалхаан Сүрэг нь зооноз өвчнийг илрүүлэх, сэргийлэх болон хянах боломжтой болсон ба малчдад хүргэж буй үйлчилгээний чанар болон хамрах хүрээг сайжруулж чадна. Өмнө нь бүх малд шинжилгээ хийх боломжгүй байсан. Зөвхөн үржлийн малын цусны дээжийг авч зооноз өвчний шинжилгээнд хамруулахаар аймгийн лабораторид хүргүүлдэг байсан. Энэ тохиолдолд аймгийн лабораториос шинжилгээний дүнг авахад 7-14 хоног болдог байсан. Харин одоо бүх малаа шинжилгээнд түргэн хугацаанд хамруулж, тээврийн нэмэлт зардал гаргахгүй болоод байна. Бид мал эмнэлгийн асуудал хариуцсан орон нутгийн төрийн байгууллага болохын хувьд энэхүү санаачилгыг дэмжиж буй бөгөөд шинжилгээний талаарх мэдээлэл хуваалцах зэргээр ажиллаж байна. Хорш хойд сумдын, жишээ нь Бат-Ширээт болон Дадал сумын малчдын хувьд өөрийн сүүний чиглэлийн үнээ, махны үхэр, малын гаралтай бүтээгдэхүүндээ шинжилгээ хийлгэх боломжтой болсон.”

Хэдий Мандалхаан Сүрэг нь үйл ажиллагаа явуулсан эхний жилдээ бруцеллёзын шинжилгээг үнэ төлбөргүй хийсэн ч тус мал эмнэлэг нь одоо сум болон аймгийн мал эмнэлгийн газартай нягт хамтран ажиллаж эдгээр тандан судалгааны шинжилгээг төрийн санхүүжилтээр хийх, үйлчилгээнийхээ татаасыг авах чиглэлээр ажиллаж байна. Үндсэндээ бруцеллёзын шинжилгээгээр дамжуулан малчид өөрийн шинжилгээний дүнг цаг тухайд нь авахын зэрэгцээ хэрхэн урьдчилан сэргийлэх болон хэрэв малд нь бруцеллёз илэрвэл ямар арга хэмжээ авах талаар мэдээлэл, зөвлөгөө хүлээн авч байна. Түүнчлэн түргэвчилсэн байдлаар хийгддэг энэ төрлийн шинжилгээ нь малчдын дунд бусад төрлийн зооноз өвчний, жишээ нь цусны өвчний шинжилгээний шинэ эрэлт үүсгэж байна.

Үр дүн 3: Үйлчлүүлэгч нартай зах зээлийн холбоосыг бэхжүүлсэн

Мандалхаан Сүрэг нь бусад талуудтай хамтран ажиллаж, санал бодлоо солилцож, суралцаж буй бөгөөд үүний хүрээнд бусад хувийн мал эмч нарыг урьж лабораторийн үйлчилгээг танилцуулснаас үр дүн гарч байгаа билээ. Энэ хүрээнд Мандалхаан Сүрэг нь Биндэр сумын өөр гурван хувийн мал эмнэлэгтэй гэрээ байгуулан, санхүүгийн болон хүний нөөцөө хуваан ашиглахаар болсон нь малын эрүүл мэндэд үзүүлэх эерэг нөлөөг нэмэгдүүлжээ. Жишээ нь сумын мал эмнэлгүүдэд тулгардаг нэг том бэрхшээл нь оффисын хүрэлцээ. Энэхүү гэрээний ачаар бусад мал эмнэлгүүд Мандалхаан Сүрэг ХХК-ийн оффис болон лабораторийг ашиглах боломжтой болсон.

Тэд мөн хөдөө, алс газарт буй малчдад шаардлагатай тохиолдолд дуудлагаар харилцан бие биесээ орлон явж ажиллахаар тохиролцжээ. Мандалхаан Сүрэг нь бусад мал эмнэлэг дээр бүртгэлтэй малчдад өөрийн үйлчилгээг хүргэн, хэрэглэгчээ нэмэгдүүлэх боломж гарахын зэрэгцээ оролцож буй бүх мал эмнэлэг ч энэхүү зохион байгуулалтаас мөнгө хэмнэх юм. Хамтран ажиллаж буй мал эмнэлгийн нэг болох Бат Тун эмнэлгийн төлөөлөл “Бидний хамтын ажиллагаа нь харилцан суралцах боломж олгож буй тул аль алинд нь үр өгөөжтэй байгаа. Бидний дундаас зарим мал эмнэлэг нь зориулалтын барилгагүй, лабораторийн үйлчилгээ үзүүлэх чадамжгүй. Жишээ нь манай гэрээт малчид Мандалхаан Сүрэг мал эмнэлгийн лабораторийн шинжилгээний үйлчилгээг ашиглаж, малын эрүүл мэндийн гэрчилгээ гаргуулан авах боломжтой. Түүнчлэн хэрэв аль нэг мал эмнэлэг нь боломжгүй бол бид дуудлагад өмнөөс нь явдаг. Бидний хамтын хүчин чармайлт нь зооноз өвчний хамрах хүрээг өргөтгөж, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх, хянах төлөвлөгөөг гаргахад дэм болно гэж найдаж байна” гэжээ.

Тус хувийн мал эмнэлэг нь лабораторийн үйлчилгээ үзүүлэх гэрээг сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, махны болон сүүний гурван дэлгүүртэй хийгээд байна. Энэхүү гэрээний хүрээнд мал эмнэлэг нь тухайн байгууллагуудын маханд шинжилгээ хийж, эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх дээр дүгнэлт гаргаж байна. Үүний хариуд тухайн байгууллагууд нь сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд, сумын иргэдэд эрүүл, аюулгүй махан хоолоор үйлчилж байна. Мөн тухайн байгууллагуудад махаа

нийлүүлж буй малчид, фермерүүд лабораторийн үр шимийг хүртэж байна. Сургууль, цэцэрлэг, эмнэлэгт махаа нийлүүлж буй малчид шаардлагатай гэрчилгээг үзүүлэх боломжтой болсон. Энэ талаар нутгийн нэг малчин “Энэ жилээс эхлэн би сумын цэцэрлэгт мах нийлүүлэх (сард 500 кг-аас 1 тонн хүртэл) болсон. Хүнсний аюулгүй байдлын шаардлагын дагуу бүх мах шинжилгээнд орж, аюулгүй гэдэг нь батлагдсан байх ёстой бөгөөд одоо энэхүү шаардлагыг биелүүлэхэд надад хялбар болсон. Би махаа мал эмнэлэг дээр аваачаад л шинжилгээний дүн нь 20- 30 минутын дараа, гэрчилгээтэйгээр гарч ирдэг болсон” гэж хэлж байв.

Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг махны дэлгүүрийн эзэн “Өнгөрсөн 8-р сард бид хувийн мал эмнэлэгтэй гэрээ байгуулсан. Үүнээс хойш би аюулгүй болох нь шинжилгээгээр батлагдаж, гэрчилгээ олгосон мах зарж байгаа. Миний үйлчлүүлэгчдийн хувьд надаас мах худалдан авахдаа итгэлтэй байх нь тун чухал. Улмаар манай нэр хүнд, ашиг өснө. Өмнө нь шинжилгээгүй мах зарахад би маш их бэрхшээлтэй тулдаг байсан бол одоо хаана очиж шинжлүүлэх талаар санаа зовох шаардлагагүй болсон. Лабораторийн үйлчилгээний төлбөр нь надад дарамт болдоггүй. Миний мэдэж буйгаар манай махны дэлгүүр нь мөн тус мал эмнэлэгтэй бизнесийн гэрээ хийсэн нь үйлчилгээ нь эрэлттэй, хэрэгцээтэй байна гэсэн үг” хэмээн тайлбарлаж байв.

Бизнесийн тогтвортой байдал болон ойрын ирээдүйн хэтийн төлөв

Тус хувийн мал эмнэлэг нь малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд буй орхигдлыг нөхөх чиглэлээр хувь нэмэр оруулсан нь ямар ч эргэлзээгүй юм. Мандалхаан Сүрэг мал эмнэлгийн эхний жилийн туршлагаас харвал тэдний үзүүлж буй үйлчилгээ нь орон нутгийн малчид, бусад бизнес эрхлэгчдэд нэмүү өртөг бий болгож, зах зээлээ улам өргөжүүлэхэд нь дэмжлэг болж байна. Мал эмнэлгийн зүгээс хэлэхдээ хэрэглэгчдийн зүгээс нэмэлтээр өөр шинжилгээ хийх, өөр клиникийн мэс заслын үйлчилгээ үзүүлэх хүсэлтийг байнга гаргаж байжээ. Мандалхаан Сүрэг хувийн мал эмнэлэг нь төсөл хэрэгжүүлэх үед гаргасан амжилт дээрээ үндэслэн цааш үргэлжлүүлэн өргөжүүлэх тодорхой төлөвлөгөөтэй ажиллаж байна.



Сумын мал эмнэлгийн байцаагч “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн дагуу сумын захиргаа нь мал эмнэлгийн үйлчилгээг хангахад шаардлагатай нөөц эх үүсвэрийн хуваарилах үүргийг хүлээдэг. Зооноз болон бусад халдварт өвчний мониторинг, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгцээ маш их өсөж байгаа. Энэ зорилгоор бид хувийн мал эмнэлгүүдтэй үргэлжлүүлэн хамтран ажиллана. Мал эмнэлгийн захирал нь хөрш сумдын (Биндэр болон Дадал) бүх малд бруцеллёз өвчний тандан судалгааг ирэх 2021 оны 5 болон 6 сард хийх санал гаргасан” хэмээж байсан.

Мал эмнэлгийн захирал нь лабораторийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх өөрийн төлөвлөгөөг хуваалцахдаа юуны өмнө мал эмнэлгийн байрыг сумын төвлөрсөн дулааны системд холбон бүтэн жилийн туршид тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжийг хангахад төвлөрч буйгаа дурдсан. Мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулж буй Биндэр суманд нядалгааны цехийн барилга одоо баригдаж байна. Энэ нь хамтран ажиллах замаар ханган нийлүүлэлтийн сүлжээний чадавхыг өргөжүүлэх өөр нэгэн боломжийн нээн өгч байна. Мал эмнэлгийн Захирал энэ талаар “Бид нядалгааны цехэд ирж буй амьд мал болон гарч буй маханд шинжилгээ хийх төлөвтэй байгаа. Эндээс гарсан бүтээгдэхүүнийг зөвхөн Биндэр суманд ч бус бусад хот, аймгуудад нийлүүлнэ. Бид энэхүү өргөтгөсөн ханган нийлүүлэлтийн системийн нэг хэсэг болохын тулд боломжтой бүх зүйлсийг хийнэ” хэмээж байна.



Амжилтын түүх

ХУВИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛСЭН НЬ

Түншлэгчийн нэр: Дэвжих Дөл ХХК

Төслийн байршил: Сэлэнгэ аймгийн Цагааннуур сум

Хугацаа: 2020 оны 4 сар- 10 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Дэвжих Дөл хувийн мал эмнэлэг нь Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын нийт 3 багийн 73 малчин өрхийн 41 мянган толгой малд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг. Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагддаг нийт малын 10 мянган нь үхэр бөгөөд энэ нь Цагааннуур сумын нийт үхрийн тал хувийг эзэлж байна.

Дэвжих Дөл ХХК-ийн байр 2019 оны 1-р сард гал түймэрт өртөж, тоног төхөөрөмж шатсан нь мал эмнэлгийн үйлчилгээг зохих ёсоор хүргэх боломжийг ихээхэн хязгаарлажээ. Зориулалтын байргүй болсон нь малын эм борлуулах, үзлэг, мэс засал зэрэг мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх боломжийг хязгаарлаж, орлого нь их хэмжээгээр буурахад нөлөөлсөн. Мал эмнэлгийн захирал “Их хүнд үе байсан. Үндсэндээ бид бүх зүйлээ алдаж, ажлын байргүй үлдсэн тул үйлчилгээ үзүүлэх, малын эмийн борлуулалт хийх боломжгүй болсон байв. Мал эмнэлгийн үйлчилгээгээ

үргэлжлүүлэхийн тулд бид энгийн, хялбар мэс заслыг малчдын хүсэлтээр хийж байсан ч клиникийн мэс заслыг хийх боломжгүй болсон юм. Улмаар бидний хийсэн мэс заслын тоо ч ихээр буурсан. Энэхүү алдагдлаа нөхөхийн тулд би эхлээд малын эмийг гэрээсээ зарж байсан ч борлуулалт тогтворгүй байсан тул мөнгөн урсгал, орлого дагаад буурсан. Эцэст нь шаардлагатай эмийн хомсдолд орж, нөөц бүрдүүлэх боломжгүй болсон” хэмээн хэлж байв.

Эдгээр сорилтыг даван туулж, бизнесээ өсгөхийн тулд тус мал эмнэлэг нь мал эмнэлгийн байртай болж, паразитын эсрэг эмчилгээ, үйлчилгээг өргөжүүлэх, малын гаралтай бүтээгдэхүүний гэрчилгээ, малын эрүүл мэндийн талаар малчдын мэдлэгийг нэмэгдүүлэх ажил хийхээр төлөвлөжээ. Ийнхүү үйл ажиллагаагаа өргөжүүлснээс мал эмнэлгийн үйлчилгээ өргөжиж, малын эрүүл мэндийн талаар малчдын ойлголт нэмэгдэж, тухайн бүс нутгийн малын эрүүл мэнд, чанарыг сайжруулна гэсэн итгэлтэй байна.

Мерси Кор нь “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөрийн хүрээнд Дэвжих Дөл мал эмнэлэгтэй хамтран ажиллаж, төслийн зорилго болох “Малын эрүүл мэндийн чанартай үйлчилгээг малчид хүртэж, мал маллагааны үр дүнтэй аргачлалыг нэвтрүүлэх” зорилгоо хангахад нь тусалсан билээ. Энэхүү зорилтыг хангахын тулд (1) чанартай үйлчилгээг малчдад хүргэх мал эмнэлгийн чадавхыг сайжруулах; (2) паразит өвчний эсрэг үйлчилгээг өргөжүүлэх; (3) мал эмнэлгийн үйлчилгээ, малын эрүүл мэндийн талаар малчдын мэдлэгийг нэмэгдүүлэх гэсэн гурван зорилтыг дэвшүүлжээ.

Үр дүн 1: Мал эмнэлгийн чанартай үйлчилгээ үзүүлэх чадавхийг сайжруулсан


Дэвжих Дөл ХХК нь Мерси Кортой хамтран хуучин барилга худалдан авч, засан сайжруулан энэхүү байрандаа анх удаагаа мал эмнэлгийн лабораторийн үйлчилгээ үзүүлж эхлэв. Мал эмнэлгийн байртай болсон нь тус мал эмнэлэгт өөрийн орон зайг төлөвлөж, үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцүүлэх замаар малын эмч нар болон үйлчлүүлэгчдэд илүү сайн, тохьтой орчин бий болгожээ. Мал эмнэлэг нь одоо эмийн сан ажиллуулах, малд үзлэг хийх, клиникийн мэс ажиллавар хийх, зөвлөгөө өгөх болон лабораторийн шинжилгээ зэрэг үйлчилгээг үзүүлэх боломжтой боллоо. Эдгээр үйлчилгээг авч буй хэрэглэгчдийн тоо нэмэгдэж, төсөл эхэлснээс хойш мал эмнэлгийн орлого нэмэгдэж байна.

Төслийн хугацаанд тус мал эмнэлэг нь өөрийн бизнесийн цар хүрээг өргөжүүлэх, үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ, санаачилга хэрэгжүүлжээ. Дэвжих Дөл нь сумын түвшинд мал эмнэлгийн лабораторийн үйлчилгээ үзүүлж эхэлсэн анхны мал эмнэлэг бөгөөд мал эмнэлгийн байртай болсон нь мах, сүүн бүтээгдэхүүнд эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээ хийх боломжийг нээн, малын гаралтай бүтээгдэхүүн аюулгүй байдал, ариун цэврийн шаардлагад нийцсэн болохыг баталсан гэрчилгээ олгох болжээ. Лабораторийн үйлчилгээ үзүүлэх

болсноор Дэвжих Дөлийн малын эмч нар махны шинжилгээ хийж, рН түвшин, нянгийн бохирдол, үлдэгдэл бодисын хэмжээ зэргийг тогтоож байна. Сумын ХАА-н тасгийн мал эмнэлэг хариуцсан мэргэжилтний хэлснээр Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн дагуу мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээ заавал хийгдэх ёстой ч лаборатори байхгүй сумын түвшинд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг ажээ. “Цагааннуур сумд 4 мал эмнэлэг үйл ажиллагаа явуулдаг ч Дэвжих Дөл нь шинжилгээ хийж буй анхны мал эмнэлэг юм. Лабораторийн үйлчилгээний хүртээмж нь мал аж ахуйн орлогоос ихээхэн хамаарал бүхий орон нутгийн иргэдэд хамгийн чухал. Хамгийн чухал нь шинжилгээ нь мах, сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдал, ариун цэврийг баталгаажуулах ба цэцэрлэг, эмнэлэг, сургууль, зоогийн газрууд нь шинжилгээнд хамрагдсан, аюулгүй бүтээгдэхүүнийг итгэлтэйгээр худалдан авах боломжтой болсон. Энэ нь мөн хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, ариун цэврийн шаардлагуудыг иргэд харгалзан үзэж, гэрчилгээ болон аюулгүй байдлын арга хэмжээнд анхаарал хандуулахад нь тусална”.

Төслийн хугацаанд нийт 244 малчин махны шинжилгээ хийлгэж, Дэвжих Дөл ХХК-аас мал эмнэлэг, ариун цэвэр эрүүл ахуйн гэрчилгээ авчээ. Үүнээс өмнө сумын хэмжээний махны чанарыг сумын лабораторийн түвшинд шинжилж байгаагүй тул Дэвжих Дөлийн үйлчилгээний эрэлт өндөр байж, 2020 оны намар үйл ажиллагааг эхлүүлснээс хойш бараг 140 тонн маханд лабораторийн шинжилгээ хийжээ.

Мал эмнэлгийн захирлын зүгээс “Эрүүл ахуй, ариун цэврийн шинжилгээний эрэлт өндөр байгаа нь тодорхой бөгөөд малчдын зүгээс ч энэхүү үйлчилгээ нь мал сүрэгт хэр ач холбогдолтой болохыг ойлгож байна. Бусад мал эмнэлэг нь өөрийн лабораторигүй тул малчид манайхаар үйлчлүүлж байна. Түүнчлэн цэцэрлэг, сургууль, эмнэлэг зэрэг төрийн байгууллагууд, махны худалдаачид болон 2 үхрийн ферм зэрэг хувийн хэвшлийнхэн 2021 оноос эхлэн манай мал эмнэлэгтэй хамтрах ажиллах хүсэлт гаргаад байна” хэмээн хэлсэн юм.



Тус хувийн мал эмнэлэг нь 406 малчинд үнэ төлбөргүй зөвлөгөө, малын эрүүл мэндийн сургалт хийсэн нь эргээд үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлжээ. Өнгөрсөн 4-р сараас 10-р сарын хооронд нийт 344 малчин үнэ төлбөргүй зөвлөгөө авч, малын эрүүл мэндийн сургалтад 62 малчин хамрагджээ. Нийт 60 малчин өрхийн 169 толгой малд үнэ төлбөргүй мэс засал хийсний дотор кесарев хагалгаа, хавдар, гэмтлийн мэс засал зэрэг багтсан бол нийт 303 малчин малын эм худалдан авчээ. Энэ талаар нутгийн нэг малчин “Өмнө нь заримдаа малчид хуурамч, чанаргүй эм худалдан авч, үүний үр дагавар нь ихээхэн хөнөөлтэй байх тохиолдол байсан. Харин одоо Дэвжих Дөл нь тогтвортой, найдвартай эм борлуулдаг болсон тул авч буй эмийн чанар, аюулгүй байдалд бид улам итгэх болсон. Дэвжих Дөлтэй хамтран ажиллахын өөр нэгэн давуу тал нь тус мал эмнэлэг уян хатан хандаж, малчид үйлчилгээ авах, жишээ нь эм авах мөнгө байхгүй бол зээлээр өгч эргэн төлөхийг удаан хугацаагаар хүлээдэг. Малчид зээлээр эмээ аваад,

дараа нь төлөх нь бидэнд их тустай байдаг. Олон төрлийн үйлчилгээ, лабораторийн үйлчилгээ авахад хялбар болсонд бид маш баяртай байна” хэмээн хэлж байв.

Түүнчлэн сумын ЗДТГ-ын Мал эмнэлгийн мэргэжилтэн энэхүү үнэ төлбөргүй үйлчилгээ нь малын эмч болон малчдын хооронд нягт харилцааг бий болгож буй цохон тэмдэглэсэн билээ. “Малчид чанартай, мэргэжлийн мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг ойлгож эхэлсэн. Өмнө нь малчид малаа өөрсдөө эмчлэх гэж оролддог байсан нь малын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг байсан.”

Дэвжих Дөлийн захирал “Мал эмнэлэг нь үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлсний үр дүнд эмийн борлуулалтаа нэмэгдүүлсэн. Энэхүү эх үүсвэрээс ирэх орлого нэмэгдсэн нь тухайн бизнест эергээр нөлөөлж, шаардлагатай эм, хэрэгслийн бүтэн жилийн нөөц бүрдүүлэх боломжтой болсон юм. Түүнчлэн чухал шаардлагатай эмийн нөөц ч тогтворжлоо. Ийнхүү эм худалдан авах эх үүсвэр нь тогтвортой болж, бусад мал эмнэлэгтэй харьцуулбал олон төрлийн эм нийлүүлдэг болсноор үйлчлүүлэгчид манай эмийн санг сонгох боллоо. Улмаар бид бид малчдад хэвийн үйлчилгээ үзүүлдэг болж, 10 мянган үхэртэй хамгийн том фермд эм ханган нийлүүлэх боломжтой болсон. Тус фермийн шинэ тугалууд суулгаж, эмийн хомсдолд ороход нь бид шаардлагатай эм нийлүүлж, малын хорогдолгүй даван туулсан” хэмээн хэлж байна.

Тус мал эмнэлэг нь мөн цаасанд суурилсан өөрийн хуучин бүртгэлийг цахим систем болгон сайжруулсан юм. Ингэснээр бүхий л мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд оруулж, малын өвчлөлийн тохиолдлуудыг бүртгэн хянаснаар малын өвчнөөс сэргийлэх болон эмчлэх нотолгоонд суурилсан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж болов. Түүнчлэн мэдээллийн сан нь малын эмч нарын ажлын ачааллыг жигдрүүлж, үр ашгийг сайжруулан, тайлан бэлтгэхэд өмнөхийн адил 2-3 хоног бус харин 30 минут л шаардагдах болов. Мөн Дэвжих Дөл нь малын эрүүл мэнд, эрүүл ахуйн гэрчилгээг малчдад шууд хэвлэж гарган өгч байна. Өмнө нь малчид гэрчилгээ авахын тулд сумын мал эмнэлэг дээр очдог байсан бөгөөд замд явах, хүлээх зэрэг олон өдөр зарцуулж байжээ. Мерси Корын “Орон нутгийн бизнес клиник” төслийн хүрээнд Дэвжих Дөл ХХК нь зөвлөх үйлчилгээний компаниас зөвлөгөө авч, компанийн маркетингийн төлөвлөгөөг сайжруулж, хүний нөөцийн баримт бичиг, санхүүгийн анхан шатны маягтууд дээр дахин ажиллаж, баримтжуулалт, хувийн хэрэг зэрэгт хамаарах үйл ажиллагааны журмуудыг сайжруулж, бизнесийн болон маркетингийн төлөвлөгөөг шинэчлэн гаргалаа. Үйл ажиллагааны хүчин чадлаа ийнхүү нэмэгдүүлснээр тус мал эмнэлэг нь илүү үр ашигтай ажиллаж эхэлжээ.

Мал эмнэлэг үйл ажиллагааны хүчин чадлаа нэмэгдүүлэн, лабораторийн үйлчилгээ, малын эмийн сан, зөвлөх үйлчилгээ, мэс ажилбар зэрэг үйлчилгээг тогтворжуулснаас хэрэглэгчдийн тоо болон орлого нэмэгдсэн. Одоо сумын малчид нь өмнө нь хүртээмжгүй байсан үйлчилгээг сумандаа авч, мал маллагаа, малын эрүүл мэндийн практик нь үргэлжлэн сайжирч байна. Энэ нь тус бүс нутгийн малын эрүүл мэнд, чанар, малчдын амьжиргаа болон мал эмнэлгийн бизнесийн тогтвортой байдлыг хангахад урт хугацааны нөлөөлөл үзүүлнэ.

Үр дүн 2: Паразит өвчнийг эмчлэх үйлчилгээг өргөжүүлсэн

Төслийн хүрээнд худалдан авсан шинэ тоног төхөөрөмж, автомашиныг ашиглан Дэвжих Дөл нь паразит эсрэг үйлчилгээг хүргэж боломжтой болжээ. Паразитын эсрэг уусмалтай танк бүхий автомашинаар үйлчлэх болсон нь алс хол ч хүрэх боломжийг нэмэгдүүлжээ. Төслийн хугацаанд паразиттах өвчний үйлчилгээ үзүүлсэн нийт малын тоо нь төслийн хугацаанд хоёр дахин нэмэгдэж 15000-аас 37503 болж өссөн. Шинэ тоног төхөөрөмж нь мөн ариутгал, халдваргүйжүүлэлтийн бусад үйлчилгээг үзүүлэх боломжтой тул малчдын анхаарлыг ихээр татжээ. Жишээ нь, төсөл эхэлснээс хойш 78 өвөлжөөнд ариутгал, халдваргүйжүүлэлт хийжээ. Түүнчлэн ийнхүү үйлчилгээг өргөжүүлсэн нь Дэвжих Дөл мал эмнэлэгт түр ажлын байрыг нутгийн иргэдэд зориулан гаргах боломжийг нээв.

Мал эмнэлгийн захирал нь “Илүү үр ашигтай тоног төхөөрөмж ашиглан малаа эмчлэх сонирхол малчдын дунд нэмэгдэж байна. Малчид нь үзүүлж буй эмчилгээ ихээхэн үр дүнтэй буйг ажиглаж, мал болон өвөлжөөг цуг ариутгаж буйг харж байгаа. Өмнө нь бид зөвхөн эмчилгээ хийж, ариутгалыг ванн ашигладаг байсан. Харин одоо манай үйлчилгээний хурд улам сайжирч, бүх малыг хамруулж богино хугацаанд өвөлжөө, бууцыг нь ариутгадаг болсон. Энэ жил манай мал эмнэлэг автомашинтай болсон тул сумын төвөөс хол буй малчдад хүрч ажиллалаа. Түүнчлэн паразитын эсрэг ариутгалын 3 тонн шингэнийг нэг удаад олон малд ашиглаж болох тул хамрах хүрээг маш ихээр өргөжүүлсэн. Бид хэдийн 20 гаруй малчнаас дараа жил ирж, 15 мянган малд үйлчилгээ үзүүлэх хүсэлтийг хүлээн аваад байна” хэмээв. Мал эмнэлгийн захирал нь малчид үйлчилгээний чанарт сэтгэл ханамжтай байгаа тул цаг тухайд нь төлбөрөө төлж буйг цохон тэмдэглэсэн. Нийтдээ үйлчлүүлэгчийг тоо өмнөхөөс 6 дахин нэмэгдэж, 200-аас 1208 болж, жилийн орлого нь өмнөх жилтэй харьцуулбал 3 дахин өссөн байна.

Үйлчлүүлэгч нэгэн малчны хэлснээр “Өмнө нь мал эмнэлэг машингүй байсан тул бид мал эмнэлгийн үйлчилгээ авахын тулд хол явах шаардлагатай байдаг байв. Малын эмч нь утсаар ярьж, малчид (багадаа 2-3 айл) хаана нутаглаж буйг асуун, мал эмнэлгийн үйлчилгээ хэрэгтэй эсэхийг нь тодруулан, малаа нэг газар авчир гэдэг байсан. Тэгэхээр малчид бод малаа л авч очихоос өөр сонголтгүй. Бог болон төл малыг тээвэрлэхэд хүндрэлтэй тул тэднийг орхидог байлаа. Харин одоо мал эмнэлэг нь айл нэг бүрээр орж, бүх малыг бод, бог ялгаагүй эмчилж, угаах ажлыг 2-3 цагт л амжуулж байна. Мөн Дэвжих Дөл хашаа хороонд ариутгал, халдваргүйжүүлэлт хийдэг. Мал, хашаа хороог цугт нь ариутган, халдваргүйжүүлэх нь өвчнөөс сэргийлж, мал хурдан тарга хүч авч, эрүүл байхад үр дүнтэй. Тийм болохоор мал эмнэлгийн үйлчилгээ ингэж сайжирсанд их баяртай байгаа бөгөөд цаашид үргэлжлүүлэн үйлчлүүлнэ”.

КОВИД-19 цар тахлын халдварын улмаас хорио тогтоосон үед тус мал эмнэлэг нь олон нийтийн газрын ариутгал, халдваргүйжүүлэлтийг орон нутгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн захиалгаар хийжээ. Энэ нь нутгийн олон нийттэй тогтоосон

түншлэлийг бэхжүүлж, мал эмнэлгийн үйлчилгээг сурталчилжээ.

Үр дүн 3: Малын эрүүл мэндийн талаар малчдын мэдлэг нэмэгдсэн

Малын эрүүл мэндийн талаарх малчдын мэдлэгийг сайжруулахын тулд мал эмнэлгээс хэд хэдэн үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Малын эрүүл мэндийн талаар үнэ төлбөргүй зөвлөгөө нь малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх хамгийн нөлөө бүхий үйл ажиллагаа байлаа. Нийтдээ 400 гаруй малчид үүнд хамрагдаж, малын өвчлөлийг хэрхэн илрүүлэх, урьдчилан сэргийлэх болон мал эмнэлгийн зөвлөгөөний дагуу малыг хэрхэн арчлан маллах талаар мэдлэгтэй болжээ. Малчид мөн мэргэжлийн үйлчилгээг цаг тухайд нь авснаар малаа эрүүл, өндөр бүтээмжтэй байлгахын ач холбогдлыг ойлгожээ. Мал эмнэлгийн захирлын зүгээс сургалт, зөвлөгөө нь малчдын мэдлэгийг сайжруулж, зан төлвийг өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн тухай ярьж байв. Нутгийн малчин “Бид үнэ төлбөргүй зөвлөгөө авсан нь ихээхэн үр дүнтэй байж, малаа хэрхэн эрүүл байлгах талаар илүү анхаарахад хүргэсэн. Хэрэв малчид илүү хариуцлагатай, өвчний шинж тэмдгийн талаар мэдлэгтэй байвал малын өвчин бага гарна л гэж бодож байна. Малын эрүүл мэндийг хамгаалах нь мал эмнэлэг болон малчдын хамтын үүрэг юм” хэмээн хэлжээ.

Тус мал эмнэлэг нь мөн малын эрүүл мэндийн үйлчилгээний ач холбогдлын талаар сурталчилгааны богино видео хийлгэн түгээж, малын эрүүл мэнд, паразит өвчний талаар 2500 ширхэг тараах материал тараажээ. Видеоог YouTube хуудсанд байршуулан, товхимлыг сургалт, иргэд нийтийн хуралд оролцсон малчдад тараажээ. Төслийн хэрэгжилтийн хугацаанд мал эмнэлэг нь аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран паразит өвчний талаарх хоёр сургалт хийжээ. Эдгээр сургалтад 60 гаруй малчин оролцож, паразит өвчнөөс сэргийлэх, эмчлэх талаар мэдлэг мэдээлэл авсан байна. Малын эрүүл мэнд, паразит өвчний талаар мэдлэг мэдээлэлтэй болсон нь цаашид өвчнөөс урьдчилан сэргийлэхэд тусалж, мал сүргийг эрүүл, бүтээмж өндөртэй байлгах юм.

Цаашдын үйл ажиллагаа

Малчид, бизнесүүдийн эрэлт нэмэгдэж буй тул Дэвжих Дөлийн үйл ажиллагаа нь цаашид илүү өндөр ашигтай, тогтвортой үргэлжлэх нь тодорхой байна. Тус мал эмнэлэг нь малчид, бусад аж ахуйн нэгжүүдэд нэмүү өртөг бий болгоход хувь нэмрээ оруулж, орон нутгаас малын эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжийг олгож байна. Эрэлт өсөн нэмэгдэж буйтай холбоотойгоор хувийн мал эмнэлэг нь одоо үзүүлж буй мэс засал, лабораторийн үйлчилгээг өргөжүүлж, 2021 оноос залуу малын эмч нарт зориулан 2-3 ажлын байр бий болгохоор төлөвлөж байна.



Түншлэгчийн нэр: Хөдөө аж ахуйн их сургууль

Төслийн байршил: Улаанбаатар хот

Хугацаа: 2020 оны 11 сар- 2021 оны 4 сар

Төслийн танилцуулга

Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” (RCP) хөтөлбөрийн гол зорилтуудын нэг нь малын эмч нарыг чадавхыг бэхжүүлэх байв. Үүний хүрээнд зорилтот аймгуудын малын эмч нарт хил дамнасан өвчин, мэс заслын болон лабораторийн дадлага олгох зэрэг сургалт олон удаа зохион байгуулж, орон нутгийн мал эмнэлгүүдэд зориулсан дэд тэтгэлгийн төслүүдийг хэрэгжүүлж ирсэн.

2018 онд Мерси Кор нь мал эмнэлгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж “Хувийн мал эмнэлгүүдийг жижиг бизнесийн хувьд авч үзэх нь” гэх тайлан гаргасан бөгөөд тайланд мал эмнэлгийн хөгжилд учирч буй саад бэрхшээлийг судалж, ашигтай ажиллагааг нэмэгдүүлэх санал зөвлөмж боловсруулсан юм. Судалгаанаас

мал эмнэлгүүд бизнес менежментийн үр чадвараа дээшлүүлж, бизнесээ тогтвортой ажиллуулах нэн шаардлагатай байгаа нь харагдаж байв. Түүнчлэн мал эмнэлгүүд үйл ажиллагаандаа илүү анхаарах, бизнесийн талаас хөгжүүлэх талаар ойлголт, туршлага, мэдлэг дутмаг байгааг харуулсан юм. Цаашлаад малчид мал эмнэлгийн үйлчилгээнд төлбөр төлөхдөө хойрго, мал эмнэлгийн орлого улсын вакцинжуулалтын төлбөрөөс ихээхэн хамааралтай байдаг зэрэг нь эргэлтийн хөрөнгийг бууруулж, мал эмнэлгийн тогтвортой үйл ажиллагаанд эрсдэл учирч байна.

Мал эмч нарын бизнес менежментийн мэдлэгийг сайжруулж, тогтвортой үйл ажиллагааг дэмжих зорилгоор Мерси Кор нь Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС)-ийн дэргэдэх Мал эмнэлгийн сургууль (МЭС)-тай хамтран “Мал эмнэлгийн бизнес хөгжил” цахим сургалтыг санаачилсан бөгөөд энэ сургалт нь малын эмийн сантай болох, лабораторийн үйлчилгээ үзүүлэх зэрэг боломжит нэмэлт үйлчилгээг шинээр нэвтрүүлж орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх, бизнес төлөвлөлт, маркетинг, анхан шатны нягтлан бодох бүртгэлээ сайжруулахад туслах юм.

Түншлэл ба тогтвортой байдал

Мерси Корын RCP хөтөлбөр нь МЭС-ийн өмнөх туршлага чадавхад тулгуурлан энэхүү цахим сургалт хамтран зохион байгуулах ажлыг хамтран гүйцэтгэлээ. Төслийг ХААИС-ийн Эдийн засаг бизнесийн сургуулийн багш Д.Кадирбек удирдаж сургалтын агуулга, дизайныг ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургууль болон МЭС-ийн багш нар хамтран боловсруулсан.

МЭС нь бакалаврын оюутнуудад “Мал эмнэлгийн эдийн засаг” хичээлийг заадаг. Гэвч энэ хичээлийг танхимаас гадуур заадаггүй бөгөөд малын эмч нарт зориулсан төгсөлтийн дараах мал эмнэлгийн эдийн засаг бизнесийн сургалт байдаггүй. Гэвч ХААИС нь мал эмнэлгийн эдийн засаг, бизнес хөгжлийн цахим сургалт явуулах боловсон хүчин, сургалтын материалын хангалттай нөөцтэй, сургалтын агуулга боловсруулах талаар туршлагатай сургууль юм.

Цахим сургалтын хөтөлбөр боловсруулах эхний алхам нь МЭС-д одоо байгаа мэдээлэл, агуулга, хөтөлбөрийг орон нутгийн малын эмч нарын бодит байдалд нийцүүлэн сайжруулах явдал байв. МЭС нь малын эмч нарын бодит байдлыг илүү сайн ойлгож, цахим сургалтандаа тусгахын тулд 2020 оны 12-р сард 25 мал эмнэлгийг судалгаанд хамруулжээ. Хэдий судалгаанд цөөн тооны мал эмнэлгийг оролцуулсан ч үйл ажиллагааны хувьд төлөөлөх чадвартай байхад анхаарсан. Судалгаанд Монгол орны бүх бүсийн төлөөл болсон мал эмнэлгүүд хамрагдсан.

Бидний дараагийн алхам нь агуулгаа зорилтот мал эмнэлгүүдэд зориулсан цахим сургалтын модуль руу хөрвүүлэх ажил байв. ХААИС Ковид-19 цар тахлын хорио цээрийн үед оюутнууддаа онлайн хичээл зааж эхэлсэн туршлага нь энэхүү ажилд ихээхэн тус нэмэр болсон юм.

Төслийн хүрээнд ХААИС нь (их сургуулийн вэбсайт: <https://veterinary.muls.edu.mn>) өөрийн цахим платформд сургалтыг байршуулахыг зөвшөөрч, RCP хөтөлбөр дууссаны дараа ч сонирхсон хүмүүст тогтвортой хүргэх юм.

Мерси Кор цахим сургалт, сургалттай холбоотой бүх материалуудыг МЭС болон төв ХААИС-д хүлээлгэн өгсөн. МЭС, ХААИС нь сургалтын материалуудыг бүрэн “өмчлөх” ба өөрийн платформ дээрээ байршуулах эрхтэй болж байгаа. Ингэснээр уг сургалт нь цаашид тогтвортой явагдах боломж хангагдаж байна. Тус цахим сургалт нь үнэ төлбөргүй бөгөөд цаашид ч үнэ төлбөргүй явагдах болно.

МЭС нь Мерси Кортой байгуулсан гэрээний дагуу уг сургалтыг цаашид тогтвортой үргэлжлүүлэх үүрэг хүлээсэн. Тиймээс МЭС нь цаашид сургалтын агуулга, хэлбэрийг тогтмол сайжруулж ажиллах юм.


Сургалтын модуль

Цахим сургалт нь ойролцоогоор 8-10 цагийн хугацаанд бие даан үзэх дараах 5 модулиас бүрддэг.

1. Мал эмнэлгийн хууль, эрхзүй
2. Мал эмнэлгийн үйлчилгээний зохион байгуулалт
3. Мал эмнэлгийн бизнес төлөвлөгөө
4. Мал эмнэлгийн үйлчилгээний бизнес хөгжлийн асуудал
5. Мал эмнэлгийн санхүүгийн асуудал

Оролцогч нь модулиа үзэж дуусгасны дараа 10 асуулт бүхий тест өгнө. Тухайн тестийг 75 ба түүнээс дээш оноотойгоор давж байж дараагийн модулийг үзэх эрх авна. Тестэнд ашигладаг 10 асуултыг асуултын сангаас түүврийн аргаар сонгодог.

Тухайн модулиа үзэж, тестээ дуусгалгүйгээр дараагийн модулийг үзэх боломжгүй. Хичээлээ бүрэн үзэж, бүх тестээ өгсний дараа цахим платформ нь сертификатыг автоматаар хэвлэж өгдөг.

Мал эмнэлгийн бизнес хөгжил” цахим сургалтын ерөнхий бүтэц

Сургалтын модуль нь дараах материалуудаас бүрдэнэ:

- Өөрсдөө дарж дамжих боломжтой слайдтай танилцуулга.
- Бусад мэдээллийн эх үүсвэртэй холбогдсон линк
- Статик хуудас
- Сургалт нь бүхэлдээ дуу оруулга, тайлбартай
- График болон зураг
- Асуулт/хариулт, богино тест гэээр интерактив аргууд, тухайн модультай холбоотой бусад арга хэрэгслүүд
- Оролцогчид дараа нь ашиглаж болох, татаж болохуйц хураангуй эсвэл арга хэрэгсэл (эх загвар) баримт бичгийн файлууд

Оролцогчдын тухай

Энэхүү сургалтад Говь-Алтай, Булган, Дорнод, Ховд, Өвөрхангай, Баянхонгор, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Төв, Архангай, Орхон, Баян-Өлгий, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ зэрэг 16 аймаг болон Улаанбаатар хотоос нийт 200 суралцагч бүртгүүлж орсон.

Эдгээр 200 хүнээс 141 нь сургалтыг эхлүүлсэн бөгөөд сургалтын эхний сарын хугацаанд дараах явцтай байсан:

- 132 оролцогч сургалтаа дуусгаж, гэрчилгээгээ авсан.
- Нийт оролцогчдын 64% нь эмэгтэй, 36% нь эрэгтэй байв.

Үүнээс тус сургалт нь эрэлт хэрэгцээтэй, цаашид тогтвортой явагдах боломжтой гэж дүгнэж болно. Оролцогчид болон сургалтын үнэлгээний тухай мэдээллийг хүснэгтээр доор оруулав.

**Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Бид анх 2021 оны 3 сар гэхэд нийт 70 малын эмчийг сургах төлөвлөгөөтэй байсан ч сургалт эхэлснээс хойш нэг сарын хугацаанд 200 хүн бүртгүүлсэн нь орон нутгийн малын эмч нарын дунд энэ сургалтын эрэлт хэрэгцээ, бизнесээ сайжруулах сонирхол маш их байгааг харуулж байна.

МЭС нь цаашид “Мал эмнэлгийн бизнес хөгжил” сэдэвт цахим сургалтыг кредиттэй болгож төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт өөрсдийн боловсруулсан хичээлийн материалыг нэвтрүүлэн тогтвортой үргэлжлүүлэх болно.

Түүнчлэн сургалтын цаашдын хөгжил, тогтвортой байдлыг МЭС дангаараа хариуцах бөгөөд МЭЕГ болон МҮМЭХ-той хамтран энэхүү онлайн сургалтыг малын эмч нарыг магадлан итгэмжлэх сургалттай холбох, мал эмнэлгийн сургалтуудыг бусад сургалтын платформд нэгтгэхийг зорьж ажиллана.

“Мал эмнэлгийн бизнес хөгжил” сургалт нь орон нутгийн малын эмч нарт зориулсан анхны цахим сургалт бөгөөд цаашид төгсөлтийн дараах үргэлжилсэн цахим сургалтын эхлэл болж мянган мянган малын эмч нарын мэдлэг, оюунд хувь нэмэр оруулна гэдэг гүнээ итгэж байна.

Хаалтын хурал

2021 оны 4-р сарын 8-нд Мерси Кор болон ХААИС-ийн МЭС болон ЭЗБС хамтран төслийн цахим хаалтын хуралдаан хийв. Уг хуралд цахим сургалтын боловсруулахад оролцсон Мерси Кор болох ХААИС-ын хамт олноос гадна МЭЕГ болон МоҮМЭХ-ны төлөөлөл бүхий 11 хүн оролцсон юм.

Хурлын үеэр МЭС-ын зүгээс цахим сургалтын агуулга, платформын давуу тал, бүртгүүлэх болон сертификат авах процесс, сургалтын явц болон оролцогчдын үнэлгээ зэргийг дэлгэрэнгүй тайлбарлаж танилцуулсан юм.

Танилцуулгын дараагаар МЭС зүгээс цахим сургалтыг сар гаруй хугацаанд явуулсан туршлага дээрээ үндэслэн цаашид хэрхэн хөгжүүлэх – жилд тодорхой давтамжтайгаар явуулах, ингэснээр оролцогч нар хичээлийг олон долоо хоног дамжуулахгүйгээр тогтсон хугацаанд дуусгах, багш сурагчид цаашид багшийн оролцоотой, багш оролцогчдын хооронд интерактив хэлбэрээр хэлэлцүүлэг, даалгавар өгөх зэргээр цаашид хөгжүүлэлт хийх асуудлуудын тухай ярилцсан юм.

Уулзалтын бүх оролцогчид (МЭЕГ, ХААИС болон МҮМЭХ) нь хөдөө орон нутгийн малын эмч нарын чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ асар их байгаа бөгөөд энэхүү хэрэгцээг олж харж, Мерси Кор санаачилж болон МЭС-тай хамтран ажиллаж “Мал эмнэлгийн бизнес хөгжил” цахим сургалтыг амжилттай зохион байгуулж байгаад талархлаа илэрхийлсэн юм.

Хурлын үеэр МЭЕГ-ын зүгээс малын эмч нарын чадавхыг бэхжүүлэхэд ихээхэн анхаарч ажиллаж байгаа бөгөөд тус цахим сургалт нь үүнд хувь нэмрээ оруулж буй талархал илэрхийлээд, тус сургалтын МЭЕГ малын эмч нарыг чадавх бэхжүүлэх сургалтын төлөвлөгөөнд хэрхэн холбох тухай ярилцахаар дараа дараагийн уулзалтыг ХААИС-ын МЭС хийхээр товлосон юм.

Уулзалтын үеэр МЭС нь тус сургалтын тогтвортой явуулах, цаашлаад МҮМЭХ-той хамтран Малын эмч нарын үргэлжилсэн болон итгэмжлэлийн сургалтад энэхүү сургалтыг нэвтрүүлэн кредиттэй болгож баталгаажуулах тухай ярилцаж байгаа тухай мөн мэдэгдсэн юм.

Хичээлийн агуулга нь таны мэдлэг чадварыг дээшлүүлэхэд хэр хангалттай санагдсан бэ?



Хичээлийн практик жишээ бодит амьдралтай хэр холбоотой вэ?



Хичээлийн онол, практикийн харьцаа



Амжилтын түүх

ЗОХИОМОЛ ХЭЭЛТҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ СУМАНД НЭВТРҮҮЛСЭН НЬ



Түншлэгчийн нэр: Төгс Ген ХХК

Төслийн байршил: Сэлэнгэ аймгийн Хушаат, Сайхан сум

Хугацаа: 2020 оны 4 сар- 10 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Монгол улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн системд шилжсэнээр мал ах ахуйн үржлийн хөтөлбөрүүд, төрийн санхүүжилт бүхий тэжээл, хадлангийн хөтөлбөр үйл ажиллагаа ихээхэн хэмжээнд буурсан юм. Үүнээс үүдэн малын чанар, үр шим багасан, өндөр чанартай махны чиглэлийн үхрийн тоо толгой буурч, улмаар дотоод болон гадаадын зах зээл дээрх өсөн нэмэгдэж буй махны эрэлтийг хангах Монгол улсын боломж бололцоог хязгаарлаж иржээ.

Мал аж ахуйн зах зээлийн систем дэх эдгээр сорилтыг шийдэхийн тулд Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөр нь Төгс Ген ХХК-тай түншлэн ажиллаж, зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлэх тус компанийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн билээ. Зохиомол хээлтүүлэг нь сайн чанарын

бухын үр ашигладаг тул малчдад өөрийн малыг сайжруулах, хянах боломжийг бүрдүүлж өгдөг. Зохиомол хээлтүүлэг нь уламжлалт үржлийн аргатай харьцуулбал цаг хэмнэдэг, илүү үр дүнтэй бөгөөд үхэр болон үржлийн техникчид ч аюул осол багатай байдаг. Зохиомол хээлтүүлэг ашиглах нь үхрийн эрүүл мэнд, үр шимийг сайжруулан, улмаар зах зээлд гаргаж буй махны чанарыг нэмэгдүүлдэг орчин үеийн мал аж ахуйн шилдэг арга ажиллагаа хэмээн тооцогддог.

Төгс Ген ХХК нь 2005 онд үүсгэн байгуулагдсанаас хойш зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ үзүүлдэг цорын ганц үржлийн чиглэлийн аж ахуйн нэгж байв. Тиймээс Мерси Кор нь Төгс Ген компанитай хамтран “Өндөр чанартай зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний хүртээмжийн сайжруулах” зорилгыг боловсруулан гаргасан юм. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд хоёр үндсэн үр дүнг төлөвлөсөн нь (1) Төгс Ген компанийн зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний үйл ажиллагааны үр ашигтай байдлыг сайжруулах; (2) зохиомол хээлтүүлгийн талаар мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэн малчдын дунд зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний эрэлтийг өсгөх явдал байв.

Үр дүн 1: Зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний бүтээмж, үр ашиг сайжирсан

Дэд тэтгэлэгийн хүрээнд Төгс Ген нь хэд хэдэн төрлийн тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагааны хүчин чадлаа сайжруулан, улмаар үржлийн үйлчилгээнийхээ чанарыг сайжруулжээ. Үүнд үржлийн шинэ багажууд, ороо шалгах багаж, болон хээл шалгах хэт авианы төхөөрөмж зэрэг тоног төхөөрөмжийн худалдан авсан байна.

Төгс Ген мөн зохиомол хээлтүүлгийн үйл ажиллагаанд зориулан автомашин худалдан авч, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр тоноглон, явуулын үржлийн нэгж байдлаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Одоо Төгс Ген нь малчдаас ирсэн хүсэлтийн дагуу хурдан хүрч үйлчлэх боломжтой болсон тул малчид үржлийн үйлчилгээ авахын тулд хол явах, малаа туун очих шаардлагагүй болжээ. Түүнчлэн явуулын үржлийн нэгж нь газар зүйн хувьд ч илүү өргөн хүрээг хамарч, зэргэлдээх сумдаар явж төрөл бүрийн үүлдрийн үрээр хээлтүүлэг хийх боломжтой болжээ. Энэхүү төслийн үр дүнд Төгс Ген нь Хушаат суманд Герефорд үүлдрийн үрээр, Сайхан суманд Симменталь үрээр зохиомол хээлтүүлэг хийжээ.



Энэхүү төслийн өөр нэгэн чухал хэсэг нь Төгс Генийн үйлчилгээ үзүүлж буй бүс нутгийн малчдад сайжруулсан үржлийн үйлчилгээг тэгш, шударга хүргэх явдал байв. Компани нь эхлээд төсөл хэрэгжилтийн хугацаанд багадаа 20

малчин өрхөд хүрч ажиллахаар төлөвлөсөн ч малчдын зүгээс хүсэлт маш ихээр ирүүлсэн тул энэхүү зорилгоо давуулан биелүүлжээ. Төслийн үр дүнд нийтдээ 45

малчин өрхийн 341 толгой үхрийг зохиомлоор хээлтүүлсэн байна. Энэ нь өнгөрсөн жил дөнгөж 150 үхэрт зохиомол хээлтүүлэг хийж байсан үр дүнтэй харьцуулбал 127%-аар өндөр үзүүлэлт юм.

Энэхүү өсөлтийг хангахын тулд компани нь одоо байгаа нэг ажилтан дээрээ нэмж дахин 3 ажилтан авч ажиллуулжээ. Ийнхүү хүний нөөцийг нэмэгдүүлсэн нь нэг өдөрт зохиомол хээлтүүлэг хийх хүчин чадлыг хоёр дахин нэмж, өдөрт 15 үхэрт хийдэг байсан бол 30 хүртэл нэмэгдэж, Төгс Ген нь хоёр байрлалд буюу суманд нэгэн зэрэг ажиллах боломжтой болжээ.

Явуулын үржлийн нэгжтэй болсон, тоног төхөөрөмжийн хүчин чадлаа ихээхэн нэмэгдүүлсэн нь үйлчилгээний чанар, хурдыг мөн нэмэгдүүлжээ. Компанийн захирлын зүгээс “Бид өмнө нь ажиглалтын аргаар хээлтэгч малын орооны үеийг бүрэн тодорхойлж чаддаггүй байсан. Одоо зориулалтын ороо илрүүлэгч багажтай болсноор хээлтэгчийн ороог найдвартай тодорхойлж чаддаг болсон нь зохиомол хээлтүүлгийн хээл авалтын хувийг нэмэгдүүлж байна. Мөн үйлчилгээнийхээ чанарыг сайжруулж, генетикийн материалыг гэсгээх тусгай цахилгаан багаж ашиглаж байна.

Өмнө нь хийн зуух ашиглаж хөлдөөсөн үрээ 38 хэм болгон гэсгээдэг байсан. Тухайн ямар нэгэн байдлаар термометр буруу, алдаатай заах эсвэл ямар нэгэн байдлаар үр гэсгээх температур хэтэрсэн тохиодолд тухайн тун үр үр тогтоох чадваргүй болдог. Харин одоо иймэрхүү эрсдэл огт байхгүй болсон. Түүнчлэн өмнө нь гэсгээсэн үртэй ажиллахад хүндрэлтэй, нар, салхинаас хамгаалан жигд температурт байлгах ёстой учраас хувцас дотроо хийн, үнээ дээрээ аваачдаг байлаа.

Харин одоо гэсгээсэн тун үрээ температураа барьдаг зориулалтын цүнхэнд хялбар, аюулгүй зөөж хэрэглэх болсон. Мөн манай компани хэт авианы ЭХО төхөөрөмж ашиглаж эхэлсэн тул гараар бус багажаар хээл авсан эсэхийг нь шалган тогтоодог боллоо. Энэ нь 35-45 хоногийн дараа хээл авсан эсэхийг нь нарийн тогтоох боломж олгож байна. Өмнө нь хээл авалтыг гараар шалгадаг байсан учраас малчид зохиомол хээлтүүлгийн үр дүнд итгэдэггүй байсан бол одоо дэлгэц дээр шууд харах боломжтой болсон” хэмээн хэлж байв.

Компани нь хээл авалт өмнө нь 60%-тай байдаг байсныг 81.5% болгон амжилттай нэмэгдүүлжээ. Компанийн захирал нь энэхүү амжилт нь технологи сайжирснаас шууд холбож, ялангуяа ороо илрүүлэгч, хэт авианы багажтай болж, ороо идэвхижүүлэгч зэргийг ашиглах болсонтой холбоотой хэмээн үзэж байна. Хэт авианы оношилгооны тоног төхөөрөмжтэй болсон нь давуу тал болж, үржлийн ажилтнууд нь шуурхай шийдвэр гаргах, ямар нэгэн хүндрэл гарвал шуурхай арга хэмжээ авах боломжтой болжээ. Хэрэв хээл аваагүй бол дахин 72 цагт багтаан хээлтүүлэг хийж болдог байна. Хээл авалтыг хурдан хугацаанд илрүүлэх болсон нь хамгийн чухал үзүүлэлт юм.



Төслийн үр дүнд компани нь зохиомол хээлтүүлгийн үйлчилгээнээс олох орлогоо өмнөх жилтэй харьцуулбал 44% өсгөжээ. Компани нь төслийн эхний жилд үнийн стратегийг барьж, малчдад 30%-ийн хөнгөлөлттэй үнээр зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг санал болгож, тугалласны дараа нь төлбөрийг авч байв. Энэ нь малчдын хувьд тун таатай нөхцөл болсон бөгөөд зах зээл, хэрэглэгчийн тоог өсгөхөд чухал нөлөөлсөн юм. Төгс Ген ХХК-ийн зоотехникч “Өмнө нь бид хувь малчид биш голчлон фермүүдтэй ажиллаж байсан. Харин одоо бид малчид хамгийн гол томоохон хэрэглэгч болохыг ойлгосон. Малчид хавар төл авч, зохиомол хээлтүүлгээр гарсан төлийн ялгааг харсаны дараа ирэх жил зохиомол хээлтүүлгийн эрэлт ихээхэн нэмэгдэнэ хэмээн би найдаж байна. Жилээс жилд сайжруулсан, үр өгөөж сайтай мал сүрэгтэй байхын давуу талуудыг малчид олж харснаар мах, сүүнээс илүү өндөр орлого олох боломж тэдэнд нээгдэнэ” хэмээн хэлсэн юм.

Үр дүн 2: Зохиомол хээлтүүлгийн тухай мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн

Төслийн хугацаанд Төгс Ген зохиомол хээлтүүлгийн үйлчилгээний талаарх товхимол, сурталчилгааны видео бүтээн түгээж, энэ талаарх малчдын мэдлэг, мэдээллийг сайжруулжээ. Видеог орон нутгийн телевизээр нэвтрүүлж, компанийн сошиал медиа хуудас дээр байрлуулсан. Тус хуудсаар 1,700 гаруй хүмүүс зочлон, зохиомол хээлтүүлэг болон үүний үр дүнгийн талаарх сурталчилгааны хуудсыг үзжээ. Түүнчлэн компани нь үржлийн үйлчилгээний талаар 214 малчинд шууд сургалтыг хийжээ.

Үүнээс гадна хэд хэдэн фермер болон ойролцоох сумдын малчдаас дараагийн үржлийн улиралд зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ авах хүсэлт хүлээн авсан байна. Жишээ нь, фермерийн аж ахуй эрхэлдэг 5 өрх Сайхан суманд 100 хүртэл толгой малд үржлийн үйлчилгээг авахаар албан ёсоор ханджээ. Хушаат суманд гэхэд 10 малчин 30 үхэрт зохиомол хээлтүүлгийн үйлчилгээ авахаар болжээ. Хушаат болон Сайхан сумдаас гадна Төгс Ген нь зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Орхонтуул сумдад үзүүлж байна.

Төгс Ген компанийн захирал “Манай төсөл нь Монгол улсад маш өвөрмөц, онцлог төсөл болсон бөгөөд аймаг болон сумдаас хальсан үр дүн үзүүллээ. Бид шинжлэх ухааны аргаар шалгасан, хамгийн сайн чанарын үр ашигладаг учраас гарсан төл нь үр шим илүү өндөртэй байдаг. Үүнд эргэлзэх зүйл байхгүй. Малчид ч бидний үйлчилгээний чанарт сэтгэл ханамжтай байдаг нь үнэнд зохиомол хээлтүүлэг хийгдсэн, сайн чанарын төл гаргана гэдгийг сайн мэдэх болсонтой холбоотой. Дараа жил 2021 онд анхны төл хүлээн аваад малчид их баяртай байх болно. Бид ч гэсэн хийсэн ажлаараа, орчин үеийн зохиомол хээлтүүлгийн арга ажиллагааг ашиглан малын удмын санг сайжруулж байгаадаа бахархаж байна. Манай төсөл нь бусад үржил/зохиомол хээлтүүлгийн нэгжүүд, үхрийн фермүүдэд малын удмын санг сайжруулах, илүү үр шим сайтай малтай болоход нь үлгэр жишээ болно гэж итгэж байна” хэмээн өгүүлсэн байна.

Цаашдын үйл ажиллагаа

Мерси Корын “Орон нутгийн бизнес клиник” төслийн хүрээнд Төгс Ген нь Кинг Консалтинг ХХК-аас зөвлөх үйлчилгээ авч, түүний үр дүнд сошиал сүлжээ хуудас хөгжүүлэн, маркетингийн үйл ажиллагаагаа эхлүүлсэн юм. Компани мөн өөрийн маркетингийн төлөвлөгөө болон 5 жилийн бизнес төлөвлөгөөг сайжруулжээ.

Компанийн стратегийн төлөвлөгөөгөөр Төгс Ген нь зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг бог малд хийж үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байна. Энэхүү зорилтыг хангахын тулд компани нь бог малд зохиомол хээлтүүлэг хийх багаж, тоног төхөөрөмж худалдан аваад байна.

Бизнес төлөвлөгөөний дагуу компани нь ирэх 5 жилд 10 мянган малд зохиомол хээлтүүлэг хийх хүчин чадалтай болж, 30 салбар нээх юм. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд компани нь бусад үржлийн нэгжтэй хамтран цуврал арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Жишээ нь, тус компани үржлийн нэгжүүдийн бизнесийн сүлжээг бий болгоход түүчээлж, эрчимжсэн фермерийн аж ахуйг байгуулах сонирхол бүхий фермерүүдтэй хамтран ажиллана.

Компанийн удирдлага нь ирээдүйн бизнесийн өсөлтийг өөдрөгөөр харж, Монгол улсын өнцөг булан бүрээс олон зуун хүсэлт хүлээн авна хэмээн итгэж байна. Мал аж ахуй нь Монгол улсын эдийн засгийн хоёрдогч (уул уурхайн дараа) гол тулгуур учраас мал ахуйн удмын санг хөгжүүлэх зах зээлийн орон зай их бий хэмээн үзэж байна. Малын үүлдэрлэг байдал сайжирч, мал аж ахуйн салбарын бүтээмж нэмэгдсэнээр Монгол орон даяар үр шимээ хүртээнэ.



Амжилтын түүх
**ХУТАГ-ӨНДӨР
СУМЫН МАЛ
ҮРЖЛИЙН ТӨСӨЛ**

Түншлэгчийн нэр: Занаду Разорбак ХХК болон Хутаг-Өндөр сумын ЗДТГ

Төслийн байршил: Булган аймгийн Хутаг-Өндөр сум

Хугацаа: 2018 оны 4 сар- 2020 оны 11 сар

Төслийн мэдээлэл

Булган аймгийн Хутаг-Өндөр суманд хэрэгжсэн сумын үржлийн үхрийг сайжруулах төсөл нь Казахын Цагаан Толгойт (КЦТ) үүлдрийн үхэр өсгөн үржүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилготой. Энэхүү төслийг Мерси Корын хэрэгжүүлж буй мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, мал аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх, зах зээлийн мэдээллийн хүртээмжийг сайжруулах, эдийн засгийн төрөлжилтийн боломжуудыг бий болгох замаар хөдөө орон нутгийн иргэдийн чадавхыг сайжруулах, эдийн засгийн өсөлтийг хангах зорилго бүхий “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” (RCP) хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэв.

1970-аад онд ЗХУ-ын техникийн тусламжийн хүрээнд Герефорд үүлдэртэй эрлийзжүүлсэн, өндөр ашиг шим бүхий КЦТ үүлдрийн махны чиглэлийн үхрийг Казахстанас импортлон, улмаар нутгийн үүлдэртэй эрлийзжүүлэн нутагшуулсан юм. Өнөөдөр КЦТ үхрийг үндсэндээ Булган аймгийн хойд талын сумд, үүний дотор Хутаг-Өндөр суманд үржүүлж буй ч 1990-ээд онд Монгол улсын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо нурснаас хойш КЦТ үхрийн тоо толгой, сүргийн бүтээмж ихээр буураад байна. Тухайн үеийн улсын мал үржлийн аж ахуйнууд хаагдаж, бараг бүх малаа шууд малчдад хувьчилсан нь сүргийн удмын сан болон үр ашиг нь ихээхэн хэмжээгээр буурахад хүргэжээ.

КЦТ нь нутгийн Монгол үхрээс харьцангуй өндөр ашиг шимтэй үүлдэр юм. Жишээ нь нас гүйцсэн бух 500 кг хүрэх бол нутгийн үүлдрийн бух 380 кг татаж байна. Түүнчлэн дөнгөж төрсөн тугал нь нутгийн үүлдрээс 5-7 кг илүү жинтэй байдаг нь энэ үүлдрийн давуу талыг харуулж байгаа юм. Монголын төр засгаас гадна хувийн хэвшлийнхэн ч энэ үүлдрийн давуу талыг ойлгож, илүү сонирхох болсон. КЦТ үүлдрээр сүргийг сайжруулах нь малчдын орлогыг нэмэгдүүлж, экспортын боломжийг сайжруулна гэдэгт бүхий л талууд санал нэгтэй байна.

КЦТ үүлдрийн удмын санг хадгалах, хамгаалахад дэмжлэг үзүүлэхийн тулд Мерси Кор байгууллага нь Булган аймгийн Хутаг-Өндөр суманд төр, хувийн хэвшилтэй хамтран үхэр үржлийн хөтөлбөр хэрэгжүүлж байна. Мерси Кор нь Хутаг-Өндөр сумын ЗДТГ болон тус суманд үйл ажиллагаа явуулдаг 300 үхэр борддог аж ахуй бүхий Занаду Разорбак ХХК-тай энэхүү төслийг амжилттай хэрэгжүүллээ. Занаду нь нутгийн малчдаас тугал, бяруу худалдан авч, бордон таргалуулж, нядладаг. Улмаар тус аж ахуй нь чанартай махыг Улаанбаатар хотын дээд зэрэглэлийн ресторан, хүнсний дэлгүүрүүдэд нийлүүлдэг. Занаду Разорбак ХХК-ийн бордох үхрийн эрэлт нь сумын малчдын өсгөж буй үхэр сүргийн чанар, үр шим буурсан үетэй давхцаж байна. Тиймээс Занаду Разорбак, нутгийн захиргаа, Мерси Кор нь энэхүү боломжийг харж, Мерси Кор нь тухайн орон нутагт КЦТ үүлдрийн үхрийг үржүүлэх чиглэлийн жижиг хэмжээний төсөл хэрэгжүүлэхээр шийдсэн юм. Энэхүү үржлийн төсөл нь а) өндөр үр шимтэй үржлийн мал ашиглан нутгийн малчдын үхэр сүргийн чанарыг сайжруулах, б) зах зээлийн өндөр үнэлгээ бүхий КЦТ үүлдрийн үхэр өсгөхөд малчдыг дэмжих, болон в) үржлийн ажлын үр шимийг хүртэх малчид болон тэднээс үхэр худалдан авах Занаду хоорондын зах зээлийн холбоог бэхжүүлэх зорилготой.

Төслийг эхлүүлэхийн тулд Мерси Кор нь хөрш Сэлэнгэ аймагт махны чиглэлийн үхэр өсгөдөг Газар Агро ХХК-иас КЦТ үүлдрийн үржлийн 10 бух худалдан авсан. Хутаг-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй малын үржлийн технологи үйлчилгээний нэгж байхгүй тул Занаду Разорбак нь тухайн бүхыг өвлийн саруудад арчлан маллахаар зөвшөөрч, улмаар Занаду болон сумын ЗДТГ жил бүр үржлийн улиралд бух ашиглах мал өрхүүдийг хамтран тодорхойлж, нутгийн үүлдрийн үнээг хээлтүүлэх, үхэр сүргийн удмын санг сайжруулахаар ажиллаж байна.

Хамтын түншлэлээ албажуулахын тулд Мерси Кор нь Занаду Разорбак ХХК болон Хутаг-Өндөр сумын ЗДТГ-тай 2019 онд Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнд мониторинг хийх талуудын үүргийг тодорхойлсон. Түүнчлэн Санамж бичиг нь үржлийн хөтөлбөрөөс өгөх үр шимийг тодорхойлж, талууд хоорондын харилцан хүлээсэн үүрэг хариуцлага, зарчмуудыг тогтоосон. Санамж бичгийг 2020 оны 1-р сард шинэчилж Мерси Кортой тогтоосон түншлэлийг 2020 оны эцэс хүртэл сунгахын зэрэгцээ цаашид 2022 оныг хүртэл төсөл үргэлжилж Занаду болон орон нутаг хоорондоо хамтран ажиллах хүлээлтэй байгааг баталгаажуулсан. Шинэ Санамж бичиг нь үржлийн бүхыг нутгийн малчид ирэх гурван жилийн хугацаанд түрээслэн ашиглах, Занаду нь тухайн үржлийн малыг хариуцан, үржлийн үеэр ашиглах малчдыг тодорхойлоход нутгийн захиргаатай хамтран ажиллах талаар заасан. Малчин өрхүүдийг а) албан ёсоор хүсэлт гаргасан, болон б) Мерси Кор, Занаду болон сумын захиргаанаас гаргасан сонгон шалгаруулалтын шалгуур зэрэгт үндэслэн сонгоно.

Үндсэндээ Хутаг-Өндөр суманд үр дүнтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг үржлийн механизм бий болсон нь Занаду Разорбак ХХК, Мерси Кор болон сумын захиргаа хоорондын нягт хамтын ажиллагааны үр дүн юм. Хутаг-Өндөр сумын үржлийн үхрийг сайжруулах үржлийн төсөл нь хэд хэдэн нөлөө үзүүлсэн ба үүний дотор үржлийн үйл ажиллагааны чадавхыг сайжруулах, малчид үржлийн ажлын сайжруулсан арга ажиллагаанд суралцах зэрэг үр нөлөө багтахын зэрэгцээ үржлийн чиглэлийн бусад төслүүд ч үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх сургамжууд гарсан.

Үр дүн 1: Үржлийн үйл ажиллагааны чадавхыг сайжруулсан нь

Бух нэг бүрийн хээлтүүлэх чадвар нь бүх болон үнээний зохистой харьцаанаас хамаардаг. Энэхүү харьцаа нь үндсэндээ 1 бух 25-30 үнээ байдаг. Тиймээс жилд 10 бухны (нас бие гүйцсэн) үр төл 300 хүрэх боломжтой. Сүүлийн хоёр үржлийн хугацаанд 8 малчин бүхыг хариуцан авч, одоогоор нийт өндөр үр шимтэй удмын сан бүхий 354 тугал (2019 онд 4, 2020 онд 350) бойжиж буй бөгөөд 2021 оны 5-р сарын эцэс гэхэд дахин 350- 400-гаар нэмэгдэх хүлээлттэй байна. Занаду Разорбак ХХК-ийн Захирал Жереми Тиссен “үржлийн эхний жил бух залуу байсан учраас бид дөнгөж 4 тугал авсан, хээл авалт бидний хүлээлтээс маш бага байсан. Дараагийн жил хээл авалт нэмэгдэж одоо жилд 300- 350 тугал авч байна” хэмээн тайлбарлаж байна.

Үржлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, КЦТ үүлдрийн бүхыг малчдад түрээслэх ирэх гурван жилийн хугацаанд (2021 оны үржлийн хугацааг оруулаад) сайжруулсан үүлдрийн үхрийн тоог 0-700 хүртэл нэмэгдэнэ хэмээн тооцоолж байна. Энэ нь малчид сүргээ бүрэн сайжруулахын тулд 2-3 жил бух тавьдаг бөгөөд ижил төстэй үржлийн хөтөлбөрүүдэд үр дүн гаргах, мал сүргээ бодитоор сайжруулахын тулд олон жил шаардлагатайг харуулж байна. Төслийн хүрээнд 10 бух худалдан авч, малчдад ашиглуулах төдий мэт харагдавч гарах үр дүн нь маш өндөр байна. Төсөл нь мөн үхэр өсгөх малчдын сонирхлыг эргэн сэргээснээр дараагийн үржлийн

хугацаанд сайн чанарын бух ашиглах хүсэлтэй малчдын хүсэлт эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна.

Үржлийн үйл ажиллагааг сайжруулах энэхүү төслийн гол үр нөлөө нь бух түрээслүүлэх тогтолцоо/механизм бий болгосон, малчин өрхүүдийг сонгон шалгаруулах журмыг нэвтрүүлсэн явдал юм. Бух түрээслэх малчин өрхүүдийг ил тод, шударга, өрсөлдөөнт байдлаар сонгох зорилгоор дараах шалгуурыг баримтлан өрхүүдийг сонгон шалгаруулдаг. Үүнд:

- Хамгийн багадаа үржлийн 25-30 үнээтэй байх
- Вакцинжуулалт болон эрүүл мэндийн үйлчилгээг хариуцан хийлгэх
- Сумын үхэр сүргийн үүлдэр, чанарыг сайжруулах сонирхолтойгоо илтгэн харуулсан байх (жишээ нь малчдын бүлгийн гишүүн байх эсвэл Занаду компанийн арга ажиллагааны талаар мэддэг, ойлголттой байх),
- Хулгай, чоно зэрэг эрсдэлээс мал сүргийг хамгаалах үүргийг хүлээх, эрсдлийг бүрэн хариуцах
- Малын болон үржлийн ажлын бүртгэл хөтлөх.

Түүнчлэн сонгогдсон малчидтай хийсэн “Үүрэг хариуцлагын зөвшилцлийн бичиг баримт”-д тухайн малчин өрхүүд, Занаду Разорбак болон сумын захиргаа үржлийн хугацаанд ямар үүрэг, хариуцлага хүлээхийг тодорхой зааж өгсөн. Бух түрээслэж буй малчин өрх бүр үржлийн хугацаанд тухайн бухыг маллах, тэжээх, бусад эрсдэлээс хамгаалах үүрэг хүлээж, бух түрээсийн төлбөрт 200 мянган төгрөг төлөх ба уг түрээсийн төлбөр нь тухайн бухын өвлийн улирлын тэжээлд зарцуулагдана. Занаду Разорбак нь эм тариа, эрдэс бодис зэрэг бусад зардлыг гарган, эрүүл мэндийг нь хариуцна. Үүний зэрэгцээ сумын захиргаа нь техникийн туслалцаа үзүүлж, Хөдөө аж ахуйн тасаг нь хяналт тавихын зэрэгцээ үржлийн хээлтүүлэгчийн эрүүл мэндийн үйлчилгээг хариуцна.

Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, түрээсийн механизм бий болгосны үр дүнд бух түрээслүүлэх үйл явц нь тодорхой, ил тод болж, малчид ч сонгон шалгаруулалт, түрээс, хариуцлага, төлбөр зэрэг үйл явцын талаар сайн ойлголт мэдээлэлтэй болжээ. Энэхүү механизмын өөр нэгэн давуу тал нь цаашид КЦТ үүлдрийн бух түрээслэн ашиглах тэгш боломжийг бүх малчинд олгож байгаад оршино.

Мерси Корын ярилцлага хийсэн бух түрээслэгч малчин хэлэхдээ сонгон шалгаруулах шалгуур нь өөрийн мал сүргээ хариуцан, эрүүл мэндэд нь анхаарах эрмэлзэл, үүрэг хариуцлагыг нь нэмэгдүүлсэн хэмээн дурдаж байна. Тэрээр хэлэхдээ тухайн шалгуурууд нь хөрш амьдарч буй малчдад цаашид бух ашиглахын тулд малдаа анхаарах сэдлийг нь төрүүлсэн гэв. Өөрөөр хэлбэл түрээсийн үйл явц нь шууд сургалтаас илүүтэйгээр малчдын хандлага, сэтгэлгээ, үйл ажиллагаанд илүү эерэг нөлөөтэй байна.

Төсөл нь Монгол орны хөдөө орон нутгийн малчдын амьжиргааг сайжруулах чиглэлээр Мерси Корын зуучлан үүсгэсэн төр болон хувийн хэвшил хоорондын

шинэлэг түншлэлийн амжилттай жишээг илтгэн харуулж байна. Сумын захиргаа болон нутгийн иргэд нь бүс нутгийн үхрийн удмын санг сайжруулахад үржлийн чиглэлийн санаачилгыг дэмжихийн ач холбогдлыг ойлгосон. Сумын захиргаа нь өөрийн сумын КЦТ үүлдрийн үхрийн удмын санг сайжруулах зорилгыг тэргүүн эгнээнд тавьжээ. Энэ талаар Сумын Засаг даргын орлогч “Мерси Короос үзүүлсэн тусламж нь орхигдоод байсан үржлийн ажилд анхаарал хандуулах шаардлагатай байгааг санууллаа. Энэ нь мал аж ахуйн салбарт тулгараад буй асуудлыг шийдэх суурь юм. Одоо мал сүргийнхээ чанарыг сайжруулахад малчдад тохирох зохистой шийдэл олох гэж эргэлзэх, цаг зарцуулах шаардлагагүй болсон. Ямар нэгэн тодорхой шийдэлгүйгээр аймгийн ХАА-н бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх боломжгүй. Өнөөдөр цаасан дээрх хууль болон хэрэгжилтийн хооронд ихээхэн зөрүү байна. Энэхүү зөрүүг арилгах нь яаралтай шаардлагатй байгаа ч бидэнд төсөв хүрэлцээгүй. Мерси Корын уг төсөл үнэхээр цагаа олсон, чухал дэмжлэг болж, малчдын арга ажиллагаа, сүргийг сайжруулах шийдлийг бий болгосон. Иймэрхүү энгийн арга замаар малчдын орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болж, ирээдүйн эдийн засгийн тогтвортой байдлыг хангах нутгийн захиргааны хүсэл тэмүүллийг бий болгосон” хэмээн онцлон хэлж байв.

Түүнчлэн Занаду Разорбак ХХК-ийн амжилтад суурилан нутгийн захиргаанаас УИХ-аар баталсан “Шинэ Хөдөө” төслийн хүрээнд үржлийн чиглэлээр өөр нэгэн шинэ санаачилгыг хэрэгжүүлж эхэлжээ. Энэхүү төслийн хүрээнд Хутаг-Өндөр сумын захиргаа 2018-2020 онуудад нийт 33 КЦТ үүлдрийн бух хүлээн авсан байна. Өмнө нь туршигдсан малчин сонгон шалгаруулах туршлага, Мерси Кор болон Занаду Разорбак ХХК-тай хамтран ажиллаж байсан туршлага нь сумын захиргаанд тухайн 33 бухыг хариулах, ашиглах, зохион байгуулах чиглэлээр ажиллахад нь ихээхэн дэм болсон ба ялангуяа тухайн бухыг хариуцах малчдын үүрэг, хариуцлагыг тодорхойлоход ихээхэн түлхэц болжээ. Мөн сумын захиргаа нь сумын хэмжээнд үхэр өсгөх чиглэлээр арга хэмжээ авч буйг бусад сум, аймгуудад харуулах үүднээс олон унаа тээвэр зорчих замын дагуу голдуу нутагладаг малчдад бухыг хариуцуулан өгчээ. Энэ талаар сумын Засаг даргын орлогч “Бидний үржлийн чиглэлээр хийж буй ажил нь өндөр ашиг шимтэй үүлдрийн үхрийн тоог нэмэгдүүлж, үр ашиг багатай үхрийг ирэх жилүүдэд бүрэн сэлбэнэ гэж найдаж” байна хэмээн өгүүлсэн юм.

Засаг даргын орлогчийн хэлж буй төслөөс үзүүлсэн өөр нэгэн үр дүн нь төр болон хувийн хэвшлийн түншлэл сайжирсан явдал юм. Энэ талаар Засаг даргын орлогч “Энэхүү төсөл нь бидэнд төр, хувийн хэвшил болон олон улсын байгууллага хоорондын үр дүнтэй түншлэлийн хамгийн сайн загварыг харууллаа. Маш олон өөрчлөлт хийгдсэн. Малчид малын чанар нь тооноос чухал гэдгийг ойлгосон. Тэд мөн бэлчээрээ хайрлан хамгаалах үүргийг ухамсарлаж, малын тоо толгойг бууруулахын ач холбогдлыг ойлгож, олон тооны малаа цөөн тооны ч илүү өндөр үр ашигтай малаар сольж байна” хэмээн тэмдэглэн хэлэв.

Үр дүн 3: Малчид үржлийн ажлын арга ажиллагаагаа сайжруулсан нь

Хутаг-Өндөр сумын үржлийн үхрийг сайжруулах төсөл нь Занаду Разорбак ХХК-д нутгийн малчин өрхүүдтэй нягт хамтран ажиллах боломжийг нээжээ. Компанийн захирал болон сумын захиргааны төлөөлөл хамтдаа малчин өрхүүдээр хэд хэдэн удаа айлчилж уулзалт зохион байгуулж ажилласан байна. Энэ үеэр малчид мал маллагааны арга ажиллагааны талаар чухал мэдээлэл авч, сүргийн бүтцийг хэрхэн бүрдүүлэх, хэрхэн өндөр ашиг шим бүхий сүрэгтэй болох, малын чанарыг хэрхэн сайжруулах талаарх чухал мэдээллүүдийг авчээ. Занаду Разорбакын захирал Жереми Тиссен үржил, селекцийн хөтөлбөр ашиглан хэрхэн малын чанараа сайжруулж болох, тэр тусмаа заавал сайжруулсан үүлдэр бус харин нутгийн үүлдрийг ашиглан сайжруулах талаар мэдээлэл өгчээ.

Түүнчлэн Занаду Ракорбак болон сумын захиргаа нь гарсан тугалыг цаг тухайд нь бүртгэх, үхрийн бүртгэлжүүлэлтийг сайн хийхийн ач холбогдолыг таниулах ажлыг чухалчлан ажилласан байна. Сумын захиргаа болон Мерси Кортой хамтран Занаду Разорбак үхрийн аж ахуй болон үржлийн үйл ажиллагаа, үржлийн бүртгэл хөтөлх талаарх сургалтыг зохион байгуулсан. Үүний үр дүнд 60 малчин үржлийн ажлыг сайжруулахын үр ашиг, тугалуудыг сайтар бүртгэх нь ямар ач холбогдолтой, хэрхэн бүртгэх тухай ойлголт мэдээлэл авсан. Мал бүртгэлийн ажил нь малчдын хувьд үржлийн ажил, үйлчилгээг бүртгэх, удирдах, шинэ төрсөн тугалын удам зүй, үүлдрийг бүртгэхэд чухал үүрэгтэй. Үүний үр дүнд дэлгэрэнгүй, иж бүрэн бүртгэл бий болж, тухайн малын, ялангуяа үржлийн малын зах зээлийн үнийг тогтоох гол үзүүлэлт буюу цэвэр үүлдэр/эрлийз болохыг батлан харуулах гол нотолгоо болно.

Занаду Разорбакын захирал Жереми Тиссений хэлсэнчлэн “Сүүлийн гурван жилд малчид үржлийн ажлын үр шимийн талаарх ойлголт, мэдлэг маш их өөрчлөгдсөн. Одоо тэд шинэ гарч буй тугал, бяруу мэдэгдэхүйц сайжирч буйг харж байна. Малчид сайжруулсан үүлдрийн үхэр болон бусад нутгийн үүлдрийн үхрийн хоорондын бодит ялгааг тод харах болсон. Улмаар уг үржлийн төсөлд хамрагдах, үржлийн ажил үйлчилгээнд анхаарах нь нэмэгдсэн ” байна.

Өнгөрсөн 2 жилийн туршид бүх түрээслэн ашигласан нэг малчин “энэхүү үржлийн хөтөлбөр нь малчдад маш их тустай төсөл бөгөөд өмнө нь үхрийнхээ чанарыг сайжруулах гэхээр сайн чанарын бүх олоход хэцүү, орон нутагт маш их хомсдолтой, олсон ч гэсэн үнэ нь өндөр багадаа 4-5 сая төгрөг байсан. Харин одоо Занаду Разорбак орон нутагт энэ ажлыг хийх болсон тул 200,000 төгрөгөөр л бүх авч ашиглах боломжтой болсон. Тиймээс энэ нь бидэнд үхрийнхээ үүлдрийг сайжруулах маш их үр дүнтэй ховор боломж тохиолдсон.

Энэхүү үржлийн ажлын үр дүнд би 20 төл авсан ба 2021 оны хавар гэхэд 30 шинэ тугал төрнө. Төслөөр дамжуулан төрсөн тугалыг хэрхэн бүртгэх, тогтмол хэмжилт хэрхэн хийх талаар зөвлөгөө заавар авсан. Нутгийн үүлдрийн тугал нь ойролцоогоор 300,000 төгрөгөөр зарагддаг бол генетикийн хувьд илүү сайн нь 700,000-1,000,000 төгрөгөөр зарагддаг. Манай нэг бяруу одоо Монгол хясаалан

үхэртэй ижил жинтэй, ойролцоогоор 300 кг татаж байгаа. Миний хувьд малынхаа үр шимийг сайжруулж орлогоо нэмэгдүүлж буйдаа маш баяртай байгаа. Энэ нь амьжиргаагаа сайжруулахад маш их тус болж байна” гэж хэлж байна. Үржлийн хөтөлбөрт оролцсон малчид нь ийнхүү төслийн үр шимийг хүртэж байгаа нь тодорхой харагдаж байна.

Сургамжууд

Хутаг-Өндөр сумын Үржлийн төслийн хэрэгжилтийн үеэр хэд хэдэн чухал сургамжууд гарч ирсэн бөгөөд энэ чиглэлийн үйл ажиллагааг сонирхон эрхэлж буй бусад хэн бүхэн харгалзан үзэх нь зүйтэй. Үүнд:

- Үржлийн хөтөлбөрт урт хугацаа шаардагдана- Үржлийн хөтөлбөрөөс орон нутгийн мал сүрэгт үзүүлэх нөлөөлөл, үр дүн гарах хүртэл тодорхой хугацаа шаардагдана. Тиймээс хэрэгжүүлэх хугацаа нь хамгийн багадаа 5 жил байх ёстой. Анхны гарсан тугал нь бараг 4 жилийн дараа үржлийн насанд хүрнэ. Үржлийн ажлын үр дүн нь мал насанд хүрч, үржлийн эсвэл хэрэглээний хэмээн ангилалт хийсний дараа л тодорхой болно.
- Тодорхой төлөвлөлт, зохицуулалт чухал үүрэгтэй – Үржил нь тодорхой цаг хугацаатай, улирлын чанартай тул бүхий л оролцогч талууд нь төлөвлөлтөө сайн хийж тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэрэгтэй. Түүнчлэн мэргэжлийн багийн дэмжлэгтэйгээр байнгын бүртгэлийн үйл ажиллагаа, мониторингийн аяллуудыг сайн зохицуулж байх шаардлагатай. Сумын хувьд үржлийн чиглэлээр мэргэшсэн ажилтнууд байхгүй байсан нь гол бэрхшээл байв.
- Малчдад шинэ арга ажиллагааг эзэмшихэд нь тусгайлан зориулсан дэмжлэг үзүүлэх шаардлагатай – Үхрийн бүртгэлийн ажлыг малчид зохих ёсоор хийдэг болох хүртэл төсөл хэрэгжүүлэгчид болон нутгийн захиргаанд тодорхой хугацаа шаардагдсан. Мерси Кор нь шаардлагатай зааварчилгаа, сургалтаар хангасан ч бүртгэлийн ажил удаашралтай хийгдэж эсвэл тогтмол хийгдэхгүй байсан тул орон нутгийн оролцогч талуудын зүгээс байнгын хяналт хийх, зааварчилгаа өгөх шаардлага үүссэн. Тиймээс сумын захиргаа болон бусад орон нутгийн манлайлагч талуудын зүгээс тусгайлан дэмжлэгийг малчдад үзүүлэх замаар эдгээр арга ажиллагааг орон нутагт нэвтрүүлэн, нутагшуулах боломжтой.
- Төр болон хувийн хэвшлийн үр дүнтэй түншлэл чухал үүрэгтэй – Төр болон хувийн хэвшлийн байгууллагууд эрчимжсэн мал аж ахуйн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Мал аж ахуйн салбар дахь энэхүү түншлэлийг харгалзан сумын захиргаа нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй газар тариалангийн компаниудтай хамтран ажиллаж, тэднийг тэжээлийн ургамал тариалахад нь дэмжлэг үзүүлсэн. Нийт 1034 газрыг тэжээлийн ургамал тариалах зориулалтаар хуваарилсан. Түүнчлэн Монгол улсын Засгийн газар Монгол улсад КЦТ үүлдрийг сайжруулах, тоо толгойг нэмэгдүүлэх бодлого гаргах, удмын санг хамгаалах арга хэмжээг авах, мал үржлийн ажлыг удирдах зааварчилгаа боловсруулж, түүнийгээ үйлдвэрлэлийн системтэй холбож өгөхийг зөвлөмж болгож байна. Бүх нь генетикийн хувьд дээд тал нь 3 жилийн хугацаанд

хамгийн дээд хэмжээнд бүтээмжтэй байх тул шинэ бух худалдан авч байх шаардлагатай байдаг. Тиймээс үржлийн нэгжүүд үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжоор хангахын тулд Засгийн газрын зүгээс үржлийн ажилд дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Цаашдын ирээдүй

Дэлхий ертөнц хурдтай өөрчлөгдөн шинэчлэгдэж буй өнөө үед байгаль орчин болон бэлчээр хамгаалах чиглэлээр үр ашигтай дасан зохицох, өндөр чанартай цөөн тооны мал маллах, бүс нутагт зохицсон мал өсгөх шаардлагатай байна. Үржлийн ажлын чанарыг сайжруулах, малын ашиг шимийг нэмэгдүүлэх нь мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийн үндэс болно. Иймд Хутаг-Өндөр сумын ЗДТГ нь Занаду Разорбак ХХК-ийн үржлийн үйл ажиллагаатай хамтран ажиллаж, өндөр ашиг шимтэй үржлийн хээлтүүлэгч өсгөхөөр зорьж байна.

Энэхүү бодлогын хүрээнд Занаду Разорбак ХХК нь цаашид үржлийн ажлаа үргэлжлүүлээд зогсохгүй бизнесээ өргөжүүлж орон нутгийн зах зээлд сайн чанарын үржлийн бух нийлүүлэх хүсэл сонирхолтой болсон. Занаду Разорбакын захирал одоогийн үхэр сүргийн чанарыг сайжруулах зорилгоор өөрийн нөөц эх үүсвэрээр сайн чанарын бух худалдан авах төлөвлөгөөтэй байна. Компанийн захирах Жереми Тиссен “Манай компани одоо цэвэр эсвэл сайн чанарын эрлийз үүлдрийг худалдан авах эсвэл импортлох боломжийг харж байна.

Одоо малчид фермерүүд сайн чанарын үржлийн мал худалдан авах сонирхол өндөр байгаа учраас үржлийн ажил их эрэлттэй байна. Шинэ бух худалдан авахын тулд бид үржлийн үйлчилгээгээ өргөжүүлэх төлөвлөгөөг хэдийн гаргаад байна” хэмээн хэлж байна.

Энэхүү төсөл нь Занаду Разорбак болон малчдад үржлийн малын борлуулалтын зах зээлийн эрэлтийг харж, ойлгоход түлхэц болжээ. Ирээдүйд тэд өндөр чанартай тугал, бяруу, бух, үнээг үржлийн зорилгоор зарж борлуулдаг болно.



Амжилтын түүх

**КАЗАХЫН ЦАГААН
ТОЛГОЙТ ҮХРИЙН
ЧАНАР, ҮР ШИМ,
БОРЛУУЛАЛТЫГ
САЙЖРУУЛЖ,
МАЛ ҮРЖЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЧАДАВХИЙГ
БЭХЖҮҮЛЭХ НЬ**

Түншлэгчийн нэр: “Хушаатын хамтын хүч” хоршоо

Төслийн байршил: Сэлэнгэ аймгийн Хушаат сум

Хугацаа: 2017 оны 4 сар – 2020 оны 8 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Монголчууд нүүдлийн мал аж ахуйн олон мянган жилийн уламжлал, түүхтэй билээ. Олон жилийн туршид Монголчууд өөрийн нутаг орны эрс тэс уур амьсгалд зохицсон малын үүлдрийг бий болгож ирсэн. 20-р зууны эдийн засгийн хөгжил, аж үйлдвэржилттэй зэрэгцэн Монгол улсад өндөр үр ашиг шимт үхрийн хэрэгцээ өсчээ. Үүнээс үүдэн 1970-аад онд өндөр үр ашиг бүхий Казахын Цагаан Толгойт (КЦТ) болон Герефорд үүлдрийн үхрийг Казахстанас импортлон авчирч, нутгийн үүлдрийн үхэртэй эрлийзжүүлэв. Энэхүү үржлийн ажлын үр дүнд биеийн жин, ашиг шим өндөртэй Казах-Монгол эрлийз гарган авсан нь хүйтэн цаг уурт тэсвэртэй үүлдэр болон хөгжсөн байна. Энэ үүлдрийг сайжруулах үйл ажиллагаа төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үед үргэлжлэн явагдсан ба тухайн үед мал аж ахуйн салбарт төрийн зүгээс дэмжлэг үзүүлэн, үржлийн ажлын сайтар

төлөвлөн хэрэгжүүлж байв. Үүний дүнд 1954-1984 оны хооронд Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийг 10 аймгийн 40 гаруй фермд үржүүлж, 2 болон 3-р үеийн эрлийз үхрийн тоо толгой нь 60 мянга, цэвэр үүлдрийн³ үхрийн тоо толгой 20,000 хүрч байв. Энэ нь хуучин социализмын үед төрийн өмчит фермүүдийн хамтын ажиллагааны үр дүнд гарган авсан махны чиглэлийн анхны үхрийн үүлдэр байв.

Монгол улсын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг 1990 онд нуран унаснаар тухайн үеийн төрийн өмчит ферм, нэгдлүүдэд хэрэгжиж байсан махны чиглэлийн үхэр үржүүлэх хөтөлбөрүүд ч мөн зогссон юм. Тухайн ферм, нэгдлүүдийн эзэмшиж байсан мал, хөрөнгө, тухайлбал 30 жилийн туршид хийгдсэн үржил селекцийн ажлын үр дүнд гарган авсан Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрүүдийг хувьчлан, малчдад өгсөн байна. Өвлийн улиралд чанартай, шимт тэжээлээр хангах зорилгоор төрийн зүгээс хэрэгжүүлж байсан хадлан, тэжээлийн хөтөлбөр мөн л зогсож, өвлийн хүйтэн цагаар малын хорогдол ихээр гарах болжээ. Түүнчлэн мал эмнэлгийн үйлчилгээ ч буурсан юм. Өнөөдөр Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийн чанар, бүтээмж буурч, цэвэр үүлдрийн үхрийн тоо 2500 болтлоо буураад байна.

Давах туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд хөтөлбөрийн үйл ажиллагаа явуулах гол чиглэлийн нэг нь үржлийн ажлыг сайжруулах явдал болохын тодорхойлон, Мерси Корын зүгээс 2017 оны 4-р сарын 25-ны өдөр малын чанарыг сайжруулах, орон нутаг дахь үржлийн ажил, мал эмнэлгийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх чиглэлийн боломжит шийдлийг олж тогтоохын тулд мал аж ахуйн чиглэлийн тэргүүлэх мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Сэлэнгэ болон Булган аймгийн ХАА-н газрын дарга, их дээд сургуулиудын тэргүүлэх судлаачид, эрдэмтэд зэрэг нийт 17 мэргэжилтэн, Мерси Корын ажилтнууд дээрх уулзалтад оролцжээ.

Энэхүү уулзалтын үр дүнд Мерси Кор болон мал аж ахуйн мэргэжилтэнүүд нь зорилтот аймгуудын нэгийг сонгон авч, үржлийн чиглэлээр дэмжлэг үзүүлэхээр тохирон, Мерси Корын зүгээс орон нутгийн үржлийн нэгжтэй тасагтай хамтран ажиллах мэргэжилтэнүүдийн багийг авч ажиллуулсан.

2017 оны зун Мерси Корын баг Булган, Хэнтий аймгуудад ажиллан, үйл ажиллагааны ерөнхий цар хүрээнд судлан, үйл ажиллагаа явуулж буй үржлийн нэгжүүд дээр үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнд Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Хушаатын Баялаг үржлийн хоршоог сонгон авсан ба тус хоршооны мал үржлийн чиглэлийн түршлага, өөрийн үржлийн мэргэжилтэнтэй, хөтөлбөрийн түншлэлд шаардлагатай малтай зэрэг үзүүлэлт нь сонгогдох гол шалтгаан болов.

Мерси Кор нь “Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийн чанар, үр ашиг, борлуулалтыг сайжруулах, үржлийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх” зорилго бүхий төслийг боловсруулсан ба Казахын Цагаан Толгойт үүлдэр нь а) үр ашигтай

³ Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхэр нь Герефорд үүлдрийг нутгийн үүлдэр болон эрлийзтэй хольж эрлийзжүүлэн гарган авсан бөгөөд үндсэндээ 1 болон 2 дугаар үеийн эрлийзгийг буцаан эрлийзжүүлэн авсныг цэвэр үүлдэр хэмээн тооцдог.

махны чиглэлийн үхэр, б) уур амьсгалд сайн дасан зохицсон, в) бэлчээр болон эрчимжсэн хэлбэрээр түргэн хугацааны тарга хүч авдаг, г) хөтөлбөрийн зорилтот аймгуудад голлон өсгөдөг, д) Казахын Цагаан Толгойт үүлдрийн удмын санг сэргээх, бусад аймгуудад цөм сүрэг бүрдүүлэх хэрэгцээ их зэрэг шалтгаанаас “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөрийн гол сонголт болсон.



Мал үржлийн чиглэлээрх энэхүү санаачилгыг тэргүүлэн ажиллах зорилгоор Мерси Кор нь 2017 оны 5-р сард зөвлөх үйлчилгээний компани болох Хөгнө Мээж компанитай гэрээ байгуулсан. Тус компани нь үндэсний мэргэжлийн өндөр чадвартай мэргэжилтнүүдээс бүрдсэн багтай, тэр дундаа Казахын Цагаан Толгойт үүлдрийг анхлан гаргахад ажилласан эрдэмтдийн нэг О. Мэдэхгүй тус багийн тэргүүн байв. Хөгнө Мээж нь төслийн хэрэгжилтийн хугацаанд гурван гол чиг үүргийг гүйцэтгэсэн ба үүнд: 1) загвар үржлийн нэгж үүсгэн байгуулах ажлын удирдан явуулах; 2) малын эмч, хөдөө аж ахуйн чиглэлээр сургууль төгсөгчид, хувийн үржлийн нэгжийг мал аж ахуй, тэжээл, малын эрүүл мэндийн чиглэлээр сургах, болон 3) сүргийн удирдлагын арга техник, практик ашиглан Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийн үржлийн чадавхыг сайжруулах зэрэг байв.

Хөгнө Мээж нь 2017 оны 8-р сард Хушаат сумын үхэр сүргийн нас, жин, үр шим, орон нутгийн хоршоодын техникийн чадавх, бэлчээрийн нөхцөл байдал, тэжээл болон усан хангамж, үхэр хариулдаг малчдын хүн ам зүйн мэдээлэл (нас, хүйс, малын тоо толгойгоор нь задаргаатай) зэргийг тодорхойлох суурь судалгаа хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнд үндэслэн Мал аж ахуйн стратегийн баримт бичгийг (2017-2025) боловсруулан гаргаж, энэхүү баримт бичгийн Сэлэнгэ аймгийн Хушаат сумын ИТХ 2018 оны 2-р сард баталсан. Энэхүү стратеги төлөвлөгөө нь цаашдын махны чиглэлийн үхэр өсгөхөд дэмжлэг үзүүлэх тодорхой зорилтуудыг тусгасан ба үүнд;

- Хушаат сум болон хоршооны мал аж ахуйн нөөц эх үүсвэрийн тогтвортой ашиглалт, хөгжлийн өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох;
- Сэлэнгэ аймагт 2017 онд батлагдан хэрэгжиж буй “Эрчимжсэн мал аж ахуй” хөтөлбөрийн хүрээнд малын тоо толгойг бэлчээрийн даацтай уялдуулах замаар орчин үеийн махны чиглэлийн үхрийн аж ахуйн эдийн засгийн өсөлтийг дэмжсэн эрх зүйн орчныг бий болгох;
- Малын эрүүл мэндийн үйлчилгээг цаг тухайд нь хүргэх, малын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах замаар өндөр зэрэглэлийн махны чиглэлийн үхрийн эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх;
- Казахын Цагаан Толгойт үхрийг үржилд ашиглах боломжит орчныг бүрдүүлж, Хушаат сумын нийт үхэрт эзлэх хувийг багадаа 30%-д хүргэх;
- Малын үржлийн ажил, мал аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;
- Аймаг, сумын удирдлага, мэргэжлийн байгууллагууд, нутгийн иргэд зэрэг хамаарах бүхий л талуудын идэвхтэй оролцоог дэмжин урамшуулж, стратегийн хэрэгжилт дэх оролцоог хангах.

Энэхүү стратеги нь одоогийн хийж буй болон ирээдүйд хийгдэх үржлийн ажил, сумын хэмжээний үйл ажиллагааны үндэс суурийг бий болгож, төслийн дараагийн шат болох орон нутгийн хоршоотой хамтран мал аж ахуйн арга ажиллагаа, хоршооны бизнесийн чадавхыг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөхөд гол мэдээллийг ханган өгсөн. Энэхүү түншлэлийн гол зорилт нь а) үржлийн нэгжийн үйл ажиллагаа явуулах боломжийг нь бүрдүүлэх болон б) бус нутаг дахь мал аж ахуйн загварыг гаргах зорилтууд байсан. Сумын Мал аж ахуйн салбарын стратеги дээр үндэслэн Мерси Кор болон Хөгнө Мээж нь өндөр үр ашиг бүхий Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийн цөм сүрэг бий болгох ажлын удирдан гүйцэтгэж, мэдлэг олгох цуврал сургалтуудыг хийж, зардал хуваалцах замаар хоршоонд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Хөгнө Мээж болон Мерси Корын хамтран ажиллахаар сонгон авсан түншлэгч хоршоо нь үхрийн чиглэлээр дагнан ажилладаг Хушаатын Баялаг хоршоо байв. Тус хоршоог хүний нөөцийн чадавх (92 гишүүнтэй), техникийн мэдлэг (үржлийн 2 зоотехникчтэй) болон байршил (Дархан хот болон Сэлэнгэ аймаг хэмээн мал аж ахуйн хоёр зах зээлтэй ойр) зэрэг үзүүлэлтээр сонгон авсан. Гэвч Мерси Кор, Хөгнө Мээж болон хоршоо хоорондын нэг жилийн хамтын ажиллагааны дараагаар өдөр тутмын үйл ажиллагаанд хэд хэдэн асуудлууд үүсэн гарсан. Хоршооны гишүүдийн дийлэнх нь хоршооны үйл ажиллагаанд, ялангуяа үхэр үржүүлэх чиглэлийн ажилд оролцдоггүй байснаас үүдэн үйл ажиллагаа саарчээ. Түүнчлэн, Монгол улсын Хоршооны тухай хуульд “хоршооны дүрэмд хийгдэх нэмэлт өөрчлөлтийг гишүүдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцсон гишүүдийн үнэмлэхүй олонхын саналаар батална” (75%-иас дээш саналаар) хэмээн заасан байна.

Эдгээр болон бусад шаардлагуудаас үүдэн Мерси Кор нь Хушаатын Баялаг хоршоон дээр төсөлд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж, хүлээгдэж буй үр дүнг хангахад

хязгаарлалт тулгарав. Улмаар Мерси Корын зүгээс Хушаатын Баялаг хоршоотой хамтран ажиллахаа зогсоох шийдвэр гаргасан.

Мерси Кор нь тус хоршооны идэвхтэй цөөн тооны гишүүдтэй хамтран ажиллаж, махны чиглэлийн үхэр үржүүлэх чиглэлд төвлөрөн ажиллах Хушаатын Хамтын Хүч хоршоог шинээр 2018 онд байгуулсан. Энэхүү хоршоог үүсгэн байгуулах хурал 2018 оны 8-р сард зохион байгуулагдан, үүсгэн байгуулагч 17 хүн оролцон шинэ хоршоо байгуулахын дэмжин, хоршооны үйл ажиллагааны эхлэлийн хөрөнгө болох 2 сая төгрөгийн дүрмийн санг бүрдүүлжээ. Тус шинэ хоршоо нь махны чиглэлийн үхрийн үржлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг цорын ганц хоршоо, гишүүд нь нэг зорилгын доор нэгдсэн малчид, үржлийн мэргэжилтнүүд, бизнес эрхлэгчид (Хушаат сумын тариаланчид) байдгаар онцлог юм. Ийнхүү Хушаатын Хамтын Хүч үржлийн нэгж албан ёсоор байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Үр дүн 1: Үржлийн хоршооны чадавхийг бэхжүүлсэн нь

Хоршооны хөгжил нь хэд хэдэн үе шатны дагуу явагдсан ба үүнд а) хоршоо үүсгэн байгуулах, б) мал аж ахуй, үржлийн чиглэлээр чадавх бэхжүүлэх, в) махны үхэр үржүүлэх чиглэлээр бодлого хэрэгжүүлэх, г) үржлийн нэгжийн хувьд бизнесийн чадавхаа сайжруулах болон д) мэргэшсэн үржлийн нэгж болох зэрэг үе шатууд багтаж байна.

а) Хоршоо үүсгэн байгуулсан нь: Хоршооны хөгжлийн анхны үе шат нь үндсэндээ Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийн цөм сүрэг бүрдүүлэхэд голлон төвлөрсөн. Цөм сүрэг бүрдүүлэхийн тулд хоршоо нийт 63 толгой өндөр чанарын үнээ, 10 бухыг орон нутгаас худалдан авсан. Сүргийн удмын санг бий болгох, өндөр чанартай эрлийз үүлдэр гаргах зорилгоор хоршоо нь мөн цэвэр үүлдрийн 10 Герсфорд үхэр, 30 хээлтэй үнээ, 10 бухыг хөрш Зүүнбүрэн суманд үйл ажиллагаа явуулж буй Газар Агро компаниас худалдан авсан. Гурван жилийн дараа гэхэд хоршоо нь өөрийн сүрэгт буй Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийн тоог хоёр дахин нэмэгдүүлж 210 толгойд хүргэсэн. Хоршооны тэргүүний зүгээс удмын санг хамгаалах, өндөр ашиг шимтэй малын орон нутгийн хүртээмжийн нэмэгдүүлэхэд Мерси Корын зүгээс нутгийн иргэдийн сүргийн бүтцийг үр дүнтэйгээр эргэн сэргээхэд үзүүлсэн тусламжийн оруулсан хувь нэмрийг цохон тэмдэглэж байна. Санхүүжилт, техникийн зөвлөгөөгүйгээр цөм сүрэг нөхөн сэргээх нь хялбар хийгдэх ажил бус юм. Энэхүү үйл ажиллагаанд зарцуулсан нийт санхүүжилт нь 250 сая төгрөг болжээ. Нутгийн иргэдийн уламжлалт мэдлэг болон орчин үеийн шинжлэх ухааны ололт нь өндөр ашиг шимтэй үржлийн малыг нутгийн малчид болон гадаад эх үүсвэрээс цуглуулах замаар удмын санг нөхөн сэргээх суурь болжээ. Манай хамтран ажиллагч хоршоонд түлхэц болсон өөр нэгэн зүйл нь Хушаат сумыг Монгол улсын хэмжээнд махны чиглэлийн үхрийн фермерийн аж ахуйн хөгжлийн гол төв болгох зорилт юм. Энэхүү тэмүүлэл нь бидний хоршооны гишүүдийг өмнөө тавьсан алсын хараандаа хүрэхэд нь ихээхэн урам зориг өгсөн.

б) Мал аж ахуй, үржлийн чиглэлээр чадавх бэхжүүлсэн нь: Нөөц эх үүсвэрийн чадамжаа сайжруулж, цөм сүрэг бий болгосноос гадна Хушаатын Хамтын Хүч хоршооны Үржлийн нэгж нь хоршоон доторх дотоод хүчин чадал, нөөц эх үүсвэрийн чадамжийг бэхжүүлж эхэлсэн. Хөгнө Мээж нь сургалт, семинар хийж, мал маллагааны арга ажиллагаагаа сайжруулах нөөц эх үүсвэрээр хоршоог хангасан. Энэ чиглэлээр үзүүлсэн дэмжлэгт хоршооны хөгжил, малын биеийн үзүүлэлтийн үнэлгээ хийх, үржил селекц, нэмэлт тэжээл бэлтгэл, үржил зэрэг чиглэлд төвлөрсөн.

Хоршооны гишүүд болох үржлийн мэргэжилтнүүд, малчид, бизнес эрхлэгчид нь өөр өөрийн гэсэн үр чадвар, мэдлэгийг хоршоонд нэмэрлэж, үүний үр дүнд хоршоо байгуулах, хөгжүүлэх үйл ажиллагаагаа улам бэхжүүлж байна. Төгс Ген ХХК2 нь зохиомол хээлтүүлгийн чиглэлээр мэргэшсэн компани юм. Зохиомол хээлтүүлэг нь хялбар тээвэрлэх боломжтой сайн үүлдрийн бухын үрээр хангах, нутгийн малчид бух шаардлагагүйгээр мал хээлтүүлгийн ажил явуулах, чанарыг сайжруулах боломжийг олгодог. Төгс Ген нь хоршооны гишүүнчлэлтэй болсноор хоршооны үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлж, хоршоо өөрийн нийт үнээний 20%-д нь тус компаниар хээлтүүлэг хийлгэжээ. Хоршооны гишүүдийн тоонд мөн орон нутагт тариалан эрхэлдэг 6 аж ахуйн нэгж багтсан байна. Өндөр ашиг шимтэй махны чиглэлийн үхэр үржүүлэхэд тэжээлийн хангамж чухал ач холбогдолтой тул эдгээр аж ахуйн нэгж нь хоршооны мал аж ахуйн үйл ажиллагаанд чухал үүрэгтэй.

Энэхүү мал аж ахуйн нэмүү өртгийн сүлжээний олон чиглэлийн үр чадвартай хувь хүмүүсийн нэгдэл нь мал аж ахуй, тэр дундаа үхэр үржүүлэх чиглэлээрх иж бүрэн хандлагыг бий болгожээ. Иж бүрэн хандлага нь үржлийн ажлаас гадна бусад чиглэлээр ч хоршооны тогтвортой үйл ажиллагааг улам сайжруулах боломжтой юм. Хоршооны нэг гишүүний зүгээс “энэ нь бидний бизнесийг урт хугацаанд тогтвортой байлгана. Бидэнд байгаа нөөц нь цаашид ч орон нутгийн зах зээл дээрх тэжээлийн хангамжийг бүрдүүлнэ. Манай гишүүд тэжээл ханган нийлүүлэх чиглэлээр өөрийн үүрэг ролийг бэхжүүлж, зах зээлийн үнийг бусад малчид, фермерүүдэд хямд байлгана гэж найдаж байна” хэмээн хэлж байна.

в) Махны чиглэлийн үхрийн үржлийн бодлогын орчныг бий болгосон нь: Хоршооны гишүүдийн хувьд Хөгнө Мээжийн зүгээс үзүүлсэн хамгийн гол дэмжлэг нь хоршооны үйл ажиллагаанд ээлтэй зах зээл, бодлогын экосистемийг бүрдүүлж өгсөн явдал байв. Үүний тулд Хөгнө Мээж нь Хушаат сумын Мал аж ахуйн салбарын дунд хугацааны стратеги бодлогыг тодорхойлж, сумын Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр ажилласан байна. Энэхүү арга хэмжээ нь тус хоршооны үржлийн хөтөлбөр амжилтад хүрэх улс төр, нийгмийн орчныг бий болгожээ. Мал аж ахуйн салбарын дунд хугацааны стратеги нь сайн чанарын үхрийн махны эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглээд зогсохгүй мөн эдийн засгийн өсөлтийг хангах эрх зүйн орчныг хоршоодод зориулан бий болгох, орчин үеийн махны үхрийн үйлдвэрлэлийг эдийн засгийн хувьд үр ашигтай болгоход мөн чиглэсэн байна. Бодлогын орчин болон стратегийг бий болгосны үр дүнд орон нутгийн захиргааны 100 га газрыг хоршооны цөм сүргийн зун, намрын бэлчээрт, 150

га газрыг хадлан бэлтгэлд, 30 га газрыг тэжээл тариалахад зориулан хуваарилан өгснөөр хоршооны цөм сүргийн ч өвөл болон хаврын тэжээлийн хэрэгцээг хангах боломжийг бүрдүүлжээ. Бэлчээр ашиглалттай холбоотой журам байхгүй, газар ашиглах эрх нь зөрчилтэй байдгийн улмаас ийнхүү газар олгон хоршоо болон малчид хоорондын зөрчилдөөнөөс сэргийлжээ. Эдгээр үр ашиг бүхий бодлого хэрэгжиж, сумын захиргааны зүгээс хоршоог дэмжих арга хэмжээ авч эхэлсэн нь үржлийн нэгж болж ажиллах хоршооны боломжийг нэмэгдүүлж, сумын тэр ч байтугай Сэлэнгэ аймгийн нийт нийт сүргийн чанарыг сайжруулах боломжийг нээх болжээ.

г) Үржлийн нэгжийн бизнесийн чадавхыг хөгжүүлсэн нь: Иж бүрэн үйл ажиллагаа бүхий үржлийн нэгж, бизнесийн байгууллага болж ажиллахын тулд хоршоо нь өсөлтийн олон шатыг дамжсан. Үйл ажиллагааны хэрэгжилтийн хугацаанд хоршоо нь дотоод үйл явцаа хөгжүүлэх, журмаа гаргах зэргээр бизнесээ үр ашигтай, үр дүнтэй хийх үйл ажиллагааны чадавхаа хөгжүүлжээ. Хоршооны даргын хэлж буйгаар “анх хоршоо байгуулагдаж байсан үеийг эргэн харж, харьцуулбал багийн менежмент, бүтцэд ихээхэн өөрчлөлт гараад байна. Бизнесийн болон жил тутмын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хүн бүрийн үүрэг, хариуцлагыг тодорхойлон гаргасан нь бидэнд бүх гишүүдтэйгээр тодорхой холбоотой байж, чиглэл өгөх боломжийг хангаж, шийдвэр гаргах үйл явцыг хөнгөвчилсөн. Санхүүгийн баримт бүрдүүлэх, санхүүгийн тооцоо хийх чиглэлээр ихээхэн өөрчлөлт гарч, нягтлан бодох бүртгэл цахимжсан” байна.

Бизнесийн хөгжлөөс тухайн хоршоо дотор үзүүлсэн нөлөөллийн тоонд үхэр бүртгэлийн үйл явцыг батлан хэрэгжүүлсэн, бух түрээс, төлбөрийн схемийг бий болгосон, үхэр борлуулах журам гаргасан зэрэг багтаж байна. Үхэр бүртгэлийг гар утасны аппликейшн ашиглан сайжруулсан нь үхэр нэг бүрийг оруулсан зураг, ээмэгний дугаар, удмын сангийн холбоо хамаарлын мэдээлэл зэрэгт нь үндэслэн ялган таних боломжтой болжээ. Үржлийн хугацаанд бух түрээслэн ашиглахад баримтлах стандарт үйл явц, журмыг баталгаажуулах зорилгоор бух түрээслүүлэх механизм/схемийг боловсруулан гаргасан.

Одоо малчид сонгох шалгуур, түрээсийн гэрээ, төлбөр зэрэг нь үйлчлүүлэгч болон хоршооны гишүүдэд ил тод болжээ. Эцэст нь хэлэхэд өөрийн борлуулах (үржлийн болон үржлийн бус зориулалтаар) малаа сонгох, борлуулахад баримтлах журмыг тогтоожээ. Эдгээр өөрчлөлтүүд нь хоршоонд урт хугацааны төлөвлөлт хийх боломжийг олгосон талаар “эдгээр журам, заавар нь цаашдын борлуулалтаа төлөвлөх, 5 жилийн бизнесийн төлөвлөгөө боловсруулах боломжийг хангаж байна” хэмээн хоршооны дарга үзэж байна. Үүний үр дүнд хоршоо нь бизнесийн хөгжлийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд 5 жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулах чиглэлээр ажилласан. Тус төлөвлөгөө нь бизнесээ өргөжүүлэх, санхүү, маркетингийн бүрэлдэхүүн хэсэг болон бизнесийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгийг хамран хийгджээ. Хоршооны тэргүүний зүгээс “энэхүү төлөвлөгөө нь манай багийн хувьд бүс нутагтаа загвар үржлийн аж ахуй болох зорилгодоо хүрэх

тодорхой чиглэл бий болгосон. Одоо бид энэхүү төлөвлөгөөнийхөө дагуу урагшлах хэрэгтэй” хэмээн үзэж байна.

д) Үржлийн нэгж болсон нь: Төслийн нэгэн томоохон нөлөөлөл нь Хушаатын Хамтын Хүч хоршооны хөгжил, бизнесийн байгууллага хэлбэрээр ажиллах чадавх, мэргэшсэн үржлийн нэгжид тавигдах шаардлагыг хангах боломж бүрдсэн зэрэг байв. Нийт сүрэг нь эдийн засгийн хувьд ашигтай болоход Хушаатын Хамтын Хүч хоршоо нь техникийн эр чадвартай болж, орон нутгийн хэмжээнд бодлогын орчин бүрдэж ирснээр хоршоо нь бизнесийн үйл ажиллагааныхаа албан ёсны гэрчилгээ гардан авахаар ажиллаж байна. Түүнчлэн тус хоршоо нь дараах гол шаардлагуудыг хангах боломжтой болжээ: а) мэргэшсэн боловсрон хүчинтэй байх, б) өндөр чанартай үржлийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай нөөц эх үүсвэр/барилга байгууламжтай байх; болон в) мал а ахуй, бизнесийн чиглэлийн техникийн чадавх, жишээ нь урт хугацааны бизнес төлөвлөгөө зэрэг шаардлагыг хангах болжээ. Хэдий УИХ-аас Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийг 2017 онд батлан гаргасан ч ХХААХҮЯ-ны хувьд дагалдан гарах журмуудыг боловсруулах ажил удаашралтай явагдаж байна. Тиймээс Сэлэнгэ аймгийн ХАА-н газар нь 2020 оныг хүртэл үржлийн нэгжийн гэрчилгээ олгох боломжгүй байв. Хоршоо нь орон нутгийн сүргийг өндөр ашиг шимтэй мал, удмын сангийн үйлчилгээгээр хангаж буй ба үүнийг бухын үр ашиглан зохиомол хээлтүүлэг хийх, бух түрээсээр ашиглуулах, охин гунж, үнээг нутгийн иргэдэд түгээх зэрэг арга замаар хийж байна. Малчдын дунд ч сүргийн удмын санг сайжруулах, үүний тулд үйлчилгээ ханган нийлүүлэгчтэй хамтран ажиллахын ач холбогдлыг ойлгосон тул үржлийн үйлчилгээний эрэлт улам нэмэгдэж байна.

Үр дүн 2: Түншлэлийг сайжруулсан нь

Бизнесийн хэрэгцээг хангахын тулд өөрийн дотоод үйл ажиллагаа болон гишүүдийн чадавхыг сайжруулах үйл ажиллагааг эрэмбэлэн тэргүүн зэрэгт тавьжээ. Хоршооны гишүүд нь төсөл хэрэгжсэн гурван жилийн хугацаанд гарсан ахиц дэвшлийг тусган авчээ. Тэд, “Бид үйл ажиллагаа нь жигдэрсэн хоршоо болж амжилттай хөгжөөд байгаа ба дотоод болон гадаад зах зээлийн эрэлтийг хангахад бэлэн болсон” хэмээн хэлж байна. Төсөл нь бусад талууд, аж ахуйн нэгж байгууллагуудтай харилцаагаа өргөжүүлэх олон боломжуудыг нээж өгсний дотор олон төрлийн уулзалтууд, бага хурлууд, туршлага судлах аяллуудыг зохион байгуулжээ. Эдгээр арга хэмжээ нь хоршооны гишүүдэд олон талуудтай шууд уулзах, өөрийн бизнесийн үйл ажиллагааг танилцуулахад ихээхэн дэм болсон. Түүний дундаас нэгэн чухал арга хэмжээ нь ХХААХҮЯ-наас 2019 оны 3-р сард зохион байгуулсан Хоршооны үндэсний чуулган байсан. Энэ арга хэмжээний үеэр хоршоо нь өөрийн ололт амжилт, сургамж, сайн туршлагууд, цөм сүрэг, үржлийн чиглэлийн ажлын талаараа хоршоод, төрийн байгууллагууд, дотоод болон гадаадын ТББ-уудын 300 гаруй төлөөлөлд танилцуулжээ. Энэ нь тус хоршооны хувьд хэр ач холбогдолтой байсан талаар “үүнд оролцсон нь бидний хувьд түншлэл, хэлхээ холбоогоо Монгол

орон даяарх өргөжүүлэх боломжтой болсон ба олон тооны оролцогчид цаашид бидэнтэй хамтран ажиллах сонирхолтой буйгаа илэрхийлсэн” хэмээн хоршооны тэргүүн онцлон тэмдэглэсэн.

Түүнчлэн Казахстан улсад хийсэн туршлага судлах аялал нь (Мерси Корын дэмжлэггүй зохион байгуулагдсан) хоршооны гишүүдэд махны чиглэлийн үхэр үржүүлэх фермерийн аж ахуйн давуу талуудыг бүрэн ойлгоход нь тусалжээ. Туршлага судлах аялал нь эрчимжсэн мал аж ахуй гэж ямар байх талаарх өргөн хүрээний ойлголт бүрдүүлж хоршооны тэргүүн нь “Бид туршлага судлах аяллаас Монгол брэндийн махны чиглэлийн үхэртэй болох хүсэл эрмэлзэлтэй буцаж ирсэн. Одоо махны чиглэлийн үхрийн үржлийн хэрэгцээ өндөр болсон тул бид өөрийн бизнесийн харилцаагаа өргөжүүлэхэд төвлөрч ажиллана. Ялангуяа үржлийн залуу эр үхрийн зах зээлийн эрэлт нэмэгдэж байгаа” хэмээн өгүүлж байна. Хоршооны гишүүдийн зүгээс мөн Архангай, Хөвсгөл, Булган, Төв, Хэнтий, Дорнод, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь болон Баян-Өлгий аймгуудад өндөр ашиг шимтэй үхэр үржүүлэх үйл ажиллагаа эхэлсэн талаар хэлж байв.

Үржлийн нэгжийн үйл ажиллагаа явуулах хоршоо үүсгэн байгуулах анхан шатандаа тус хоршоо нь өөрийн цөм сүрэг бүрдүүлэхэд төвлөрөн ажилласан. Хоршооны гишүүдийн хэлж буйгаар “Бид нутагтаа өндөр чанартай үхрийн тоог нэмэгдүүлэхэд төвлөрсөн. Хоршооны цөм сүрэг нь зах зээлийн өндөр эрэлтийг хангах боломжгүй нь тодорхой байв. Тиймээс эхний удаад хоршоо нь өөрийн үржлийн бүхэн хэрэгцээг гишүүдээр эрэмбэлэн гаргаж, улмаар орон нутагтаа өндөр чанарын удмын сан бий болгохоор хичээж” байна.

Хоршоо нь улмаар нутгийн малчин иргэдэд, хоршооны гишүүн бус малчдад өндөр чанарыг үхрийн удмын санг сайжруулах боломж олгохын тулд үржлийн бус түрээслэх механизмд шилжжээ. Үүний үр дүнд нутгийн 9 малчин өрх түрээсийн гэрээ байгуулан хоршооноос бүх түрээслэн үржлийн ажилдаа ашигласан. Түрээсийн бүхий л үйл ажиллагааг маш сайн баримтжуулсан нь шударга, өрсөлдөөнт үйл явц явагдсан болохыг харуулав. Ил тод, шударга түрээсийн механизмыг бий болгосон нь хоршоо болон малчдын хоорондын харилцааг сайжруулж, итгэлцэл бий болгож, бизнесийн үйл ажиллагаа өсөхөд зориулсан орон нутгийн хүчирхэг түншлэлийг бий болгожээ.

Орон нутгийн захиргаатай тогтоосон түншлэл нь хоршооны гишүүд орон нутгийн хөгжлийн үйл ажиллагаанд гар бие оролцсоноор илүү бэхэжжээ. Хоршооны 5 гишүүн өөрийн сумаас ИТХ-д⁴ сонгогдсон байна. Ийнхүү хоршооны гишүүд шинэ албан тушаалд ажиллах болсноор өөрийн бизнесийн төлөвлөгөөг махны чиглэлийн брэндийг сурталчлан таниулах сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулах боломжтой болжээ. Хоршоо нь мөн Мерси Кортой хамтран ажиллах замаар өөрийн бизнесийн чадавх, зах зээлийн холбоосыг сайжруулсан ба хоршооны

⁴ Орон нутгийн ИТХ нь өөрийн нутаг дэвсгэрт хамаарах эдийн засаг, нийгэм, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргах эрхтэй байдаг.

хоёр гишүүн (Ар Сэвд Могойт ХХК болон Төгс Ген ХХК) мөн төсөл хэрэгжүүлэхээр сонгогдсон байна. Мерси Кортой тогтоосон түншлэлийн үр дүнд Ар Сэвд Могойт ХХК нь өөрийн тэжээл (вандуй, арвай, улаан буудай, овъёос) тариалалтаа хоёр дахин нэмэгдүүлж, дарш үйлдвэрлэх болж, худалдан авагчдын тоо нэмэгдэж, зөвхөн Хушаат сумын малчдаар тогтохгүй бусад аймаг, сумдаас тус компанийн даршийг худалдан авах болжээ. Төгс Ген ХХК нь зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг хөрш Сайхан суманд үзүүлэх болсон байна. Хушаат болон Сайхан сумдаас гадна Төгс Ген нь мөн зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Орхонтуул сумдад хүргэж байна. Эдгээр түншлэлүүд нь тус хоршоонд цаашдын түншлэлээ улам төрөлжүүлэн, шинэ санаачилгуудыг санхүүжүүлэх, санхүүжилтээс гарсан үр шимийг илтгэн харуулах боломжийг бий болгосон.

Үр дүн 3: Үржлийн чиглэлийн сайжруулсан арга ажиллагаанд малчид суралцсан нь

Хоршоо үүсгэн байгуулах болон хөгжлийн эхний шатанд Хөгнө Мээж нь үржлийн ажил, бэлчээрийн менежментийн чиглэлээр олон тооны сургалтыг Хушаат сумын малчин өрхүүд, хоршооны гишүүдэд хийсэн ба чадавх бэхжүүлэх чиглэлээр үзүүлсэн дэмждэг нь зөвхөн иргэдээр хязгаарлагдахгүй Сэлэнгэ аймгийн сумдын нийт 36 үржлийн мэргэжилтэн, малын эмч нарын мэргэжил, үр чадварыг мөн сайжруулжээ. Малчин бүрд зөвлөгөө өгсний дараа бүх малд бруцеллёзын шинжилгээ хийж, биеийн үзүүлэлтүүдэд хэмжилт хийжээ. Эдгээр үйл ажиллагаа нь малчдад өөрийн сүргийн чанарыг анхаарах, өндөр чанарын дарш болон ногоон тэжээлээр малаа тэжээж байх арга ажиллагааг нь сайжруулсан байна.

Хоршооны тэргүүний хэлсэнчлэн тус хоршоо нь өөрийн 5 жилийн бизнес төлөвлөгөөний хүрээнд маркетингийн төлөвлөгөөг боловсруулжээ. Тус төлөвлөгөөний дагуу хоршоо нь юуны өмнө бизнесийн маркетингийн үйл ажиллагаа болон чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Энэ зорилгоор хоршоо нь орон нутгийн ТВ, вебсайт, сонин зэрэг олон төрлийн суваг ашиглан нутгийн иргэдэд өөрийн бизнесийн талаарх мэдээллийг хүргэхээр төлөвлөжээ. Түүнчлэн үржлийн үйлчилгээ үзүүлж байхдаа малчдын хотонд техникийн зөвлөгөө өгч эхэлжээ. Энэ талаар нутгийн нэг малчин “Казахын Цагаан Толгойт нь хүйтэн цаг уур, Монгол орны нөхцөлд маш сайн зохицсон үүлдэр. Бэлчээрээр таргалуулах боломжтой. Мах, сүүний гарц нь нутгийн үүлдрээс хамаагүй өндөр. Өнгөрсөн жил бид хоршооноос цэвэр үүлдрийн хоёр Герефорд бух түрээслэн ашигласан. Хоршооноос бух түрээслэх нь малаа хээл авхуулахад бидэнд зардал хэмнэж ба бид малынхаа үүлдэр угсааг сайжруулах хүсэлтэй байсан ч цэвэр үүлдрийн бух худалдан авах мөнгө хүрдэггүй асуудлыг шийдэж өгсөн. Одоо харин бид хямд үнээр бух түрээслэх боломжтой болоод байна. Сайн чанартай үхэртэй болоход хийсэн энэ хөрөнгө оруулалтын өгөөж нь цаашид түрээсээр авснаас илүү өндөр байна” хэмээн хэлж байна. Сүүлийн гурван жилийн хугацаанд төсөл хэрэгжсэн, мөн зах зээлийн үнэ нэмэгдсэнээс үүдэн малчид үржлийн ажлаа сайжруулах зэрэг

шаардлага гарсан тул малчдын дунд бух түрээслэн ашиглах эрэлт ихээр нэмэгджээ. “Удмын сан сайжирснаар малаас олж буй орлого нэмэгдэж, малын тоо толгойгоо бууруулж, цөөн тооны өндөр чанартай малтай болоход тусална” хэмээн малчид хэлж байна.

Сургамжууд

Хушаат суманд хэрэгжүүлсэн үржлийн төсөл нь Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд хөтөлбөрийн хувьд хамгийн удаан хугацаанд хэрэгжсэн төсөл юм. Төслийн явцад хэд хэдэн сорилтууд тулгарч, сургамжууд үүсэн гарч, амжилтын хүчин зүйлс тогтоогдсон ба эдгээрийг төслийн баг болон Хамтын Хүч хоршоо тодорхойлон гаргасныг доор харууллаа.

- 1) Үржлийн чиглэлийн төсөлд урт хугацаа шаардлагатай – Үржлийн чиглэлээрх арга ажиллагааг сайжруулан нутгийн иргэдэд үр нөлөөг нь хүргэхийн тулд урт хугацааны төлөвлөлт шаардлагатай. Ажлын үр дүнг бодит, материаллаг болгохын тулд олон жил шаардагдахыг зэрэгцээ цаг хугацаа, нөөц эх үүсвэрийн ихээхэн хөрөнгө оруулалт шаардлагатай. Хушаатын Хамтын Хүч хоршооны хувьд нутгийн иргэдэд үржлийн үйлчилгээ үзүүлж эхлэх хүртэл гурван жилийн хугацаа шаардагдсан ба төслийн хугацаанд шинээр төрсөн тугалууд нь дөнгөж одоо л өсөж, насанд хүрч, үржлийн чиглэлийн үйлчилгээг хоршооноос авахын үр шимийг илтгэн харуулж эхлээд байна.
- 2) Хоршоотой ажиллахад онцлог сорилтууд тулгардаг – Хоршоо нь бусад төрлийн бизнесийн байгууллагатай харьцуулбал ялгаатай өөр бүтэцтэй байдаг бөгөөд гишүүдийн идэвхтэй оролцоог шаарддаг. Хушаатын Баялаг хоршоо 92 гишүүнтэй байсан зэрэг хэт олон тооны гишүүнтэй хоршоо нь үр дүн багатай бүтэц юм. Төслийн анхан шатны төлөвлөлт, хэрэгжилтийн явцад гишүүдийн дийлэнх олонхыг нэг доор цуглуулах, шийдвэр гаргахад ихээхэн хүндрэлтэй байсан. Хушаатын Баялаг хоршооноос Хушаатын Хамтын Хүч хоршоотой хамтран ажиллахаар шилжсэн нь мөн төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн. Төслийн анхны зорилт нь “Үржлийн нэгж болох Хушаатын Баялаг хоршооны чадавхыг бэхжүүлэх” явдал байсан ч явцын дунд түншлэгч тал өөрчлөгдөж, зорилт нь “Үржлийн шинэ нэгжийн чадавхыг сайжруулах” болсон. Нийт төсөл нь амжилттай хэрэгжсэн ч шинээр үүсгэн байгуулагдсан хоршоонд дэмжлэг үзүүлэх болсон энэхүү өөрчлөлт нь хэрэгжилтийн хугацаанд сөргөөр нөлөөлж, хамаарах бүхий л талуудын зүгээс уян хатан хандах шаардлагыг бий болгосон.
- 3) Гишүүдийн дундах олон талт байдал, хамтын алсын халаа нь амжилтын гол түлхүүр болдог – Хушаатын Хамтын Хүч хоршооны гарсан амжилт нь малчид, үржлийн мэргэжилтнүүд, орон нутгийн бизнес эрхлэгчид зэрэг олон төрлийн мэргэжил, мэдлэг бүхий талууд нэгдэж, орно нутгийн Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийн удмын сангийн хүртээмжийг сайжруулах хамтын зорилгын төлөө ажилласантай салшгүй холбоотой байсан. Гишүүн нэг бүр нь өөрийн өөрийн гэсэн хувь нэмрийг оруулсан ба үржлийн мэргэжилтэй гишүүн нь үржил, селекцийн ажилд тусалж, тэжээлийн бизнес эрхэлдэг гишүүн нь цөм

сүргийн тэжээлийг нийлүүлэх зэргээр хувь нэмрээ оруулсан. Энэ нь тус хоршоог сайн чанарын цөм сүрэг бүхий үр дүнтэй, иж бүрэн үржлийн нэгж болох боломжийг нээсэн.

- 4) Мал үржлийн чиглэлийн санаачилгад нөхцөл байдал тохируулсан, иж бүрэн стратеги чухал үүрэгтэй – Хөгнө Мээж болон хоршоо хоорондын мэргэжлийн харилцаа нь төслийн хэрэгжилтийг амжилтад хүргэх чухал ач холбогдолтой байсан. Үржлийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Хөгнө Мээж компанитай хамтран Мерси Корын боловсруулсан стратеги нь мал аж ахуйн арга ажиллагааг ахисан түвшинд хүргэн сайжруулах нь өндөр чанарын махны чиглэлийн үхрийн эрэлт, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хоршооны чадавхыг бэхжүүлэх, эдийн засгийн өсөлт авчрахуйц эрх зүйн орчныг бий болгох болон орчин үеийн махны үхэр үржүүлэх үйл ажиллагааг 2025 он гэхэд Хушаат сумын малчдын хувьд эдийн засгийн хувьд ашигтай болгох боломжтой болохыг харуулсан. Энэхүү стратеги нь одоогоор Хушаат сумын 300 малчин өрхөд л хэрэгжиж байгаа ч хэрэгжилтээс гарах нөлөөлөл, инновац, үр нөлөө нь хөрш зэргэлдээ сумдад ижил төрлийн стратеги хэрэгжүүлэх сэдэл болж, улмаар Монгол улсад нийцсэн, тогтвортой загварын дагуу мал үржлийн үйл ажиллагаа явуулж, Монгол орон даяарх малчин өрхүүдийн амьжиргааг сайжруулах боломж нээгдэнэ хэмээн үзэж байна.

Бизнесийн тогтвортой байдал болон ойрын ирээдүйн хэтийн төлөв

Хоршоо нь 2023 оны хүртэл өөрийн таван жилийн бизнесийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Энэхүү төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа нь Хушаат сумын малчдад мал үржлийн үйлчилгээг үзүүлэхэд төвлөрнө. Цаашид тус хоршоо нь Сэлэнгэ аймгийн зэргэлдээ сумдад болон бусад аймгуудад махны чиглэлийн үрэх өсгөж буй малчид, фермерүүдэд үйлчилгээгээ өргөжүүлэн хүргэнэ.

Өөрийн цаашдын төлөвлөгөөний талаар тус хоршооны дарга “одоо бидний ирэх жилүүдийн ирээдүй маш тодорхой болсон ба манай хоршоо нь Казахын Цагаан Толгойт үүлдрийн үхрийн тэргүүлэх ханган нийлүүлэгч болж, Монгол улсад махны чиглэлийн үхэр үржүүлэх салбарыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно. Түүнчлэн махны чиглэлийн үхэр үржүүлэх сонирхол бүхий бидний үржлийн бухны хэрэгцээ бусад малчид, бизнес эрхлэгчдийн дунд нэмэгдэнэ хэмээн бид найдаж байна” хэмээн өгүүлж байна. Хоршооны гишүүд бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн сайжруулж, үржлийн нэгж болж хамтран ажиллах юм.



Амжилтын түүх

МАЛЫН ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

Түншлэгчийн нэр: Мөнх Түрүү ХХК

Төслийн байршил: Булган аймгийн Тэшиг сум

Хугацаа: 2019 оны 8 сар – 2020 оны 6 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Мөнх Түрүү ХХК нь Булган аймгийн Тэшиг суманд 800 га газарт тариалан эрхэлдэг. Ургацыг дотоодын гурилын үйлдвэрүүдэд борлуулдаг байжээ. Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн хүрээнд тогтоосон түншлэлээр Мөнх Түрүү нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэн, малын тэжээл үйлдвэрлэх болсон. Мөнх Түрүү нь орон нутагт малын тэжээлийн хүртээмж хомс буйг олж харж, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр шийджээ. Мөнх Түрүү нь хэрэв малчид өөрийн малыг тэжээллэг сайтай тэжээлээр бүтэн жилийн туршид тэжээвэл мал нь эрүүл, тарга хүчтэй байж, улмаар мал, мах зарахад илүү их орлого болохыг орж харсан байна.

Энэхүү төслийн хүрээнд Мөнх Түрүү нь тэжээл боловсруулан үйлдвэрлэх цех байгуулсан нь тус суманд үйл ажиллагаа явуулж буй цорын ганц тэжээлийн үйлдвэр

болоод байна. Орон нутгаасаа тэжээл худалдан авах боломжтой болсноор малчдын зардал буурч, орон нутгийн нэмүү өртгийн сүлжээнд хамаарах зах зээлийн холбоос улам бэхэжжээ. Компанийн зүгээс Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран овьёос, арвай, царгас болон бусад үйлдвэрлэгчдээс худалдан авсан вандуй, улаан буудайн хаягдал, сүрэл зэргийг ашиглан тэжээлийн орц, найрлага боловсруулжээ. Малчдын дунд малын тэжээлийн ач холбогдлыг ойлгуулж, эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд компани нь мэдээлэл түгээх, үхэр тэжээх туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтын болон мэдлэг олгох видео түгээх, тэжээх аргачлал болон үйлдвэрлэлийн талаар гарын авлага тараах зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулжээ.

Төслийн зорилго нь “малчид бүтэн жилийн туршид малаа уурагт тэжээлээр тэжээдэг боломжтой болох” байв. Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд хоёр үндсэн үйл ажиллагааг төлөвлөсөн ба эдгээр нь (1) тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх; (2) тэжээлийн ач холбогдлын талаарх малчдын мэдлэгийг нэмэгдүүлсэн байх явдал юм.

Үр дүн 1: Малын тэжээл үйлдвэрлэл

Төслөөс гарсан үндсэн үр нөлөө нь хоёр талтай буюу: 1) орон нутгийн малчид малын тэжээлийг орон нутгаас хялбар худалдан авах боломжтой болсон, 2) компанийн үйл ажиллагаа нь орлогын шинэ эх үүсвэрийг бий болгож өгсөн явдал байлаа. Компани нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулсан эхний улиралд 80 тонн малын тэжээл үйлдвэрлэж нэмэлтээр 35 сая төгрөгийн нэмэлт орлого олжээ. Компанийн захирлын үзэж буйгаар үйлдвэрлэсэн тэжээлийн тонн бүрийн зах зээлийн үнэ нь улаан буудайн дайвар бүтээгдэхүүнээр хийсэн тэжээлийн үнээс 3 дахин өндөр, орон нутагт эрэлт өндөр буйгаас хамааран ашиг ихээр өссөн хэмээн үзэж байна. Түүнчлэн тэжээлийн цех ашиглалтад орсноор нутгийн иргэдэд шинээр ажлын байрыг бий болгожээ. Төсөл эхэлснээс хойш компани нь нийт долоон хүнийг байнгын ажилтнаар авсан байна. Эдгээр шинэ ажилтнууд нь компанид үргэлжлүүлэн ажиллаж, малын тэжээл үйлдвэрлэх, савлах болон борлуулалтад ажиллана.

Үхрийн хүчит багсармал тэжээлийн стандартын (MNS 5928:20085) дагуу Мөнх Түрүү нь Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран зургаан төрлийн тэжээлийн жор боловсруулан, түршжээ. Тэжээлийн дээжийг МХЕГ-т илгээн тэжээлийн орц, найрлага, чанар, илчлэгийн хэмжээг албан ёсоор баталгаажуулахаар хандсан байна.

Улмаар тус газраас Мөнх Түрүү компанийн 6 төрлийн тэжээлийн жорыг баталж, тухайн бүтээгдэхүүний хэмжээ, чанар, орц найрлага нь стандарт шаардлагад нийцсэн, хэрэглэхэд аюулгүй гэсэн дүгнэлт гаргажээ. МХЕГ-ын зүгээс тухайн бүтээгдэхүүн нь бусад ижил төрлийн бүтээгдэхүүнээс илүү чанартай болохыг

⁵ Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулиар зах зээлд санал болгож буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Стандарт, хэмжил зүйн үндэсний төвөөс гаргасан стандартад нийцсэн байх ёстой.

дурдсан нь тэжээлийн зах зээл тус компанид ихээхэн өрсөлдөх чадвартай гэдэг нь харагдаж байна. Ийнхүү тэжээлийн орц, найрлага батлагдсан нь цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг бий болгосон юм.

Хэдийгээр МХЕГ зургаан жорыг баталсан ч төсөл хэрэгжүүлэх хугацаанд Мөнх Түрүү нь гурван төрлийн тэжээл үйлдвэрлэх, түрших чиглэлээр ажилласан. Ингэх болсон үндэслэл нь эдгээр гурван бүтээгдэхүүний орц нь (улаан буудай, дайвар бүтээгдэхүүн, сүрэл) нь тэдний үндсэн бизнес болох улаан буудайн тариалангаас гарч байсантай холбоотой. Эхний гурван бүтээгдэхүүн амжилттай болсон нь борлуулалт болон орлого нэмэгдсэнээр нотлогдсон тул шаардлагатай бусад тэжээлээ үйлдвэрлэх, тариалах урам зориг оржээ. Тиймээс 2020 оны хавар компани нь 73 га газарт царгас, эрдэнэ шиш, вандуй болон овьёос тариалжээ. Энэ талаар компанийн захирал “Өөрийн нөөц эх үүсвэрээ ашиглан бүх 6 орцоо тариалснаар тэжээлийн үйлдвэрлэлийн зардлаа бууруулах боломжтой” хэмээн хэлж байна.

Үр дүн 2: Мал тэжээх арга ажиллагааны талаар малчдын мэдлэгийг нэмэгдүүлсэн

Малчдад хүрч ажиллахын тулд компани нь Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн болон орон нутгийн “Булган нэг үе клуб” ТББ-тай түншлэн ажилласан. Эдгээр гурван байгууллага хамтран, үхэр тэжээснээр нэмэгдэх амьдын жинг харьцуулан туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийсэн. Туршилтын хөтөлбөрийг Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд удирдан явуулж үхэр дээр газар дээр ажиглалт хийж, тэжээх цаг, тэжээлийн хэмжээ болон авч буй таргыг тэмдэглэн судалсан.

Хөтөлбөрийн хүрээнд үхрийн тэжээлийг 4 малчинд үнэ төлбөргүй өгч, нийт 45 хоногийн хугацаанд 20 үхрийг тусгайлан тэжээжээ. Туршилтын хугацаанд тухайн ажиглалтад авсан үхэрт өдөр бүр 5 кг тэжээлийг өвсний хамт өгч, ашиг шим болон жингийн нэмэгдлийг нь ажигласан байна. Тэжээлд орсон үхэр нэг бүр нь 50 кг жин нэмжээ. Хөтөлбөрт хамрагдсан нэг малчин эрүүл мэнд доройтсон, жин алдсан 5 үхрийг тусгайлан тэжээн түршсэн. Мөнх Түрүүгийн үйлдвэрлэсэн тэжээлийг ашиглаж эхэлснээс хойш 25 өдрийн дараа тухайн малчин нь “Манай үхэр хамаагүй сэргэж, бие биетэйгээ тоглож эхэлсэн. Эрүүл мэндийн хувьд хамаагүй сайжирсан” хэмээн хэлсэн.

Мөнх Түрүү нь Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн болон “Булган нэг үе клуб” ТББ-тай хамтран туршилтын төслийн үр дүнд үндэслэн малын тэжээл болон тэжээх аргачлалын талаар хэрэгцээнд тулгуурласан сургалт, маркетингийн материалыг боловсруулан гаргаж, малчдад тараасан. Эдгээр материалд нэг гарын авлага, нэг товхимол, 2 видео зэрэг багтсан ба бүгдийг нь хөдөө орон нутгийн иргэдэд зориулан бэлджээ. Анхны төлөвлөгөө нь “Булган нэг үе клуб” ТББ нь эдгээр материалыг ашиглан сургалтыг биечлэн явуулахаар төлөвлөсөн боловч байсан ч Ковид-19 цар тахлын халдварын хорио цээрийн дэглэмээс шалтгаалан сургалтын

хэлбэрийн цахимжуулж юидео бичлэгээр түгээсэн. Энэхүү малчдад мэдлэг олгох болон маркетингийн зориулалт бүхий тухайн материалуудыг Булган аймгийн зарим сумдаар тэр дундаа Тэшиг сумын малчдад тараажээ. Нийт 2500 товхимол, 600 гарын авлагыг түгээгээд байна.

Малчид эдгээр мэдээлэл ихээхэн үр дүнтэй болохыг илэрхийлж, малын тэжээлийн эрэлт болон сонирхол нь нэмэгджээ. Малчдын хувьд Мөнх Түрүүгийн тэжээлээр тэжээсэн мал нь 50 кг жин нэмсэн талаар дурдсан ба дан бэлчээрээр явж буй малын хувьд энэ хэмжээний жин нэмэхийн тулд бүтэн зун болдог бол эрчимтэй тэжээснээр 45 хоногт багтаан энэ хэмжээний жинг нэмж, малчдын хувьд илүү ашигтай байгааг дурдаж байв.

Үр дүн 3: Орон нутгийн тэжээлийн зах зээлийг хөгжүүлсэн

Бүс нутгийн зах зээлтэй холбогдохын тулд Мөнх Түрүү нь борлуулалтын гурван цэг байгуулсан ба нэг нь Булган аймгийн төвд, хоёр дахь нь Хутаг-Өндөр суманд, гурав дахь нь Тэшиг суманд ажиллаж байна. 12-р сард нийт 80 тонн тэжээл үйлдвэрлэн 3-р сар гэхэд бүрэн борлуулж дуусгажээ. Энэхүү амжилтыг өндөр эрэлттэй бүтээгдэхүүн борлуулж буйгаас гадна орон нутгаас авах боломжтой, хямд үнэтэй тэжээл үйлдвэрлэж буйтай нь холбон тайлбарлаж болно. Тэшиг сумын малчдын зүгээс тээврийн зардлаа бууруулан, орон нутгаас тэжээл худалдан авах боломжтой болсондоо талархалтай буйгаа илэрхийлж байна. Энэхүү сэтгэгдлийг зэргэлдээх 5 сумын малчид ч мөн илэрхийлж буй бөгөөд тэд аймгийн төв дээрх борлуулалтын цэгээс худалдан авч буй нь Мөнх Түрүү компанийн борлуулалтын тайлангаас харагдаж байна.

Түүнчлэн Мөнх Түрүү нь Мерси Корын бизнесийн зөвлөх үйлчилгээний компанитай хамтран ажиллаж бүтээгдэхүүний идэвхжүүлэлт, маркетингийн материалуудыг боловсруулсан. Зөвлөх компани нь мөн үйлдвэрлэлийн хүчин чадал, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор маркетингийн төлөвлөгөөг сайжруулахад тусалсан. Мөнх Түрүү нь малын тэжээл үйлдвэрлэлээ тусдаа салбар компани болгож ажиллуулахаар төлөвлөж байна.

Бизнесийн тогтвортой байдал болон ойрын ирээдүйн хэтийн төлөв

Мөнх Түрүүгийн хэрэгжүүлсэн төсөл нь малын ялгаатай хэрэгцээнд зориулж малын тэжээл үйлдвэрлэхийн үр ашиг, давуу талуудыг харуулсан юм. 2020 оны намар компани бух, хээлтэй үнээ болон шинэ тугалд тусгайлан зориулсан тэжээлийг өөрийн тариалдаг тэжээлийн ургамал ашиглан үйлдвэрлэхээр төлөвлөөд байна. Компани нь мөн тахиа, гахай болон адууны тэжээл бэлтгэхээр төлөвлөж байна. Ингэснээр борлуулалтаа нэмэгдүүлж, зах зээлийн эрэлтийг хангах боломжийг бүрдүүлэх юм.

Тэжээл үйлдвэрлэлийн бизнест орсон нь Мөнх Түрүү компанид цаашид зах зээлд сайн чанарын мах нийлүүлэх махны үхрийн фермерийн аж ахуй байгуулах сэдэл өгсөн бөгөөд ингэснээр бизнесийн ашиг орлогоо улам нэмэгдүүлнэ хэмээн тооцож байна. Үхрийн фермерийн үйл ажиллагаандаа тэд Занаду Разорбак ХХК-ийн арга зүйг баримтлан бордон таргалуулах ферм нээхээр төлөвлөж байна. 2021 онд 50-60 үнээтэй болж, улмаар цаашид 300-400 болтол нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Компани нь бордон таргалуулах байр барих зорилгоор сумаас 2 га газар аваад байна. Мөнх Түрүү нь тэмүүлэлтэй, шинэлэг инновац бүхий бизнес бөгөөд цаашид ч тасралтгүй өсөн дэмжиж, хөдөө аж ахуйн бизнесийн зах зээл дээр амжилт олно хэмээн найдаж байна.

хэрэглэх хэрэгтэй болон хэрхэн ашиглах талаар мэдээлэл өгснөөр Арт Маргад нь малчдын мал аж ахуйн үйл ажиллагааг илүү бүтээмжтэй болгоход дэмжлэг болжээ.



2020 онд Мерси Кор нь зорилтот аймгуудад “залуусын удирдан ажиллаж” буй бизнесийг дэмжихийг тэргүүлэх зорилтоо болгон, төслийн санал авах үйл явцыг эхлүүлжээ. Залуус нь нийт хүн амын 35%-ийг эзэлдэг ч мал аж ахуйн салбарт ажиллаж буй залуусын тоо тун цөөн байна. Тиймээс Мерси Кор нь малын тэжээл тариалах чиглэлээр залуусын эрхэлдэг бизнесийн байгууллага болох Арт Маргад компанитай

түншлэл тогтоон, “Малчид бүтэн жилийн туршид төрөл бүрийн тэжээлээр малаа тэжээдэг байх” хэмээх зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлэн ажиллажээ. Энэхүү зорилтоо хангахын тулд гурван үр дүнг тодорхойлсон ба эдгээр нь (1) үйл ажиллагаа, хөрөнгө болон үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх замаар бизнесийн өсөлтийг хангах; (2) Зах зээл, борлуулалт, бизнесийн арга ажиллагааг өргөжүүлэх замаар орлогоо нэмэгдүүлэх; (3) ногоон тэжээл ашиглах үр өгөөжийн талаар малчид, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх зэрэг байжээ.

Үр дүн 1: Үйлдвэрлэлийн барилга байгууламж, хүчин чадлаа сайжруулан бизнесээ өргөжүүлсэн

Мерси Кортой хамтран Арт Маргад нь тэжээл үйлдвэрлэх өөрийн бизнесийг амжилттай өргөжүүлж, тэжээлийн ургамал тариалах талбайгаа 10 га-гаас 30 га болгон 3 дахин нэмжээ. Үүний үр дүнд ургацын хэмжээ бараг 4 дахин нэмэгдэж 35 тонн байснаас 137 тонн болж нэмэгдсэн байна. Энэ талаар компанийн захирал “Энэхүү төсөл нь бид дангаараа ажиллаад хүрэх боломжгүй байсан үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх хэмжээний боломжийг бидэнд бүрдүүлж өгсөн. Шинэлэг шийдэл ашиглан бизнесийн үйл ажиллагааг ангилан үзэж, зах зээл дээрх байр суурийг нь ашигласан бизнесийн загварыг санал болгон хэрэгжүүлсэн” хэмээн хэлж байв.

Залуусын удирдан ажиллаж буй бизнесийн хувьд компани нь инновацад нээлттэй хандаж, шинэ зүйлсийг туршин үзэж байна. Компани нь царгас, буудай, арвай тариалах туршилт хийжээ. Өмнө нь тус компани нь овъёос болон гурвалжин будаа тариалах чиглэлээр туршлага хуримтлуулсан байв. Харин царгасыг Монгол улсад тэр бүр тариалдаггүй бөгөөд анхлан тариалахын тулд 2 жилийн хугацаа зарцуулсан нь энэхүү олон наст ургамлыг уургийн агууламж өндөртэй, үнэ цэн бүхий бүтээгдэхүүн болгожээ. Шинэ төрлийн ургамал тариалах болсон тус компанийг зах зээлд холимог ногоон тэжээл гаргах боломжийг нээжээ (өмнө үйлдвэрлэн нийлүүлж байсан овъёосон ногоон тэжээлээс гадна). Компани нь энэ төрлийн ногоон тэжээл тариалж байсан туршлага байгаагүй тул 8800 боодол овъёос, холимог тэжээл

Амжилтын түүх

НОГООН ТЭЖЭЭЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

Түншлэгчийн нэр: Арт Маргад ХХК

Төслийн байршил: Хэнтий аймгийн Хэрлэн сум

Хугацаа: 2020 оны 4 сар- 10 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Арт Маргад ХХК нь Хэнтий аймгийн Хэрлэн суманд 200 га тариалангийн газар бүхий хөдөө аж ахуйн компани юм. 2017 оноос хойш Арт Маргад нь малын тэжээл бэлтгэн, нутгийн малчид, фермерүүдэд нийлүүлж байна. Хэрлэн сумын хэмжээнд малын шахмал хүчит тэжээл үйлдвэрлэдэг маш цөөхөн тооны үйлдвэрлэгч байдаг.⁶ Арт Маргад нь Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөртэй түншлэн ажиллаж, гурван төрлийн шахмал тэжээл, овъёос, царгас болон холимог (овъёос, буудай, арвай, гурвалжин будаа) тэжээл үйлдвэрлэн зах зээл дээрх энэхүү хомсдолыг шийдэхээр ажиллаж байна. Энэ төрлийн тэжээл нь малын тэжээллэг хэрэгцээг бүрэн хангаж, жин нэмж, эрүүл мэндийг сайжруулдаг. Түүнчлэн төсөл нь тэжээлийн үр өгөөжийн талаарх малчид, фермерүүдийн мэдлэгийг сайжруулахад төвлөрөн ажилласан. Малчидтай холбогдож, нэмэлт тэжээлийг яагаад

үйлдвэрлэхээр төлөвлөж байв. Гэсэн ч компани энэхүү зорилтоо давуулан биелүүлж 5482 боодол овъёос бүхий тэжээл үйлдвэрлэсэн нь нэг мянгаас 2986 хүртэл гурав дахин нэмэгдэж, мөн шинээр 2496 ширхэг холимог тэжээл үйлдвэрлэжээ. Ийнхүү ногоон тэжээлийн үйлдвэрлэл нэмэгдсэнийг Хэнтий аймагт хур бороо их орж, ургац сайн байсантай холбон тайлбарлаж болно. Хоёрдугаарт төсөл эхлэхээс өмнө компанид шаардлагатай тоног төхөөрөмж байгаагүй тул зорилтоо өөрийн боломжийнхоо хүрээнд дэвшүүлсэн хэмээн үзэж болно. Гэсэн ч шинээр худалдан авсан тоног төхөөрөмж нь бүтээмжийг сайжруулж, үйлдвэрлэлийн түвшнийг хүлээж байснаас илүү өндөр түвшинд хүргэжээ.

Энэхүү төслөөр дамжуулан Арт Маргад нь шинэ төрлийн тэжээлийн ургамал тариалан, тэжээлийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх туршилт хийжээ. Компани нь холимог ногоон тэжээлдээ царгас ашиглахаар анх төлөвлөсөн ч царгас тариалсан цагаас ургац авах хүртэл хоёр жил шаардлагатай байжээ. Царгас нь 10 хүртэл жилийн настай олон наст ургамал бөгөөд олон жил ургац өгдгөөрөө өндөр өгөөжтэй хөрөнгө оруулалт болдог ч өгөөжөө өгч эхлэхэд хугацаа шаарддаг онцлогтой юм.

Энэхүү авсан “сургамжийн” талаар компанийн захирал “Хавар анх царгас тариалахад надад энэ талаар мэдээлэл маш бага байсан тул намар нь ургац авна гэж хүлээж байсан. Сүүлд нь тарьсан эхний жилдээ ургац авах боломжгүй болохыг мэдсэн, учир нь эхний жил үндсээ хөрсөндөө гүн суулгаж, дараа жилээс нь хураадаг болохыг мэдсэн. Энэ нь надад сургамж болсон бөгөөд одоо шинэ төрлийн ургамал тариалахын өмнө хөдөө аж ахуйн мэргэжилтэн эсвэл туршлагатай фермерээс зөвлөгөө авах шаардлагатайг ойлгож авсан. Залуу, шинэ тариаланч болохоор би ургамлын талаар их зүйлд суралцах, өөр өөр арга зүйг мэдэх шаардлагатай. Тэмдэглэн хэлэх нэг зүйл маань энэ төслөөс өмнө манай компани үндсэндээ хүнсний ногоо тариалж байсан явдал. Гэхдээ тэжээлийн ургамал тариалах нь илүү ашигтай болохыг олж мэдсэн ч үүнд санхүүгийн эх үүсвэр, хөдөлмөр/ажилчдын зардал шаардлагатай. Гэхдээ зах зээлийн эрэлт болон үнэ нь хүнсний ногооноос өндөр, тэжээлийг хадгалахад ч хялбар байсан. Одоо бид хүнсний ногооны тариалангаа төрөлжүүлэх зөв замд орсон гэж бодож байгаа. Энэхүү төслөөс би шинэ техникийн болон бизнесийн туршлага олж авсандаа баяртай байна” хэмээн хэлж байна.

Мерси Кортой тогтоосон түншлэлээр дамжуулан Арт Маргад нь шинэ тоног төхөөрөмж худалдан авсны тоонд хөрс тэгшлэгч, үрлэгч, хаман боогч зэрэг багтжээ. Сайжруулсан тоног төхөөрөмж, машин механизмтай болсноор компани нь өөрийн бүтээмжийг сайжруулахын зэрэгцээ тоног төхөөрөмжөө түрээслүүлэх байдлаар илүү орлого олох болжээ. Өмнө нь компани нь нэг л трактортой, бусад тоног төхөөрөмжөө түрээсээр ашиглаж байв. Түрээсийн төлбөр нь нэг тариалалтын хугацаанд л гэхэд 1 сая гаруй төгрөг байсан ба түрээслэхийн тулд их цаг зарцуулдаг байсан нь ургацын чанарт сөргөөр нөлөөлдөг байжээ. Тоног төхөөрөмж хомс байх нь компанийн бизнесийн өсөлтөд тохиож байсан нэг том саад тотгор байв. “Заримдаа ажил явагдаж байх үед түрээсээр авсан тоног төхөөрөмж эвдрэх тохиолдол гарч байсан. Бид үндсэндээ 10 га газраас ургац хураахад нийт 4 өдөр

зарцуулдаг. Харин энэ жил бид 30 га газар дээр 4 өдөр зарцуулсан. Сайжруулсан тоног төхөөрөмжтэй болсон нь түрээсийн төлбөр, ажилчдын цалин, цаг хугацааг ихээр хэмнэж буй. Шинэ тоног төхөөрөмж мөн эвдрэл багатай” хэмээн компанийн захирал хэлж байна.



Компани нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхийн хэрээр ажиллах хүчин нь 5 байснаас 10 болж нэмэгдсэн. Ажилчид нь бизнесийн гол хөдөлгөгч тул хүний нөөцөө дэмжих стратеги хэрэгжүүлэхийн ач холбогдлыг компани ойлгожээ. Үүний хүрээнд компани нь Мерси Корын “Орон нутгийн бизнес клиник” төслийн хүрээнд Кинг Консалтинг ХХК-тай хамтран ажиллаж, ажилчдынхаа хөдөлмөрийн гэрээг шинэчлэх, урамшуулал, ажилчдаа хадгалж үлдээх чиглэлээр хөдөлмөрийн дотоод журмаа сайжруулах зэрэг арга хэмжээг авсан. Үүний үр дүнд компани нь өөрийн бизнесийн журам дүрэм болон баримт бичгүүдийн бүрдлийг бүрэн хэмжээнд сайжруулжээ. Ажилчидтайгаар албан ёсны гэрээ байгуулж, хоёр талын хүлээх үүрэг, хариуцлагыг тусгахын зэрэгцээ ажлын болон амралтын цагийг харилцан тохиролцох замаар ажилчдынхаа ажиллах хүсэл, итгэлийг бүрдүүлжээ.

Тус компанийн нэгж ажилтан “Би 4-р сараас хойш албан ёсны хөдөлмөрийн гэрээтэйгээр Арт Маргад компанид ажиллаж байна. Байнгын ажилтай болж, амьдрал ахуйгаа дээшлүүлэх боломжтой болсондоо би баяртай байгаа. Ургац хураалтын үеэр шинэ машин, техниктэй болсон байсан тул бүтээмж сайтай, ажлыг маань маш их хөнгөвчилж өгсөн” хэмээн ярьж байна.

Компани нь зөвхөн хүний нөөцийн бодлогоо сайжруулаад зогсохгүй нягтлан бодох бүртгэл, бизнес төлөвлөлт, маркетинг зэргээ зөвлөх үйлчилгээний хүрээнд сайжруулжээ. Компани нь хэрхэн өөрийн бараа, бүтээгдэхүүнээ сурталчлах, борлуулах хөтөч болсон бизнесийн болон маркетингийн төлөвлөгөөг боловсруулан гаргасан. Түүнчлэн Арт Маргад нь өөрийн сошиал сүлжээний хуудастай болж, сурталчилгааны товхимол боловсруулан хэвлүүлжээ.

Үр дүн 2: Зах зээлээ өргөжүүлэн орлогоо нэмэгдүүлсэн



Өөрийн бизнесийг зах зээлд гаргах, хэрэглэгчдийнхээ тоог нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний эрэлтийг өсгөхийн тулд компани нь хэд хэдэн алхмыг хийжээ. Эдгээр санаачилгын нэг нь эмзэг бүлэгт хамаарах

өрхийн залуу малчдад 10%-ийн хямдрал санал болгожээ. Нийт 16 залуу малчид 1300 боодол тэжээлийг 10%-ийн хямдралтай худалдан авсан. Ийнхүү борлуулалтын үнийг буулгасан нь олон малчдын анхаарлыг татаж, богино хугацаанд борлуулалтыг нэмэгдүүлжээ.

Мөн Арт Маргад нь өөрийн болон зэргэлдээ Хэрлэн, Мөрөн, Баянхутаг, Баян-Овоо зэрэг сумдын зах зээл дээрх малын тэжээлийн нийлүүлэлт, олдцын талаас нь зах зээлийн судалгаа хийсэн. Энэхүү судалгааны дүнд эдгээр бүх суманд тэжээллэг чанар өндөр, малын тэжээлийн хэрэгцээ их буйг тогтоосон. Тухайн сумдын малчдад хүрэхийн тулд компани нь сошиал медиа хуудас нээж, бизнесийн тухай болон өөрийн санал болгож буй тэжээлийн талаарх мэдээллийг түгээсэн. Энэ нь малчдад хүрч ажиллах үр ашигтай, зардал багатай стратеги байж, тэжээл худалдан авах сонирхол малчдын дунд ихээхэн өсөхөд хүргэсэн байна.

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш компани нь зах зээлийн холбоосыг маш амжилттай бүрдүүлжээ. Байнга худалдан авдаг хүмүүсийн тоо 11 байсан бол 40 хүрч нэмэгдсэн. 2 сарын дотор бүх тэжээлээ борлуулж дуусгасан ч малчдын зүгээс малын тэжээл байгаа эсэхийг үргэлжлүүлэн асуусаар байжээ. Төслийн үр дүнд компани нь өөрийн орлогыг өнгөрсөн жилтэй харьцуулбал гурав дахин нэмэгдүүлжээ. Үүнийг Арт Маргадын хэрэгжүүлсэн хямд, тогтвортой үнийн стратегитай холбон тайлбарлаж болно.

Мөн компани нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сүүний 2 фермтэй гэрээ байгуулан, цаашид өөрийн үйлдвэрлэсэн тэжээлийг байнга ханган нийлүүлэхээр болсон. Энэ төрлийн гэрээ нь Арт Маргад их хэмжээгээр худалдан авч буй үйлчлүүлэгчээ хадгалан үлдэх, нөгөө талаар фермүүдэд тогтвортой үнээр худалдан авч байх боломжийг нээжээ. Мөн компани нь Нийгмийн халамжийн газар, ХАА-н газар зэрэг төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааг улам бэхжүүлсэн. Энэ жил Арт Маргад нь тухайн байгууллагуудад орон нутгийн тэжээлийн зах зээлийн талаарх судалгааны дүнгээ танилцуулан дэмжлэг үзүүлсэн байна. Энэхүү хамтын ажиллагааг аймгийн ХАА-н газрын харьяа Тэжээлийн нөөцийн санд тэжээл нийлүүлэхээр хичээл зүтгэл гаргасныг өндрөөр үнэлжээ.

Энэхүү сан нь өвөл цаг хүндрэх үед яаралтай тэжээл шаардлагатай болсон эмзэг бүлгийн малчдад туслалцаа үзүүлдэг сан юм. Тус сангийн ханган нийлүүлэгч болох нь орон нутагт компанийн нэр хүндийг нэмэгдүүлж, борлуулалтыг тогтвортой болгож, малчид өндөр чанартай ногоон тэжээл авах боломжийг нь нээн өгч буй юм.

Үр дүн 3: Тэжээлийн талаарх малчид, иргэдийн мэдлэг нэмэгдсэн

Энэ жил компани нь малын тэжээлийн давуу талын тухай 500 ширхэг товхимол хэвлүүлж, 1459 хүнд хүрсэн сошиал медиа хуудас хөгжүүлээд байна. Түүнчлэн орон нутагт зохион байгуулагдсан Намрын Баярт оролцож, тэжээлээ сурталчлан, сурталчилгааны материал тараасан. Компани нь мөн тэжээллэг шахмал тэжээлийн давуу тал, үр өгөөжийн талаар 56 малчинд сургалт хийжээ. Энэхүү сургалтыг тэжээл худалдан авахаар ирсэн болон Намрын Баярт оролцсон малчдад хийсэн байна.

Компанийн нэгэн ажилтны хэлсэнчлэн ам дамжсан маркетингийн үйл ажиллагаа малчдын дунд маш чухал ач холбогдолтой байдаг ажээ. Нэмэлт тэжээл хэрэглэхийн үр ашгийн талаарх малчид бусад малчдаасаа сонсож, мэдэх сонирхолтой байдаг. Үүнд нь итгэхийн тулд хамгийн түрүүн авч хэрэглэж, үр дүнг нь үзэх боломжид малчид дуртай байдаг ажээ. Хэрэв нэг малчин малдаа ногоон тэжээл худалдан авч, мал нь тарга хүч орж байвал энэхүү эерэг үр дүнгийн талаарх мэдээлэл орон нутагт хурдан тархаж, олон малчид өөрийн малд ногоон тэжээл худалдан авах хандлагатай байдаг ажээ. Түүнчлэн сошиал медиа болон бусад онлайн платформ нь хэрэглэгчидтэй шууд болон шууд бусаар харьцах, бизнесийн харилцаагаа хадгалахад тустай байдаг байна.

Цаашдын үйл ажиллагаа

Ирэх жилүүдэд компани нь тариалангийн талбайгаа 100 га газраар нэмэгдүүлж, илүү их хэмжээний тэжээлийн ургамал тариалан, тарьж буй ургамлын төрлөө олшруулахаар төлөвлөж байна. Тогтвортой бизнес байхын тулд компани нь мөн үрийн нөөцийн сан байгуулж, өөрийн болон орон нутгийн бусад тариаланчдын хэрэгцээнд нийлүүлэх зорилго тавьжээ. Энэ зорилгодоо хүрэхийн тулд компани нь сайн чанарын үрийг найдвартай нийлүүлэгчээс худалдан авч, үр нөөцлөх ажлаа хийх төлөвлөгөөтэй байна. Хэдий сайн чанарын үр гарган авахын тулд олон жилийн чармайлт, мэргэжилтнүүдийн зөвлөгөө шаардах ч Арт маргад нь энэхүү зорилгоо хангах чин эрмэлзэлтэй ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр бизнес эрхэлж буй залуу хүн болохын хувьд компанийн захирал нь мал аж ахуйн зах зээлийн ирээдүйн талаар өндөр сэтгэгдэлтэй, хэрэглэгчдийн илэрхийлж буй сэтгэгдэл нь түүнийг урамшуулж байна. Өөрийн бизнесийг өргөжүүлэх эцсийн зорилго нь тэжээлийн бизнесээ үндэс болгон дараагийн 5 жилд махны чиглэлийн үхэр үржүүлэх явдал юм. Махны чиглэлийн үхэр өсгөснөөр энэхүү залуу бизнес эрхлэгч нь эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр шинэлэг, инновац ашиглаж, зах зээлд сайн чанартай, аюулгүй бэлтгэсэн мах нийлүүлэх зорилттой ажиллаж байна.



Амжилтын түүх

ЧАНАРТАЙ ДАРШ ҮЙЛДВЭРЛЭЛ

Түншлэгчийн нэр: Ар Сэвд Могойт ХХК

Төслийн байршил: Сэлэнгэ аймгийн Хушаат сум

Хугацаа: 2020 оны 4 сар- 10 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Ар Сэвд Могойт ХХК нь Сэлэнгэ аймгийн Хушаат суманд тариалангийн бизнес эрхэлдэг. Тариалангийн чиглэлээр, ялангуяа улаан буудай тариалахад 20 гаруй жилийн туршлага хуримтлуулсан Ар Сэвд Могойт ХХК нь өөрийн бүтээгдэхүүн, ургамлаа төрөлжүүлэн нэмэгдүүлэх ихээхэн сонирхолтой байжээ. Сүүлийн жилүүдэд компанийн удирдлага нь сум болон аймгийн мал ахуйн нэмүү өртгийн сүлжээн дэх дутагдаж буй зүйл нь тэжээлийн ургамал тариалалт, дарш үйлдвэрлэл маш хязгаарлагдмал байгааг анзаарчээ. Эргэлтийн 800 га тариалангийн газар бүхий Ар Сэвд Могойт нь үүнийг бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх боломж хэмээн үзэж, тэжээлийн ургамал тариалах болжээ. Зах зээл дээрх энэхүү асуудлыг шийдэхийн тулд Ар Сэвд Могойт ХХК нь Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” (RCP) хөтөлбөртэй түншлэн ажиллажээ.

2018 онд тус компани нь тэжээлийн ургамал тариалалт нэмэгдүүлэх зорилго бүхий төслийн тэтгэлгийг Мерси Короос авсан. Энэхүү санхүүжилтийг ашиглан компани нь хөх будаа, овьёосны үр, бутлах тоног төхөөрөмж, бордоо, пестицид зэргийг худалдан авч, малын тэжээлийн ургамал тариалж эхэлсэн байна. Энэ нь компани анх удаагаа малын тэжээл үйлдвэрлэсэн тохиолдол байсан бөгөөд энэ талаар компанийн захирал “Тухайн үед Мерси Кор нь малын тэжээлийн үйлдвэрлэлд орох бидний зорилтыг урамшуулан дэмжсэн. Малын тэжээл нь зах зээл дээр борлуулах чухал бүтээгдэхүүн гэж үзсэн. Малын тэжээлийн эрэлт шинээр үүсэн гарч байсан ч ихэнх малчид бэлчээрээр малаа хариулдаг тул би бүрэн итгэлтэй болоогүй л байсан. Эргээд харахад энэхүү дэмжлэг нь яг цагаа олсон зүйн бөгөөд миний бизнесийг цаашид төрөлжүүлэхэд гол хөдөлгөгч хүч болсон” хэмээн өгүүлжээ.

2020 онд RCP хөтөлбөрийн хүрээнд тус компани нь өрсөлдөөнт сонгон шалгаруулалтад дахин шалгарчээ. Энэ удаад тэдний санал болгосон төсөл нь илчлэг, тэжээллэг чанар өндөртэй дарш үйлдвэрлэх, орон нутгийн зах зээл дээрх малын тэжээлийн хангалтыг нэмэгдүүлэхийг зорьжээ. Түүнчлэн дараагийн тариаланд ашиглах үрийн нөөцийг бэлтгэх, зөвхөн өөртөө ч бус харин бусад тариаланчдыг үрээр хангах зорилгыг дэвшүүлсэн байна. Ар Сэвд Могойт нь өвөл болон хавар малаа даршаар тэжээн жингийн алдагдлаас сэргийлэх, хорогдлыг бууруулах талаарх мэдээллийн материалыг боловсруулсан.

Өмнөө тавьсан “Малчид хүчит тэжээлээр өвлийн туршид малаа тэжээдэг болсон байх” хэмээх зорилгодоо хүрэхэд нь Мерси Кор тус компанитай түншлэн ажиллажээ. Зорилгоо хангахын тулд 4 зорилт дэвшүүлсэн нь; (1) овьёос, арвай, вандуй, буудай бүхий дарш үйлдвэрлэх хүчин чадлаа нэмэгдүүлэх; (2) тэжээлийн үйлдвэрлэлийн хэрэгцээний үрийн нөөцийг нэмэгдүүлэх; (3) орон нутгийн зах зээл дээрх даршны хангалтыг нэмэгдүүлж, дарш болон даршны үр шимийн талаар мэдлэг нэмэгдүүлэх; (4) бүс нутаг дахь тэжээл тариаланг өргөжүүлэх зорилгоор сайн чанарын тэжээлийн ургамлын үрийн хангалтын орон нутгийн зах зээлд нэмэгдүүлэх зэрэг багтжээ.

Үр дүн 1: Дарш үйлдвэрлэх хүчин чадлаа сайжруулсан

Мерси Кортой тогтоосон түншлэлийн хүрээнд Ар Сэвд Могойт нь өөрийн үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэн, овьёос, вандуй, арвай, улаан буудай тариалан, шахан боож дарш үйлдвэрлэж байна. Эдгээр тэжээлийн ургамал нь малын уураг, хивэг зэрэг өндөр илчлэгийн тэнцлийг хангаж, ашиг шимийг нь сайжруулдаг. Энэ талаар компанийн захирал “Холимог дарш нь олон төрлийн тэжээллэг бодис агуулдаг тул бүх төрлийн малд ашигтай” хэмээн хэлж байв. Бизнесээ өргөжүүлэх зорилтоо хангахын тулд компани нь тэжээлийн ургамал тариалах талбайгаа хоёр дахин нэмэгдүүлэн 40 га байсныг 100 га болгосон нь өндөр үр ашигтай тэжээл тариалах, өмнөх жилтэй харьцуулбал илүү их хэмжээний дарш бэлтгэж боломжтой болжээ. Компанийн үйлдвэрлэдэг 300 кг бүхий даршны боодлын тоо 503-аас 1722 болж нэмэгдсэн. Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх хүрээнд компани нь дарш ороох машин болон сэрээт ачигч худалдан авсан энэ шинэ тоног төхөөрөмж нь

малын тэжээлийн зах зээлд бизнесээ өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Ажлын бүтээмж ч шинэ машин, тоног төхөөрөмж ашиглаж эхэлснээс хойш нэмэгдэж, дарш хураан, хаман бооход хялбар болжээ. Ар Сэвд Могойт нь цаашид бусдаас тоног төхөөрөмж түрээсээр ашиглах шаардлагагүй болсноор үйл ажиллагааны зардлыг 2 сая төгрөгөөр бууруулж, орчин үеийн тоног төхөөрөмж ашиглан үйлдвэрлэл явуулах болсон тул тэжээл үйлдвэрлэлд зарцуулах өдрийн тоог ч багасгажээ. Энэ жил гэхэд компани нь 100 га газарт дарш хаман орооход 10 хоногийг л зарцуулсан байна. Өмнө нь 40 га газраас хураан, хаман орооход 14 хоног зарцуулж байв.

Компанийн захирлын тайлбарлаж буйгаар энэхүү амжилтад зөвхөн орчин үеийн техник тоног төхөөрөмжийн туслалцаа бус мөн ажилчдын ажиллах зохион байгуулалтыг сайжруулсны үр дүнд хүрсэн байна. Бизнесийн цар хүрээ өсөхийн хэрээр компани нь дахин 3 ажилчин шинээр авсны 1 нь байнгын, 2 нь түр ажилчин байв. Компани нь ажилчдынхаа гүйцэтгэлийг сайжруулах, тогтвортой ажиллуулах зорилгоор зарим төрлийн урамшууллыг санаачилсны тоонд өвлийн түлш, малын тэжээл өгөх, хүүхдийн сургуулийн төлбөр төлөх, гэр орныг нь сайжруулах зэрэг багтжээ. Энэ талаар компанийн захирал “Үр чадвартай, сэтгэлтэй ажилчин нь компанийн өсөлт, ашигт ажиллагааны үндэс байдаг. Удирдлагын хувьд би ажилтнуудаа компанидаа удаан хугацаагаар ажиллахыг нь урамшуулан дэмжихийг хичээдэг тул гүйцэтгэл дээр нь суурилсан зарим урамшуулал нэвтрүүлсэн. Одоо манайд 11 байнгын ажилтан байгаа. Тариалалтын болон ургац хураалтын үеэр бид нэмэлтээр түр ажилчин авч ажиллуулдаг. Ажилчдынхаа сайн сайханд хөрөнгө оруулах нь маш зөв зүйл бөгөөд бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, хөгжилд эергээр нөлөөлдөг” хэмээн үзэж байна.

3 шинэ ажилтан ажилд авснаар нийт 11 ажилтантай болсон
ХҮНИЙ НӨӨЦӨӨ 37%-ААР НЭМЭГДҮҮЛСЭН

Ар Сэвд Могойт нь бүтээгдэхүүнээ хямд үнээр борлуулдаг нь нутгийн иргэдэд малын тэжээлийн хүртээмж, олдцыг хангаж байна. Компани нь 300 кг жинтэй боосон даршаа 75000 төгрөгөөр зардаг нь өвстэй харьцуулбал хоёр дахин хямд үнэ юм. Компани нь малчдад хүртээмжтэй байлгахын тулд зориудаар хямд үнэ тогтоосон ба энэ нь өвс бус тэжээл худалдан авахад нь хөшүүрэг болж байна. 2020 оны 10-р сарын байдлаар 1772 боодол даршны 60% гаруй нь зарагдсан. Малчид өвөл, хаврын улиралд худалдан авдаг тул борлуулалтын нийт орлого нь өнгөрсөн жилтэй харьцуулбал 4 дахин нэмэгдэх төлөвтэй байна.

Төслийн хугацаанд даршны борлуулалт 2 дахин өссөн
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГОО 4 ДАХИН НЭМЭГДҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ БАЙНА

Захирлын зүгээс хэлэхдээ компани ийнхүү тэжээл үйлдвэрлэл рүү орсноор ашгаа нэмэгдүүлж чадсан. Тэрээр тэжээлийн ургамлыг буудайтай сэлгэн тариалах нь хоёр дахь орлогын эх үүсвэр бий болгохын зэрэгцээ, хөрс сайжруулдаг тул ихээхэн үр ашигтай байдаг гэв. Түүнчлэн тэжээл үйлдвэрлэлийн эдийн засгийн ашиг нь улаан буудайнаас илүү өндөр байдаг ба шалтгаан нь тэжээлийн ургамал нь улаан буудайтай харьцуулбал 3.8 дахин өндөр,

га бүрээс 5-10 тонн илүү байдаг ажээ. Ар Сэвд Могойт нь Мерси Кортой түншлэн ажилласнаар үйл ажиллагааны болон бизнесийн удирдлагын хүчин чадлаа нэмэгдүүлсэн үр дүнтэй байна. Үүний тоонд бүртгэл хөтлөлт, нягтлан бодох бүртгэл сайжирч, бизнесийн болон маркетингийн төлөвлөгөө сайжирч, компани нийтэд танигдаж иржээ. Эдгээр үр дүнгүүд нь Мерси Корын “Орон нутгийн бизнес клиник” төслийн хүрээнд Кинг Консалтинг компанийн үзүүлсэн дэмжлэгтэй холбоотой. Компанийн захирлын зүгээс хэлэхдээ тэрээр одоо компанийн ажилчдын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож өгөх нь чухал гэдгийг ойлгосноо хэлж байв. Өмнө нь бизнес эрхлэхдээ зөвхөн өдөр тутмын үйл ажиллагаа, борлуулалтад анхаарч, ихэнх шийдвэрийг өөрөө гаргаж ирсэн нь удирдлагын өндөр түвшний үйл ажиллагаанаас түүнийг холдуулсан байж. Энэ асуудлыг шийдэхийн тулд албан ёсны дотоод журмуудыг гарган, үүрэг хариуцлагыг тодорхой ноогдуулж, гүйцэтгэлээ тайлагнах бүтцийг бий болгожээ. Өөрийн брэндийг бүрдүүлэхийн тулд компани нь социал медиа хуудас үүсгэж, олон нийтэд хүрэх, үйлчлүүлэгчтэй холбоо тогтоох болжээ.

Үр дүн 2: Малын тэжээлийн ургамлын үрийн нөөцөө нэмэгдүүлсэн

Үрийн нөөц нь Монгол улсын хувьд, тэр тусмаа малын тэжээлийн ургамлын хувьд тийм ч түгээмэл байдаггүй. Орон нутагт сайн чанарын үрийн хүртээмж хомс буй нь тариаланчдад томоохон саад бэрхшээл учруулж байна. Нэг бол Оросоос өндөр үнээр үр авах эсвэл найдваргүй дотоодын нийлүүлэгчдээс үр худалдан авах сонголттой байдаг.




Тиймээс Ар Сэвд Могойт нь 1) дараагийн тариалангийн үед хэрэглэх үрийн нөөцийг бүрдүүлэн, шинээр худалдан авах үрийн мөнгийг хэмнэх, үрийн хангамжийн чанарыг үргэлжлүүлэн хангах, 2) орон нутгийн бусад тариаланчдыг үр худалдан авах боломжоор хангах, ирэх жилүүдэд тэжээлийн үйлдвэрлэл эрхлэх боломжийг Монгол орны хамгийн том тариалангийн бүс нутаг болох Сэлэнгэ аймгийн тариаланчдад ханган өгөх зорилгоор үрийн нөөц бүрдүүлэхээр зорьжээ. Компани үрийн нөөц бүрдүүлэх нь тус бүс нутгийн хувьд шинэлэг, стратегийн хувьд чухал. Мерси Кортой түншлэн ажилласан нь өөрийн үр үйлдвэрлэлийн талбайг 10 га-гаас 26 га болгон нэмэгдүүлж, үр дүнд нь хураан авсан үрийн хэмжээ 35%-иар буюу 13 тонноос 17.6 тонн болж нэмэгдсэн байна.

Зун бороо их орж, мөндөрт цохиулсны улмаас ургацын хэмжээ тооцож байснаас бага байсан ч компани нь орон нутгийн хөдөө аж ахуйн 5 компанитай гэрээ байгуулан, үр ханган нийлүүлэхээр болжээ. Ар Сэвд Могойт нь 25 тонн буудайн үр 2 компанид борлуулж, 8 тонн вандуй, арвай, овъёосны үрийг бусад гэрээт худалдан авагч нартаа нийлүүлсэн.

Компани нь ирээдүйд үрийн нөөцөө улам өргөжүүлэх боломж буйг мэдрэхийн зэрэгцээ үрийн чанарыг сайжруулахаар ажиллаж байна. Малчдын зүгээс өвөл, хаврын улиралд малаа тэжээх нь элбэг болсонтой холбоотойгоор эрэлт шинээр үүсэн гараад байна. Иймээс малчид тэжээл ихээр худалдан авах болсон нь тариаланчид шаардлагатай ургамал тариалахад нь түлхэц болжээ. Гэсэн ч дотоодод сайн чанарын үр нийлүүлдэг аж ахуйн нэгж цөөн байгаагаас Ар Сэвд Могойт нь маш бага өрсөлдөөнт зах зээлд ажиллаж байна. Компанийн захирлын зүгээс үрийн нөөцөө үргэлжлүүлэн сайжруулах нь компанийг өргөжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх дараагийн алхам хэмээн үзэж байна. Тэжээлийн ургамлын үр нь улаан буудайн үрийн үнээс ойролцоогоор 20% өндөр тул цаашид үүнд төвлөрөн бизнесээ өргөжүүлэх юм.

Үр дүн 3: Даршны зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн



Компани болон үйлдвэрлэж буй даршны тухай сурталчилгааны видео орон нутгийн телевизээр цацаж, сошиал медиа хуудсанд байршуулжээ. Компанийн захирал онлайн маркетинг нь компани болон бүтээгдэхүүний

талаар мэдээлэл хэрэглэгчдэд түгээхэд маш өндөр үр дүнтэй болохыг онцлов. Ийнхүү цахим хэлбэрээр хүргэсэн нь дарш худалдан авах сонирхол бүхий худалдан авагчдын тоог нэмэгдүүлэхэд түлхэц болсон. Түүнчлэн нийт 5000 товхимлыг сурталчилгаанд ашиглан, компанийн талаарх мэдээллийг орон нутагт хүргэсэн. Эдгээрийг малчид болон Хушаат сумын ЗДТГ, Сэлэнгэ аймгийн 17 суманд түгээсэн. Боломжит худалдан авагчдын тоо нэмэгдэж, зөвхөн Хушаат сумаар хязгаарлагдахгүйгээр бусад аймаг, сумдаас Ар Сэвд Могойтын даршийг худалдан авахаар ирдэг болжээ.

Даршны хямд үнэ нь өмнө нь худалдан авах боломжгүй байсан малчдад ч хүртээмжтэй болгож, улмаар компанийн хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлсэн. Маркетингийн өөр нэгэн сайн арга зам нь Хушаат суман дахь өөрийн байгууламж дээр борлуулалтын цэг ажиллуулан, хүртээмжийг хялбаршуулсан явдал байв. Улмаар Ар Сэвд Могойт нь өөрийн бүтээгдэхүүний борлуулалтыг идэвхжүүлэх үүрэг бүхий борлуулалтын нэг ажилтан авсан. Борлуулалтын цэгтэй болсноор компани нь бусад сум (Ерөө, Сант), аймагтай (Архангай, Төв, Өвөрхангай) зах зээлийн холбоог үүсгэсэн.



Төслийн хугацаанд компанийн захирал нь 80 гаруй малчин өрхөөр орж, биечлэн уулзалт хийж, компани болон бүтээгдэхүүний талаар танилцуулжээ. Энэхүү уулзалт нь

талуудын хооронд итгэлцэл бий болгож, урт хугацааны бизнесийн харилцааг үүсгэх эхлэл болсон. Үүний үр дүнд компани нь боломжит шинэ 35 худалдан авагч олж, дарш худалдан авах гэрээ байгуулжээ. Ярилцлагын үеэр нэг малчин "Өмнө нь би Ар Сэвд Могойтоос тэжээл худалдан авахдаа амаар тохироод л авдаг байсан.

Энэ жил харин би албан ёсны гэрээ хийж, гарын үсэг зурсан нь компанитай маш найдвартай харилцаатай болсон гэх итгэл төрүүлсэн. Өмнө нь бага хэмжээний тэжээл худалдан авч байсан бол энэ жилээс хэмжээгээ нэмэгдүүлээд байна. Бид энэ тэжээлийн ашиглахад малд үзүүлэх үр шимийн талаар ойлгож байгаа. Би өөрөө үхэр, хонины чанарыг бас сайжруулсан. Хатуу өвлийг давахын тулд надад нэмэлт тэжээл хэрэгтэй бөгөөд зөвхөн хадлан авсан байх нь хангалтгүй. Тиймээс цаг агаар муудахад малаа хашаанд нь байлган тэжээдэг. Өнгөрсөн жил мал маань жин алдаагүй маш сайн үр дүн үзсэн. Зарим нь бүр жин нэмсэн. Даршны өөр нэгэн давуу тал нь илчлэг өндөртэй тул өвөл мал даардаггүй. Одоо малчдын сэтгэлгээ өөрчлөгдөж, мал маллагааны сайжруулсан арга ажиллагааг туршин хэрэгжүүлж байна. Түүнчлэн одоо малчид, фермерүүд ногоон тэжээл нь хадсан өвснөөс илүү болохыг ойлгож, хэрэв хангалттай тариалангийн газар, тоног төхөөрөмж, мөнгө санхүүжилт байвал ногоон тэжээл тариалах, тариалангаа өргөжүүлэх хүсэлтэй болоод байна" хэмээн хэлж байв.

Цаашдын үйл ажиллагаа

Ар Сэвд Могойт нь тэжээл үйлдвэрлэлд зориулсан тариалангийн талбайн хэмжээг 30 га болгон нэмэгдүүлж, 10 га бүрд вандуй, арвай, овьёос тариалахаар төлөвлөж байна. Тэжээл үйлдвэрлэлийн хувьд компани нь хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тэжээлийн илчлэг тэжээллэг чанар зэргийг тогтооход хамтран ажиллахаар шийджээ.

Компани нь мөн дараагийн тариалалтын хугацаанаас эхлэн хэрэглэгчдийн хэрэгцээнд үндэслэсэн захиалгын дагуу шинэ тариалалт хийх төлөвлөгөөтэй байна. Энэ талаар компанийн захирал "Энэхүү төслөөс авсан нэг гол сургамж нь дараа жил тэжээлийн үйлдвэрлэлээ төрөлжүүлэхийн тулд тариалж буй ургамлуудаа өөрчлөх нь чухал байв. Компани нь ирэх жилээс олон төрлийн ургамал тариалж, хурдан морины, махны болон сүүний чиглэлийн үхрийн тусгайлсан тэжээлийг захиалгаар үйлдвэрлэнэ" хэмээн төлөвлөж байна.

Компани нь мөн худалдан авагчдад хүрч ажиллах арга механизмаа бэхжүүлэхээр төлөвлөжээ. Захирлын хэлж буйгаар мал тэжээх талаар нотолгоонд суурилсан мэдээллийн үйл ажиллагаа нь худалдан авагчдад хүрэх механизмыг сайжруулан, мал аж ахуйн арга ажиллагаанд томоохон өөрчлөлт авчирна хэмээн үзэж байна. Өнгөрөгч хавар Ар Сэвд Могойт нь өөрийн 40 үхрийг ойролцоогоор 30 хоног бордсон ба энэ хугацаанд нэг үхэрт өдөрт 5 кг нэмэлт тэжээл өгч байв. Захирлын зүгээс даршны малын ашиг шимд үзүүлэх эерэг нөлөөг харуулсан мэдлэг олгох видео бүтээхээр төлөвлөж байна.

үйлдвэрлэхээр шийдэж, Сэлэнгэ аймагт маш цөөн тооны ферм л малын тэжээл үйлдвэрлэж буйг тогтоожээ.

Сэтэби нь овъёос, буудай, арвайн орц бүхий тэжээллэг дарш үйлдвэрлэн зах зээлд буй энэхүү эрэлтийг хангахаар зорьжээ. Эдгээр орц нь малын тэжээллэгийн хэрэгцээг бүрэн хангаж, тарга хүч авах, эрүүл мэндийг сайжруулдаг. Энэ чиглэлээр ажиллах буй цорын ганц аж ахуй болохын хувьд Сэтэби нь орон нутгийн зах зээл дээр шинэ төрлийн бүтээгдэхүүн нэвтрүүлж, малчид болон фермерүүдэд тэжээллэг өндөртэй тэжээлийн хүртээмжийг хангаж өгчээ.

2020 онд Мерси Кор нь Төсөл шалгаруулан санхүүжүүлэх өрсөлдөөнт зар гарган “залуусын удирдан ажиллаж буй” бизнесийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг тэргүүлэх чиглэлээ болгожээ. 35 нас хүртэлх залуус Монгол улсын хүн амын бараг 35%-ийг эзэлдэг ч мал аж ахуйн салбарт маш цөөн тооны залуус бизнес эрхэлж байна. Тиймээс Мерси Кор нь залуу бизнес эрхлэгчдийн компани болох Сэтэби ХХК-тай түншлэн ажиллаж, үүний өмнөө тавьсан зорилго болох “Малчид олон төрлийн багц малын тэжээлээр бүтэн жилийн туршид малаа тэжээдэг байх” гэсэн зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлсэн. Энэхүү зорилгод хүрэхийн тулд гурван гол үр дүн болох (1) үйл ажиллагаа явуулах хүчин чадлыг өргөжүүлж, орон нутгийн зах зээлд зориулан сайн чанарын тэжээл үйлдвэрлэх замаар бизнесийн өсөлтийг хангах; (2) зах зээл, борлуулалтаа өргөжүүлж, бизнесийн арга ажиллагааг сайжруулснаар орлогоо нэмэгдүүлэх; (3) ногоон тэжээл болон даршийг ашиглахын үр өгөөжийн талаар малчид, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх үр дүнг тодорхойлжээ.

Үр дүн 1: Чанарлаг тэжээл үйлдвэрлэх бизнесийн чадавх сайжирсан

Төсөл хэрэгжсэний үр дүнд компани нь малын тэжээлийн үйлдвэрлэлээ өргөжүүлсэн. Тэжээл үйлдвэрлэх өөрийн хүчин чадлыг сайжруулахын тулд Сэтэби нь өмнө нь тариалан эрхлээгүй байсан 50 га газарт тариалалт хийсэн. Сэтэби нь овъёос, буудай, арвайг зэрэгцүүлэн⁷ тариалж, улмаар эдгээр ургамлын орц бүхий даршин тэжээл үйлдвэрлэсэн. Мөн компани нь дарш ороох машин, гялгар уут зэрэг шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авчээ. Тус машин нь даршин тэжээлийг маш хурдан хугацаанд нягтаршуулан ороохоос гадна ийнхүү ороосноор бичил тэжээллэг бодисыг нь удаан хадгалан, муудахаас сэргийлдэг. Компанийн хувьд шинээр тэжээл үйлдвэрлэх нь танил бус үйл явц байсан тул ажилтнуудаас их хэмжээний цаг, хүчин чармайлт шаарджээ. Компанийн захирлын зүгээс 2020 оны



⁷ Зэрэгцүүлэн тариалах гэдэг нь олон төрлийн ургамлыг нэг талбайд тариалах арга юм. Энэ тохиолдолд газрыг аль болох үр дүнтэй ашиглах зорилготой.

Амжилтын түүх

НОГООН ТЭЖЭЭЛ, ДАРШНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ

Түншлэгчийн нэр: Сэтэби ХХК

Төслийн байршил: Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум

Хугацаа: 2020 оны 4 сар – 10 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Сэтэби ХХК нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд 200 га газарт тариалан эрхэлдэг хөдөө аж ахуйн компани юм. Сүүлийн хоёр жилийн хугацаанд тус компани нь орон нутгийн малчид, фермерүүдэд бэлчээрийн хадланг бага үнээр нийлүүлж иржээ. Компани нь анх 2017 онд овъёос, арвай, улаан буудай тариалан туршиж, ногоон тэжээл үйлдвэрлэж эхэлсэн ч туршлага хомс байсан, тэжээл боловсруулах тоног төхөөрөмж дутмаг байсны улмаас дараа жил нь буцаалд хадлангийн бизнестээ эргэн оржээ.

Хэдий компани нь ажлын хангалттай туршлагатай, хадлан бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжтэй хэдий ч байгалийн хадлангийн гарц нь цаг агаарын байдлаас ихээхэн хамааралтай тул бизнесийн үйл ажиллагаа нь ихээхэн хэлбэлзэлтэй байжээ. Тиймээс өмнөх туршлагаас суралцан тус компани нь малын шахмал илчлэг тэжээл

тариалангийн улиралд Мерси Кортой тогтоосон түншлэл нь тэжээл, тэжээлийн ургамлын талаар мэдлэг, үр чадвар эзэмшихэд зорьсон болохыг дурдаж байсан. “Энэхүү төслийн хүрээнд бид агрономичтой хамтран ажиллаж, талбай дээр шууд зөвлөгөө авч байсан нь маш үнэ цэнтэй хөрөнгө оруулалт болж, залуу бизнес эрхлэгчдийн мэдлэг, түршлагыг бий болгосон.



Хөрс бэлтгэхээс эхлээд ургац хураах хүртэл бүхий л үйл явц нь хялбар байгаагүй ч бид сорилт нэг бүрээс ихийг сурч, практик үр чадвар олж авсан. Жишээ нь атар газрыг элдэншүүлэх нь маш хүндрэлтэй, биднээс элдэншүүлэлт хийж, ургамлаа тариалах хүртэл маш их хүчин чармайлт шаардсан. Төслийн үеэр бид орчин үеийн тоног төхөөрөмж, машин механизмын давуу талыг мэдэрч, нийт 56 сая төгрөгийг үндсэн хөрөнгөө шинэчлэх, ирээдүйн бизнесээ баталгаажуулахад зориулан хөрөнгө оруулалт

хийсэн.” Компанийн захирал мөн хөрс бэлтгэх, тариалах арга техник, ургамал арчлах болон дарш үйлдвэрлэх зэргээс олж авсан түршлага, мэдлэг нь ихээхэн үр дүнтэй байж, тэжээлийн үйлдвэрлэл, бизнесээ үр дүнтэй хадгалахад түлхэц өгсөн хэмээн өгүүлж байв.

6-р сард хэт халалт болсны улмаас Сэтэби нь томоохон сорилттой тулгарсан ба ургамал гандаж, ургацын хэмжээ буурчээ. Гэсэн ч компани нь 400 тонн тэжээлийн ургамал хураан авч, нийт 4000 боодол даршийг борлуулахаар бэлджээ.

Шинэ үйлдвэрлэл, өсөлтөөс үүдсэн эрэлт хэрэгцээг хангахын тулд Сэтэби нь 3 байнгын ажилтан, 7 түр ажилтан авч ажиллуулан, нийт ажилчдынхаа тоог бараг 2 дахин нэмсэн. Ийнхүү ажилчдынхаа тоог нэмсэн нь компани цаашид өөрийн хүний нөөцийн бодлогыг шинэчлэн сайжруулах сэдлийг бий болгожээ. Мерси Корын “Орон нутгийн бизнес клиник” төслийн хүрээнд компани нь Кинг Консалтинг компанитай хамтран ажилласан. Үүний үр дүнд компани хүний нөөцийн бодлогоо сайжруулж, байнгын болон түр ажилчидтай хийсэн гэрээний агуулгыг хянан үзсэн. Мөн Кинг Консалтинг компанитай тогтоосон түншлэлийн хүрээнд маркетинг, бизнесийн төлөвлөгөөгөө шинэчилсэн. Тэд мөн өөрийн сошиал хуудас, олон нийтэд зориулсан материалуудыг хөгжүүлэн, тараах материал, сургалтын материал бэлтгэж, шинэлэг санаачилгуудыг туршин хэрэгжүүлсэн. Мөн компани нь өөрийн хуучин цаасанд суурилсан бүртгэлийн системтэй буюу хэрэглэгчийн мэдээлэл, орц болон гарц зэргийг тэмдэглэдэг байсан бол одоо цахим системд шилжсэнээр борлуулалт болон санхүү, бүртгэлийг илүү сайн удирдах болжээ.

Сэтэби компанийн захирлын дурдсанчлан Мерси Корын залуу бизнес эрхлэгчдийг дэмжих санаачилга орон нутгийн зах зээл дээрх залуусын бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэх ихээхэн чухал, цагаа олсон дэмжлэг болжээ. Энэ нь тухайн компанийг

энэхүү шинэ салбарт байр сууриа бат бэх тавихад нь тусалсан байна. “Бид энэхүү төсөлд маш өндөр сэтгэл ханамжтай буй бөгөөд учир нь үүний үр дүнд бидний бизнесийн санаа бодитоор хэрэгжсэн” хэмээн тэр үзэж байв. Төсөл нь компанид өөрийн тэжээлийн үйлдвэрлэл эхлүүлэх, шинэ бизнесийн түршлагаа нэмэгдүүлэх боломжийг хангажээ.

Үр дүн 2: Зах зээл, борлуулалтаа өргөжүүлэн орлогоо нэмэгдүүлсэн

Шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлсэнтэй давхцан Сэтэби нь өөрийн зах зээлд ажиллах хэд хэдэн чухал санаачилгыг эхлүүлсэн. Төслийн хугацаанд компани мөн зах зээлийн боломжуудыг бүрэн ашиглах зорилгоор боломжит малчин, фермер өрхүүдийн талаар зах зээлийн судалгаа хийж гүйцэтгэсэн. Компанийн захирлын зүгээс энэхүү арга хэмжээ нь үр дүнгээ өгч малчид, фермерүүд “урьдчилсан захиалга” өгөх боломжийн санал болгож, энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй хүргэлтийн үйлчилгээтэй хослон хэрэгжсэнээр зөвхөн зорилтот сумдын ч бус мөн Сэлэнгэ аймгийн зэргэлдээ сумдын шинэ хэрэглэгчдийг татжээ. Энэхүү аргачлал нь малчид, фермерүүдийг татахад их үр дүнтэй болох нь батлагдсан ба малчид, фермерүүд одоо шаардлагатай хэмжээний тэжээлийг урьдчилан захиалж, хүргэлтээр хүргүүлэн авч, мөнгө болон цагаа хэмнэх боломжтой болжээ. Энэ бүхний үр дүнд компани нь үйлдвэрлэл эхэлсэн эхний жилдээ 34 шинэ хэрэглэгчийг олж тодорхойлжээ.

Түүнчлэн компани нь бартерын солилцоо хийх борлуулалтын шинэ аргыг туршин хэрэгжүүлсэн. Үүний хүрээнд малчид өөрийн малаар илчлэг сайтай тэжээл сольж, Сэтэби нь тухайн малыг орон нутгийн дэлгүүрээр борлуулах тогтолцоо юм. Энэхүү шинэ аргыг Сэтэби нь шинэ даршин бүтээгдэхүүний эрэлтийг нутгийн иргэдийн дунд бий болгох, мөн бэлэн мөнгөөр худалдан авах боломжгүй орлого багатай малчдыг татах замаар зах зээлд эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэх арга хэмээн үзжээ. Шударга, ил тод шалгуур ашиглан компани нь үхрээр даршин тэжээл солилцох 5 малчин өрхийг сонгон, туршин хэрэгжүүлжээ. Нийт 300 боодол даршин тэжээлийг 13 толгой үхрээр сольсон байна. малчид малаа өгч малдаа тэжээл худалдан авах нь малчдын ашигладаг түгээмэл арга зам юм.

Бартерын солилцоо нь компани хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх, үүнд бэлэн мөнгөний хомсдолд буй малчдыг оруулах боломжит арга хандлага болжээ. Компани нь бартераар авсан малын махыг борлуулахаар орон нутаг дахь махны дэлгүүртэй гэрээ байгуулсан. Бартерын систем нь Сэтэбид шинэ бизнесийн санаа төрүүлж, махны чиглэлийн үхрийн ферм байгуулах сэдэл төрүүлжээ. Энэ талаар компанийн захирал “Бидэнд өөрийн тэжээлийн нөөц дээрээ суурилан үхрийн фермерийн аж ахуй байгуулах шинэ төлөвлөгөө байгаа бөгөөд учир нь бидэнд бартерын систем ашиглан илүү олон үхэртэй болох өргөн боломж байна” хэмээн үзэж байна.



Хэрэглэгчдэд олгосон өөр нэгэн давуу тал нь бүтэн жилийн туршид тэжээлийн үнийг тогтвортой, хямд барьсан явдал байв. Сэлэнгэ аймаг нь ХАА-н зориулалтын газар, бүтээгдэхүүнээр баялаг тул орон нутгийн малчин, фермерүүд нь малаа тэжээхийн тулд олон боломжийн дундаас сонголт хийхэд хүрдэг. Энэ жил шинээр дарш ороох машин авсны дараа даршны ороомог хийх зардал ихээр буурчээ. Одоо Сэтэби нь зах зээл дээр чанартай, машинаар ороосон даршин бүтээгдэхүүн борлуулж буй цорын ганц компани болжээ.

Тиймээс үйлдвэрлэлийн зардал буурсан, шинэ бүтээгдэхүүн зах зээлд гаргасан зэргээс үүдэн Сэтэби нь шинэ бүтээгдэхүүн худалдан авах илүү олон хүнийг татаж, малдаа өгч турших боломжийг нь хангахын тулд зах зээлийн үнийг ердийн үнээс 20% хямдралтай байлгахаар шийджээ. Энэ нь хэрэглэгчдийн тоог нэмж, нутгийн малчид чанартай тэжээлийн хүртээмжтэй болж, компанийн борлуулалтын орлогыг гурав дахин өсгөжээ. 11-р сарын эхний байдлаар нийт 4000 боодлоос 300 боодол дарш л үлдсэн байв.

Үр дүн 3: Тэжээлийн үр шимийн талаар малчид, олон нийтийн мэдлэг нэмэгдсэн



Төсөл хэрэгжүүлэх хугацаанд компани нь өөрийн сурталчилгааны материал, социал сүлжээний хуудсыг бэлтгэн өөрийн бизнес болон үйлдвэрлэлийг сурталчилж, өөрийн үйлчлүүлэгч нартайгаа идэвхтэй харилцаагаа хадгалахын зэрэгцээ өөрийнх нь бүтээгдэхүүний талаар хараахан сонсоогүй шинэ үйлчлүүлэгч нарт хүрч ажилласан. Сошиал медиа хуудсаараа

дамжуулан, мөн сурталчилгааны материал тараах замаар компани нь 4080 хүнд хүрчээ. Мөн компани тэжээлийн ач холбогдол, үр өгөөжийн талаар 31 малчинд шууд сургалт хийжээ. Тэд мөн иргэдийн нийтийн хурал болон бусад арга хэмжээнд оролцож өөрийн бизнес, тэжээл болон хүргэлтийн үйлчилгээний талаар сурталчилжээ.

Сэтэби компанийн захирлын хувьд ийнхүү мэдлэг олгосон нь бизнесээ сурталчлах, тэжээлээ зах зээлд гаргах, зах зээл дээрх эрэлтийг нэмэгдүүлэхэд маш амжилттай болсон гэж үзэж байна. Улмаар компанийн тухай сурталчилгааны видеог бэлтгэн, YouTube болон компанийн социал хуудас дээр байршуулсан. 6-11 сарын хооронд



видео нь 3580 хүнд хүрсэн нь компанийн маркетингийн сайн гараа болжээ. Энэ талаар компанийн захирал “энэхүү видео нь ихээхэн сонирхол татаж, бизнес болон бүтээгдэхүүний талаар их мэдээлэл өгч, аймаг болон сумаас гаднах боломжит худалдан авагчдад хүрсэн” хэмээн үзэж байна.

Цаашдын үйл ажиллагаа

Тус төсөл нь бэлчээрийн доройтол, даац хэтрэлтээс үүдэн малчид, тариаланчид нь цаашид уламжлалт мал ахуйгаас эрчимжсэн аж ахуйд шилжиж буйг илтгэн харуулсан. Нутгийн захиргаа ч мөн Сэлэнгэ аймгийн хувьд эрчимжсэн мал аж ахуйг түлхүү анхааран, малчдыг тооноос илүү чанарт төвлөрөхийг шаардаж байна.

Компани нь одоо шаардлагатай машин, техникээр бүрэн тоноглогдсон, ур чадвар бүхий ажилчидтай болсон нь ирэх жилүүдэд бизнесээ өргөжүүлэх үндэс болно хэмээн үзэж байна. Энэ нь компанид цааш өргөжин тэлж, зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх боломж юм.

Энэ жил компани нь 50 га газарт тариалалт хийсэн ба цаашид дараа жилээс эхлэн талбайгаа дахин 20 га-гаар нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Түүнчлэн компани нь усалгааны систем суурилуулан, ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд агрономчидтой хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Зах зээлд эзлэх хувь хэмжээний хувьд тус компани нь энэ жил бартерын борлуулалтын аргыг амжилттай туршин хэрэгжүүлсэн. Энэхүү арилжааны шинэ аргыг нутгийн малчид баяртай хүлээн авч, малаараа дарш солихдоо баяртай байжээ. Энэ арга нь хоёр гол үр дүнтэй хэмээн батлагдаад байна. Нэгдүгээрт, Сэтэби нь бэлэн мөнгөний хомсдолд орсон малчдад боломж олгон, малын үр шимээ сайжруулахын тулд чанартай тэжээлээр тэжээх боломжийг нээсэн. Хоёрдугаарт, Сэтэби нь бартерлаж авсан үхрээ ашиглан өөрийн сүрэгтэй болж, ирэх жилүүдэд эрчимжсэн үхрийн ферм байгуулан бизнесээ өргөжүүлэх боломжтой болжээ. Эрчимжсэн үхрийн ферм нэмэгдэх тусам малын тэжээлийн эрэлт нэмэгдэх ба Сэтэби нь энэхүү эрэлтийг хангахаар төлөвлөж байна.



Амжилтын түүх

БАЯЖУУЛСАН АРВАЙН ТЭЖЭЭЛ

Түншлэгчийн нэр: Гурванборхууд ХХК

Төслийн байршил: Булган аймгийн Хутаг-Өндөр сум

Хугацаа: 2020 оны 4 сар – 10 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Булган аймгийн Хутаг-Өндөр суманд үйл ажиллагаа явуулдаг Гурванборхууд ХХК нь тухайн бүс нутагтаа хамгийн том газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж юм. Өөрийн талбайд 13 жил арвай тариалсан туршлага бүхий Гурванборхууд нь малын тэжээл үйлдвэрлэх замаар бизнесээ өргөжүүлэхээр шийдсэн. Тус компани нь өмнө нь зүгээр хаягддаг байсан арвайн ургацаас гарсан хаягдлыг⁸ ашиглах боломж байгааг харж, үүнийг малын тэжээлийн орцод ашиглах болжээ. Энэ нь зөвхөн бизнесээ өргөжүүлэн, орлогоо нэмэгдүүлэх боломжийг олгоод зогсохгүй нутгийн олон нийтэд ч мөн хэрэгцээтэй ажил болсон. Сайн чанартай малын тэжээлийн хүртээмжийг хангах нь малын эрүүл мэнд, чанар болон ашиг шимийн гарцад эергээр нөлөөлөх ба ялангуяа орон нутгийн эдийн засгийн гол тулгуур

⁸ Арвайн дайвар бүтээгдэхүүнд хүнсний хэрэглээнд тохирохгүй бяцарсан үр, хальс, сүрэл багтана.

болох үхрийн аж ахуйг тэжээлээр хангах ач холбогдолтой юм. Малын эрүүл мэнд, ашиг шим нэмэгдэхээс гадна малыг холимог тэжээлээр тэжээх нь байгаль орчинд сайн нөлөөг үзүүлдэг юм. Сумын бэлчээрийн даац хэдийн хэтэрч, малын тоо нь бэлчээрийн даацаас 5 дахин хэтрээд буй энэ асуудал нь зөвхөн тухайн нутгийн ч бус Монгол улс даяар тулгараад буй асуудал юм.

Компанийн захирал арвайн хаягдлаар малын тэжээл хийх болсон талаараа “Бид өмнө нь арвайн хаягдлыг шууд хаядаг байсан. Энэ нь нийт ургацын ойролцоогоор 10 орчим хувийг хаяж байсан гэсэн үг. Бид малчдад арвайн хаягдлыг үнэ төлбөргүй өгч байсан ба энэ нь мал тарга авах, ашиг шимийн гарц сайтай байхад арвайн хаягдал ихээхэн үр дүнтэйг харуулж өгсөн. Улмаар илүү олон тооны малчид малаа тэжээхийн тулд хаягдал арвай асууж ирдэг болсон. Тиймээс бид үүнийг бизнесийн үйл ажиллагаагаа төрөлжүүлэх боломж байна гэж бодох болсон” хэмээн хэлж байв. Тиймээс компани нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн хийх зорилгоор арвайн хаягдлыг ашиглах боломжийг судалжээ. Энэ зорилгоор компани Дархан дахь Ургамал, газар тариалангийн судалгааны хүрээлэнтэй хамтран ажиллаж арвайн тэжээлийн илчлэгийг тодорхойлон, арвайн үр болон дайвар хаягдал ашиглан шинээр малын тэжээл үйлдвэрлэх боломжийг судлан үзсэн байна.

Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд хөтөлбөр нь Гурванборхууд ХХК-тай хамтран ажиллаж, малын тэжээлийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх, хүчийн чадлаа нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Тэтгэлэгт төсөл хэрэгжүүлснээр Гурванборхууд нь хоёр төрлийн арвайн хольц бүхий тэжээл үйлдвэрлэхээр сонголт хийсэн нь – а) эрдсээр баяжуулсан арвайн тэжээл болон б) арвай, буудайн холимог тэжээл бөгөөд эдгээрийг зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөжээ. Төслийн зорилго нь “орон нутгийн малчдыг баяжуулсан, илчлэгт тэжээлээр хангах” байсан. Үүний тулд гурван үр дүнг тогтоосон ба үүнд (1) дайвар бүтээгдэхүүн ашигласан илчлэгт тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, (2) борлуулалт, орлогыг нэмэгдүүлэх; болон (3) малчдын дунд мэдлэг олгох, сурталчлах ажил зохион байгуулах хэмээх үр дүнгүүдийг тодорхойлжээ.

Үр дүн 1: Малын тэжээл үйлдвэрлэх хүчин чадлыг сайжруулсан

Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Гурванборхууд нь малын тэжээл үйлдвэрлэх хүчин чадлаа нэмэгдүүлж, улмаар энэ нь тухайн бизнесийг өөрийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, нийт ашгаа нэмэгдүүлэх боломжийг нээжээ. Мерси Кортой түншлэн ажиллаж, авсан дэмжлэгийн хүрээнд компани нь өөрийн арвай тариалах талбайг 200 га-гаас 498 га болтол 2 дахин нэмэгдүүлж, малын тэжээлийг их хэмжээнд үйлдвэрлэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн.

Арвайн хаягдлыг үр дүнтэйгээр хураахын тулд компани нь шинээр ангилах машин авч, гэмтсэн арвайн үр, А сортын (бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэлд ашигласан) арвайн хальс, иш ялгахад ашиглажээ. Шинээр авсан ангилан ялгах машин нь нарийвчлал сайнтай, ялгах хүчин чадал өндөртэй тул хуучин ашиглаж байсан

машинтай харьцуулбал ажил болон цаг хэмнэж өгсөн. Гурванборхууд нь мөн өөрийн бүтээгдэхүүнийг зах зээл дээр борлуулахад бэлтгэхийн тулд савлах машин худалдан авсан. Өөрийн бизнесийн үйл ажиллагааны талаар компанийн менежер “Өмнө нь ангилах хурд, нарийвчлал муу байсан тул сайн сортын арвайнаас хаягдлыг ялгахад цаг их авдаг байсан. Түүнчлэн малчдад зориулан хаягдлыг савлах ажлыг гараар хийдэг байснаас цаг их зарцуулж, ажилчдаас их ажиллахыг шаарддаг байв. Харин одоо автоматжуулсан ангилах, савлах машин нь бидний цаг, зардлыг хэмнэж байна” хэмээн хэлсэн. Тэрээр мөн автомат үйлдвэрлэлийн шугам нь бизнесээ өргөжүүлэхэд туслахын зэрэгцээ ажилтнуудын аюулгүй ажиллагаа, бизнесийн тогтвортой өсөлтийг хангасан хэмээн хэлж байв.

Үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдсэнээр компани нь бизнесийн үйл ажиллагаандаа анхлан төлөвлөснөөс илүү их хөрөнгө оруулалтыг өөрийн зүгээс хийжээ. Жишээ нь төслийн хүрээнд анхлан төсөөлөн, төсөвт тусгаагүй ч Гурванборхууд нь ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд комбайн болон автомат ачигт машин худалдан авчээ. Өмнө нь ажилчид зөвхөн хураан авсан таримлаа ашиглаж, гараар боловсруулалт хийх нь ихээхэн цаг авсан, үр дүн багатай байжээ. Түүнчлэн компани нь шинээр худалдан авсан машин, тоног төхөөрөмжийг хадгалах байр барьж, төсөл дууссанаас ч хойш найдвартай, урт хугацааны хэрэглээг нь хангах арга хэмжээг авсан. Мөн компани нь 5 тонн тэжээл хадгалах хүчин чадал бүхий агуулах барьсан. Захирлын зүгээс эдгээр нь ухаалаг, цагаа олсон хөрөнгө оруулалт байсан ба “Бид эдгээр машин, механизмыг худалдан авахад их хэмжээний хөрөнгө оруулалт буюу 185 сая төгрөг зарцуулсан. Орчин үеийн машин механизм ашиглахын давуу талыг энэ жил бид мэдэрч, боловсруулах болон үйлдвэрлэх хүчин чадлаа бодитоор нэмэгдүүлсэн. Энэхүү хөрөнгө оруулалтын өгөөжийг ойрын ирээдүйд үзнэ гэдэгтэй би бат итгэлтэй байна” хэмээн хэлжээ.

Энэхүү төслийн хүрээнд Гурванборхууд нь үйл ажиллагаагаа төрөлжүүлж, шинэ хоёр төрлийн тэжээлийг өөрийн үйлдвэрлэлд нэвтрүүлсэн ба тухайн бүтээгдэхүүн нь өвөрмөц орцтой жишээ нь нэг нь эрдсээр баяжуулсан арвайн тэжээл, нөгөө нь арвай, улаан буудайн холимог тэжээл байна. Холбогдох хууль тогтоомжийн дагуу Аймгийн Стандарт Хэмжилзүйн Хэлтсээс шинж тэжээлийн жорыг хянаж үзээд тохирлын гэрчилгээг олгосон. Мөн тухайн тэжээлийн орц болон чанар нь хамаарах стандартыг бүрэн хангасан тул Гурванборхууд нь эдгээрийг үйлдвэрлэн, зах зээлд борлуулах албан ёсны эрхүүдийг (зохиогчийн эрх болон патент) авчээ.

Шинээр 5 ажилтан нэмж өөрсөөр нийтдээ 31 байнгын ажлын байртай болсон
ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИ 20%-ААР НЭМЭВ

Төслийн хэрэгжилтийн хугацаанд компани нь малын тэжээлийн зориулалтаар ашиглах арвайн арвайн хаягдлын хэмжээг 26 тонноос 72 тонн болгон бараг 3 дахин нэмэгдүүлжээ. Төслийн хугацаанд бараг

24 тонн тэжээл үйлдвэрлэн борлуулсан ба компани нь нэмэлт тэжээлийн эрэлт өсөх



өвөл, хаврын улиралд дахин 59 тонн тэжээл борлуулахаар төлөвлөжээ. Өнгөрсөн жилтэй харьцуулбал компанийн орлого 2020 оны 10-р сарын байдлаар хоёр дахин нэмэгдэж, тэжээл үйлдвэрлэсэн бүтэн жилийн хугацаанд орлого нь 10 дахин илүү байхаар хүлээгдэж байна.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын орлогч Гурванборхуудын бизнес өргөжин тэлж буйн ач холбогдлын талаар “Орон нутагт хямд үнэтэй тэжээлийн эрэлт маш өндөр буй тул тэжээлийн үйлдвэрлэл нь маш чухал ач холбогдолтой. Энэхүү тэжээлийн шинэ зах зээл нь малчдад малын тэжээлийн найдвартай хүртээмжийг бий болгож байна. Нутгийн малчид одоо аймгийн төв эсвэл өөр газар руу тэжээл худалдан авахаар явах шаардлагагүй болж байна. Бэлчээрийн ургац жилээс жилд буурч буй энэ цаг үед энэхүү шинэ нөхцөл байдал нь малчдыг зөвхөн уламжлалт мал маллагааны арга болох бэлчээрт найдах бус харин нэмэлт тэжээл худалдан авч, ашиглахад хүргэж байна” хэмээн өгүүлжээ.

Бизнес өргөжин тэлж буйгаас үүдэн ажилчдын тоог нэмэх шаардлага гарснаар компани нь 5 шинэ ажилтан авч нийт ажилчны тоо нь 31 байнгын ажилчин болж өсжээ. Шинээр ажилд орсон нэг ажилтан “Гурванборхууд нь орон нутагтаа танигдсан, иргэдийн дунд нэр хүнд сайтай, ажилтандаа тогтвортой ажиллах боломж олгодог компани учраас би энэ компанийн нэг хэсэг болсондоо баяртай байна. Өмнө нь би амьжиргаагаа хангах гэж олон тооны түр ажлууд хийж байсан. Тухайн үед манай нөхөр бас ажилгүй байсан болохоор их хэцүү байсан. Одоо би тогтвортой орлоготой болж, компани манай амьжиргааг бодитоор дэмжиж байна. Жишээ нь саяхан компани Ургацын баяр тэмдэглэж, ажилчдаа амрааж, бүгдэд нь шагналт цалин олгосон” хэмээн хэлж байв.

Компанийн захирал нь мөн ажилчдынхаа хэрэгцээнд мэдрэмжтэй хандаж, өөрийн ажилтнуудаа тогтвор суурьшилтай ажиллуулахыг тэргүүлэх чиглэлээ болгоод байна. “Бид ажилтнууддаа анхаарч, тэдний мэргэжлийн болон техникийн чадамжийг үнэлдэг. Тиймээс бид ажилтнуудаа сэдэлжүүлэх, бүтээмжийг нь нэмэгдүүлэх чиглэлээр урамшуулах механизмыг хэрэгжүүлээд байна. Гүйцэтгэлийн нөхцөл байдалд үндэслэн бид шагналт цалин олгосон. Жил бүр бид 15 сая төгрөгийг хуваарилан ажилтнууд сургалтад хамрагдахад нь ивээн тэтгэж, амралтын үед нь дэмжлэг үзүүлдэг. Өнгөрсөн хэдэн сарын хугацаанд нийт гурван ажилчин мэргэжлийн сургалтад хамрагдаж, тракторын жолоочийн үнэмлэх авсан. Мөн онцгой тохиолдолд бид ажилтнууддаа мөнгөн тусламж үзүүлдэг” хэмээн хэлж байв.

Түүнчлэн, Мерси Корын “Орон нутгийн бизнес клиник” төслийн хүрээнд үзүүлсэн дэмжлэгээр компани нь нягтлан бодох бүртгэл, хүний нөөцийн бодлогын бичиг баримтыг шинэчилж, маркетингийн болон бизнесийн төлөвлөгөөг боловсруулаад байна. Баримт бичиг нэг бүрийг төрөөс тавьдаг албан ёсны шаардлагатай нийцүүлэн боловсруулжээ. Маркетингийн хувьд компани нь сошиал хуудас болон маркетингийн мэдээлэл харилцааны материалыг боловсруулан гаргасан.

Үр дүн 2: Бизнесээ өргөжүүлж, борлуулалтаа нэмэгдүүлсэн

Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш компани нь олон нийтийн дунд өөрийгөө таниулахаар ихээхэн цаг, хөдөлмөр зарцуулжээ. Компанийн менежерийн зүгээс маркетингийн эрчтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн ач холбогдлын талаар илүү сайн ойлголттой болсон байна. Компанийн өвөрмөц бүтээгдэхүүнийг танилцуулсан сурталчилгааны видеог бүтээж, сошиал медиад байрлуулсан нь 3200 хүнд төслийн хугацаанд хүрчээ.

Байршилд суурилсан маркетинг нь хэрэглэгчтэй холбоо тогтоох, борлуулалт нэмэгдүүлэхэд мөн амжилттай хэрэгжжээ. Үндсэндээ сумын төвөөс 50- 90 км зайд байдаг алслагдсан багт амьдарч буй малчдын малын тэжээлийн хүртээмжийг хангасан борлуулалтын биет цэг нь чухал ач холбогдолтой байдаг. Үүнийг ухамсарласан компани нь багуудад байдаг дэлгүүрүүдтэй гэрээ байгуулан, тэжээлээ борлуулахаар болжээ. Төслөөс өмнө тэжээл борлуулах нэг л цэгтэй байсан бол одоо борлуулалтын ийм дөрвөн цэгтэй болсон байна.

25 кг-аар шуудайд савласан тэжээл нь түгээмэл ашигладаг хивэгт тэжээлийн үнийг ойролцоогоор талтай тэнцэх үнээр үнэлэгдэж байна. Энэ нь хэрэглэгчдийг татах гол хүчин зүйл болжээ. Борлуулалтын цэгийн нэг менежерийн хэлснээр “Малын тэжээлийн хэрэгцээ маш их байна. Бид энэ сард гэхэд ойролцоогоор 10-15 тонн тэжээл борлуулаад байна. Борлуулалт хүлээж байснаас ч илүү амжилттай байгаа бөгөөд жишээ нь Гурванборхууд бидэнд 10-р сарын дундуур 3000 кг тэжээл нийлүүлснээс сарын дотор 525 кг л үлдээд байна. Үнэ бага байгаа нь хэрэглэгчдийг татаж, тэд нэг шуудай хивгийн үнээр хоёр шуудай тэжээл авах боломжтой. Байнга тэжээл авдаг 20-30 үйлчлүүлэгч байна” гэжээ.

Эдгээр бүтээгдэхүүний маркетинг иргэдийг татаж чадсан тул зөвхөн орлого ч бус мөн хэрэглэгчдийн тоо нь өссөн байна. Компанийн менежер “Бид хөрш аймаг болох Хөвсгөл аймгаас борлуулалтын илүү их хүсэлт ирнэ гэсэн хүлээлттэй байгаа. Бид саяхан Хөвсгөл аймгийн 2 сургуультай бизнесийн гэрээ хийж, тэдэнд 4 тонн тэжээл ханган нийлүүлсэн” хэмээн хэлж байв.

Үр дүн 3: Тэжээлийн хэрэглээ, үр өгөөжийн талаар малчдын мэдлэгийг нэмэгдүүлсэн

Төслийн хугацаанд хэрэгжүүлсэн шууд болон шууд бус маркетингийн арга хэмжээ нь малын тэжээлийн ач холбогдол, түүнийг хэрхэн хэрэглэх мэдээллийг малчдад хүргэх үйл ажиллагаанд чиглэсэн. Компанийн захирал 500 малчдыгаар орж, нүүр тулж уулзан, нэмэлт тэжээлийн давуу тал, үр шимийн тухай мэдээллээр хангасан. Түүнчлэн малчдын мэдлэгийг сайжруулах, борлуулалтаа идэвхжүүлэхийн тулд эдгээр уулзалтын үеэр ихээхэн хүчин чармайлт гарган ажилласан.

Гурванборхууд нь тэжээлийн сав баглааны дизайныг шинэлэг байдлаар гарган зөвхөн брэндингийн зориулалтаар ч бус мөн бүтээгдэхүүн, үүний хэрэглээний

талаар мэдээлэл түгээх боломж болгон ашиглажээ. Одоогоор энэхүү мэдээллийг 6000 шуудан дээр хэвлэж, компанийн брэндийг сурталчлаад байна. Компани нь мөн малын тэжээлийн тухай 500 ширхэг товхимол хэвлүүлэн, борлуулалтын цэгүүд дээрх төлөөлөгчид нь хэрэглэгчдэд түгээжээ.

Арвайн тэжээлээр мал тэжээхийн давуу талуудыг харуулахын тулд Гурванборхууд нь олон жил хамтран ажилласан нутгийн нэг малчны өөр өөр насны махны чиглэлийн 5 үхрийг өөрийн арвайн тэжээлээр туршилтаар тэжээсэн. 2020 оны 10-р сард нэг сарын хугацаанд хийгдсэн туршилтын үеэр үхэр нь дунджаар 7-8 кг жин нэмжээ. Тэд туршилтаар үхэр бүрд 150 кг тэжээлийг бүтэн сарын туршид өгсөн. Энэхүү туршилт нь бусад малчдад малын тэжээлийн үр дүнг тодорхой харуулжээ. Хөрш зэргэлдээ амьдарч буй олон тооны малчид үхэрт гарч буй өөрчлөлтийг өөрийн нүдээр өдөр бүр үзэж, бүтээгдэхүүн болон хэрэглээг практикаар харуулахын үр дүнг харуулсан.

Цаашдын үйл ажиллагаа

Бизнес нь хэдийн өөрийн үйл ажиллагааны хүчин чадал, орлого болон зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлсэн ба харин одоо ирэх жилүүдэд нэмүү өртөг шингээсэн төрөл бүрийн малын тэжээл, тэжээлийн орц бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөж байна. Тэд удахгүй махны чиглэлийн үхрийн эрчимжсэн фермүүдэд зориулсан тусгай шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлнэ. Сумын хэмжээнд эрчимжсэн махны үхрийн ферм, болон бордох цэг байгуулах хүсэл эрмэлзэл өндөр буй тул үйлдвэрлэлийн эдгээр шинэ байгууламж нь малын тэжээлийн нэмэлт эрэлт бий болгож, мал аж ахуйн зах зээл өснө хэмээн үзэж байна.

Бизнесээ улам өргөжүүлэхийн тулд Гурванборхууд нь өөрийн тариалангийн талбайг одоо байгаа 1100 га-гаас цаашид нэмэгдүүлнэ. Мөн улаан буудайн хаягдлыг тэжээлд ашиглах замаар одоогийн газар тариалан болон шинэ тэжээл үйлдвэрлэх үйл ажиллагааг холбон уялдуулахаар төлөвлөж байна.



Амжилтын түүх

БЭЛЧЭЭР САЙЖРУУЛАХ ТҮРШИЛТЫН ТАЛБАЙ

Түншлэгчийн нэр: Зорилтот сумдын ЗДТГ

Төслийн байршил: Булган аймгийн Сэлэнгэ сум, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум

Хугацаа: 2020 оны 6 сар – 11 сар

Төслийн танилцуулга

Үүр амьсгалын өөрчлөлт, мал маллагааны зохисгүй менежмент, бэлчээрийн даац хэтрүүлэх зэргээс үүдэн Монгол улсын нийт бэлчээр нутгийн 60% орчим нь доройтолд өртөөд байна. Малын тоо толгой өссөнөөс үүдэн бэлчээрийн даац хэтэрч энэ нь хөрсний давхарга элэгдэлд орсноор бүрэн доройтох, улмаар цөлжилт үүсгэх болжээ. Эдгээр сорилтууд, байгаль орчинд үзүүлж буй аюул занал нь Монголын мал аж ахуйн салбарын ирээдүйг эрсдэлд хөтөлж байна.

“Даван туулах, дасан зохицох чадвартай нутгийн иргэд” хөтөлбөрийн хүрээнд 2019 оны 9-р сард Мерси Корын хөтөлбөрийн баг нь Сэлэнгэ, Булган, Хэнтий аймгуудын зорилтот сумдаар аялан, бэлчээрийн менежментэд тулгарч буй сорилтууд болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний өнөөгийн хэрэгжилтийн талаар сумдын

албаны хүмүүстэй уулзан санал солилцсон. Аяллын дараагаар сумдын удирдлагын зүгээс хөтөлбөрийн багт хандаж, бэлчээр сайжруулах төрөл бүрийн аргачлалуудыг танилцуулахыг хүссэн. Сайжруулсан бэлчээрийн үр өгөөжийг малчид өөрийн нүдээр харснаар өөрийн бэлчээрийг хамгаалах чиглэлээр ажиллах сэдэл, тэмүүлэлтэй болохыг хичээнэ гэсэн төсөөлөл байсан.

Аймаг, сумын Хөдөө аж ахуйн газруудтай хэлэлцсэний дараагаар Мерси Кор нь сонгосон 2 суманд бэлчээрийн туршилтын талбайг аймаг, сумдын захиргаатай хамтран байгуулах шийдвэр гаргасан. Туршилтын талбай байгуулах гол зорилго нь:

- Бэлчээрийг хашиж, хамгаалж, бордох ач холбогдлыг олон нийтэд таниулах;
- Бэлчээр сэлгээх аргуудыг танилцуулах
- Бэлчээрийг шинжлэх ухааны аргаар сайжруулах.

Туршилтын талбай нэг га газар эзлэнэ. Туршилтын талбайг дөрвөн хэсэг хувааж хашина. (Зураг 1 дээр үзнэ үү).


Талбай А: Энэ хэсгийг хашаалж, мал бэлчээхгүй амрах ба ямар нэгэн ургамал тариалахгүй

Талбай В: Энэ хэсэгт олон наст ургамал тариална

Талбай С: Энэ хэсэгт органик бордоо ашиглан хөрс сайжруулах ажил хийгдэнэ (бууц);

Талбай D: Энэ хэсэгт царгас тариална

Зураг 1. Туршилтын талбайн зохион байгуулалт



Төслийн хэрэгжилт

Төслийн санал ирүүлэх урилга

2020 оны 6-р сард Мерси Кор нь бэлчээр сайжруулах туршилтын талбай байгуулах төслийн саналаа ирүүлэхийг 6 сумын захиргаанд хандан илгээсний тоонд Булган аймгийн Хангал, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумд, Сэлэнгэ аймгийн Сант, Зүүнбүрэн сумд, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум багтсан. Мерси Корын зүгээс тухайн 6 суманд хандсан шалтгаан нь 1) тухайн сумд нь бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй, 2) төвийн зам болон усны нөөц эх үүсвэртэй ойр оршдог зэрэг байсан.

Урилга хүргүүлсэн бүх зургаан сумаас төслийн санал ирүүлсэн. Төслүүдийг Монгол хэл дээр ирүүлсэн бөгөөд тойм мэдээллийг нь англи хэл рүү орчуулж, танилцуулга бэлтгэн Мерси Корын сонгон шалгаруулах багт хүргэсэн. Саналууд нь дараах мэдээллийг агуулсан байв:

- Үндсэн мэдээлэл (бэлчээрийн менежментэд тулгарч буй өнөөгийн сорилтууд)
- Туршилтын талбайн тухай дэлгэрэнгүй мэдээлэл (байршил, хэрэгжүүлэх арга, мэдээллийн самбарт тавигдах мэдээлэл)
- Сумын захиргаанаас төсөлд оруулах хувь нэмэр
- Туршилтын талбайн ирээдүйн төлөвлөгөө

Ирүүлсэн саналуудыг судлан үзсэний дараа Мерси Кор нь дараах шалгуурын дагуу эхний ээлжинд 4 сумыг сонгосон:

- Туршилтын талбайг үзэж сонирхох хүмүүсийн тоо
- Талбайн 4 хэсгийг хөгжүүлэх тодорхой төлөвлөгөө, үндэслэл
- Малчдад өгөх мессеж, бэлчээрийн менежментийн талаархи мэдлэг ойлголтыг дээшлүүлэх нарийвчилсан төлөвлөгөө
- Талбай хөгжүүлэхэд сумын зүгээс тодорхой удирдлага, зохион байгуулалтаар хангахын бэлэн байдлын илэрхийлэл
- Талбай байгуулахад нутгийн иргэдээс оруулах хувь нэмэх
- Талбайг цаашид тогтвортой арчилж тордох ажлыг хариуцах бэлэн байдал
- Илгээсэн техникийн зураг нь ойлгомжтой, тодорхой байгаа эсэх

Эдгээр сонгогдсон сумд нь Булган аймгийн Сэлэнгэ, Сэлэнгэ аймгийн Сант, Зүүнбүрэн, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сум байсан. Хөтөлбөрийн баг тухайн сумдад 6-р сард очиж ажилласан. Бүх 4 сумын засаг даргатай уулзалт хийж, тухайн туршилтын талбайг судлан үзсэний дараа Мерси Кор нь Булган аймгийн Сэлэнгэ болон Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумдыг сонгосон. Эдгээр хоёр сумыг сонгоход тухайн сумдын удирдлагын хүсэл эрмэлзэл, талбайн байршил, тухайн талбайг хариуцан ажиллах орон нутгийн мэргэжилтнүүдийн чадавх зэрэг нөлөөлсөн.

Эцсийн сонголт хийгдсэний дараа Мерси Кор нь тухайн сумдын засаг дарга нартай 2020 оны 6 болон 7-р сард Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан. Бусад сумдад Мерси Корын зүгээс татгалзсан тухай албан бичиг явуулж, тухайн сумыг ямар шалтгааны улмаас сонгогдоогүй болохыг тайлбарласан.

Хамтын ажиллагааны санамж бичиг нь талуудын хариуцах үүргийг зааж, туршилтын талбайн ирээдүйн ашиглалтын төлөвлөгөөг тусгасан. Доорх хүснэгтийг үзнэ үү:

Хүснэгт 1: Түншлэгч талуудын үүрэг хариуцлага

Сумын захиргаа, малчдын бүлгүүд	Мерси Кор
<ul style="list-style-type: none"> • Явган зам, сүүдрэвч барих, мэдээллийн самбар босгох • Үр тарих, ургуулах • Туршилтын талбай байгуулах ажилд автомашин, ажиллах хүч гаргах • Талбайг услах, усалтын системийн материалыг нийлүүлэх • Аймгийн ХАА-н зөвлөлтэй хамтран үр тарих, бордох, услах • Туршилтын талбайг цаашид үргэлжлүүлэн ашиглаж, засвар үйлчилгээний зардлыг сумын жил тутмын төсөвт тусгаж санхүүжүүлэх • Аймгийн ХХА-н газартай хамтран туршилтын талбайг сурталчлах, сайн туршлагаудыг хуваалцах, туршлага судлах аяллыг зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Үйлдвэрлэлийн орц ханган нийлүүлэгчдийг нээлттэй, шударга өрсөлдөөнт байдлаар сонгон шалгаруулах • Барилгын материал худалдан авах: төмөр хашаа, сүүдрэвч, явган замын хавтан, олс, усалтын систем, мэдээллийн самбар • Талбайг тойруулан хашаа барих • Төслийн хэрэгжилтэд мониторинг хийж, дууссаны дараа үнэлгээ хийх. • Талбайд тохирох ургамал, сэлгэлтийн горимыг тогтоох, нийтэд хүргэх мессежийг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх

Худалдан авах ажиллагаа

Дараагийн алхам нь барилгын материал болон ургамлын үр худалдан авах, хашаа, явган хүний зам, сүүдрэвч барих, мэдээллийн самбар босгох зэрэг ажил байсан. Мерси Кор хоёр аймагт худалдан авалтын тендер зарласан.

Нийтдээ 7 компани тендерт оролцсон ба эдгээрийн 3 нь Хэнтий аймагт, 4 нь Булган аймагт ажил гүйцэтгэх санал ирүүлсэн. Ирүүлсэн тендерийн материалыг судлан үзсэний дараагаар Мерси Кор нь Мон Хашаа ХХК-ийг Хэнтий болон Булган аймагт сонгон ажиллуулах болсон. Сонгон шалгаруулалтад бид 1) туршлага болон техникийн чадавх, 2) бүтээгдэхүүний чанар 3) зардал 4) хүлээлгэн өгөх хугацаа зэрэг шалгуурыг харгалзсан.

Цэнхэрмандал сумын туршилтын талбай

Мерси Кор болон Цэнхэрмандал сумын Засаг дарга нар 2020 оны 6-р сарын 18-ны өдөр Хамтын ажиллагааны санамж бичгэнд гарын үсэг зурсан. Мон Хашаа ХХК нь хашаа барих ажлаа эхлүүлж, 14 хоногт багтаан дуусгасан. Сумын зүгээс сүүдрэвч болон явган зам барих, мэдээллийн самбар босгох зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэсэн. Дэд бүтцийн ажил 2020 оны 8-р сарын 30 гэхэд бүрэн дууссан.

Дэд бүтэц дууссаны дараа бид хөрсөө бордож эхэлсэн. Мерси Кор бууцаар бордох талаар техникийн зөвлөгөөг сумын ХАА-н ажилтанд өгсөн. Түүнчлэн Хэнтий аймгийн ХАА-н мэргэжилтэн нь Цэнхэрмандал суманд бууц цацах ажилд тусалсан.

10-р сарын сүүлээр Мерси Корын мэргэжилтэн, аймгийн ХАА-н мэргэжилтэн, малчид, сумын захиргааны ажилтнууд гээд нийт 21 хүн хамтран олон наст ургамал болон царгасны үр тариалсан. Тус баг нь жижиг оврын трактороор газар хагалж (2-3 см гүн, эгнээ хооронд 20 см), үр суулган, хүйтнээс хамгаалахын тулд өвсөөр хучсан.



Зардал хуваалцах

Туршилтын талбай байгуулахад Мерси Корын зүгээс 26.8 сая төгрөг хандивласан. Энэ хөрөнгийг хашаа, сүүдрэвч, явган зам барих, мэдээллийн самбар босгох, олон наст ургамлын үр, услалтын систем худалдан авах зэрэгт зарцуулсан.

Цэнхэрмандал сумын ЗДТГ-ын зүгээс үр хучих өвч худалдан авах, хүн ажиллуулах, үр суулгахад трактор түрээслэх зэрэг ажилд 2.4 сая төгрөгийг зарцуулсан.

Булган аймгийн Сэлэнгэ сумын туршилтын талбай

Сумын Засаг даргатай Хамтран ажиллах санамж бичигт 2020 оны 7-р сарын 28-ны өдөр гарын үсэг зурсан. Хашаа барих ажил 2020 оны 9 сарын 15-ны өдөр дууссан. Сумын ЗДТГ нь олсон хашаа, модон шон бүхий явган зам байгуулсан. Дэд бүтцийн ажил дууссаны дараа талууд нь үр суулгах, бууц цацах ажлыг хийсэн. 52 хүн үр, бууц цацах ажилд Мерси Корын зааварчилгааны дагуу ажилласан. Өвөл хүйтнээс хамгаалахын тулд бүх үрийг өвсөөр хучсан. Эхний усалгааг 2020 оны 6-р сард хийнэ.

Зардал хуваалцах

Энэхүү үйл ажиллагаанд Мерси Кор 22.2 сая төгрөг хандивласан. Энэ хөрөнгийг хашаа, сүүдрэвч, явган зам барих, мэдээллийн самбар босгох, олон наст ургамлын үр худалдан авах зэрэгт зарцуулсан. Сумын ЗДТГ-ын зүгээс шаардлагатай ажилд хүн хүчээ оролцуулах замаар 0.5 сая төгрөгийг зарцуулсан. Сэлэнгэ сумын талбай дээр орон нутгийн 52 иргэн ажилласан.

Сорилтууд

- Цэнхэрмандал сумын зүгээс анх санал болгосон туршилтын талбай байгуулах газрын байршлыг хөтөлбөрийн баг хүлээж аваагүй. Тухайн газар нь төв замтай ойрхон байсан ч царгас болон олон наст ургамал тариалахад тохиромжгүй байсан. Төслийн амжилтад хөрс, газрын байдал нь ихээхэн чухал ач холбогдолтой. Сумын захиргаатай хэлэлцсэний дараа усны эх үүсвэртэй ойр, хөрс сайтай өөр байршлыг сонгосон.
- Бид хүйтнээс хамгаалах зорилгоор үрийг өвсөөр хучиж үлдээсэн. Цэнхэрмандал сум нь өвч худалдан авах мөнгө санхүү дутмаг байсан тул Мерси Кор өвч худалдан авах зардлаас төлөлцсөн.

Үр нөлөө

Хамтын ажиллагаа: Эдгээр жижиг хэмжээний төслүүд нь орон нутгийн засаг захиргаа болон нутгийн иргэдийн хамтын ажиллагааны үнэ цэнийг илтгэн харуулсан. Сумын захиргаа болон нутгийн иргэд нь хөрөнгө болон хөдөлмөрөө хандивлан, бордох, үр тарих, мэдээллийн самбар босгох зэрэг дээр ажилласан. Сумын захиргаа, ИТХ нь талбайн цаашдын засвар ашиглалт, арчилгааг хариуцаж, сумын ЗДТГ нь туршилтын талбайг хариуцан ажиллах өөрийн ажилтууддаа урамшуулал олгоно.

Мөн цаашид аймгийн ХАА-н газар нь талбайн засвар үйлчилгээ, арчилгаанд техникийн туслалцаа үзүүлнэ. Аймгийн бэлчээрийн мэргэжилтэн нь тухайн талбайд жилд хоёр удаа ирж ажиллан, сумын мэргэжилтэнд зөвлөгөө өгч, хашааны ашиглалт, завсар үйлчилгээний талаарх төлөвлөгөөг боловсруулна. Тэд мөн туршлага судлах аялал, мэдлэг сайжруулах арга хэмжээг төрийн албан хаагчид болон бусад сумдын малчдын бүлгийн ахлагч нарт зориулан зохион байгуулна.

Мэдлэг нэмэгдүүлэх: Сумдын захиргаад нь хамгийн багадаа 15 мянган хүн жил тутам туршилтын талбайг үзэж сонирхох, бэлчээрийн доройтлын сөрөг нөлөө, бэлчээр хамгаалахын ач холбогдол, хөрс сэлгэх болон бордохын давуу талуудын талаар мэдэж авна хэмээн тооцож байна.

Энэ тоо нь нутгийн болон хөрш сумдын малчид, сумын иргэд, сумаар дайран өнгөрч буй хүмүүсийг багтаасан. Туршилтын талбай нь ирж буй бүх хүмүүст бэлчээрийн нөхөн сэргээлтийн аргуудын талаар мэдэх боломжийг олгож байгаа юм. Түүнчлэн мэдээллийн самбарууд нь нөхөн сэргээлтийн арга бүрийг тайлбарлаж, давуу талуудын тухай мэдээлэл өгнө. Мэдээллийг самбарыг сумын мэргэжилтнүүд аймгийн ХАА-н газраас туслалцаа авсны үндсэн дээр хоёр жил тутамд шинэчлэх үүрэгтэй.



Амжилтын түүх

БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ, ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ БҮСЧИЛСЭН СУРГАЛТ

Түншлэгчийн нэр: ХХАХХҮЯ, ГЗБГЗЗГ, МБАХ, ХААИС, МААЭШХ

Төслийн байршил: Ховд, Баян-Өлгий, Хэнтий аймгийн төв

Хугацаа: 2020 оны 10 сар – 11 сар

Танилцуулга

Цаг уурын өөрчлөлт, мал маллагааны хоцрогдсон арга, бэлчээрийн даац хэтэрсний улмаас монголын нийт бэлчээрийн 60% нь доройтолд орсон. Малын тоо нь бэлчээрийн даацаас хэтэрч, улмаар хөрсний өнгөн давхарга элэгдэх, Монголд бэлчээр доройтох, цөлжих үйл явц эрчимжиж байна. Эдгээр асуудлууд монголын мал аж ахуйн салбарын ирээдүйг эрсдэлд оруулж байгаа билээ.

Бэлчээрийн зохистой менежмент нь бэлчээрийн доройтлыг арилгах, сэргээхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Сум бүрт бэлчээрийн менежментийг хариуцсан гурван мэргэжилтэн байдаг. Үүнд: бэлчээр хариуцсан мэргэжилтэн, мал үржлийн мэргэжилтэн, газрын даамал нар орно. Газрын даамал нь аймгийн газрын алба, мал үржлийн мэргэжилтэн

нь аймгийн мал эмнэлгийн газар, бэлчээр хариуцсан мэргэжилтэн нь сумын засаг даргад харьяалагддаг. Түүнчлэн, ихэнхи суманд эдгээр гурван мэргэжилтэн хамтран бэлчээрийн менежментийн чиглэлээр ажиллуулдаг нэгдсэн төв, систем байдаггүй. Бодит амьдрал дээр гурван мэргэжилтэн бие биенийхээ ажил үүргийг сайн мэддэггүй, хоорондоо бэлчээртэй холбоотой мэдээлэл солилцдоггүй.

Бэлчээр хариуцсан мэргэжилтэн нь сумын хэмжээнд бэлчээрийн менежментийн жилийн төлөвлөөг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үүрэгтэй. Бэлчээр хариуцсан ихэнх мэргэжилтнүүд энэ чиглэлээр эзэмшсэн мэргэжлийн зэрэггүй, өөр мэргэжилтэй хүмүүс байдаг нь хүндрэл үүсгэдэг. Түүнчлэн бэлчээрийн менежментийг санхүүжүүлэх талаар тодорхой хууль журам байдаггүй. Үр дүнд нь суманд бэлчээрт зориулсан төсөв байдаггүй бөгөөд энэ нь бэлчээрийг удирдан зохион байгуулахад саад учруулдаг.

Газрын даамал нь газар төлөвлөлт, бүртгэл (кадастр) болон бэлчээрийн эрүүл мэндийн хяналтыг сумын түвшинд хийдэг. Фото мониторингийн үр дүн дээр үндэслэж, бэлчээрийн төлөв байдал болон даацыг тодорхойлдог. Газрын даамал нь бэлчээрийн фото мониторингийн мэдээллийг суманд танилцуулахгүй Газрын удирдлагын нэгдсэн системд шууд татаж оруулдаг. Фото мониторингийн мэдээллийг аймгийн газрын алба хянаж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт (ГЗБГЗЗГ) хүргэдэг. ГЗБГЗЗГ-ын мэргэжилтнүүд өгөгдлийг ашиглан гурван төрлийн газрын зураг боловсруулдаг: 1) бэлчээрийн төлөв байдал, доройтол 2) бэлчээрийн нөхөн сэргэлт чадавх 3) бэлчээрийн даац.

Мал үржлийн мэргэжилтэн нь суман дахь малын чанар, сүргийн менежментийг хариуцдаг. Тэд сүргийн менежментийг судалж, дүн шинжилгээ хийх замаар, малчдад малын тоог бэлчээрийн даацад тохируулахад нь тусалж, бэлчээрийн доройтлыг бууруулдаг. Мал үржлийн мэргэжилтэн малын тоо толгой, бэлчээрийн даац дээр үндэслэн сүргийн менежментийн богино болон урт хугацааны стратеги боловсруулдаг. Хэрэв малын тоо толгой нь бэлчээрийн даацаас хэтэрвэл малын чанарыг сайжруулж, малын тоог бууруулахыг малчдад зөвлөдөг. Шинжилгээ хийснээр аль малчин өрх малынхаа тоо толгойг бууруулж, хэдэн мал жил бүр нядлахыг тодорхойлно. Одоогийн байдлаар мал үржлийн мэргэжилтэн нь малын тоо толгой, бүтцийг тооцоолохдоо хуучирсан арга хэрэглэдэг. Энэ ажилд маш их цаг хугацаа зарцуулж, алдаа их гардаг.

Товч хураангуй

“Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь – 3” (LTS3) төсөл нь гамшгийн эрсдэлийн бэлэн байдал болон бэлчээрийн менежментийг сайжруулах замаар малчин өрхүүдийн эмзэг байдлыг бууруулахыг зорьдог. LTS3 төсөл Ховд, Увс, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар аймгуудад хэрэгждэг. Эдгээр таван аймагт 10 сум сонгож бэлчээрийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад техникийн болон мөнгөн бус

туслалцаа үзүүлсэн. LTS3 төсөл нь зорилтот аймгуудад бэлчээрийн менежментийг сайжруулах төрийн бодлогод илүү өргөн хүрээнд дэмжлэг үзүүлж байгаа. Энэ ажлын хүрээнд Мерси Кор 2020 оны 10-11-р сард, зорилтот аймгуудад “Бэлчээрийн менежментийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх” бүсчилсэн цуврал сургалтыг Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХАХХҮЯ), ГЗБГЗЗГ, Монголын бэлчээр ашиглагчдын холбоо (МБАХ), Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС), Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнтэй (МАОЭШХ) хамтран зохион байгууллаа. Сургалтын зорилго нь:

- Бэлчээрийн нөхцөл байдал, менежмент, бэлчээр ашиглалтын гэрээ, бэлчээр ашиглах журам, мал түүхий эдийн бүртгэл мэдээллийн систем, бэлчээрийн менежментийн сайн туршлагауудыг танилцуулах
- Бэлчээр хариуцсан мэргэжилтэн, мал үржлийн мэргэжилтэн, газрын даамалыг мэргэжлийн зөвлөхүүдтэй холбож ажиллуулах;
- Бэлчээрийн доройтлоос хамгаалахад малчдад дэмжлэг үзүүлэх, мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг сайжруулахад шаардлагатай бүх мэдээллийг сумын мэргэжилтнүүдэд олгох

Сургалтыг Мерси Кор болон ХААИС, ХХААЯ, ГЗБГЗЗГ, МБАХ, МАОЭШХ-гийн зөвлөхүүд гурван өөр аймагт, гурван бүлэг оролцогч нарт зохион байгуулсан. Доорх хүснэгтээс дэлгэрэнгүй мэдээллийг харна уу:

Хүснэгт 2. Нийт оролцогчдын тоо

Сургалтын нэр	Байршил, аймаг	Огноо	Оролцогч
Бэлчээр хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалт	Ховд, Хэнтий	10-р сарын 19-20 10-р сарын 28-29	Ховд, Увс, Баян-Өлгий аймгаас 48 оролцогч Хэнтий, Сүхбаатар аймгаас 32 оролцогч
Мал үржлийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалт	Ховд, Хэнтий	10-р сарын 21-22 10-р сарын 30-31	Ховд, Увс, Баян-Өлгий аймгаас 49 оролцогч Хэнтий, Сүхбаатар аймгаас 32 оролцогч
Газрын даамлуудад зориулсан сургалт	Баян-Өлгий, Хэнтий	10-р сарын 23-25 11-р сарын 1-3	Ховд, Увс, Баян-Өлгий аймгаас 55 оролцогч Хэнтий, Сүхбаатар аймгаас 32 оролцогч
Нийт дүн			248 оролцогч

Арга зүй

Сургалтын хөтөлбөрүүд хоорондоо ижил төстэй байсан бөгөөд дараах сэдвээр явагдсан:

1. Мал аж ахуй, малын эрүүл мэнд, бэлчээрийн менежментийн талаар төрөөс баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ;
2. Бэлчээрийн менежмент: одоогийн нөхцөл байдал, бэлчээрийн даац, бэлчээр ашиглалтын гэрээ, бэлчээр ашиглах журам, бэлчээрийн эрсдэлийн сан, мал түүхий эдийн бүртгэл мэдээллийн систем, сайн туршлагаууд;
3. Сүргийн менежмент: эрчимжүүлсэн мал аж ахуй, малын чанар ашиг шим, сүргийн хэмжээ, бүтэц;
4. Сургалтын өмнөх ба дараах мэдлэг шалгах тест.

Ерөнхий хөтөлбөр адилхан байсан боловч мэргэжилтнүүдийн үүрэг, хариуцлагаас хамаарч сургалтууд хоорондоо ялгаатай байсан. Тухайлбал, мал үржлийн мэргэжилтнүүд компьютерын шинэ программ дээр тухайн бэлчээрийн даацанд тохирсон малын тоог урт болон богино хугацаанд тооцоолж гаргаж сурсан.

Бэлчээр хариуцсан мэргэжилтнүүд бэлчээрийн менежментийн шилдэг туршлагауудаа танилцуулж, мэргэжилтнүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, бүс нутагтаа бэлчээрийн менежментийн үйл ажиллагаа хэрхэн хэрэгжүүлэх талаар санал бодлоо солилцож, сумынхаа ирэх жилийн БМТ-г боловсруулсан.

Газрын даамалууд нь бэлчээр ашиглалтын гэрээ болон бэлчээрийн менежментийг сайжруулахад өөрсдийн үүрэг оролцоогоо хэлэлцсэн. Сумдууд дөрвөн жилийн өмнө бэлчээр ашиглалтын гэрээг бүртгэж эхэлсэн, гэвч хуучирсан програм хангамж, бүрэн бус гэрээнээс болж бүртгэлийн үйл явц тодорхойгүй хугацаагаар зогссон. Сургалтын үеэр газрын мэргэжилтнүүд компьютерийн шинэ программаар цахим бүртгэл хөтлөж сурч, бүх гэрээг Газрын удирдлагын нэгдсэн системд бүртгэсэн.

Мерси Кор сургалтыг ХААИС, ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ, МБАХ зэрэг түнш байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Сургалтын эхний өдрийг Мерси Корын гэрээт зөвлөхүүд удирдан зохион байгуулсан. Мерси Кор бэлчээр болон сүргийн менежмент, бэлчээр ашиглалтын гэрээ, журам, эрсдэлийн сан, сайн туршлага зэрэг сэдвээр оролцогчдод мэдээлэл өгсөн. Сургалтын хоёр дахь өдрийг ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ удирдсан. Тэд төрөөс баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, өвлийн бэлтгэл, малын татвар болон бэлчээрийн хуулийн талаарх мэдээлэл өгсөн (тэр хууль дээр өөрсдөө одоо ажиллаж байгаа). ГЗБГЗЗГ техникийн хоёр зөвлөхийг газрын даамлуудад зориулсан сургалтанд оролцуулсан. Зөвлөхүүд нь газрын даамлуудад бэлчээр ашиглуулах гэрээг Газрын удирдлагын нэгдсэн системд алдаагүй бүртгэхийг зааж өгч, ирэх жилийн ГЗБГЗЗГ-ын төлөвлөгөөний талаар мэдээлэл солилцсон.

Эдгээр сургалтууд нь төвийн болон орон нутгийн байгууллагуудын хооронд холбоо тогтоох сайхан боломж олгосон. Санхүүжилтийн хомсдлоос болж үндэсний агентлагууд орон нутгийн мэргэжилтнүүдтэй уулзах боломж тэр бүр олддоггүй.

ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ-ын зөвлөхүүд төрийн бодлогыг тайлбарлаж, орон нутагт тулгарч буй саад бэрхшээлийн талаар сонслоо.

ХХААХҮЯ-ын зөвлөх сүргийн менежмент, малын чанар, мал үржил, сүргийн менежментийн хөтөлбөрт тулгарч байгаа асуудлуудаар ярилцсан. МБАХ-ын зөвлөх бэлчээрийн одоогийн төлөв байдал, менежмент, бэлчээр ашиглалтын гэрээ, бэлчээр ашиглах журам, түүхий эдийн бүртгэл мэдээллийн систем, бэлчээрийн менежментийн шилдэг туршлагауудын талаар хэлэлцсэн.

Зардал хуваалцах

Мерси Кор 58.3 сая төгрөгийг сургагч багш нарын унаа, байр, томилолтын зардалд зарцуулсан. Мөн оролцогчдын сургалтын үеэр байрлах байр болон томилолтын зардлыг даасан. Төрөөс оролцогчдын замын зардал, томилолт, цалингийн зардлыг төлсөн.

Үр нөлөө

Сургалтаар олсон мэдлэгийг үнэлэхийн тулд оролцогчид сургалтын өмнө болон дараа нь тест өгсөн. Сургалтын өмнө Мерси Кор, ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ-ын хоёр зөвлөхтэй хамтран тестийн асуулгыг боловсруулсан. Тест бүр 11 асуултаас бүрдсэн бөгөөд оролцогчдын төрлөөс хамааран асуултууд өөр, өөр байсан.

Сургалтын үр дүнд оролцогчдын мэдлэг, ойлголт дунджаар 20%-оос илүү хувиар дээшилсэн. Газрын даамлуудын мэдлэгийн түвшин 64%-иас 84% болж өссөн. Мал үржлийн мэргэжилтнүүдийн мэдлэг дунджаар 14%-иар нэмэгдэж, 65-аас 79% болж өссөн. Бэлчээрийн мэргэжилтнүүдийн мэдлэг хамгийн их өссөн: 58-аас 80% болсон.

Сургалтууд амжилттай болж өнгөрсөн. Анх удаа сумын бэлчээртэй холбоотой гол мэргэжилтнүүд цугларч, бэлчээрийн менежмент, бэлчээр ашиглалтын гэрээ, журмын талаар мэдлэг мэдээлэл олж авсан. Сургалтын гол үр дүн:

Бэлчээрийн менежментийг сайжруулахад хамтын ажиллагааны ач холбогдлыг оролцогчид ойлгож авсан. Дээр дурьдсанаар гурван гол мэргэжилтэн өөр өөр хэлтэст ажилладаг, өөр хүмүүст ажлаа тайлагнадаг, чухал мэдээллийг бие биетэйгээ хуваалцдаггүй. Сургалтын үр дүнд оролцогчид мэдээлэл солилцохын ач холбогдлыг ойлгож, бусад мэргэжилтнүүдийн ажил үүргийн талаар илүү мэдлэгтэй болж, бусад хэлтэс, газрын ажилтнуудтай үр дүнтэй хамтран ажиллах үр чадвараа бэхжүүлсэн.

Хамтын ажиллагаа сайжирвал БМТ, газрын менежментийн төлөвлөгөөг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Түүнчлэн сургалтын үеэр аймгууд бэлчээрийн менежментийн шилдэг туршлагауудаа танилцуулсан. Үр дүнд нь оролцогчдод бусад мэргэжилтнүүдээс суралцах, хамтран ажиллах сонирхол төрж, төрийн бодлогод нийцсэн бэлчээрийн менежментийн стратеги боловсруулах урам зориг нэмэгдсэн.

Оролцогчид шинэ мэдлэг, үр чадвар олж авсан.

- Мал үржлийн мэргэжилтнүүд сүргийн эргэлт тооцоолох програм хангамж ашиглаж сурсан. Энэ нь малын тоо толгойг компьютерт шивж оруулснаар сүргийн бүтэц, хэмжээг богино хугацаанд тооцоолох боломж олгодог шинэ, дэвшилтэт программ юм. Энэ мэдээллийг ашиглан сумын газрын менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, бэлчээрийн даацад тохирсон малын тоог тооцоолох боломжтой юм. Засгийн Газар энэхүү програм хангамжийг ашиглахыг үүрэг болгосон ч газрын даамлуудад үүнийг сурах, ашиглах боломж хомс байсан. Тиймээс сургалтын хөтөлбөртөө энэ шинэ программыг сурах, дадлага хийх тусгай цаг гаргаж, асуулт асууж, зөвлөгөө авах боломжийг нь нээсэн.
- Газрын даамлууд бусад аймгийн бэлчээрийн менежментийн шилдэг туршлагауудын талаар мэдээлэл авч, бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахын ач холбогдлыг сайтар ойлгосон. Түүнчлэн газрын даамлууд сургагч багштайгаа хамтарч бүртгүүлээгүй үлдсэн бүх бэлчээр ашиглалтын гэрээг Газрын удирдлагын нэгдсэн системд бүртгэж оруулсан. Даамлууд энэхүү системийг өмнө ашиглахдаа байнга алдаа гаргадаг байсан. Тиймээс сургагч багш мэдээллийг хэрхэн алдаагүй оруулахыг зааж өгсөн.
- Эцэст нь газрын даамлууд ГЗБГЗЗГ, Ногоон Алт төсөлтэй (ШХС-гийн санхүүжилттэй) хамтран бүх суманд хэрэгжүүлсэн фото мониторингийн үр дүн ба ирэх жилийн төлөвлөгөөний талаар мэдээлэл авсан.
- Бэлчээр хариуцсан мэргэжилтнүүд бэлчээрийн менежментийн ач холбогдлын тухай мэдлэгээ нэмэгдүүлж, шилдэг туршлагауудын тухай сонссон. Сургалтын үеэр мэргэжилтнүүд сумынхаа БМТ-г боловсруулах дадлага хийсэн. Сургалтын дараа тэд бусад мэргэжилтнүүдтэйгээ хамтран БМТ-г сайжруулах болно. БМТ бэлэн болохоор ИТХ-д өргөн барьж батлуулна.

Төвийн болон орон нутгийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа бэхжсэн – Орон нутаг болон төвийн мэргэжилтнүүд хамтын ажиллагаагаа сайжруулсан. Мэргэжилтнүүд сургалтын үеэр ХХААХҮЯ, шийдвэр гаргагч нарт ажлын хүнд нөхцөл байдал, мэргэжлийн үр чадвараа дээшлүүлэх боломж хомс, бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх төсөв хөрөнгө дутагдаж байгаа талаарх асуудлуудаа танилцуулсан. Бэлчээрийн менежментийн салбарт ажилладаг ч бэлчээрийн менежмент эсвэл хөдөө аж ахуйн мэргэжилгүй хүмүүст зориулан богино хугацааны сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх хүсэлтийг ХХААХҮЯ-д тавьсан. ХХААХҮЯ-ны төлөөлөгч нар эдгээр саналуудыг хүлээж авч, мэргэжилтнүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэжлийн бус хүмүүст бэлчээрийн менежментийн богино хугацааны сургалтыг зохион байгуулахыг амласан.

Шагдарсүрэн, Хэнтий аймгийн Дархан сумын мал үржлийн мэргэжилтэн

Би мал үржлийн мэргэжилтнээр олон жил ажилласан боловч шинэ технологийг ашиглах тал дээр мэдлэг дутагддаг байсан. Би энэ сургалтанд сууж сүргийн эргэлтийн программ ашиглаж сурсан. Миний ажил 90% сайжирсан. Компьютерийн товчлуур дарж, тооцоо хийх нь ямар амархан байдагт итгэж чадахгүй байсан. Би энэ программаар бэлчээрийн даацыг тодорхойлох, даацанд тохирсон малын тоо бүтцийг тооцоолох, бэлчээрийн урт хугацааны стратеги боловсруулдаг.

Б. Салауат, Баян-Өлгий аймаг, Толбо сумын газрын даамал

Энэ сургалтаас би бэлчээр ашиглуулах гэрээ, журам, бэлчээрийн эрсдэлийн сангийн ач холбогдлыг сайн ойлгосон. Газрын удирдлагын нэгдсэн системд бэлчээр ашиглуулах гэрээг бүртгэж сурах нь надад маш хэрэгцээтэй байсан. Сургагч багш нарын тусламжтайгаар сумынхаа 13 бэлчээр ашиглагчдын бүлгийн бүх гэрээг бүртгэж авлаа. Энэ сургалтыг зорилгодоо хүрсэн гэж би бодож байна. Туршлагатай сургагч нарынхаа удирдлага дор бид дадлага хийсэн. Сургалтыг зохион байгуулсан Мерси Кор, ГЗБГЗЗГ болон сургагч нартаа талархсанаа илэрхийлье.

Ц. Гантөмөр, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Бэлчээр хариуцсан мэргэжилтэн

Би өнгөрсөн жил Баян-Өлгий аймагт Бэлчээрийн үнэлгээ хийх сургалтанд суусан. Энэ бол Мерси Корын зохион байгуулсан миний хоёр дахь сургалт байсан. Сумын хөдөө аж ахуйн нэгжид гурван мэргэжилтэнтэй. Нөгөө хоёр мэргэжилтэнтэй харьцуулбал бэлчээрийн мэргэжилтнүүд чадавх бэхжүүлэх сургалтанд хамрагдах боломж хомс байдаг. Түүнчлэн, миний энэ ажлын байранд бэлчээрийн мэргэжилтэй хүн маш цөөхөн ажилладаг. Би энэ чиглэлээр сүүлийн хоёр жил ажиллаж байгаа, надад бэлчээрийн менежментийн зэрэг мэргэжил байхгүй. Тийм учраас ийм сургалтууд надад нэн чухал байдаг.

Сургалтаар би бэлчээрийн талаар баримталдаг төрийн бодлого, бэлчээр ашиглалтын гэрээ, журам, бэлчээр хамгаалахад малчдын оролцоо ямар чухал болохыг олж мэдлээ. Бид бэлчээрийн шилдэг туршлагаудаа бусадтай хуваалцсан бөгөөд мөн өөрийнхөө суманд хэрэгжүүлж болох олон сонирхолтой түүх сонсож авлаа. Тэр ч байтугай хууль эрх зүйн орчингүйгээр бусад мэргэжилтнүүдтэйгээ бэлчээрийн чиглэлээр үр дүнтэй хамтран ажиллах олон боломжууд байгааг олж харлаа.



Амжилтын түүх

**НОГООН БЭЛЧЭЭР
ТУРШИЛТЫН ТӨСӨЛ**

Түншлэгчийн нэр: Сумын малчид, ХасБанк, Бодлого Судлалын Төв

Төслийн байршил: Хэнтий аймгийн Баян-Овоо сум

Хугацаа: 2018 оны 12 сар – 2021 оны 1 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” (RCP) хөтөлбөр хоёр том зорилготой: 1) малчид болон орон нутгийн бизнес эрхлэгчдийн санхүүгийн хүртээмжийг ихэсгэх 2) Монголын хөдөө орон нутагт мал аж ахуйн үйлдвэрлэлийн чанарыг сайжруулах. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Мерси Кор нь ХасБанктай хамтран Ногоон Бэлчээр Туршилтын Төслийг хоёр жилийн турш хэрэгжүүлсэн. Мал аж ахуй, мал маллах нь Монгол улсын ДНБ-ийн 10% болон нийт ажлын байрны 30%-ийг эзэлдэг эдийн засгийн томоохон хэсэг юм. Мал аж ахуйн салбарын өсөлт нь сүргийн тоог нэмэгдүүлэхээс хамааралтай байдаг бөгөөд нийт малын тоо 2010 онд 32.7 сая байсан бол 2020 онд 67.1 сая болж өссөн байна. Гэвч энэ өсөлтийн хажуугаар малын ашиг шим буурах, бэлчээрийн даац хэтрэх зэрэг сөрөг үр дагаварууд зэрэгцээд бий болсон. Бэлчээрийн талбай

олон нийтэд нээлттэй байдаг мөн сүргийн тоо толгойн өсөлтөд Засгийн газраас хяналт сул байдгаас үүдэн хүрээлэн буй орчин болон нийгэмд тохиолдох сөрөг үр дагавар ихсэж байна. Үүнд баян малчид нь бэлчээрийн талбайгаа өсгөх, ядуу малчид нь газар эзэмших эрхээ алдах, бэлчээр доройтсоноос болж биологийн төрөл зүйл устгах болон аялал жуулчлалын үнэ цэн алдагдах гэх мэт үр сөрөг дагавартай байна. Одоогийн байдлаар нийт бэлчээрийн 65% нь даац хэтэрснээс болж доройтолд орсноос 7% нь сэргээгдэх боломжгүй болсон байна.

Эдийн засгийн хувьд бэлчээрийн доройтол нь малын тэжээлийн хомсдолд хүргэж, мал нь амьдын жингийнхээ тал хүртэлх хувийг алдах, малаас гарах ашиг шимийг багасах болон өвчинд амархан нэрвэгдэхэд хүргэдэг. Малын ашиг шим буурснаас үүдэлтэйгээр жилд нэг малчин өрхөд 2.6 сая төгрөгийн алдагдал ногдож байгаа нь тухайн малчны жилийн орлогын 20% орчим эзэлдэг байна. 2017 оны малын зах зээлийн үнэлгээг 2013 онтой харьцуулахад 37%-иар буурсан байна⁹. Малын тоог өсгөх уламжлалт сэтгэлгээ нь малчдын тоо хэмжээнээс илүү чанарыг баримтлах, ашиг шимийг дээшлүүлэх боломжуудыг олж харах чадварт саад болдог. Түүнчлэн махны өртгийн сүлжээний сул талууд, ялангуяа мах үйлдвэрлэгчдийн хот суурин газарт төвлөрдөг нь ядуу малчдад зах зээлд гарахад ноцтой бэрхшээлийг бий болгодог.

2015 оны байдлаар 200-аас цөөн малтай ядуу малчид нийт малчдын бараг тал хувийг (45.5%) бүрдүүлж, нийт малын 14%-ийг эзэмшиж байгаа бол 1000-аас олон малтай баян малчид нийт малчдын 5.4%-ийг бүрдүүлж, нийт малын 22%-ийг эзэмшиж байна. 200-аас цөөн малтай ядуу малчид илүү хүчирхэг, танил тал сайтай баян малчдад шахагдаж өвөлжөө, хаваржаа эзэмших эрхээ алдаж, барагцаагаар гуравны нэг нь өвөлжөө, хаваржаа байдаггүй байна.

Ойрын хугацаанд Монгол Улсын Засгийн газар энэхүү бодит байдлыг мэдэрч эхлэн, малын тооноос илүүтэйгээр малаас гарах ашиг шимийг эрхэмлэх хандлагатай болж байна. “Монгол мал” үндэсний хөтөлбөр (2012) мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэх зорилго дэвшүүлжээ. Түүнчлэн малын тоог 43.3 саяас 35.3 сая болгон бууруулах зорилт тавьсан боловч, энэ зорилт биелээгүй, эсрэгээрээ малын тоо дээр дурьдсаны дагуу 2020 онд 67.1 сая болж өссөн байна.

“Монгол Улсын тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө” нэртэй бодлогыг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар 2018 оны 6-р сард баталсан. Уг бодлогын хүрээнд бэлчээр ба усны нөөцийг сэргээх, зохистой, хариуцлагатай ашиглах, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг

⁹ Бодлого Судлалын Төв “Монголчууд Америкчуудын 100 жилийн өмнө шийдвэрлэж чадсан асуудлыг хийж чадах уу” (2019)

бууруулах, малын тоо 2017 оны байдлаар бэлчээрийн оновчтой даацаас 25 сая хонин толгойгоор хэтрээд байгааг 5 сая хонин толгойгоор¹⁰ бууруулах зорилт дэвшүүлжээ. Гэвч малын тоо хөөцөлдсөн малчдын сэтгэлгээг өөрчлөх чадвартай урамшууллын хөшүүргүүдийг нэвтрүүлэхгүйгээр эдгээр зорилтот хүрэх эсэх нь нэн эргэлзээтэй хэвээр байна.

Тиймээс бэлчээрийн доройтлын нэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, малчин өрхийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Мерси Кор байгууллага ХасБанк, Бодлогын Судлалын Төвтэй хамтран Хэнтий аймгийн Баян-Овоо суманд Ногоон Бэлчээрийн төслийг 2018 оны 12-р сараас хэрэгжүүлж эхэлсэн. Төслийн зорилго нь малчдыг бэлчээрийн даац хэтрүүлэн ашигладаг тогтвортой бус зан үйлээс татгалзуулж, үүний оронд урт хугацааны туршид байгальд ээлтэй аргаар малчдын орлогыг нэмэгдүүлэх стратеги хэрэгжүүлэх туршилтын төсөл юм.

Хэрэгжүүлэгч байгууллага болох Бодлого Судлалын Төв (БСТ) нь байгальд ээлтэй аргаар малчдын орлогыг нэмэгдүүлэх санаачилгыг 2000 оноос эхлэн хэрэгжүүлж ирсэн. 2017 онд Бодлого Судлалын Төв нь (а) малчид малын тоог сайн дурсаар цөөлөх боломжтой болохыг Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (ДБХ)-ийн “Ирвэст ээлтэй бэлчээрийн менежмент” төслийн хүрээнд баталсан бөгөөд (б) малын тоог цөөлөх санаачилгыг дэмжих малчдын зээлийн бүтээгдэхүүнийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн хүрээнд боловсруулсан. Энэхүү өмнөх туршлагаас харахад Бодлого Судлалын Төвийн үйл ажиллагаа нь Мерси Кор, ХасБанкны хэрэгжүүлэх төслийн зорилгод нийцсэнээр бэлчээрийн менежментийг сайжруулах, малчдын хандлагыг өөрчлөх төсөлд нэгдсэн.

Анх 2018 онд төсөл хэрэгжиж эхлэхэд Хэнтий аймгийн Баян-Овоо сумыг дараахь шалгууруудыг үндэслэн төслийн байршлаар сонгосон:

- Одоогоор хэрэгжүүлж буй бэлчээр хамгаалах үйл ажиллагаа. “Бэлчээр ашиглалтын журам”-ыг сумын ИТХ-аар 2018 онд баталж, малчдын бүлэг тус бүрт бэлчээрийн хамгаалалтад хяналт тавих ахлагчийг томилсон.
- Албан ёсны 8 малчин хоршоо, 29 аравт малчдын бүлэгтэй бөгөөд хоршоодын чадавхи нь өндөр болон малчдын бүлгийн зохион байгуулалт сайн.
- Сумын малын эмч нар нь өндөр чадавхитай. Үйл ажиллагаа явуулдаг 3 ХМЭ, 8 малын эмч, 4 малын зоотехниктэй.
- Орон нутгийн засаг захиргааны дэмжлэг. Орон нутгийн засаг захиргаа төслийн үйл ажиллагаа, төлөвлөгөөг бүрэн дэмжиж байсан бөгөөд урьд нь бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг сайжруулах санаачилга гаргасан.
- Мерси Корын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хөтөлбөртэй уялдаа холбоотой. Мерси Кор нь өмнө нь суманд суурь судалгаа хийсэн ба LTS3 төслийн зорилтот сум байсан
- Сумыг эрүүл малын бүс болгон зарлах боломжтой. Өмнөх 4 жилийн хугацаанд

¹⁰ Хонин толгой нь коэффициент ашиглан малын төрөл зүйлийг нэгтгэхэд хэрэглэдэг нэгж юм. (Хонь = 1 хонин толгой; Ямаа = 0.9 хонин толгой; Морь = 6.6 хонин толгой; Тэмээ = 5.7 хонин толгой)

суманд малын гоц халдварт өвчин гараагүй. Түүнчлэн бүх вакцинжуулалт, мал эмнэлгийн үйлчилгээг цаг тухайд нь хийсэн.

Аравтын системийн философи нь бэлчээрийн менежментийн гэрээг хэрэгжүүлэхэд үндэслэн сумын малчдыг бие биендээ харилцан туслалцах зохицуулалтыг хийхэд оршино. Баян-Овоо суманд Аравтын системд 29 малчны бүлэг байдаг ба тус бүр нь 10 малчин өрхтэй. Сонирхолтой нь Баян-Овоо суманд Аравтын удирдагчдын ихэнх нь эмэгтэйчүүд байна.

Эдгээр шалгууруудад үндэсдэн Хэнтий аймгийн 4 сумаас Баян-Овоо сумыг хамгийн боломжтой, орон нутгийн засаг захиргаанаас төслийн үйл ажиллагаанд бүрэн хамтран ажиллах төслийн байршлаар сонгосон. Хэдий сумын малчдын зохион байгуулах тогтолцоо нь сайн ч гэсэн 2017 онд сумын нийт малын тоо 188 мянган толгой буюу 352 мянган хонин толгойд хүрч, нэг хонин толгойд ногдох бэлчээрийн хэмжээ ердөө 0.6 га болон буурч, Баян-Овоо сумын бэлчээрийн даац нь 90% ихэссэн байна.

Төслийн аргачлал

Ногоон Бэлчээр төсөл нь Баян-Овоо сумын малын тоог цөөлөх, байгальд ээлтэй аргаар малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор хэд хэдэн шинэлэг аргачлалыг ашигласан. Эдгээр аргачлал нь БСТ байгууллагын өмнө нь хэрэгжүүлж байсан чадавхи бэхжүүлэх сургалтууд болон эко ногоон зээл олгох замаар малчдыг төсөлд оролцуулах туршлага дээр үндэслэсэн. Төслийн талаар мэдээлэл хүргэх, сурталчлах зорилгоор, эхний ээлжинд БСТ байгууллага малчид болон сумын удирдлагуудтай төслийн зорилго, төсөлд хамрагдахын ашиг тус болон эко зээлд хэрхэн хамрагдах талаар нүүр тулсан уулзалт, сургалт зохион байгуулсан. Шаардлага хангаж, эко зээлд хамрагдахын тулд малчдаас эхлээд Бэлчээр ашиглалтын гэрээ (БАГ) болон Малын тоо цөөлөх гэрээ гэсэн хоёр гэрээ байгуулах шаардлагатай байв. Малын тоог оны эцсээр 6% бууруулах шаардлагатай гэрээг байгуулснаар, малчид зээлд хамрагдах хүсэлт гаргах боломжтой болсон. Малчдын зээлийн өргөдлийг эхлээд БСТ болон сумын албан хаагчид хамтран шалгаж, шалгуур хангасан өргөдлүүдийг ХасБанк руу дараачийн шатны хяналтад явуулсан. Өргөдөл өгсөн бүх малчид зээлд хамрагдаж чадаагүй ч, БАГ, малын тоо цөөлөх гэрээ байгуулсан малчдыг МААЭС болон МЧХБЦ-т хамрагдан мал, малын гаралтай бүтээгдэхүүнээ худалдахыг төслийн шугамаар уриалсан.

Доор дэлгэрэнгүй тайлбарласны дагуу туршилтын төсөл нь хандлагыг өөрчлөх зорилгодоо хүрэхийн тулд дараах аргачлалыг ашигласан:

Малчдын бүлэг, сумын Засаг даргын хооронд Бэлчээр ашиглалтын гэрээ (БАГ) байгуулах, малчин өрх, сумын Засаг даргын хооронд малын тоо цөөлөх гэрээ байгуулах замаар малчдын мал сүргийн тоог цөөлж, бэлчээрийн даацад зохистой төвшинд хүргэх амлалт бий болгох

Сонгогдсон малчдад эко ногоон зээл олгох замаар малчдын малын тоог бууруулах сонирхлыг улам дээшлүүлэх

- МААЭС-г нэвтрүүлж, бэлчээрийн болон малын эрсдэлийн менежментийн дагуу малчдын санаачлагыг санхүүжүүлэн дэмжих
- МЧХБЦ-г ажиллуулж, малын борлуулалтын ихэсгэх, малын эмчийн үзлэг, гарал үүслийн гэрчилгээгээр зах зээлийн үнээс дээгүүр үнээр борлуулах боломжийг бий болгох
- Малчид болон сумын захиргааны чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулж, төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэдлэгтэй болгох

Бэлчээр ашиглалтын гэрээ болон малын тоо цөөлөх гэрээ

Монгол Улсад хүнээс үүдсэн бэлчээр талхагдалт, доройтлын гол шалтгаан нь “нийтлэг хэрэглээний” дэглэм буюу хариуцлага хүлээлгэх механизм байхгүйгээс болж малаа хяналтгүй бэлчээрлүүлдэг шалтгаанаас болж бэлчээр доройтолд ордог байна. Энэ тогтолцооны хүрээнд бэлчээр ашиглагчид зөвхөн газар эзэмших эрхтэй байж ашиг шимээ хүртэх, газар нутгаа тогтвортой ашиглах хүчин чармайлт гаргадаг боловч орон нутагт бэлчээрийн газрыг хувийн өмчлөлд оруулахыг Үндсэн хуулиар хориглодог. Энэ нь онцгой байдлын үед бэлчээрийн газрыг сэлгэх, эргэх хөдөлгөөнд оруулах шалтгааны улмаас хориглодог байна. Тиймээс, бэлчээр ашиглалтын гэрээ (БАГ) нь өмчлөх сэтгэлгээг төлөвшүүлэх, малчдын талаас Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу малын тоог бэлчээрийн даацад тохируулан бууруулах цорын ганц хууль ёсны арга зам юм.

Бэлчээр ашиглалтын гэрээний гол зорилго нь одоогийн эмх замбараагүй, тогтвортой бус бэлчээр ашиглалтыг зогсоох хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж, албан ёсны гэрээгээр хэрэгжүүлэхэд оршино. Ногоон Бэлчээр төслийн хүрээнд, бэлчээр ашиглалтын гэрээг дараах үе шаттайгаар байгуулсан:

- Сумын засаг захиргаа, малчдад БАГ-г сурталчилж, нүүр тулсан сургалт зохион байгуулсан
- Хөрш айлын малчидтай бэлчээрийн хил хязгаарыг зөвшилцөх, тохиролцоход малчдын бүлэгт туслалцаа үзүүлсэн
- Малчдын бүлэгт баг, сумын Засаг даргатай БАГ байгуулахад туслалцаа үзүүлсэн
- Сумын засаг захиргаанд БАГ хэрэгжүүлэх, БАГ-ийн хүрээнд бэлчээрлэж байгаа мал сүрэгт хяналт тавихад туслалцаа үзүүлсэн
- Малчдын бүлэгт малын орлогын өсөлтийг хангалттай төвшинд байлгаж 5 жилийн хугацаанд малын тоо цөөлөх төлөвлөгөө гаргахад туслалцаа үзүүлсэн.

Малын тоог бууруулах гэрээ

Малын тоо цөөлөх гэрээ нь малчин өрх болон сумын Засаг даргын хооронд хийгдсэн гэрээ бөгөөд жил бүр малын тоогоо 6% бууруулахаар тодорхойлж байгуулсан. Түүнчлэн малчдад нийт хонин толгойг бууруулах 5 жилийн төлөвлөгөө боловсруулахад туслалцаа үзүүлсэн бөгөөд энэ төлөвлөгөө нь бэлчээр ашиглалтын гэрээний хавсралтад орсон.

Эко ногоон зээл

Малчдын орлого нь улирлын шинж чанартай байдаг бөгөөд ихэнх малчид богино хугацааны мөнгөний хэрэгцээгээ хангахын тулд арилжааны банкуудаас зээл авдаг. Хаан банк, Төрийн банк зэрэг банкуудын арилжааны зээл нь таагүй нөхцөлтэй, жилийн 18-24%-ийн өндөр хүүтэй, 24 сар хүртэлх зээл байдаг. Тиймээс, богино хугацааны зээлийн эрэлт өндөртэйг үндэслэн, Мерси Кор, ХасБанк хамтран бэлчээр ашиглалтын гэрээ, малын тоо цөөлөх гэрээ байгуулсан малчдад хөнгөлттэй эко ногоон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгосон.

ХасБанк нь жилийн 12% хүүтэй, 300 мянга- 20 сая төгрөгийн зээл олгосон. Түүнчлэн энэ зээл нь дараах давуу талтай:

- Хөнгөлттэй хүү (арилжааны хүүгээс бага)
- Хагас жилийн зээлийн эргэн төлөлттэй
- Малын даатгал авах сонголттой
- Малын эрүүл мэнд, бэлчээрийн чанарын талаарх чадвар бэхжүүлэх сургалтанд хамрагдах боломжийг олгосон.

БСТ баг нь сумын удирдлагууд, малчидтай малын тоог нэмэгдүүлэхийн оронд малын чанарыг сайжруулахын давуу тал, мах, малын гаралтай бүтээгдэхүүнийг борлуулах замаар бэлчээрт ээлтэй орлого нэмэгдүүлэх талаар нүүр тулсан уулзалт, сургалт зохион байгуулсан. БСТ нь малчдад зээлийн өргөдөл бичихэд туслалцаа үзүүлж, анхны саналуудыг шигшиж, зээлийн өргөдлийг Хэнтий аймгийн төвийн ХасБанкны салбарт хүргүүлсэн.

Мал аж ахуйн эрсдэлийн сан (МАОЭС)

Мал аж ахуйн эрсдэлийн сан нь Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (ДБХС)-гийн санхүүжилтээр 2017 – 2018 онд Ховд аймгийн Мөнх-Хайрхан суманд хэрэгжүүлсэн “Ирвэст ээлтэй бэлчээрийн менежмент” төслийн хүрээнд БСТ-ийн нэвтрүүлсэн шинэлэг аргачлал юм.

МАОЭС нь малчид болон сумын захиргаанд малын эрсдэлийн менежментийн үйл ажиллагааг хамтран санхүүжүүлэх, зардал хуваах механизмийг бүрдүүлэх зорилготой юм. Малчдаас нэг хонин толгой тутамд 500 төгрөг (сангийн нийт орлогын 62.5%), сумаас 300 төгрөг (сангийн нийт орлогын 37.5%) шимтгэж сангийн төсвийг бүрдүүлсэн. МАОЭС-ийн төсвийг дараах байдлаар зарцуулсан:

- 135 төгрөгийг малын үзлэг, гэрчилгээ олгох цэгийн үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг сумын төвшний ажлуудыг санхүүжүүлэх зорилгоор зарцуулсан
- 365 төгрөгийг бэлчээрийн менежмент, малын эрсдэл, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаатай холбоотой малчдын саналыг санхүүжүүлэх зорилгоор зарцуулсан
- 300 төгрөгийг МЧХБЦ дээр зах зээлд нийлүүлэх чанарын шаардлага хангасан малаа авчирч борлуулахад малчдыг урамшуулах зорилгоор зарцуулсан.

МЧХБЦ нь малчдыг зохих үзлэг, гэрчилгээжүүлэх зорилгоор нэг цэг дээр авчирч (мал эмнэлгийн гарал үүслийн гэрчилгээг нүдэн үзлэгт үндэслэсэн), гэрээ байгуулсан мах боловсруулах байгууллагад худалдан борлуулах шинэлэг аргачлал болохыг анхаарна уу.

МАОЭС-ийн хүрээнд малчид дараах 21 үйл ажиллагаанд саналаа ирүүлэх боломжтой байсан. Эдгээр үйл ажиллагаануудыг БСТ нь өмнө хэрэгжүүлсэн төслийн туршлага дээрээс үндэслэж, эрс тэс цаг уурын үед малын эрсдэлийг бууруулах, бэлчээр ашиглалтыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж болохуйц үйл ажиллагаанууд гэж сонгосон. Түүнчлэн, сумын захиргаа болон малчидтай санал солилцож тохирилцсон.

Сумын мал аж ахуйн эрсдэлийн сангаас санхүүжүүлэх боломжтой ажлын жагсаалт:

1. Хадлангийн талбай бууцаар бордох
2. Булгийн эх хаших, булаг тохижуулах
3. Бэлчээрийн хортон, мэрэгч, царцаатай тэмцэх арга хэмжээ авах
4. Тэжээлийн олон наст ургамлын үр бэлтгэж, бэлчээр хадлан сайжруулах
5. Гэрээт бэлчээр дээрх амьтан, ургамал хамгаалах
6. Гүний худгийн насос, онгоц засах
7. Усан сан, хөв байгуулах, засах
8. Байгаль хамгаалах зорилгоор мод, бут тарих
9. Гэрээт бэлчээрийн ургац тогтоох, хяналтын хэмжилт хийх ажлыг гишүүдийн хүчээр гүйцэтгэх
10. Бэлчээр ашиглалтын гэрээ, МАОЭС-аас санхүүжүүлж хэрэгжүүлсэн ажлын хэрэгжилтэд бүлгийн ахлагчийн зүгээс хяналт тавих
11. Өвс, тэжээл бэлтгэх, түүнд зориулж дундын сан бүрдүүлэх
12. Малын хашаа, саравч засварлах, дулаалах
13. Өвс, тэжээлийн хашаа, жижиг агуулах засварлах
14. Бага оврын цас хагалагч (дальпуу) хийх
15. Гар худаг гаргах, лайдах, худгийн хашлага, ам, ховоо, онгоц засах
16. Хадлан, тэжээлийн жижиг оврын техник худалдан авах
17. Орлого нэмэгдүүлэх зорилгоор төмс, хүнсний ногоо, мод, жимс, жимсгэнэ тарих
18. Хадлангийн талбайн хөцөө засах
19. Үржлийн мал худалдан авах
20. Малын эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ авах

21. МАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах, чанар, стандартыг сайжруулах

Сумын захиргаа, малчдад хийсэн чадавхи бэхжүүлэх сургалт

БСТ баг МААЭС болон МЧХБЦ-ийг байгуулах, ажиллуулахад хэрэгцээтэй мэдлэг олгох зорилгоор сумын захиргаанд чадавхи бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Тухайн сургалтуудын гол сэдвүүд нь төсөлтэй холбоотой дүрэм, журам боловсруулах, МААЭС-ийн саналуудыг хянах үүрэгтэй салбарын зохих мэргэжилтнүүдийг хэрхэн томилох, хувийн хэвшлийн байгууллагуудтай хэрхэн хамтарч МЧХБЦ-ээс мах/мал, ноолуур борлуулах, МААЭС-ийн төсвийг хэрхэн зарцуулах, цаг уурын өөрчлөлт болон бэлчээрийн менежментийн үндсэн ойлголтууд, ХМЭ болон малын эмч нарт зориулсан аюулгүй ажиллагааны сургалт болон төслийн ерөнхий хэрэгжилтийн талаар сургалтуудыг явуулсан.

Чадавхи бэхжүүлэх сургалт хийхдээ малчидтай нүүр тулж уулзах эсвэл сумын захиргааны байранд цуглуулж хийж байсан. Малчидтай хийсэн сургалтууд нь бэлчээрт ээлтэй орлого нэмэгдүүлэхийн давуу тал, цаг уурын өөрчлөлтийн ойлголт, зээлийн өргөдөл бичих, МААЭС-д хэрхэн шимтгэл төлөх, МЧХБЦ-т хэрхэн хамрагдах, сумын захиргаатай бэлчээр ашиглалтын гэрээ болон малын тоо цөөлөх гэрээ хэрхэн байгуулах сэдвээр сургалт зохион байгуулсан.

Малын тооллого, хяналтын бүлгийн судалгаа

Төслийг хэрэгжүүлэх хоёр жилийн хугацаанд Засгийн газраас малын тооллогыг 4 удаа хийх төлөвлөгөөтэй байсан – жилийн дунд болон жилийн эцэст. Ногоон Бэлчээр төслийн үр дүнд хяналт тавих зорилгоор БСТ баг Баян-Овоо суманд очиж, төслийн малчдын малын тооллогыг өөрсдөө хийж, гарсан үр дүнг Засгийн газрын тооллогод орсон төслийн бус хяналтын бүлгийн малын тоотой харьцуулсан. Үүний гол зорилго нь төслийн малчдын малын тоог төсөлд хамрагдаагүй малчидтай харьцуулж төслийн аргачлалуудаар дамжуулж малын тоог хэр их бууруулж чадсаныг харьцуулах юм.

Төслийн хэрэгжүүлэлт

Ногоон Бэлчээр төслийг анх нэг жилийн хугацаанд 6 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан. Гэсэн хэдий ч эко ногоон зээл хоёр жилийн хугацаатай байсан тул ХасБанк төслийг дахин нэг жил хэрэгжүүлэх хүсэлт гаргасан. Тиймээс төслийн үр дүнг цаашид нэмэгдүүлэх, сумын чадавхыг бэхжүүлэх, зээлийн эргэн төлөлтийг дагаж мөрдөх зорилгоор төслийг 10 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр болж дахин нэг жилээр сунгасан. Төслийн үе шатуудын тоймыг дор харуулав:

1-р үе шат (2018 оны 12 сар – 2019 оны 1 сар)

Эхний үе шат нь төслийн ажлыг эхлүүлэх, төслийн хандлагын талаар бүх малчин өрхүүдэд сурталчилгаа хийж, 21 сумын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх

сургалт зохион байгуулах замаар ХасБанкны эко ногоон зээлийг авах малчдыг тодорхойлоход чиглэгдсэн. БСТ баг Баян-Овоо суманд хоёр удаа очиж 353 малчин өрхөд нүүр тулсан сургалт явуулсны үр дүнд 141 малчин өрх төсөлд хамрагдах хүсэлтээ илгээсэн. БСТ баг сумын удирдлагуудтай хамт 88 зээлийн өргөдлийг шалгаж, ХасБанкинд хянуулахаар 48 өргөдөл ирүүлснээс 45 малчин өрх 500 сая төгрөгийн эко ногоон зээл авсан байна. Ногоон Бэлчээр төслийн тогтвортой хэрэгжилтийг хангах гол зорилтуудын нэг нь орон нутгийн засаг захиргаанаас өмчлөл, амлалт авах явдал байсан тул эхний шатанд Мерси Кор ба Баян-Овоо сумын хооронд санамж бичиг байгуулсан.

2-р үе шат (2019 оны 1 сар – 7 сар)

Энэ үе шат нь МААЭС ба МЧХБЦ-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд анхаарч, сумдын удирдах ажилтнууд, малчдад зориулсан цуврал сургалтуудыг зохион байгуулав. МААЭС-ийн төсөвт сумын засаг захиргаанаас болон малчдаас тохирсон санхүүжилтын хувийг оруулах шаардлагатай байв. Энэ үед Монголын Засгийн газар ХХААХҮЯ-аас хяналт тавьж байсан ЖДҮ хөгжүүлэх сангаас зориулалтын бусаар ашигласан гэх улс төрийн дуулиантай нүүр тулж байв. Энэ үйл явдлын дараа Сангийн яам бүх аймаг, сумдын захиргаанд шинэ данс нээхийг хориглосон. Үүний дүнд Баян-Овоо сум ОНХС-ийг санхүүжүүлэх төсвөө аваагүй, МААЭС-д тусд нь данс нээлгэх боломжгүй болсон.

Түүнчлэн мах боловсруулах худалдан авагчаар Эрдэнэ хүнс ХХК шалгарч, МЧХБЦ-дээр зарагдах малд зах зээлийн үнээс 5%-иар илүү төлөх санал тависан. “Эрдэнэ хүнс” ХХК нь малчин тус бүрт төлбөр олгох хүндрэлтэй байсан тул төлбөр шилжүүлэх нийтлэг дансыг хүссэн. Эдгээр хоёр шалтгааныг харгалзан БСТ нь сумын засаг захиргаа, малчидтай зөвлөлдөн МААЭС-ийн үйл ажиллагааны шимтгэлийг дэмжих зорилгоор хоршоо эсвэл ТББ байгуулахыг зөвлөв.

Үүний үр дүнд, мал махны борлуулалтаас МААЭС-д малчдын оруулах хувь нэмрийг төвлөрүүлэх зорилгоор төлөөллийн 5 малчинтай “Эко-Баян овоо” ТББ байгуулагдав. 2019 оны 5-р сараас МААЭС нь 44 малчин (эко ногоон зээлийн бүс 1 малчин)¹¹ 16 сая төгрөг (3297 хонин толгой мал), Мерси Кор 9.6 сая төгрөг (зөвхөн төслийн эхний жилд сумын төсөв байхгүй байсан тул) төвлөрүүлж ажиллуулж эхэлсэн. МААЭС-д нийт 25.6 сая төгрөг төвлөрүүлсэн. Жилийн дунд үеийн мал тооллогыг мөн энэ үеэр явуулсан бөгөөд төслийн 45 өрхийн 24930 толгой мал тоологджээ.

3-р үе шат (2019 оны 7 сар – 8 сар)

Гурав дахь үе шат нь МААЭС-д ирсэн малчдын саналыг хүлээн авах, тэдэнд туслахад чиглэгдэв. Малчдын санал батлагдсаны дараа малчид санхүүжилтийн 80%-ийг эхлээд авсан бөгөөд үйл ажиллагаагаа дуусгаад үлдсэн 20%-ийг авсан.

¹¹ 45 эко зээл авсан малчдаас 2 малчин өрх зээлээ эргэн төлж МААЭС-д шимтгэл төлөхгүй, төсөлд оролцохгүй гэж шийдсэн. Эко зээлд хамрагдаагүй ч бэлчээр ашиглалтын гэрээ болон малын тоо цөөлөх гэрээ байгуулсан 1 малчин өрх МААЭС-д оролцох хүсэлт гаргаж оролцсоноор МААЭС-д нийт 44 малчин өрх оролцсон.

Малчдаас МAAЭC-д ирүүлсэн саналыг батлахын тулд сумын ЗДТГ нь үнэлгээний бүлгийг байгуулж, нэмэлтээр мониторингийн төлөвлөгөө боловсруулж, малчин өрх тус бүр дээр очиж саналын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулав.

4-р үе шат (2019 оны 8 сар – 2019 оны 10 сар)

Дөрөв дэх үе шат нь сумын албан хаагчдад чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулах, МAAЭC ба МЧХБЦ-ийн үйл ажиллагаанд хяналт тавихад чиглэгдсэн. Энэ үе шатанд МAAЭC-ийн санхүүжилтийг малчид өвс худалдан авах (саналын 56.8%), малын хашаа хороо засах (18.2%), худаг засварлах (6.8%), үржлийн мал худалдан авах (4.5%), ногоон тэжээл худалдан авах (4.5%) хадлангийн тоног төхөөрөмж худалдаж авахад (2.2%) зарцуулсан. “Эрдэнэ хүнс” ХХК нь 132 үхрийг МЧХБЦ дээр малчдаас нэг кг жинд 3200 төгрөгөөр худалдаж авснаар 30 малчин 110 сая төгрөгийн орлого олжээ. Гэвч Засгийн газраас 2019 оны 8-р сард баталсан махны экспортод тавьсан хоригоос шалтгаалан “Эрдэнэ хүнс” ХХК мал худалдан авах үйл ажиллагаагаа зогсоож, төслөөс гарах шаардлагатай болсон.

5-р үе шат (2019 оны 5 сар – 12 сар)

Тав дах үе шат нь малын тоог цөөлөх, малын ашиг шимийг дээшлүүлэх тогтвортой орлого олоход чиглэсэн мал аж ахуйн ашгийг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн дагуу хандлагыг өөрчлөх зорилгоор сумын удирдлагууд, малчдад мэдлэг олгох сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулахад чиглэгдсэн. МAAЭC ба МЧХБЦ-ийн бүх үйл ажиллагаа нь малчдын хэрэгжүүлсэн 11.6 сая төгрөгийн өртөг бүхий төслүүдээс бүрдсэн. 12-р сарын мал тооллого нь энэ үе шатанд явагдсан бөгөөд хяналтын бүлэг болох Баян-Овоо сумаас түүврийн байдлаар сонгогдсон төсөлд оролцоогүй 21 малчин өрхийн мал сүргээ 8.9% өсгөсөнтэй харьцуулахад төсөлд оролцогч малчид малынхаа тоог 13.2%-иар бууруулж чадсан байна. Нэмэлтээр төслийн малчид МЧХБЦ-ээр дамжуулан олон тооны мал, мах борлуулжээ. Махны борлуулалтаас өрхийн дундаж орлого төслийн бус хяналтын бүлгийн малчдаас 3.3 сая төгрөгөөр өндөр байсан.

6-р үе шат (2020 он 1 сар)

Зургаа дахь үе шат нь БСТ нь 1-р жилийн эцсийн тайланг Мерси Корд хүргүүлэхэд чиглэгдсэн.

7-р үе шат (2020 оны 1 сар – 3 сар)

Долоо дах үе шат нь чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулж, сумын ЗДТГ-тай МAAЭC-ийн 2020 оны үйл ажиллагааны бэлтгэл ажлын талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулахад чиглэв. Эдгээр хэлэлцүүлгийн үеэр БСТ баг болон сумын удирдлага, малчидтай гэрээ сунгах ажил дээр хамтран ажилласан. 40 малчин өрх 2020 он хүртэл сумын Засаг даргатай хамтран ажиллах Бэлчээр ашиглалтын гэрээ

ба Малын тоо цөөлөх гэрээг сунгахаар болсон¹². Нэмж дурдахад сумын захиргаа болон малчид 3-р сард ноолуурын борлуулалтад ихээхэн ач холбогдол өгдөг. Эрдэнэ хүнс ХХК нь төсөлд хамрагдах боломжгүй болсон тул БСТ баг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны ноолуурын Ногоон Бэлчээр төсөлтэй холбож зохицуулсан¹³. Ногоон Бэлчээр төслийн 13 малчин ЕСБХБ-ын төсөлд хамрагдаж, ноолуур самнах зөв арга зүйн сургалтанд хамрагдсан.

8-р үе шат (2020 оны 4 сар – 6 сар)

Найм дах үе шат нь бэлчээр ашиглалт, мал аж ахуйн менежмент, МAAЭC-ийн санхүүжилтийн олголт, малчдын хувь нэмэр, ноолуурын тогтвортой үйлдвэрлэлийн талаарх сургалтыг сумын удирдлага, малчдад өгөхөд чиглэгджээ. Төслийн 40 малчин энэ хугацаанд МAAЭC-д 13.2 сая төгрөг төвлөрүүлж, үлдсэн 7.9 сая төгрөгийн санхүүжилтийг ЕСБХБ-ийн төслөөс (нийт 21.1 сая төгрөг) төвлөрүүлсэн байна. Энэ үе шатанд Ханбогд ноолуур ХХК уг төсөлд хамрагдаж төслийн 21 малчнаас 1541 кг ноолуурыг кг тутамд нь зах зээлийн үнээс 1000 төгрөгөөр өндөр үнээр худалдан авчээ. 6-р сард хагас жил тутамд явагддаг мал тооллогыг явуулж, 40 өрх 27835 хонин толгойтой гэж тоологдсон. Энэ өсөлт нь хаврын улиралд 3805 шинэ мал мэндэлсэнтэй холбоотой юм.

9-р үе шат (2020 оны 6 сар – 8 сар)

Ес дэх үе шат нь малчдын саналд зохицуулан МAAЭC-ийн санхүүжилтийг хянах, зарцуулахад сумын засаг захиргаанд туслалцаа үзүүлэхэд чиглэгджээ. Хаврын шинэ төллөлтөөс нэмэгдэх сүргийн тоо толгойн өсөлттэй холбогдуулан өрх бүрийн малыг зорилтот хэмжээнд (Бэлчээр ашиглалтын гэрээний дагуу) бууруулах зорилгоор зарах малын тоог БСТ тооцоолсон. Малчдаас мал худалдаж авах хувийн мах боловсруулах үйлдвэр байхгүй тул БСТ баг МAAЭC-ийн урамшууллыг нэмэгдүүлж, МЧХБЦ дээр зарагдаж буй хонин толгой бүрд 750 төгрөг нэмэхийг санал болгов. Үүний үр дүнд 32 малчин 3193 хонин толгойг зах зээлд борлуулжээ.

10-р үе шат (2020 оны 8 сар – 2021 оны 1 сар)

Сүүлийн үе шат нь МAAЭC-ийн 2020 оны үйл ажиллагаанд мониторинг хийх, мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулахад чиглэгдсэн. 12-р сарын мал тооллогыг явуулж, 2 дахь жилийн эцсийн тайлангаа Мерси Корд хүргүүлэхэд чиглэгдэв. МAAЭC-ийн 2020 оны үйл ажиллагаанд өвс худалдан авах (60.1%), хадлан бэлтгэх тоног төхөөрөмж (23%), малын хашаа хороо засах / барилга (11.9%), малын давс тээвэрлэх (4.4%), малын эм худалдан авах (0.6%) зэрэг багтсан байна. Мэдлэгийг

¹² Анхны 45 эко зээлийн малчдаас 2 нь эхний жилдээ зээлээ эргэн төлсөн. Хоёр дахь жилд 4 малчин зээлээ төлж, төслийн үйл ажиллагаанд оролцохгүй байхаар шийдсэн. МAAЭC-ийн эко зээл аваагүй 1 малчинтай нийлээд 40 малчин гэрээгээ сунгасан.

¹³ ЕСБХБ-аас 2019 оны 9-р сараас хойш БСТ-тэй хамтран Баян-Овоо суманд хэрэгжүүлж буй “Монгол Улс: Бэлчээр ашиглалт, мал аж ахуйн менежмент, ноолуур бэлтгэлийн сайжруулж, тогтвортой ноолуурыг дэмжих нь” төсөл.

дээшлүүлэх нүүр тулсан сургалт явуулсны үр дүнд төсөлд хамрагдаагүй 58 шинэ малчин өрх сумын Засаг даргатай Бэлчээр ашиглах гэрээнд гарын үсэг зурав. 12-р сард хийсэн мал тооллогын дүнгээс харахад төслийн малчид сүргийнхээ тоог 16.2% буюу бүр 2019 оноос их хэмжээгээр цөөлсөн нь хяналтын бүлгийн 3.6% цөөлсөнтэй харьцуулахад мэдэгдэхүйц үр дүн байлаа. Төслийн малчид ноолуур, малын борлуулалтаас дунджаар хяналтын бүлгийн 20.4 сая төгрөгтэй харьцуулахад нийт өрхийн дундаж орлогоо 29.3 төгрөгийг хүргэж өсгөсөн байна. Төслийн төгсгөлд 98.8% нь зээлийн эргэн төлөлттэй, зөвхөн нэг малчин 6 сая төгрөг дутуу төлсөн байна.

Төслийн үр нөлөө

Ногоон Бэлчээр Төсөл нь малчдыг санхүүгийн эх үүсвэрт хүргэх, санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааны механизмыг бий болгох, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, малчид болон сумын албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх өргөн хүрээтэй зорилт тавьсан. Энэхүү санхүүжилтийн механизм, түншлэл, чадавхыг сайжруулах аргачлал нь малчдын олон мянган жилийн туршид өөрчлөгдөөгүй тогтсон сэтгэлгээ, хандлагыг өөрчлөхөд хувь нэмрээ оруулж чадсан нь төслийн хэрэгжилтийн төгсгөлийн үе шатанд тодорхой болж байна. Ногоон Бэлчээр төсөл нь төслийн малчид, сумын удирдлага болон Баян-Овоо сумыг бүхэлд нь хамарсан олон янзын эерэг үр дүнтэй байсан. Ногоон Бэлчээр төслийг хэрэгжүүлсэн хоёр жилийн хугацаанд үзүүлсэн үр нөлөө, нөлөөллийг дор тодорхойлон тайлбарлав.

1. Малчдын санхүүгийн хүртээмж нэмэгдсэн

Малчдын орлого нь малын түүхий эдийн төрлөөс хамаарч улирлын чанартай байдаг. Монгол орон даяар малын биеийн байдал, тарга сайжирсан үе болох 7-р сараас эхлэн 10-р сард дээд цэгтээ хүрэх үед малыг махлан борлуулдаг. Ноолуурын орлого 3-р сараас 5-р сард ямаа самнах үед гарч ирдэг. Сүү, сүүн бүтээгдэхүүний орлого 6-р сараас 11-р саруудад, 8-р сард дээд цэгтээ хүрдэг. Мал мах, ноолуурын орлого нь ихэнх малчин өрхийн нийт орлогын 70-80%-ийг бүрдүүлдэг байна. Малчдын хувьд зээл авах хамгийн өндөр шаардлагатай улирал бол 1-р сарын сүүлээс 2-р сарын эх буюу сар шинийн баярын үе байдаг бөгөөд 5-р сард ноолуурын борлуулалтаас эргэн төлөгддөг ба 8-р сард оюутны төлбөр төлөх бэлтгэн ажлын зардлыг мал махны орлогоос эргэн төлдөг. Ихэнх малчид арилжааны банкны шаардлагын дагуу жилийн 24-30% хүүтэй зээлийг 24 сар хүртэл хугацаагаар авдаг.

Ногоон Бэлчээр төсөл хэрэгжиж эхэлснээс хойш, эхний сард 45 малчин ХасБанкнаас санал болгож буй жилийн 12% хүүтэй, нийт 500 сая төгрөгийнэко ногоон зээл болох хөнгөлөлттэй зээлийн үр шимийг хүртэв. Малчид эдийн засгийн хөшүүрэг болох аргачлалаар сүргийнхээ тоог бууруулж ашиг шимийг нь дээшлүүлснээр орлогын

өсөлтөө баталгаатай болгох нөхцөлд хариу үйлдлийг хангалттай үзүүлсэн бөгөөд малынхаа тоог бууруулан, ашиг шим хүртэх талаар өөрсдийн тогтсон хандлагаа өөрчилж чадна гэдгээ харуулсан. Зээлийн шаардлагад нийцүүлэхийн тулд малчид Бэлчээр ашиглалтын гэрээ, Малын тоо цөөлөх гэрээнд гарын үсэг зурсан бөгөөд сүргийнхээ зорилтот тоонд хэрхэн хүрч ажиллахаа нарийвчлан гаргасан 5 жилийн төлөвлөгөө боловсруулсан.

Эко ногоон зээл дээр нэмж МAAЭC, МЧХБЦ байгуулж малчдыг малаа зарж борлуулах замаар бэлчээрт ээлтэй орлого олох санаачлагыг нэмэгдүүлэх зорилгоор зарагдсан хонин толгой бүрд эсвэл МЧХБЦ дээр зарагдсан ноолуурын кг бүрд мөнгөн урамшуулал олгох МAAЭC-ийн саналуудад хамрагдах санаачлагыг бий болгосон. Малчдаас худалдан авах чадварт нь сөргөөр нөлөөлсөн Засгийн газрын бодлогын улмаас мах боловсруулах үйлдвэрүүд үйл ажиллагаагаа зогсоох хүртэл 2019 онд төслийн малчид мал махаар 110 сая төгрөгийн борлуулалтыг хийж чадсан.

Засгийн газраас махны экспортыг хориглосны улмаас төслийн баг (МЧХБЦ)-ээр дамжуулан малчдын орлого олох, санаачлалыг дэмжих өөр боломжуудыг хайж олох шаардлагатай болсон. Энэ боломж нь ЕСБХБанктай хамтран ажиллах болсноор биеллээ олсон. Баян-Овоо суманд бэлчээрт ээлтэй тогтвортой ноолуурын үйлдвэрлэлд чиглэсэн төсөл хэрэгжиж байсан бөгөөд ингэснээр ЕСБХБ-тай, хамтран ажиллах боломжтой болсон юм. 2020 онд төслийн малчид ноолуураа зах зээлийн үнээс 1000 төгрөгөөр илүү борлуулж ноолуурын борлуулалтаар 940,000 төгрөг нэмж хийсэн. Нэмж дурдахад малчид МЧХБЦ орж зарагдсан нэг кг ноолуур тутамд 2000 төгрөгийг МAAЭC-ээс шагнал урамшуулал болгон авсан.

Төслийн малчид малынхаа тоог тогтмол цөөлж байсан, төслийн хэрэгжилтийн эхний жилд 13.2%-иар бууруулж байсан бол хоёр дахь жилдээ 16.2%-д хүргэн малаа цөөлсөн байна. Төслийн малчид нь тухайн сумынхаа малчдын хяналтын бүлгээс илүү их мал мах, ноолуурыг борлуулж илүү их орлого үргэлжлүүлэн олж байсан.

2: Хамтын ажиллагаа бэхжсэн

Сумдын удирдлага, малчин өрх, хувийн хэвшлийн түншүүд, төслийн багийн хоорондын тасралтгүй хамтын ажиллагаа байхгүй бол Ногоон Бэлчээр Туршилтын Төсөл нь амжилттай хэрэгжихгүй байлаа. Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах, малчидтай малын тоо цөөлөх гэрээг байгуулахын тулд туршилтын төсөл нь эхнээсээ орон нутгийн засаг захиргаанаас бүрэн дэмжлэг шаардсан. Бэлчээр ашиглалтын гэрээ, Малын тоо цөөлөх гэрээнүүд нь засаг захиргаа болон малчдын бүлгүүдийн түншлэлийг бэхжүүлээд зогсохгүй малчин өрхүүдийн хоорондын түншлэлийг бэхжүүлдэг. Бэлчээрийг хамгаалах хүчтэй түншлэл, нийгмийн гэрээ нь хувь оролцогчид илүү том шалтгаантай холбогдсон гэдгээ мэдэрч, түүнчлэн хамтын зорилгоо биелүүлэх, бэлчээрийг хамгаалах тодорхой ажлуудыг тууштай хэрэгжүүлэх чиглэлд нийтийн хандлагыг өөрчлөх чухал механизм болдог.

Төслийн хэрэгжүүлэлтийн туршид МААЭС, МЧХБЦ-ийн бүх үйл ажиллагаа нь сумдын засаг захиргааны хяналт, үнэлгээ, үйл ажиллагааны туслалцаанаас хамаарч байсан. Цаашилбал МААЭС-ийн хөрөнгийг зарцуулах хамгийн боломжит замыг бий болгохын тулд сумын удирдлагууд болон малчдын бүлгүүд хамтран Эко Баян-Овоо ТББ-ыг байгуулахаар шийдвэрлэсэн нь төслийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд нэн чухал болохыг нотолсон юм. МААЭС, МЧХБЦ-ийг ажиллуулахын тулд сумын албан хаагчид хоорондоо харилцан уялдаатай хамтран ажиллах шаардлагатай байсан, тухайлбал, мал эмнэлэг, хөдөө аж ахуйн нэгжийн хооронд малчдын саналыг үнэлэх, малчин өрхөд хяналт шинжилгээ хийх хяналтын хороо байгуулсан.

Хамгийн чухал түншлэл нь сумын засаг захиргаа, малчдын хооронд байсан бол орон нутгийн хувийн хэвшлийн түншүүд мөн МЧХБЦ-ийн үйл ажиллагааг урагшлуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн. МЧХБЦ нь албан ёсны түншлэлийг эхлүүлж бэхжүүлэх замаар худалдан авагчид/боловсруулагчид, үйлдвэрлэгчид/малчдын хоорондох зах зээлийн холбоог бэхжүүлсэн нь оролцогч бүх талуудын хувьд зах зээлийн тодорхой бус байдал, хэлбэлзлийг бууруулсан юм. Жишээлбэл, “Эрдэнэ хүнс” ХХК нь малчдад зах зээлийн үнээс 5% илүү үнээр төлөх хүсэлтийг хүлээн зөвшөөрсөн цорын ганц компани байв. Гэхдээ нөгөө талаас “Эрдэнэ хүнс” ХХК нь гарал үүслийн гэрчилгээтэй эрүүл малыг бөөнөөр нь худалдаж авснаар цаг хугацаа, хүчин чармайлт, зардлыг хэмнэж чадсан бөгөөд малыг амьдаар нь худалдаж авахын тулд алслагдсан байршил уруу явах шаардлагагүй, түүнчлэн малын эрүүл мэндийн баталгааг сумын малын эмчийн үзлэгээр баталгаажуулж авсан. Малчид малаа махны ченжээр дамжуулалгүйгээр өндөр үнээр зарж, МААЭС-аас мөнгөн урамшуулал авсан нь тэдэнд ашиг тусаа өгсөн.

ЕСБХБ-ны төсөлд оролцсон Ханбогд Ноолуур компанийн хувьд мөн адил; төслийн малчид ноолуурыг зөв самнаж, түүж сурч, чанартай ноолуурыг бэлтгэсэн. Энэ нь ноолуур худалдан авах нөхцөл- ноолуурын чанарын шаардлага, үнийн урамшууллын талаар талууд урьдчилан тохиролцсон тохиолдолд бүтээгдэхүүний боловсруулагч ба малчдын байгууллагын хооронд ноолуур худалдах/худалдан авах албан ёсны тохиролцоо хийх, эдгээр нөхцөл нь чанарын шалгалтаар дамжин хэрэгжих боломжтой болохыг харуулсан болно.

3: Бэлчээрийг тогтвортой ашиглах чадавхи сайжирсан

Малчид болон сумдын төрийн албан хаагчдад зориулсан чадавхыг бэхжүүлэх сургалт, МААЭС, МЧХБЦ-ийн оролцоо, эко ногоон зээл зэрэг үйл ажиллагаануудын бүгдийн хамтарсан үр дүн нь төслийн малчдад малынхаа тоог цөөлөх санаачлал урмыг өгсөн бол төсөлд оролцоогүй малчдын хяналтын бүлэг нь малын тоогоо цөөлөөгүй бөгөөд малын борлуулалтаас илүү их орлого олох боломжоо алдаж байсан. МААЭС нь бэлчээрийн менежмент, малын эрсдэлийн менежмент, мал тэжээх, үржүүлэх, эрүүлжүүлэх, өртгийн сүлжээний үйл ажиллагааг явуулахад санхүүгийн чухал эх үүсвэрийг бүрдүүлж өгсөн. МЧХБЦ нь малчдад зохион байгуулалттай, хамтын үйл ажиллагааны үр дүнд махны орлогоо хэрхэн нэмэгдүүлэх талаар

ирээдүйтэй арга замыг санал болгосон. Хамгийн гол нь малын тоо толгой буурна гэдэг нь малынхаа бэлчээрийн хүртээмж, чанарыг сайжруулж, урт хугацаанд малын ашиг шим, орлогыг нэмэгдүүлэхэд хүргэдэг гэдгийг малчид ойлгож чадсан.

Ногоон Бэлчээр төслийн бүх үе шатуудад бүх талууд төслийн байр суурийн хувьд ямар үүрэг хариуцлага хүлээхээ мэддэг байх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн төслийн зорилго, хандлагыг тайлбарлахаас эхлээд, ноолуурын үйлдвэрлэл, бэлчээр ашиглалтын шилдэг туршлагууд, мал тооллогын зохион байгуулалт, гүйцэтгэлийн ахиц дэвшлийг хэмжих зэрэг чадавхыг бэхжүүлэх сургалтуудыг явуулсан. Жишээлбэл, малчдыг малынхаа тоог цөөлөн бэлчээрийн даац сайжирвал малын ашиг шим хэрхэн дээшлэх талаар малчдыг нүүр тулсан сургалтад байнга хамруулж байсан. Тэдэнд 5 жилийн төлөвлөгөө боловсруулах, зээлийн өргөдөл гаргах, Бэлчээр ашиглалтын гэрээ, Малын тоо цөөлөх гэрээнүүд байгуулах зэрэгт нь туслалцаа үзүүлж, малын тоог бууруулах 6% зорилтоо биелүүлж чадахгүй бол зээлийн хүү жилийн 24% хүртэл өснө гэдгийг сануулж байсан.

Түүнчлэн 4 багийн даргыг оролцуулсан сумын төрийн албан хаагчид, Баян-Овоо сумын ХАА, малын эмнэлгийн нэгж, ЗДТГ-ын төлөөлөгчдөд зориулж төсөл хэрэгжүүлэх, МААЭС, МЧХБЦ-ийг хэрхэн ажиллуулах, БСТ ба Мерси Корыг гарсны дараа төслийг хэрэгжүүлэхэд МЧХБЦ нь үнэтэй мэдлэг, чадварыг хуримтлуулах талаар сургалт хийсэн. Орон нутгийн албан хаагчид болон малчдын чадавхыг бэхжүүлсэн нь туршилтын төслийн хамгийн чухал нөлөө юм.

Бэрхшээл ба анхаарах зүйлс

Ногоон бэлчээр төсөл нь малчдын санхүүжилтийг нэмэгдүүлэх, экологийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоо амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү туршилтын төслийг хэрэгжүүлэх үед гарсан бэрхшээл, олж авсан сургамжыг нэгтгэн дор танилцуулав. Мөн түүнчлэн, ирээдүйд төсөл хэрэгжүүлэхэд анхаарах асуудлыг мөн оруулсан болно.

Төслийн хугацаанд тулгарсан хүндрэл, бэрхшээл

- Малын тоог цөөлөх гэрээнд эко зээлийн эргэн төлөлтийг урьдчилан төлөлтийн тухай нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Жишээлбэл, төсөл хэрэгжих үед хоёр малчид 12-р сард хийгдэх мал тооллогоос өмнө нь зээлээ 8-р сард эргэн төлж дуусгасан байна. Хөнгөлөлттэй хүүтэй зээлд хамрагдах сонирхолгүй болсноор сумын Засаг даргатай байгуулсан малын тоог цөөлөх гэрээний хүчин төгөлдөр байдлыг эрсдэлд оруулж байсан. Хэдий зээлд хамрагдсан малчид зээлээ төлж барагдуулсны дараа ч малын тоог цөөлөх арга хэмжээг авч ажиллаж байх ёстой бөгөөд иймэрхүү урьдчилсан төлөлтийг болиулах нь зүйтэй юм. Энэ нь төсөлд хамрагдах хүсэлтэй бусад малчдын боломжийг нь “хулгайлж” байгаатай адил бөгөөд бусад малчид зээлээ төлж барагдуулсны дараа гэрээнд заасан малын тоог цөөлөх арга хэмжээг үргэлжлүүлнэ гэсэн баталгааг байхгүй болгох эрсдэлтэй.

- Зах зээлийн таатай орчин, ялангуяа экспортын албан ёсны зохицуулалт нь мал аж ахуйн гаралтай түүхий эд худалдан авах аливаа системийг боловсруулж хэрэгжүүлэхэд нэн чухал гэдгийг энэхүү төсөл харуулсан. ХХААХҮ яам нь мал аж ахуйн борлуулалтын оргил үеэр Хятад руу мах экспортлохыг хориглох шийдвэр гаргасан нь МAAЭC-ийн үйл ажиллагааны хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхөөс гадна малчдыг боломжит үнээр өөрдсийн бүтээгдэхүүнийг борлуулах, худалдан авагчдыг өндөр чанартай, баталгаат мал худалдан авах зэрэгт мөн сөрөг байдлаар нөлөөлсөн болно.
- Татвар, санхүүгийн тайлангийн дарамтаас болж малчид өөр хоорондоо нэгдэх, хоршоо байгуулах хүсэлгүй байв. МAAЭC-ийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө малчдад МAAЭC-ийн санхүүжилтэд хяналт тавих зорилгоор хоршоо байгуулах эсвэл нэгдмэл ТББ байгуулах сонголтыг санал болгосон. Гэсэн хэдий ч өнөөгийн хууль эрх зүй, санхүүгийн орчин нь хоршоодын малын борлуулалтаас 10%-ийн татварын шимтгэлийн өндөр ачааллыг ногдуулж байна. Тиймээс малчдын ТББ нь малчдын өртгийн сүлжээнд оролцоход саад болж буй урт хугацааны хөтөлбөрийн богино хугацааны боломжтой шийдэл болох нь батлагдсан. Гэсэн хэдий ч Ногоон Бэлчээр төслийн үеэр энэ ТББ нь БСТ-өөс, ялангуяа бүтэц, засаглалын талаархи чадавхийг хөгжүүлэхэд ихээхэн дэмжлэг үзүүлэх шаардлагатай болсон. Монгол Улсын Их Хурлаас Малын албан татварын тухай шинэ хууль баталж, 2021 оны 1-р сараас эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд хуулийн дагуу малчдын байршлаас хамаарч нэг малаас 2000 хүртэлх төгрөгийн татвар төлнө. Малын албан татвараас 70-140 орчим тэрбум төгрөг байхаар тооцсон. Тиймээс ирээдүйд МAAЭC-ийг тус малын албан татвараар санхүүжүүлэхээр төлөвлөж байна.
- Ногоон Бэлчээр төслийн хувьд сумын малчдад хангалттай мэдээлэл хүргэхэд нүүр тулсан сургалт нэн чухал ач холбогдолтой бөгөөд эхний ээлжинд элсэх сонирхолтой малчдын тоог нэмэгдүүлэхэд өндөр хувь нэмэр оруулсан юм. Гэсэн хэдий ч КОВИД-19 цар тахлын хязгаарлалтаас болж аймаг хоорондын тээврийг хориглосны улмаас БСТ баг дараа дараагийн сургалтыг зохион байгуулах боломжгүй болсон. Мөн түүнчлэн, Баян-Овоо суманд БСТ болон ХасБанк нь оффисгүй байсан тул биечилсэн сургалт зохион байгуулах нь харьцангуй зардалтай, цаг хугацаа их шаарддаг байв. Шинэ нөхцөл байдалтай дасан зохицоход БСТ нь сумдын хөдөө аж ахуй, малын тасаг, “Эко Баян-Овоо” ТББ-тай нягт хамтран ажиллаж, малчдад алсын зайнаас зөвлөгөө өгөх замаар үргэлжлүүлэн сургалт зохион байгуулсан. Мөн, 2020 оны 12-р сарын мал тооллогын ажилд мөн тус албан хаагчид болон ТББ-г оролцуулсан болно.
- Сумын төсөвт МAAЭC-д хоёр жилийн хугацаанд мөнгө төвлөрүүлэх төсөв тусгагдаагүй байсан. Олон улсын байгууллагууд гараа сунган эхний жилд Мерси Кор, хоёр дахь жилд ЕСБХБ сумын засаг захиргаанд хөрөнгө оруулав. Сумын захиргаа нь холбогдох хууль журмын дагуу МAAЭC-д санхүүжилтийг хадгалах тусдаа данс үүсгэх боломжгүй байсан бөгөөд Ногоон Бэлчээр төслийг амжилттай хэрэгжүүлэхэд тусдаа шинэ нэгж (Эко Баян-Овоо ТББ)-ыг байгуулсан болно. Хэдий ТББ нь санхүүжилтийг хөнгөвчлөх, дэмжлэг үзүүлэх шийдэл байсан ч БСТ-аас ихээхэн дэмжлэг шаардсан богино хугацааны

шийдэл юм. Дээд дурдсанчлан малын албан татвар нь МAAЭC-ийн үйл ажиллагааны ирээдүй юм. ТББ байгуулахаас илүү энэхүү шинэ татварын зохицуулалт нь оновчтой шийдэл юм.

- Анхны төлөвлөгөөнд 88 малчин өрхийг эко зээлд хамруулахаар төлөвлөж байсан хэдий ч банкнаас санал болгосон 500 сая төгрөгийн хязгаарыг харгалзан зорилтот бүлэгт хамрагдсан малчин өрхийн тал хувь нь л зээл авах боломжтой байв. Төслийн эхэнд 141 малчин Бэлчээр ашиглалтын гэрээ болон Малын тоо цөөлөх гэрээнд гарын үсэг зурсан нь малчдын дунд эко зээлд хамрагдах эрэлт өндөр байгааг харуулж байна. Төслийн төгсгөлд нэг малчнаас бусад бүх малчид зээлээ төлж, 98.8%-ийн зээлийн эргэн төлөлттэйгээр төслөө дуусгасан. Энэ нь малчдын зээлийн эргэн төлөлтийг өндөр үзүүлэлттэй байгааг харуулж байгаа бөгөөд ийм зээл нь эрсдэл багатайг үзүүлж байна. Иймд, олон банк малчдад хөнгөлттэй зээлийг олгох асуудлыг судлах ёстойг харуулж байна.

Төслөөс суралцсан зүйлс

- Ногоон Бэлчээр төслөөр дамжуулан эдийн засгийн болон төслийг сурталчлах урамшууллын багцаар малчдын хандлагад өөрчлөлт оруулахад хувь нэмэр оруулдаг гэдгийг харуулсан болно. Малчдын хандлагад дараах байдлаар өөрчлөлт оруулж болно. Үүнд:
 - Малын чанарыг хянан баталгаажуулах цэг зэрэг аргачлалаар дамжуулан малын тоог цөөлөх, мөн зах зээлд өндөр үнээр мал нийлүүлж орлогыг нэмэгдүүлэх – энэ нь тоо хэмжээнээс илүүтэйгээр чанарыг сайжруулж, малын тоог цөөлөх ажлыг дэмжих зорилготой юм.
 - Малын тоог цөөлснөөр орлого нэмэгдэх байдлаар малчдын сайн дурын оролцоог нэмэгдүүлэх,
- Сумын засаг захиргааны байгууллагаас дэмжлэг авах мөн тухайн сумын баримтлах бодлоготой уялдуулах зэрэг болно.
- Орон нутгийн засаг захиргаанд шинэлэг стратеги болон урамшууллын арга зүйг авч хэрэгжүүлэхэд малчдад эрчимжүүлсэн чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах нь нэн чухал юм. Ногоон Бэлчээр төслийн хүрээнд малын тоог цөөлөх нь бэлчээрийн даацыг сайжруулахад болон уур амьсгалын өөрчлөлтөд хэрхэн нөлөөлөх тухай мэдээллийг хүргүүлэх, зээлийн хүсэлт хэрхэн боловсруулах, МAAЭC болон МЧХБЦ-ийн үйл ажиллагаа, ноолуур самнах болон эрс тэс өвлийн улиралд малын жинг алдагдуулахгүй байх зэрэг орлогыг хэрхэн нэмэгдүүлэх тухай шилдэг туршлагын талаар зэрэг сэдвүүдээр сургалт хийсэн.
- Төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар дамжуулан санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх, орон нутгийн бэлчээрийн газар, малын эрсдэлийн удирдлагад эргүүлэн хөрөнгө оруулахад МAAЭC нь нэн чухал хэрэгсэл бөгөөд нэмэлт сайжруулалт хийснээр хэрэгжүүлэх боломжтой юм. МAAЭC нь хоёр үндсэн зорилготой юм. Үүнд: 1. Малын чанарыг хянан баталгаажуулах цэгийг байгуулж, малын чанарыг шалгахад дундын зуучлагчгүйгээр малчидтай шууд холбоо тогтоох, малын бүтээгдэхүүнээ зах зээлд өндөр үнээр зарж

борлуулахад хувь нэмэр оруулах, 2. Өвлийн идэш худалдан авахад шаардлагатай малчдын санхүүжилтийг нэмэгдүүлэх зэрэг малын чанарыг сайжруулах, мал аж ахуйн эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зэрэг болно. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлснээр мал аж ахуйн эрүүл мэндийг сайжруулах, бүтээмжийг хамгийн өндөр төвшинд байлгах ач холбогдолтой юм. Баталгаажсан цэг дээр малын бүтээгдэхүүнээ зарснаар олох урамшуулал болон өндөр чанартай малын бүтээгдэхүүн борлуулсны орлого зэрэг нь малын тоог цөөлөхийн ач холбогдлыг малчдад таниулж, сэтгэлгээнд өөрчлөлт оруулж байна. Энэ нь цаашлаад бэлчээрийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

- Малчид МААЭС-ийн ач холбогдол, хэрхэн хувь нэмрээ оруулах, цаашлаад ямар ашиг тустай талаар тодорхой ойлголттой болсноор хувь нэмэрийг оруулах сонирхолтой байна.
- МААЭС-ийн орлого, зарлагатай холбоотой санхүүгийн менежментийн асуудлыг илүү боловсронгуй болгох шаардлагатай бөгөөд урт хугацааны тогтвортой ажиллагааг бий болгоход тус сангийн бүтцийг бүрэн институцлэх зэрэг хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. МААЭС-д шаардлагатай мэдээллийг малчдаас авах ажил нь БСТ баг болон сумдын удирдлагаас ихээхэн хүчин чармайлт шаарддаг. Бүх малчид малын албан татварыг шинээр төлдөг болсон тул энэ асуудлыг шийдэх боломжтой болсон.
- Малын худалдааны үйл ажиллагаа явуулдаг малчдын байгууллагатай хамтран ажиллах боловсруулах үйлдвэрт хамтын ажиллагааны үр ашгыг тодорхойлж өгснөөр татан оролцуулж, хамтран ажиллах боломжтой. “Эрдэнэ Хүнс”-ийн хувьд бие даасан малчин тус бүрээс нэмэгдсэн дүнгээр худалдан авалт хийснээс илүүтэйгээр нэг цэгээс шинжилгээнд орсон, баталгаажсан мал худалдан авах, зардал бууруулах зорилготойгоор энэхүү төсөлд сайн дураар оролцсон. Энэхүү хүлээлтэд тус цэгээс авсан малаас илүү үнийн дүнг төлсөн байна.

Ирээдүйд анхаарах зүйлс:

Эко ногоон зээлийн санаачлал, урамшууллын механизм болгох: Мал аж ахуйн салбар, малчдын хандлагын талаар Монголын төрөөс баримтлах бодлого нь малчин өрхийн мал сүргийн тоог өсгөх замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх болон улмаар улсын ДНБ-д орлого олох арга хэлбэр болгон чиглүүлдэг уламжлалтай байна. Гэвч сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо толгой мэдэгдэхүйц өссөн тул бэлчээрийн ашиглалт нь дээд хязгаартаа хүрч бэлчээрийн даац хэтрэн бэлчээр доройтолд орох болсон. Эко ногоон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгосноор малчдыг орон нутгийн засаг захиргаатай бэлчээр ашиглалтын гэрээ, малын тоог цөөлөх гэрээнд гарын үсэг зурж, малынхаа тоог бууруулах амлалтыг албан ёсоор баталгаажуулж, малын тоо толгойг өсгөхөд бус харин бүтээмжид суурилсан стратегид илүү анхаарч ажиллахыг уриалж байгаа болно.

Эко зээл нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна эмзэг бүлгийн малчдад хөнгөлөлт болсон, 12% зээлийн хүү нь арилжааны банкны 24% хүүгээс хамаагүй бага хүүтэй болгож өгсөн. Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ нь 98.8%-тай байгаа нь нэлээд өндөр бөгөөд банкууд энэхүү зээлийг эрсдэл багатай зээл гэж үзэж болохыг нотолж байна. Гэсэн хэдий ч туршилтын төслийн үед малын тоог цөөлөх төлөвлөгөөгөө биелүүлээгүй зарим малчид зээлийг хугацаанаас өмнө эргэн төлсөн гэх мэт төлөвлөөгүй зарим бэрхшээлтэй тулгарч байсан. Ирээдүйд хөтөлбөрүүд энэхүү эрсдэлийг харгалзан үзэж, тодорхой бүлэг хүмүүсийн ашиг олох гэсэн хандлагаас урьдчилан сэргийлэх үүднээс гэрээний амлалтаа биелүүлээгүй тохиолдолд хөнгөлөлттэй зээлийн хүүг арилжааны хүү болгон өөрчлөх, зээлийн төлбөрийн болон бэлчээрийн ашиглалтын гэрээнд торгуулийн заалт зэргийг оруулах хэрэгтэй байна.

Орон нутгийн засаг захиргаа нь дэмжлэгийн тулгуур багана юм: Төслийг боловсруулах, эхлүүлэх, хэрэгжүүлэх, хаах үйл ажиллагааны туршид засаг захиргааны дэмжлэг, төсөлд оролцох хүсэл эрмэлзэл нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд салшгүй хүчин зүйл болж байв. Баян-Овоо сум нь малчдын бүлгүүдэд зориулагдсан өвөрмөц Аравт системтэй мөн орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь төслийг хэрэгжүүлэх хүсэл эрмэлзэл сайтай байсан тул төслийн оролцогчоор сонгогджээ. Төслийн үйл ажиллагааг зохион байгуулахад бүхий л талаар өндөр төвшинд оролцсон малчид, сумын Засаг дарга нарын хооронд бэлчээр ашиглалтын ба малын тоог цөөлөх гэрээ байгуулагдсан байна. МААЭС болон МЧХБЦ-ийн үйл ажиллагаа нь зээлийн өргөдлийг шалгах, саналыг хянах, төслийн явцыг хянах, мониторинг хийх, санхүүжилт олгох, малд үзлэг хийх, мал тооллогыг явуулахад хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүд, малын эмч нар зэрэг орон нутгийн албан хаагчдаас бүрэн оролцоог шаардаж байв. Орон нутгийн албан хаагчид нь БСТ багаас явуулсан чадавхыг бэхжүүлэх сургалт, үйл ажиллагаанд маш идэвхтэй оролцож МААЭС, МЧХБЦ-ийг ажиллуулахад мэдлэгээ дээшлүүлж, цаашид эдгээр үйл ажиллагааг бие даан хийх чадавхтай болсон. Үүнийг хэрэгжүүлэхийн

тулд МААЭС-ийн санхүүжилттэй төслүүд болон МЧХБЦ-ийн үйл ажиллагааг хянах, үнэлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлагыг холбогдох нутгийн захиргааны ажилтнуудын албан ёсны ажлын байрны тодорхойлолтод тусгах шаардлагатай байж магадгүй юм.

Орон нутгийн засаг захиргаа МААЭС-ийг санхүүжүүлэхэд зориулж төв засгийн газраас санхүүжилт олж авах боломжгүй байсан ч шинээр батлагдсан Малын татварын тухай хуулиар МААЭС-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх арга хэрэгслийг олгохоор төлөвлөгдөж байна. Шинээр батлагдсан хууль, хэрэгжүүлэлт нь эхний шатандаа явж байгаа тул Ногоон Бэлчээр Түршилтын Төсөл, МААЭС, ялангуяа МЧХБЦ нь төв засгийн газраас тухайлбал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам зэрэг байгууллагуудаас илүү өргөн дэмжлэг авах санхүүжилтийн үйл ажиллагааг сурталчлах бодлогын хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хийх шаардлагатай байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэл бол цаашдын гарц: Бэлчээрт ээлтэй орлого нэмэгдүүлэх аргачлалыг дэмжих гол механизм бол малчдад зах зээлийн үнээс дээгүүр үнэ санал болгох хувийн хэвшлийн түншүүдийг татан оролцуулах юм. Монгол Улсад үндэсний хэмжээнд махны өртгийн сүлжээний хувьд хамгийн том тулгамдсан асуудал бол малчдаас хямд үнээр мах, мал авч, цааш нь эцсийн хэрэглэгчдэд үнэ өсгөн зардаг махны ченжийн систем юм. Энэ тогтолцооны үр дүнд малчид хангалттай орлого олж чаддаггүй бөгөөд хэрэглэгчид хэт өндөр үнээр олон гар дамжсан мах худалдан авдаг. Эрдэнэ Хүнс ХХК (мах боловсруулах үйлдвэр) болон Ханбогд ноолуур (ноолуур үйлдвэрлэгч) зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулснаар, төсөл нь малчид болон үйлдвэрлэгчдийн хооронд шууд холбоо тогтоож өгсөн.

Нэмж дурдахад, МЧХБЦ-ээр дамжуулан төсөл нь олон жилийн туршид тулгараад байсан асуудлуудад болох малчдын өртгийн сүлжээн дэх хангалтгүй оролцоо, малчдын орлогыг хохироох болон хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлэх гарал үүслийн гэрчилгээгүй мал, махан бүтээгдэхүүн гэх мэт бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэх боломжит шийдлүүдийг санал болгосон. Хэдий Засгийн газраас мах экспортлохыг хориглох зэрэг гадны “давагдашгүй хүчин зүйл” нь төслийг илүү үр дүнд хүрэхээс сэргийлсэн ч, төслийн баг нь бусад боломжуудыг олж, ноолуурын төсөлтэй уялдуулах замаар малчдад орлого олох боломж нээн, ноолуур үйлдвэрлэх зохистой техник технологийн талаарх мэдлэгийг нь дээшлүүлж чадсан.

Ийнхүү, төр хувийн хэвшлийн түншлэл нь малчдад нэмэлт орлого олох боломжийг бий болгохын сацуу нэг цэгээс үйлдвэрлэгчдэд түүхий эд, мах цуглуулах боломжтой болж, зардлаа бууруулах ашиг тустай байлаа. Эдгээр давуу талуудыг харгалзан, ирээдүйд төсөл хөтөлбөрүүд хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшлийн байгууллагууд, малчдын хоорондох түншлэлийг сайжруулах тал дээр анхаарч, хичээх хэрэгтэй.

Дараагийн алхамууд

2021 оны 3-р сарын 10-ны өдөр БСТ төвөөс 4 хүн, Мерси Короос 4 хүн, ХасБанкаас 4 хүн, Баян-Овоо сумаас 3 хүн, болон Хэнтий аймгаас 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Ногоон Бэлчээр төслийн хаалтын уулзалтыг хийсэн. Хаалтын уулзалтын оролцогчид төслийн хоёр жилийн хэрэгжилт, үр дүнгийн талаар хэлэлцсэн бөгөөд төсөл дууссаны дараа ямар алхамууд хүлээгдэж байгааг ярилцсан.

Уулзалтын үеэр, бүх түншлэгч байгууллагууд малын тоог бууруулах төслийн зорилго нь бэлчээрийн даацад нөлөөлсөн эсэхийг ихэд сонирхож байв. Хариулт нь тийм, нөлөөлсөн – Баян-Овоо суманд 90% хэтэрсэн байсан бэлчээрийн даац төслийн үр дүнд 29% буурсан байна.

Хүмүүсийн ахиад сонирхсон асуулт нь ХасБанкнаас цаашид малчдад эко зээл олгох төлөвлөгөөтэй байгаа эсэх байлаа. Одоогийн байдлаар, ХасБанк нь өөрсдийн боломжуудыг судалж байгаа бөгөөд төслийн үр дүнг үргэлжлүүлэхийн тулд Баян-Овоо суманд төсөл хэрэгжүүлэх тал дээр нээлттэй байгаагаар илэрхийлсэн.

Дараагийн алхамуудад Хэнтий аймгийн Хөдөө аж ахуйн газар, Баян-Овоо сумын захиргаа, ХасБанк болон Бодлого Судлалын Төвийн хооронд түршилтийн төслийг өргөжүүлэх арга замыг судлах, өөр бусад аймгийн сумдад хэрэгжүүлэх боломжийн талаар ярилцах, судалгаа хийх ажлууд багтаж байна.

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ УР ЧАДВАР

Гарын авлага

Амжилтын түүх

ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ УР ЧАДВАР ТӨСӨЛ

Түншлэгчийн нэр: Хөдөө аж ахуйн их сургууль

Төслийн байршил: Улаанбаатар хот

Хугацаа: 2020 оны 10 сар – 2021 оны 3 сар

Төслийн үндсэн мэдээлэл

Монголын хөдөө орон нутгийн залуучууд хөдөлмөрийн зах зээлд ялангуяа мал аж ахуйн салбарт ороход ихээхэн саад бэрхшээлтэй тулгардаг. Монголын нийт залуучуудын 36%-ийг орон нутгийн залуучууд эзэлдэг бөгөөд тэдний ихэнх нь боловсрол мэдлэг дутмаг гэх шалтгаанаар цалинтай багатай, нийгмийн халамж, тэтгэмж тааруу, нарийн ур чадвар шаардлагагүй албан бус салбарт ажилладаг. Анхны ажилдаа орох болон хөдөлмөрийн зах зээлд байр сууриа олж ажиллахын тулд залуучуудад мэргэжлийн ур чадвараас гадна насан туршийн боловсрол эзэмших, өөрчлөлтөд дасан зохицох, харилцаа холбоо, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, карьер төлөвлөлт, санхүүгийн менежмент, бизнес эрхлэх зэрэг ажлын гол ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай байдаг. Эдгээр амьдралын чухал чадварыг хөгжүүлэх нь эргээд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн ажлын

бүтээмж, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, ажилчдын хөдөлмөрийн нөхцөл, ажил эрхлэх чадварыг дээшлүүлэхэд нэн чухал юм.

Мерси Кор “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” (RCP) хөтөлбөрийн хүрээнд 2020 оны намар Залуучуудын хөдөлмөр эрхлэх ур чадвар (YESP) төслийг эхлүүлж, залуучуудын хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ур чадварыг нь хөгжүүлэх гарын авлага болон дагалдах цахим хичээлийг боловсруулаад байна. Гарын авлага болон цахим сургалтын модулиудыг боловсруулахын тулд Мерси Корын зүгээс хоорондоо уялдаатай хоёр төрлийн зөвлөх үйлчилгээний зар гаргасан бөгөөд үүний нэг нь гарын авлага, цахим хичээлийн агуулгыг боловсруулах, нөгөө нь интерактив цахим хичээлийг хөгжүүлэх зөвлөх баг сонгон шалгаруулах зар байв. Зарын дагуу 2020 оны 10-р сард гарын авлага болон цахим хичээлийн агуулгыг боловсруулах зөвлөх, дараа нь 2021 оны 1-р сард цахим контент хөгжүүлэх Лүүп ХХК-г тус тус сонгон шалгаруулж хамтарч ажиллалаа.

Мал аж ахуйн чиглэлээр ажиллах сонирхолтой залуучуудтай ажиллах, цахим сургалтын явуулах туршлага зэргийг нь үндэслэн Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийг (ХААИС) тус цахим сургалтын модулийг платформ дээрээ байршуулах байгууллагаар сонгосон юм. Төслийн тогтвортой байдлыг хангах үүднээс 2021 оны 1-р сард Мерси Кор ба ХААИС нь сургалтын материалыг RCP хөтөлбөрийн дууссанаас хойш платформ дээр үргэлжлүүлэн байршуулах тухай санамж бичиг байгуулав. Үүний зэрэгцээ Мерси Кор нь ХААИС-д цаашид боловсруулсан сургалтын агуулгыг сурталчлах, баяжуулах, Монгол дахь цаг үеийн өөрчлөлтөд нийцэж агуулгыг өөрчлөх бүрэн эрхийг олгов.

Төслийн хэрэгжилт

Энэхүү төслийг 2020 оны 10-р сарын 15-ны өдөр сонгогдсон зөвлөхтэй гэрээ байгуулснаар албан ёсоор эхлүүлсэн. Төслийг гурван үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд үе шат болгон дараагийн үе шатанд хувь нэмрээ оруулах байдлаар зохион байгуулагдсан болно.

Гурван үе шат нь:

- 1-р үе шат: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд тулгамдсан асуудал сэдэвт ярилцлага (2020 оны 10-р сараас 2020 оны 11-р сар)
- 2-р үе шат: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ур чадвар гарын авлагыг боловсруулах (2020 оны 12-р сараас 2021 оны 3-р сар)
- 3-р үе шат: Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ур чадвар цахим хичээлийг боловсруулах (2021 оны 1-р сараас 2021 оны 3-р сар)

1-р үе шат: Ярилцлага

Мал аж ахуйн салбарт, ялангуяа хөдөө орон нутгийн залуучуудад тулгамдаж буй ажил эрхлэлттэй холбоотой гол асуудлуудыг бүрэн дүүрэн ойлгохын тулд нэн

түрүүнд салбарын талаар өргөн туршлага, мэдлэгтэй мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх нь нэн чухал байсан. Тиймээс 1-р үе шатанд RCP хөтөлбөрийн зорилтот аймгууд болох Хэнтий, Сэлэнгэ, Булган аймгуудын Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ) байгууллагуудыг удирдлагууд, хөдөө аж ахуй, мал аж ахуйн хэлтсийн мэргэжилтнүүд, мал аж ахуйн бизнес эрхлэгчид зэрэг мал аж ахуйн салбарын оролцогчидтой цахим ярилцлага хийсэн.

Ярилцлагыг YESP-ийн зөвлөх удирдан явуулсан бөгөөд залуучуудын өнөөгийн хөдөлмөрийн зах зээл дээр тулгарч буй бэрхшээл, эдгээр бэрхшээлийг шийдвэрлэхэд ямар гол үр чадварыг хөгжүүлэх шаардлагатай байгааг олж илрүүлэх зорилтоор дараах найман асуултыг боловсруулсан. Үүнд:

1. Залуучуудад тулгардаг түгээмэл бэрхшээл юу вэ?
2. Танай байгууллагад одоо залуучуудын хөдөлмөрийг дэмжих бодлого болон үйл ажиллагаа бий юу? Хэрвээ тийм бол нь ямар хэрэгцээн дээр тулгуурлаж уг бодлого, үйл ажиллагааг гаргаж ирсэн бэ? Эдгээрээс одоо амжилттай хэрэгжиж буй ямар туршлага байгаа вэ, хуваалцаач?
3. Таныг залуу байх үед ажил хөдөлмөрийн шилжилт хийхэд ямар асуудал тулгарч байсан бэ?
4. Та дээрх саад бэрхшээлийг яаж даван туулж байсан бэ? Сорилт болон сургамжит түүхээсээ хуваалцаач?
5. Орон нутгийн хөдөлмөрийн зах зээл дээр залуучуудад ямар үр чадварыг эзэмшсэн байх нь чухал байна вэ, орон нутгийн онцлог үүнд нөлөөлөх үү?
6. Бидний дурдаж буй зорилтот бүлгүүд болон хөдөлмөр эрхлэхэд нэн чухал үр чадваруудын дотроос аль нь илүү чухал байна вэ, илүү чухал ач холбогдолтой байхаар нэмэлт санал байна уу?
7. Эдгээр үр чадварыг хөгжүүлэхэд ямархуу алхам хэрэгжүүлэх, ямар нөөц бололцоо шаардлагатай байгаа вэ?
8. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, үр чадварыг хөгжүүлэх, ажлын байранд дасан зохицох үйл ажиллагааг танай орон нутагт, эсвэл танай байгууллагад хэрэгжүүлэх гэвэл та болон танай байгууллагаас ямар хувь нэмэр оруулах боломжтой вэ?

Ярилцлагад олон жилийн туршлагатай сурган хүмүүжүүлэгч, ахмад болон залуу бизнес эрхлэгч, мал аж ахуйн салбарт залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай 12 хүн оролцсон. Ярилцлага бүрийн дараа оролцогчдоос цахим судалгааг авсан бөгөөд ингэхдээ YESP зөвлөхийн урьдчилан бэлтгэсэн үр чадварын жагсаалтаас оролцогчид өөрсдийн бодлоор хамгийн хэрэгцээтэй эсвэл хамгийн хэрэгцээгүй үр чадваруудыг эрэмбэлж бөглөсөн юм. Дээрх судалгаа болон ярилцлагаас олсон мэдээлэл нь Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үр чадвар гарын авлагын гол үндэс болж, улс орны болон орон нутгийн залуучуудад бодит амьдрал дээр тулгарч буй хөдөлмөр эрхлэлтийн асуудлууд болон хамгийн хэрэгцээтэй үр чадваруудыг тодорхойлоход хувь нэмэр болсон.

2-р үе шат: YESP гарын авлага

Өмнөх үе шатанд хийсэн ярилцлагуудаас олж авсан мэдээлэл дээр үндэслэн 2-р үе шатанд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үр чадвар гарын авлагын агуулгыг боловсруулахад төвлөрсөн. Гарын авлага боловсруулах ажлыг 2020 оны 12-р сараас эхлэн эрчимтэйгээр эхлүүлж, эхний хувилбарыг 2021 оны 1-р сард боловсруулж, эцсийн хувилбарыг 2-р сард баталсан. Одоогийн байдлаар Монголд орон нутгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үр чадварын талаар тусгайлан хийсэн цогц судалгаа дутагдалтай байгаа тул ярилцлагаас олж авсан мэдээлэл гарын авлага боловсруулахад нэн хэрэгцээтэй байв.

Гарын авлага нь дараах агуулгын хэсгүүдээс бүрдсэн:

1. Оршил
 - a. Хөдөлмөр эрхлэх үр чадварын өнөөгийн хэрэгцээ
 - b. Хөдөлмөр эрхлэх үр чадварын тухай
2. Гарын авлагын хэрэглээ
 - a. Гарын авлагын зорилтот бүлэг
 - b. Сургалтын үйл ажиллагаа
 - c. Агуулгын бүтэц, цахим хичээлтэй холбох
3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үр чадварууд
 - a. Шилжих/хөрвөх үр чадвар
 - i. Өөртөө итгэх итгэл
 - ii. Харилцаа
 - iii. Зорилгоо тодорхойлох
 - iv. Асуудал шийдвэрлэх
 - v. Манлайлал
 - vi. Багаар ажиллах
 - b. Ажлын байрны үр чадвар
 - i. Карьер сонголт
 - ii. Ажлын байрны судалгаа
 - iii. Ажлын байрны өргөдөл
 - iv. Ажлын ярилцлага
 - v. Ажлын байрны ёс зүй
 - c. Санхүүгээ удирдах үр чадвар
 - i. Орлого, зарлагаа бүртгэх
 - ii. Мөнгөө хадгалах
 - iii. Хадгаламжийн төлөвлөгөө боловсруулах
 - iv. Зээл авах
 - v. Санхүүгээ төлөвлөх

- d. Бизнес эрхлэх үр чадвар
 - i. Жижиг бизнес эрхлэгч гэж юу вэ?
 - ii. Жижиг бизнес эрхлэх давуу тал болон сорилт
 - iii. Бизнес санаа гаргах
 - iv. Бизнес төлөвлөгөө бичих

4. Ашигласан материалын жагсаалт

Гарын авлагын эхний хэсэг нь Монголын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн чиг хандлага, залуучууд ажлын байх олоход тулгарч буй бэрхшээл, хөдөлмөрийн зах зээлд хамгийн их хэрэгцээтэй байгаа үр чадварын талаар мэдээлэл өгөхөд чиглэсэн. Энэ нь уншигчдад хөдөлмөр эрхлэх үр чадварыг яагаад дөрвөн төрөл болон дотроо 20 дэд үр чадварт хуваасныг ойлгуулах эхлэлийг тавьсан.

Хоёр дахь хэсэг нь гарын авлагыг бүтэц, агуулга, цахим гэрчилгээтэй цахим сургалттай хэрхэн уялдуулж, цаашид гарын авлагыг сургалтын зорилгоор хэрхэн ашиглах талаар мэдээлэл өгөхөд чиглэгдсэн. Энэ хэсэгт гарын авлагын зорилтот хэрэглэгчдийг тодорхойлов. Үүнд:

- Одоогоор ажил хайж буй залуучууд
- Ажилтай боловч үр чадвараа дээшлүүлэх сонирхолтой залуучууд
- Их дээд сургууль, коллежийн оюутнууд болон МСҮТ-ийн суралцагчид
- Ерөнхий боловсролын төгсөх ангийн сурагчид
- Хувиараа бизнес эрхлэх сонирхолтой залуучууд
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, зөвлөгөө зохион байгуулах сонирхолтой ТББ, сургагч багш нар
- Орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг байгууллагууд
- Үр чадвараа хөгжүүлэх сонирхолтой хүн бүрд зориулав.

Гурав дахь хэсэгт 4 гол үр чадварыг тодорхойлсон: Эдгээр нь Шилжих үр чадвар, Ажлын байрны үр чадвар, Санхүүгийн үр чадвар, болон Бизнесийн үр чадварууд болно. Үр чадварын хэсэг бүрийг дараах байдлаар зохион байгуулав: Ерөнхий тодорхойлолт, хувь хүний кейс судалгаа, шалгуур / шинж чанар, өөрийгөө үнэлэх, өөрийгөө хөгжүүлэх булан.

Үр чадвар гэж юу болох, тухайн үр чадвар ажлын байранд хэр тустай болох талаар Ерөнхий тодорхойлолт хэсэгт өгүүлнэ. Уншигч дараа нь үр чадварын хэсэг тус бүрд тохирсон 3 төсөөллийн хүний кейс жишээг судална.

- Шилжих үр чадвар – Номин (эмэгтэй): одоо ажил хайж байгаа ХААИС-ийн шинэхэн төгсөгч,
- Ажлын байрны үр чадвар – Марал (эмэгтэй): Хувийн мал эмнэлэгт ажилд ороод зургаан сар ажиллаж буй шинэхэн малын эмч
- Санхүүгийн болон бизнесийн үр чадвар – Тэргэл (эрэгтэй): малын тэжээл тариалах аж ахуйтай залуу бизнес эрхлэгч

Эдгээр кейс бүрд тухайн залуучууд маань бодит амьдрал дээр тохиолдож болох бэрхшээлүүдтэй тулгарах бөгөөд гарын авлага тэдгээр асуудлуудыг хэрхэн даван

туулах, авч хэрэгжүүлж болох алхмуудын талаар зөвлөнө. Төсөөллийн дүрээр дамжуулан тайлбарлах нь уншигчдад эдгээр жишээтэй холбогдох, ойрхон санагдах боломжийг олгох бөгөөд дараа нь өөрийгөө үнэлэх асуултад хариулж тухайн үр чадварын хувьд өөрийнхөө түвшнийг тогтоох боломжийг олгоно. Ингэснээр уншигч нь ямар үр чадварыг хөгжүүлэх шаардлагатай болон ямар үр чадварууд нь тэдний давуу тал болохыг олж мэдэх болно. Өөрийгөө хөгжүүлэх булангийн хэсэгт уншигчдад гол нөөц, хэрэгсэл, зөвлөмжийг өгсөн. Жишээлбэл, Шилжих үр чадварын хэсэгт зорилго тодорхойлох хүснэгтийг уншигчид өөрсдөө бөглөх боломжтой бол Ажлын байрны үр чадварын хэсэгт ажлын намтрын загвар оруулж өгсөн. Санхүүгийн менежментийн үр чадвар хэсэгт орлого, зарлагын тайлангийн хуудас, зээлийн өргөдөл гаргах загвар төлөвлөгөө, Бизнес эрхлэх үр чадварын хүрээнд бизнес төлөвлөгөөний жишээ хуудсыг оруулсан болно.

Нийт 1450 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, ХААИС-ын вэбсайтад цахим хэлбэрээр байршуулсан болно. Хэвлэгдсэн гарын авлагыг харин интернетэд нэвтрэх боломж багатай хүмүүст болон олон нийтэд сурталчлах зорилгоор аймгуудад дараах байдлаар тараасан:

Хүснэгт 3: Гарын авлагыг түгээсэн байдал

Байршил	Гарын авлагын тоо	Тодорхойлолт
Хэнтий, Сэлэнгэ, Булган	750 (1 аймагт 250)	Аймаг бүрд: Хөдөө аж ахуйн хэлтэс – 50 Мал эмнэлгийн хэлтэс – 50 МСҮТ – 50 Хөдөлмөр, нийгэм хамгаалал – 50 Сургууль, бизнесүүдэд – 50
Баян-Өлгий, Ховд, Увс, Сүхбаатар	400 (1 аймагт 100)	Аймаг бүрд: Хөдөө аж ахуйн хэлтэс – 20 Мал эмнэлгийн хэлтэс – 20 МСҮТ – 20 Хөдөлмөр, нийгэм хамгаалал – 20 Сургууль, бизнесүүдэд – 20
ХААИС	150	150 ширхэг гарын авлага болон засварлах боломжтой зөөлөн хувийг ХААИС-ийн вэбсайтад байршуулна
Мерси Корын түншлэгч байгууллагууд	150	Стартап Монгол, Educated Enterprise, Нийслэлийн Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, бусад сургалтын байгууллагууд гэх мэт.
Нийт	1450	

3-р үе шат: YESP цахим хичээл

Залуучуудад сонирхолтой байлгах, илүү олон хүнд хүрэхийн тулд Мерси Кор гарын авлагад дагалдах цахим хичээлийг боловсруулав. YESP цахим хичээл нь гарын авлагын агуулгад суурилсан бөгөөд үндсэн 4 модуль, 20 дэд модулиудтай.

Модуль бүр 30 хүртэлх минут буюу нийт 120 минут үргэлжлэх ба суралцагч нь өөрийн хэмнэлээр суралцах боломжтой, интерактив пресентац слайд, өөрсдөө дарж хариулах асуултууд, кейс судалгаа, дараа нь ашиглаж болох дасгал ажил, файлуудтай.

Түүнчлэн модуль бүр хичээлийн өмнөх болон дараах сорилттой бөгөөд оролцогч тухайн сорилтыг амжилттай өгснөөр дараагийн модуль руу орох, модулиа үзэж байгаад орхисон бол тэндээсээ буцаж эхлэх зэрэг зохицуулалттай байна. 4-р модулийг амжилттай дуусгасны дараа оролцогч бүх 4 модулийг сурч, асуултад тэнцсэн болохыг гэрчлэх цахим гэрчилгээ авна.

Цахим сургалтыг хөгжүүлэхийн тулд Мерси Кор нь 2021 оны 1-р сараас 3-р сарын хооронд “Лүүп” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, уг сургалтын модулиудад техникийн зөвлөгөө өгч, хөгжүүлэлт хийлээ. Цахим контент хөгжүүлэгч нь YESP-ийн зөвлөх болон ХААИС-ийн мэргэжилтнүүдтэй нягт уялдаа ажиллаж, модулийг хөгжүүлэв. YESP-ийн зөвлөх цахим сургалтад ашиглах агуулга, ХААИС-ийн мэргэжилтнүүд ХААИС-ийн вэбсайтын платформ дээр эцсийн агуулгыг нэгтгэхэд туслалцаа үзүүлж ажилласан.

Цахим сургалтыг <https://elearn.muls.edu.mn/> хаягаар орж үзэх боломжтой бөгөөд агуулгад нэвтрэхийг хүссэн хүн бүр үнэгүй үзэх боломжтой.

ХААИС-тай хамтран ажилласан нь

Мерси Кор нь YESP төслийг цаашид RCP хөтөлбөр дууссан ч урт хугацаанд тогтвортой үргэлжлэх төлөвлөгөөтэйгөөр төсөөлж боловсруулсан. Энэ зорилгодоо хүрэхийн тулд Мерси Кор нь ХААИС-ийг гарын авлага болон цахим сургалтын модулийг зохион байгуулах платформ байгууллагаар сонгосон. ХААИС нь нийслэл Улаанбаатар хотод төв кампустай, Орхон, Дорнод, Ховд аймгуудад салбар сургуулиудтай, Монгол Улсын төрийн өмчит мал аж ахуй, газар тариалан, мал эмнэлгийн чиглэлээр тэргүүний их сургууль юм. Тус их сургууль нь 9000 гаруй оюутанд мал эмнэлгийн шинжлэх ухаан, малын биотехнологи, инженер, агроэкологи, эдийн засгийн чиглэлээр бакалавр, магистр, докторын зэрэг олгодог. Сүүлийн жилүүдэд цахим сургалтын чиглэлд шилжиж байгаа бөгөөд “Хувийн мал эмнэлгийн бизнес хөгжил” цахим сургалтыг боловсруулах төсөл дээр Мерси Кортой хамтран ажилласан билээ.

2021 оны 1-р сарын 25-нд Мерси Кор YESP төслийн хүрээнд ХААИС-тай санамж бичиг байгуулсан бөгөөд уг санамж бичгээр Мерси Кор нь төслийн хүрээнд боловсруулагдах гарын авлага болон цахим хичээлүүдийг ХААИС-д хүлээлгэн өгөх, эргээд ХААИС нь Сургалт Удирдах Систем (СУС)-аас YESP төслийн зөвлөх багтай хамтарч ажиллах мэргэжилтэн томилж, өөрийн платформ дээр сургалтуудыг байршуулах үүргийг хүлээсэн юм. ХААИС нь одоо суралцаж байгаа болон төгссөн оюутнуудад сургалтыг сурталчлах ажлыг зохион байгуулж, үр чадвараа дээшлүүлэх, агуулгын материалыг ашиглах сонирхолтой бүх хүн, байгууллагуудад

энэхүү агуулгыг нь үнэ төлбөргүй хүртээх болно. Мөн түүнчлэн ХААИС нь сургалтын агуулгыг улам баяжуулах зорилготой байна.

Сургалтын агуулгыг цаашид хэрхэн сайжруулах талаар оролцогчдын санаа, зөвлөмжийг авах зорилгоор нээлттэй асуултуудыг цахим сургалтын платформд оруулж өгсөн. 2021 оны 3-р сарын 15-нд ХААИС-ийн вэбсайт дээр гарын авлагын зөөлөн хувь болон цахим хичээлийг байршуулж ба олон нийтэд хүрч эхэлсэн.

Дүгнэлт болон дараагийн алхамууд

Мал аж ахуйн салбар нь Монголын эдийн засгийн ирээдүйн тулгуур багана болохын тулд залуучуудыг салбартаа татах ёстой. YESP төсөл нь залуучуудад шаардлагатай хөдөлмөр эрхлэлтийг хөгжүүлэх үндсэн сургалтаар дамжуулж тэдний хөдөлмөрийн зах зээлд амжилттай шилжих, эсвэл одоогийн ажил эрхлэлтийн байдлаа хадгалах, сайжруулах, хөдөө аж ахуйн салбар ажиллах боломжийг нэмэгдүүлэхийг зорьсон. Түүнчлэн YESP төсөл нь мал аж ахуйн зах зээлийн салбарт (махны зах зээл, мал эмнэлгийн үйлчилгээ, тэжээл гэх мэт) ажиллах залуучуудын хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох чадварыг бэхжүүлэх, орлогыг нэмэгдүүлэх, бүтээмж, орон нутгийн бизнесийн зах зээлийн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой.

Төслийн дараагийн үе шатуудад гарын авлагыг бусад аймаг, байгууллагуудад тараах, төслийн сургалтын агуулгыг хүлээлгэн өгөх албан ёсны уулзалт зохион байгуулж, ХААИС-тай үргэлжлүүлэн хамтарч ажиллах, 60 залуусыг цахим сургалтад хамруулах, сургалтыг олон нийтэд сурталчлах, үр дүнгийн хяналт тавих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх болно.



Амжилтын түүх

ОРОН НУТГИЙН БИЗНЕС КЛИНИК ТӨСӨЛ

Түншлэгчийн нэр: Кинг Консалтинг ХХК

Төслийн байршил: Сэлэнгэ, Булган, Хэнтий аймгууд

Хугацаа: 2020 оны 3 сар-11 сар

Төслийн ерөнхий мэдээлэл

Мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Мерси Кор Булган, Хэнтий, Сэлэнгэ аймагт тогтвортой үйл ажиллагааг явуулж буй газар тариалан, мал аж ахуйн чиглэлийн жижиг дунд бизнестэй хамтран тэдэнд бизнесээ өргөжүүлэх, үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн боловсруулах боломжийг олгох зорилгоор буцалтгүй тусламж үзүүлэн ажиллаж байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд “Кинг Консалтинг Фирм” ХХК нь газар тариалан, мал аж ахуй, мал эмнэлгийн салбарт Мерси Кортой хамтран ажилладаг нийт 16 аж ахуй нэгжид бизнесийн зөвлөгөө хүргэх зорилгоор “Орон нутгийн бизнес клиник” төслийг 2020 оны 3-р сараас 11-р сарын хооронд хэрэгжүүлсэн. Гэрээний өмнөх үе шатанд хөтөлбөрийн баг Кинг Консалтинг ХХК-тай хамтарч төслөө боловсруулсан. Эцсийн үр дүнд уг төслийг таван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтов. Эхний


хоёр үе шат нь жижиг, дунд өөр өөр хэмжээтэй, төрөл бүрийн бизнес эрхлэгчдийн одоогийн хэрэгцээг үнэлэх (Бизнесийн MRI аргыг ашиглан), тэдгээрийн янз бүрийн хэрэгцээнд тулгуурлан бизнесийн тусгай зөвлөгөөг боловсруулахад чиглэгдсэн.

Таван сарын хугацаанд хэрэгжүүлсэн төслийн сүүлийн гурван үе шат нь биечлэн зөвлөгөө өгөх зорилгоор Кинг Консалтингийн зөвлөх багууд өөр орон нутагт очиж биечилсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанаас бүрдсэн. Төслийн хугацаанд бизнес эрхлэгчид тус бүр биечилсэн зөвлөгөө авах төлөвлөгөөн дэх чиглэлийг шийдвэрлэхэд нь туслах, бизнес эрхлэгчдэд шинэ бодлого, практик үйл ажиллагаа эрхлэхэд цаг хугацаа олгох зорилгоор нэмэлтээр тус бүрт нь дөрвөн цагийн зайнаас зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх түүнээс гадна хоёр удаа биечлэн зөвлөлдөх өдөр гаргаж өгсөн нь зөвлөлдөх уулзалтын хооронд олж авсан ур чадварыг бэхжүүлэхэд чиглэгдсэн болно.

Төслийн аргачлал

“Орон нутгийн бизнес клиник” төсөл нь 2020 оны 3-р сарын 19-ний өдөр албан ёсоор хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2020 оны 11-р сарын 12 хүртэл дараах таван үе шаттайгаар хэрэгжсэн.

Үе шатуудыг нарийвчлан дор тайлбарлав.



Хэрэгцээний үнэлгээ, Бизнесийн зөвлөх төлөвлөгөө (1-2 дугаар үе шат)

Кинг Консалтинг нь MRI-1 ба MRI-2 ярилцлагын хэв маягийн аргууд ба бизнесийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс (MVV), бизнесийн загвар зураг (BMC) зэргийг ашиглан бизнесийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох “Бизнесийн MRI” гэсэн онцлог аргачлалтай. Энэхүү аргачлалын хүрээ нь дараах зүйлийг тодорхойлоход ашиглагддаг.

- Компани болон түүний удирдлага бизнесийн өсөлтийнхөө чиглэлийг мэдэж, ач холбогдлыг нь ойлгож байгаа эсэх;

- Компанийн зорилго, зорилт нь шаардлагатай бизнес төлөвлөгөө боловсруулах үндсэн нөхцлийг хангаж байгаа эсэх
- Бизнесийн үйл ажиллагааны өнөөгийн байдал ямар байгаа, дараа дараагийн арга хэмжээнүүдийн төлөвлөгөө талаар

Кинг Консалтинг нь хоёр багт хуваагдан бизнес эрхлэгчдийн байрладаг өөр өөр газруудаар томилогдон ажилласан. Тэдгээр багууд нь бизнесийн захирал, менежерүүдтэй нэг өдрийн ярилцлага хийж бизнес хэрэгцээний үнэлгээг хийсэн. MRI-1 нь бизнесийн бүхий л талыг үнэлэх асуултууд дээр төвлөрч ярилцлага хийсэн бол MRI-2 нь зөвлөх үйлчилгээний төвлөрөх чиглэлийг тодорхойлоход чиглэгдсэн нээлттэй асуултуудад анхаарлаа төвлөрүүлж явагдсан. Оношилгооны үйл явц нь MRI үнэлгээний аль алиных нь үр дүнг нэгтгэн бизнес тус бүрт тохирсон Бизнесийн зөвлөх төлөвлөгөө (BCP- Хавсралт 2-ын загвар) боловсруулах ажлыг үргэлжлүүлж байна. BCP нь дараах чиглэлүүдээс хоёроос гурван чиглэлийг багтаасан болно.

- Бизнесийн засаглал ба хүний нөөцийн удирдлага
- Нягтлан бодох бүртгэлийн систем ба практик үйл ажиллагаа
- Санхүүгийн тайлангууд, анализ хийх үндэс
- Бизнес, стратегийн төлөвлөгөө боловсруулах, ажиллах
- Маркетинг / Бүтээгдэхүүн хөгжүүлэх / Шинэ үйлчлүүлэгчдэд хүрэх сурталчилгааны стратеги
- Тусгай лиценз, зөвшөөрөл болон бусад холбогдох баримт бичгүүд авах, өргөдөл гаргах

Хэрэгцээний үнэлгээний үр дүн нь дараах зүйлсийг нээн илрүүлсэн.

- Ихэнх бизнес эрхлэгчид компанийнхаа эрхэм зорилго, богино хугацааны зорилгын талаар ойлголттой байсан боловч бизнесийн тодорхой стратеги байхгүй байв. Тэд ихэвчлэн өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаанд анхаарч байсан бөгөөд зах зээлийн ирээдүйн боломжийг бүрэн тодорхойлж чадаагүй байсан.
- Түншүүд бизнесийн өнөөгийн чиг хандлага, өрсөлдөх чадварын талаар тодорхой бус ойлголттой байв.
- Жижиг бизнес эрхлэгчид нягтлан бодох бүртгэлд тэмдэглэлийн дэвтэр ашигладаг бөгөөд анхан шатны санхүүгийн бүртгэл хөтлөх санхүүгийн тогтолцоог бүрдүүлээгүй байв. Нэмж дурдахад ихэнх түншүүд хөдөлмөрийн стандарт гэрээ зэрэг хүний нөөцийн баримтжуулалтын системгүй байв.
- Дунд хэмжээний бизнес эрхлэгчид нь бизнесийн засаглалаа сайжруулж, бизнесийн өмчлөгч эзэмшигчид ба менежерүүдийн дунд ажил үүргээ тодорхой тусгаарлахыг хүсч байв.
- Бүх бизнес эрхлэгчдэд маркетинг, бизнес төлөвлөгөө, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, хэрэглэгчдийг татах, хадгалах стратеги чиглэлээр тусламж хэрэгтэй байв.

Бизнесийн оношлогоо хийсний дараа Кинг Консалтинг нь бизнес эрхлэгчдийн хамт бизнес хөгжүүлэлт, менежмент гэсэн цэс дотроос хоёр ба дөрөв хүртэлх чиглэлийг сонгосон: нягтлан бодох бүртгэл, санхүүгийн менежмент, шинэлэг маркетинг ба

брэнд хөгжүүлэлтийн стратеги, бизнесийн засаглалын хөгжил, хүний нөөцийн менежмент гэх зэргээр сонгон энэ чиглэлүүдээр биечилсэн болон алсын зайн зөвлөгөө үйлчилгээ авсан.

Биечилсэн болон алсаас зөвлөгөө өгөх үйлчилгээ (2-5-р үе шат)

Бизнес эрхлэгч бүр мэдээлэл авах, шинэ бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор таван сарын туршид үргэлжилсэн хоёр өдрийн биечилсэн зөвлөгөө өгөх хоёр удаагийн уулзалт (нийт дөрвөн өдөр), нэмэлт дөрвөн цагийн зайны зөвлөх үйлчилгээ авсан.

- 16 аж ахуйн нэгжээс:
- 11 бизнес хүний нөөцийн менежментийн зөвлөгөө авсан
- 13 бизнес санхүү нягтлан бодох бүртгэлийн зөвлөгөө авсан
- 3 бизнес бизнесийн засаглалын бүтэц зохион байгуулалт / зураглал дээр төвлөрсөн
- 1 бизнес албан ёсны зөвшөөрөл авах талаархи хуулийн зөвлөгөө авсан
- 13 бизнес Маркетингийн стратеги дээр төвлөрсөн
 - 3 бизнес Бизнес хөгжүүлэх / борлуулалтын төлөвлөгөөнд илүү анхаарч ажилласан
 - 6 бизнес нь Хэрэглэгчдэд хүрэх өргөн хүрээний стратеги дээр илүү төвлөрсөн
 - 4 бизнес Бүтээгдэхүүний хөгжүүлэлтэнд илүү их төвлөрсөн

LBSP-д оролцсон МСМ-ийн 16 түншүүдээс хоёроос таван ажилчинтай есөн компани, зургаагаас арван ажилчинтай таван компани, нэг компани 25 ажиллагсадтай, 50 хүн ажилладаг нэг компани (дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү) тус тус байсан.

Хоёроос таван ажилчинтай жижиг бизнес эрхлэгчид хүний нөөцийн бодлогын / баримт бичиг, санхүү нягтлан бодох бүртгэлийн практикт илүү их анхаардаг байв. Мандалхаан Сүрэг (мал эмнэлэг, лаборатори), Арт Маргад (малын тэжээл тариалагч) зэрэг компаниуд төслөө хэрэгжүүлэх явцад ажилчдыг ажиллуулахаар төлөвлөж байсан бөгөөд хөдөлмөрийн гэрээний төсөл боловсруулах, хөдөлмөрийн дотоод бодлого боловсруулах чиглэлээр яаралтай зөвлөгөө авах шаардлагатай байв. Нэмж дурдахад Дэвжих Дөл, Юмтгэгээ (мал эмнэлэг) зэрэг компаниуд нягтлан бодох бүртгэлийн зохих системгүй, санхүүгийн бүртгэл хийх програмын оронд хуучны хар дэвтэр ашиглан хийдэг байжээ. Эдгээр компаниуд нягтлан бодох бүртгэлийн систем, компьютер ашиглах талаар өргөн хэмжээний зөвлөгөө авсан. Эдгээр компаниуд нь мөн татварын тооцоо, татварын мэдүүлгийн талаар зөвлөгөө авсан.

Зургаагаас арван ажилчинтай жижиг компаниудын дараагийн үе шат нь голчлон Маркетинг ба Хүний нөөцийн менежмент / засаглалд анхаарлаа төвлөрүүлдэг байсан. Гурванборхууд (малын тэжээл үйлдвэрлэгч), Ар Сэвд Могойт (малын тэжээл үйлдвэрлэгч) зэрэг компаниуд бүтээгдэхүүн хөгжүүлэх тал дээр илүү анхаарч байсан бол Сэтиби (тэжээлийн ферм) зэрэг компаниуд хэрэглэгчдэд хүрч үйлчлэх,

бүтээгдэхүүн хөгжүүлэлт, Занаду Разорбак (мах боловсруулах), Дээдсийн Сүрэг (мах боловсруулах) зэрэг компаниуд нь бизнесийн хөгжил, бизнес төлөвлөгөөнд анхаарлаа төвлөрүүлэн ажиллав.

Дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн дараагийн хоёр ангилал нь Хушаатын хоршоо (мал үржлийн хэсэг), Мон Мийт Трейд (мах боловсруулах үйлдвэр) байсан. Хушаат хоршоо нь LBСP төслийн 16 компанийн дунд онцгой тохиолдол бөгөөд энэ нь бизнес эрхлэгчид, иргэд, малчид гэх мэт өөр өөр гишүүдээс бүрдсэн цорын ганц хоршооны хэлбэрийн байгууллага юм. 25 гишүүн нь хоршоонд бүртгэгдсэн боловч хоршоолсон бизнесийн байгууллагыг зохих ёсоор нь бүрдүүлэх, шаардлагатай дотоод дүрэм журмыг боловсруулах, хүний нөөцийн / засаглалын талаар өргөн хэмжээний зөвлөгөө өгөх шаардлагатай байв.

Нөгөөтэйгүүр, Мон Мийт Эрейд бол 50 ажилчин ажиллуулдаг гэр бүлийн бизнес юм. Компанийн бүх шийдвэрийг хариуцдаг эхнэр, нөхөр хоёрын хоорондох үүрэг, хариуцлагын давхцал зэрэг асуудлууд гарч байсан тул энд хүний нөөцийн ба компанийн засаглалыг нэн тэргүүнд тавьсан. Зөвлөх үйлчилгээ нь компанийн засаглалын бүтцэд анхаарлаа төвлөрүүлж, мэдээллийн илүүдлийг бууруулж, эзэмшигчдийн өөр өөр үүрэг хариуцлагыг тусад нь тодорхойлдог системийг бий болгосон.

Ерөнхийдөө бизнес эрхлэгчдийн санал, бүтээгдэхүүний төрөл, хэмжээ, компанийн ажилласан жил, бүтээгдэхүүн / үйлчилгээ зэрэг нь зөвлөх үйлчилгээний чиглэлийг сонгоход нөлөөлсөн. Гэсэн хэдий ч бизнесийн өнөөгийн байдал, бизнес эрхлэгчдийн сонгож буй \ чиглэл нь зөвлөх үйлчилгээний чиглэлд шууд нөлөөлсөн. Хавсралт 1-Хүснэгтээс бүх компаниуд болон тэдгээрийн зөвлөх үйлчилгээ авсан чиглэлүүдийн талаар мэдээлэл авна уу.

Төслийн үр дүн

Есөн сарын хугацаанд “Орон нутгийн бизнес клиник” төсөл нь бизнесийн менежментийн үндсэн үр чадвараа дээшлүүлэх, бодлого, үйл ажиллагаага нэгтгэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх замаар бизнесээ хөгжүүлэх зорилготой байв. Бизнесийн оншилгоо хэрэгцээний үнэлгээ, биечилсэн ба зайнаас зөвлөгөө авах арга хэмжээний дараа төслийн үйл ажиллагаа нь дараах үндсэн үр дүнд хүрсэн болно; эдгээрийг доор дэлгэрэнгүй тайлбарлав.

Үр дүн 1: Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлс- Засаглал ба бизнесийг хөгжүүлэхэд чиглэсэн зөвлөгөө

Эдгээр зөвлөх үйлчилгээний чиглэлүүд нь бизнес эрхлэгчдийн ерөнхий үнэт зүйлс, эрхэм зорилго, алсын хараа, урт хугацааны зорилгыг сайжруулах нэг гол үр дүнд чиглэгдэн бүлэглэгдсэн болно. Хэрэгцээний үнэлгээний үеэр зөвлөхүүд болон компаниуд тодорхойгүй байгаа бизнесийн ерөнхий эрхэм зорилго, алсын хараа, зорилгоо тодорхойлж, компанийн засаглалын бүтцийн өөрчлөлтийн талаар

зөвлөгөө авах, бизнесийн үндсэн зорилго, зорилт, ирээдүйн төлөвлөгөөг бататгах гол бүрэлдэхүүн хэсэг болох бизнесийг хөгжүүлэх үр чадвар эзэмшсэн.

Үр дүн 2: Дүрэм журам, үйл явцаа сайжруулснаар бизнес менежментийн чадамжаа нэмэгдүүдэв – Хүний нөөцийн менежмент болон санхүү/ нягтлан

Ихэнх мал аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгжүүд хөдөлмөрийн гэрээгүйгээр ажилчдыг ажиллуулж, хар дэвтэр зэрэг хуучирсан аргыг ашиглан санхүүгийн тайлан гаргадаг байв. Хүний нөөцийн үр дүнтэй дотоод бодлогын журмыг бий болгон, хөдөлмөрийн гэрээ гэх мэт зохих хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулснаар компаниуд хууль ёсны журмын шаардлагыг хангаж, ажилчид, ажил олгогчдыг хамгаалах боломжийг бүрдүүлсэн. Нэмж хэлэхэд, нягтлан бодох бүртгэлийн системийг шинэчилэн компьютер програмаар хийх болгосон нь компаниуд ирээдүйд санхүүгийн хувьд сайн шийдвэр гаргах чадвартай болоход хувь нэмэр болсон.

Үр дүн 3: Маркетингийн шинэлэг санаачлага ашиглаж бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулав- Маркетингийн зөвлөгөө нь бүтээгдэхүүний хөгжил, сурталчилгаа бүтээгдэхүүн ба маркетингийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад чиглэсэн болно.

Ихэнх түншүүдийн хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах, хэрэглэгчдэд хүрэх шинэлэг арга хэрэгслийг бий болгохын тулд маркетингийн зөвлөгөө шаардлагатай байсан байна. Зөвлөх үйлчилгээнээс гарсан гол гурван үр дүн нь ерөнхийдөө бизнес эрхлэгчдийн алсын хараа, эрхэм зорилгоо тодорхойлох, сурталчлах, бизнесийн урт хугацааны төлөвлөлт хийх стратеги боловсруулах, маркетингийн төлөвлөгөө боловсруулж, байгууллагын хүрээнд засаглалын бүтцийг бий болгох чадварыг дээшлүүлж чадсан нь эцсийн эцэст бизнес эрхлэгчдийн урт хугацааны амжилт, ашигт байдалд нөлөөлөх болно. “Орон нутгийн бизнес клиник” төслийн зөвлөлдөх уулзалтын үеэр зөвлөхүүдийн хандлага, аргачлал нь бизнес эрхлэгчдэд бизнесийнхээ хэрэгцээг хамгийн сайн хангах өөрсдийн хэрэгцээт зөвлөгөөг тохируулан авах эрх чөлөөг бүрэн олгосон болно.

Үр дүн 1: Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс

Манай орны мал аж ахуйн бизнес эрхлэгчид улирлын шинж чанартай байдал, хэрэглэгчид суурилсан, урирдлагын чадамж нь бүтэц зохион байгуулалт дутмаг зэрэг шалтгаанаас үүдэн ихэвчлэн өдөр тутмын үйл ажиллагаа, богино хугацааны зорилго дээр төвлөрдөг. Хэдийгээр богино хугацааны зорилгодоо төвлөрөхөд буруудах зүйлгүй ч эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ тодорхойлох нь бизнесийн ирээдүйн буюу урт хугацааны зорилго, зорилт зэргийг зөвхөн удирдлага бус мөн ажилтнууд, цаашлаад бусад хүмүүст илүү ойлголжтой болгож өгдөг ач холбогдолтой. Хэрэгцээг тодорхойлох үнэлгээний үр дүнд 16 түнш байгууллагууд бүгд энэ тал дээр сул байсан ба Засаглал, Бизнес Хөгжил зэрэг зөвлөх үйлчилгээгээр

дамжуулан эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ хамтран тодорхойлохоор тохиролцсон.

Кинг Консалтинг ХХК нь Мон Мийт Трейд компанийн засаглалыг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн. Хэнтий, Улаанбаатарт салбартай тус байгууллагын хувьд салбар хоорондын дотоод харилцаа нь үр дүн муутай, ихэнх тохиолдолд захирлыг хэрэгцээгүй мэдээллээр дарах нь их байсан. Захирлын үүрэг, хариуцлага нь тодорхойгүй буюу бага түвшний шийдвэрт гаргалтад хүртэл оролцох шаардлагатай байв. Иймд, Кинг Консалтинггаас тус байгууллагын ажилтнуудын бүтэц зохион байгууллагыг боловсруулж, үүндээ харилцаа холбооны диаграммыг мөн оруулсан. Ингэснээр компани дахь үүрэг, хариуцлага, бүтэц тодорхой болж, ямар төрлийн мэдээллийг эхлээд хэнд тайлагнах вэ зэргийг тодорхойлж өгсөн.

Кинг Консалтингийн дараагийн ажилласан байгууллага нь Сэлэнгэ аймагт үржлийн үйл ажиллагаа эрхэлдэг Хушаатын хоршоо байсан юм. Тус хоршоонд тэжээл тариалагч компаниуд, малын эмч нар, үржлийн үйл ажиллагаа эрхлэгчид, малчид зэрэг орон нутгийн иргэд багтдаг. Хоршоотой МК 2017 оноос хойш ажиллаж байгаа ба өмнө нь хоршоо үржлийн чиглэлээрээ зөвлөх үйлчилгээ авч байсан. Хоршоо өөрийн 5 жилийн төлөвлөгөөтэй хэдий ч дотоод засаглалаа дахин зохион байгуулах хэрэгцээтэй тулгарсан. Ингэснээр хоршооны гишүүд хоршооны бүтэц, зохион байгуулалт, гишүүдийн үүрэг, хариуцлага, санал хураах дүрэм, журам талаар нэгдсэн нэг тодорхой ойлголттой болоход дөхөм болгоод зогсохгүй бизнесийн үйл ажиллагаа, гишүүдийн оролцоонд бас эергээр нөлөөлсөн. Зохиомол хээлтүүлэг, үржлийн үйлчилгээ үзүүлэгч Төгс Ген компанид эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ сайжруулан тодорхойлоход нь хамтран ажилласан. Компаний хувьд Кинг Консалтингтай ажиллахаас өмнө мэргэжлийн ур чадамждаа тулгуурлан бизнесийн зорилго, алсын хараагаа маш тодорхой боловсруулсан байсан хэдий ч малчдад үйлчилгээгээ таниулах тал дээр бага зэргийн хүндрэлтэй байжээ. Малчдад уламжлалт болон зохиомол хээлтүүлгийн ялгаа, тэр дундаа зохиомол хээлтүүлгийн давуу талыг сайтар ойлгуулах тал дээр ажиллах шаардлагатай байв. Иймд, зөвлөхүүд компанитай хамтарч байгууллагын танилцуулгыг сайжруулж, компаниас санал болгодог үржлийн бүтээгдэхүүнүүдийг төрөлжүүлэн ангилж, тараах материал боловсруулсан. Зөвлөх үйлчилгээний үр дүнд, Төгс Ген өмнө нь тодорхойлоогүй байсан зарим давуу талаа илрүүлж, одоо үзүүлж буй үйлчилгээгээ сайжруулж, төрөлжүүлэн, малчдад болон хэн ч уншихад маш ойлгомжтойгоор тараах материалаа боловсруулан бэлтгэжээ.

Үр дүн 2: Дүрэм журам, үйл явцаа сайжруулснаар бизнес менежментийн чадамжаа нэмэгдүүлэв

RCP хөтөлбөртэй хамтарсан ихэнх дэд төслийн хэрэгжилтийн төлөвлөгөөнд үйлчлүүлэгчдэд хүрэх аргаа сайжруулах, ажлын байрны тоог нэмэгдүүлэх, санхүүгийн менежментээ сайжруулах зэрэг багтсан. Дэд төсөл хэрэгжүүлэгчид Орон нутгийн бизнес оношилгооны зөвлөхүүдтэй хамтран бизнесийнхээ өсөлт, хөгжилтөд

шаардагдах зөвхөн өөрийн бизнест нь тусгайлан зориулсан арга хэрэгслүүд дээр ажилласан ба уг арга хэрэгслүүд ихэнхдээ хүний нөөц, санхүү/нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдож байсан. Бизнесийн тогтвортой өсөлт, хөжилд бизнес менежментийн энэ хоёр хэсэг зайлшгүй шаардлагатай.

Хөтөлбөрийн түнш байгууллагууд бизнесээ өргөжүүлэхийн хэрээр шинэ асуудалтай тулгарсан нь шинэ ажилтнуудаа удирдах болон хүний нөөцтэй холбогдох баримт бичгийн албажуулалт байсан юм. Ихэнх байгууллагын хувьд, хүний нөөцтэй холбоотой асуудлуудаа амаар, утсаар эсвэл бусад албан бус эх үүсвэр ашиглан солилцдог байсан нь эргээд аль аль талдаа асуудал дагуулж байв. Зөвлөх баг хөтөлбөрийн 13 түнш байгууллагатай хөдөлмөрийн хууль, журмын дагуу хүний нөөцийн журам, дотоод дүрэм журам, хөдөлмөрийн гэрээ зэргийг боловсруулахад нь хамтран ажилласан. Үүнээс гадна, дөрвөн байгууллага ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, эрүүл ахуйн журам боловсруулсан.

“Байгууллагад хөдөлмөрийн дотоод дүрэм, журам, гэрээ, заавар зөвлөгөө зэрэг анхан шатны баримт бичгүүд байснаар ерөнхий болон хөдөлмөрийн хуулийн дагуу тогтвортой үйл ажиллагаа явуулах үндэс суурь нь болж өгдөг” хэмээн Кинг Консалтингийн зөвлөхүүдийн нэг нь хэлжээ. Хүний нөөцийн зөвлөх үйлчилгээний үр дүнд Дээдсийн Сүрэг компани нь шинэ ажилтнуудтай байгуулах хөдөлмөрийн гэрээ, нууд хадгалах гэрээ, эд хөрөнгийн хариуцлагын гэрээ боловсруулан, албан ёсоор байгуулжээ. Энэ нь нэг талдаа Дээдсийн Сүрэг компанийг хуулийн хүрээнд хамгаалахаас гадна, ажилтнууд өөрсдийн эрх, үүргийн талаар бүрэн ойлголттой болох юм. Хүний нөөцийн зөвлөх үйлчилгээ авсан түнш байгууллагууд нь цаашид өргөжин тэлсэн ч авсан зөвлөмжүүдээ ашиглах боломжтой. Хүний нөөцийн сайн менежменттэй байх нь бизнесийн цаашдын өргөжилт, тогтвортой байдлын бат бөх суурь болдог.

Түнш байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн дүрэм журам, процедураа албажуулах нэн шаардлагатай гэж гарсан. Иймд, 13 байгууллагад нягтлан бодох бүртгэл, гүйлгээ, борлуулалтын бүртгэл, бүртгэл баримтжуулалтын стандарт үйл ажиллагааны журам боловсруулах, одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль дүрэмд нийцэх зэргийг багтаан зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. Кинг Консалтингийн зүгээс нягтлан бодох бүртгэлийн анхан шатны систем, үйл ажиллагаанд суурилсан өртөг тооцох арга, эрсдэлийн түвшин тооцох үнэлгээний арга зэрэг түнш байгууллагууд цаашид ашиглахуйц хэд хэдэн арга хэрэгслийг олгожээ. Зөвлөх үйлчилгээгээр байгууллагуудын санхүүгийн арга хэрэгслүүд ашиглах чадамжийг нэмэгдүүлснээр илүү сайн чанарын бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах боломжтой болсон юм.

Мандалхаан Сүрэг мал эмнэлгийн захирал хэлэхдээ “бид бизнес баримт бичгүүд болон бүртгэлийн системээ сайжруулснаар бидний үйл ажиллагааг үр ашигтай болгох боломжтойг харсан. Шинээр боловсруулсан малчдын бүртгэл нь малчидтай холбогдох, тэдэнд үйлчилгээгээ ойртуулахад давуу талтай болсон.” гэжээ. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн системээр байгууллагыг дэмжих нь урт хугацаанд бизнес

оршин тогтноход чухал ач холбогдолтой.

Үр дүн 3: Шинэлэг маркетингаар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулав

Аливаа бизнесийн хувьд үйлчлүүлэгчтэй харилцах, бүтээгдэхүүн хөгжүүлэх, стратегийн хүрээнд маркетинг боловсруулах зэрэг нь цаашдын амжилттай нь шууд холбоотой. Үүгээр дамжуулан компаниуд өөрийн мессежээ хүргэх, боломжит худалдан авагчдыг өөртөө татах, цаашлаад зөв ашиглагдсан тохиолдолд тухайн орон нутгийн иргэдэд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээг бий болгодог. Өнөө үед ихэнх маркетингийн стратеги нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулахад илүү анхаардаг ба боломжит худалдан авагчдыг татах хамгийн сайн аргаар олон нийтийн сүлжээ буюу сошиал медиагаар түгээх хэвээр байгаа.

Дээрх түнш байгууллагууд бүгд шахуу төслийн хүрээнд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгосон ч маркетингийн төлөвлөгөө боловсруулах, бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон нийтэд хүргэх стратеги боловсруулах тал дээр маш цөөн нь л тодорхой туршлагатай байсан. Кинг Консалтинг зөвлөх үйлчилгээ үзүүлсэн 14 байгууллагынхаа бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхээр эрэмбэлэх, тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Үүнд брэндинг бий болгох, сурталчилгааны материал боловсруулах, сошиал медиад өөрийн хуудсыг бий болгох, 8 компани анх удаа логотой болсон, 4 компани байгууллагын танилцуулга брошур боловсруулахад зөвлөгөө авсан зэрэг ажлууд багтна. Маркетингийн төлөвлөгөө боловсруулахдаа бизнес хөгжлийн бусад зүйлстэй нэлээдгүй холбож өгсөн.

Малын тэжээл үйлдвэрлэгч Гурванборхууд ХХК-ийн адилаар зарим түнш байгууллагуудад стратегиэ боловсруулах, зах зээл дэх эзлэхүүнээ өргөжүүлэхийн тулд бизнесийн зорилгоо тодорхойлоход дэмжлэг шаардлагатай байсан гэж Кинг Консалтинг тайландаа тусгажээ. Зөвлөх үйлчилгээ авахаас өмнө тус компани эрхэм зорилго, алсын хараагаа тодорхойлоогүй, бүтээгдэхүүнээ сурталчлахад зах зээлийн судалгаа дутмаг, үйл ажиллагааныхаа өөр өөр хэсгүүдийг хооронд нь зохицуулахад хүндрэлтэй байж. Тус компаний бүтээгдэхүүнүүд нь өөр өөр нэрээр гардаг, нэгдсэн брэндинг талаас учир дутагдалтай байсан тул зөвлөх үйлчилгээ голлон компаний маркетинг, брэндинг боловсруулахад төвлөрч, борлуулалтын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлжээ. Гурванборхууд ХХК-ийн удирдлага, ажилтнууд хамтран байгууллагынхаа лого болон арвай тариалалт, арвайн гурил үйлдвэрлэлт, малын тэжээл гэсэн гурван чиглэл бүхий брэндинг дээр ажилласан. Мөн малчдад сурталчлах зорилгоор сурталчилгааны зурагт хуудас (постер), олон нийтэд таниулах зорилгоор сошиал медиа хуудас нээсэн. Борлуулалтын болон бизнесийн ашигт ажиллагааны төлөвлөгөө тус тус боловсруулсныгаа дараа нь шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхдээ ашиглажээ.

Компанийн зорилгоо тодорхойлох, түүндээ хүрэхийн тулд маркетингийн төлөвлөгөө, бизнес загвараа бий болгох шаардлагатай компаниудын нэг нь мал аж ахуйн

тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Элит Хүнс ХХК байсан юм. Бизнесийн зөвлөхийн тусламжтайгаар тус компанийн удирдлага бизнесээ шинэ өөр нэрээр таниулах шаардлагатай, олон хүнд хүрэхийн тулд шинэ стратегийн хүрээнд ажиллах нь зүйтэй гэдгээ анзаарч, энэ талаараа “Манай компанийн мал аж ахуйн тоног төхөөрөмжийн шинэ бизнес загварын санаа нь зөвлөх үйлчилгээний үр дүнд гарсан ба уг загварт бог, бод малын тоног төхөөрөмжийн худалдаа багтна. Энэ загвараа бизнесийн урт хугацааны орлогод эерэг нөлөөтэй гэж төсөөлж байна. Шинэ нэрээр НомадТех гэх нэрийг сонгосон ба энэ нь үйл ажиллагаа, ирээдүйд өргөжих бизнесийн алсын хараатай нягт уялдаж байгаа” гэжээ.

Дээр дурдсан байгууллагууд голчлон бүтээгдэхүүн хөгжүүлэлт дээр анхаарч байсан бол зөвлөх үйлчилгээний хүрээнд шинэ санаачлага гаргасан хоёр байгууллага нь Мандалхаан Сүрэг, Дэвжих Дөл хувийн мал эмнэлгүүд байв. Сошиал медиа хуудас нээснээр Мандалхаан Сүрэг нь эмийн сан, лабораторийн үйлчилгээг хөрш сумд зэргээр илүү өргөн хүрээнд таниулах боломжтой болсон. Уг хуудас нээснээр нэгэн төлөвлөгдөөгүй эерэг өөрчлөлт нь харилцагийн эргэх холбоо сайжирчээ. Хувийн мал эмнэлэгт бүртгэлгүй малчид залуу малын эмч нартай сошиал хуудсаар нь дамжуулан холбогдож лабораторийн үйлчилгээ, малын эм тариа зэрэг мал эмнэлгийн зөвлөгөө авах болсон.

Дэвжих Дөл мал эмнэлэгт үзүүлсэн Кинг Консалтингийн зөвлөгөө нь ердөө л мал эм, бүтээгдэхүүнээ дахин зохион байгуулалт оруулах мэт боловч ингэж шинээр янзалснаар үлдэгдлийг түргэн хугацаанд харах, дараагийн худалдан авалтаас төлөвлөх, малчдад түргэн шуурхай үйлчлэх боломжоор хангах зэрэг ач холбогдолтой. Түүнчлэн компанитай хамтран бий болгосон шинэ санаачлага нь Гэрээт Малчид юм. Гэрээ байгуулсан малчдад хямдралтай үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээ олгох боломжтой бол нөгөө талд, мал эмнэлэг нь нь зорилтот хэрэглэгчдээ хадгалж үлдэх замаар орлогоо ч мөн тасалдуулахгүй байх давуу талтай.

Дүгнэлт

Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд хөтөлбөрийн түнш байгууллагуудын тодорхойлсон нэн шаардлагатай зүйлст Кинг Консалтинг Орон нутгийн бизнес оношилгоо төслөөрөө дамжуулан тусгайлсан зөвлөх үйлчилгээ үзүүлжээ. Үр дүнд нь компаниуд эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ сайжруулан тодорхойлж, менежментийн илүү үр ашигтай аргыг нэвтрүүлэн, шинэ санаачлагыг боловсруулсан. Ерөнхийд нь дүгнэхэд, уг төслийн хүрээнд олгосон зөвлөгөөнүүд нь бизнесийн үйл ажиллагааны суурь болж, цаашид урт хугацаанд ашиглагдах боломжтой юм.

16 түнш байгууллага нь бүгд амжилттайгаар бизнесээ өргөжүүлэх дэд төслүүдээ¹⁴ хэрэгжүүлсэн ба энэ хүрээндээ Кинг Консалтингтай ажиллаж амжилтанд хүрэхэд шаардлагатай сургамж, туршлага хуримтлуулсан. Эдгээр сургамж, туршлагауудыг

¹⁴ “RCP хөтөлбөрийн сайн туршлагаууд”-аас харах

Кинг Консалтингийн эцсийн тайлан, Мерси Корын мониторингийн тайлан, түнш байгууллагуудтай хийсэн ярилцлага зэргээс харах боломжтой.

Зөвлөх үйлчилгээнээс өмнө бизнесийн суурь түвшинг тодорхойлох- Үг төсөл амжилттай болсон нэг хөшүүрэг нь Кинг Консалтингийн “Бизнес MRI” хэрэгцээ тодорхойлох үнэлгээ байсан. Бизнес менежмент, үйл ажиллагааны хүрээнд хаана яваа юм, компаний зорилго, зорилт нь юу болох, бизнес хөгжлийн төлөвлөгөө нь юу зэргийн суурь түвшинг тогтоосноор зөвлөхүүдэд компанитай уулзаж, цаашид хөгжүүлэх шаардлагатай зүйлст нь төвлөрч ажиллахад хялбар болгож өгчээ. Эхлэх цэгээ тодорхой гаргаж өгснөөр хэрэгцээ шаардлага бодитоор тодорхойлоход түлхэц болж зөвлөх үйлчилгээг илүү үр дүнтэй явагдахад чухал нөлөөтэй.

Захиалагчийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан дэмжлэг- Үр дүнтэй, хэрэгцээт дэмжлэг үзүүлэхэд тухайн бизнесийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан тусгайлсан үйлчилгээ боловсруулах нь чухал. Зөвхөн тухайн компанид зориулсан арга хэрэгсэл, зөвлөгөө боловсруулах нь тус зөвлөх үйлчилгээний дараа ч тэдгээрийг ашиглах боломжтойгоороо давуу талтай. Орон нутгийн бизнес оношилгоо төслийн нэг зорилго нь Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд хөтөлбөр дууссаны дараа ч ашиглаж болохуйц бизнес өргөжилтөд нь хэрэгцээт арга хэрэгсэл, чадамжаар хангах байсан. Тусгайлсан зөвлөх үйлчилгээнд бизнесийн хүчин чадлын түвшин нэмэгдэхийн хэрээр компанийн дасан зохицох чадвар мөн багтсан. Энэ хүрээнд туршлага ихтэй, нас тогтсон бизнес эрхлэгчдийн хувьд технологийн шинэчлэлт, арга технологиос суралцах, түргэн хугацаанд ашиглаж сургах байсан бол шинэ санал, санаачлагыг түргэн хугацаанд хүлээн авдаг залуу бизнес эрхлэгчдийн хувьд нягтлан бодох бүртгэл гэх мэт тогтсон хэсгүүдэд сайжруулалт хийгдэх шаардлагатай байсан. Зөвлөх үйлчилгээ нь компанийн тусгайлсан хэрэгцээ, шаардлагад тулгуурласан учраас компани үүнийгээ цаашдын бизнесийн өсөлт, хөгжлийн суурь болгон ашиглах боломжтой юм.

Зөвлөх үйлчилгээний үе шатууд- Зөвлөх үйлчилгээг үе шаттайгаар олгосон нь компаниудад нэг дор маш их мэдээлэлд дарагдахгүй байх, тодорхой хугацааны турш үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх ач холбогдолтой. Дээр тайлбарласанчлан, эхний шатанд компаниудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон бол дараагийн шатанд компани бүрээр зөвлөх үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулсан (Хавсралт 2). Гуравдахь шатанд 16 компанид тус бүрт нь зөвлөх үйлчилгээг үзүүлсэн бол Дөрөвдүгээр шатанд зөвлөх үйлчилгээг үргэлжлүүлэн зайнаас олгосон. Ингэж үе шаттайгаар хийсэн нь компаниудад шинэ мэдээллээ боловсруулан, дараагийн уулзалтад бэлтгэх хугацаа олгох, цаашлаад уг шинэ мэдлэгээ үйл ажиллагаандаа Кинг Консалтингийн дэмжлэгтэйгээр ашиглаж үзэх чухал ач холбогдолтой байв. Сүүлийн шат буюу зайнаас хийсэн зөвлөх үйлчилгээ нь сүүлийн хоёр шатын хооронд гарсан аливаа асуудал, хэрэгцээ шаардлага юу байв, тэрийг хэрхэн шийдвэрлэх боломжтой зэргийг ярилцаж шийдвэрлэх боломж олгожээ.

Хавсралт 1: Зөвлөх үйлчилгээний чиглэлүүд

	Байгууллагын нэр	Үндсэн ажилчдын тоо	Бизнесийн төрөл	Байршил	Зөвлөн үйлчилгээний чиглэл
1	Мөнх Түрүү ХХК	5	Малын тэжээл үйлдвэрлэл	Булган	Хүний нөөц/Засаглал Санхүү/Нягтлан
2	Занаду Разорбак ХХК	9	Мах боловсруулалт/ Мал бордох	Булган	Хүний нөөцийн менежмент Санхүү/Нягтлан Маркетинг/Бизнес төлөвлөгөө
3	Юмтэгээ ХХК	3	Мал эмнэлгийн үйлчилгээ	Хэнтий	Санхүү/Нягтлан Маркетинг/Олон нийтийн түгээлт
4	Элит Хүнс ХХК	2	Мал аж ахуйн тоног төхөөрөмж	Хэнтий	Санхүү/Нягтлан Маркетинг/Бүтээгдэхүүн Патент
5	Минжийн Бор Өтөг ХХК	5	Мах боловсруулалт	Сэлэнгэ	Хүний нөөцийн менежмент Санхүү/Нягтлан
6	Мон Мийт Трейд ХХК	50	Мах боловсруулалт	Хэнтий	Хүний нөөц/Засаглал Маркетинг/Бүтээгдэхүүн Санхүү/Нягтлан
7	Ар Сэвд Могойт ХХК	9	Малын тэжээл үйлдвэрлэл	Сэлэнгэ	Санхүү/Нягтлан Маркетинг/Бүтээгдэхүүн
8	Төгс Ген ХХК	2	Малын зохиомол хээлтүүлэг	Сэлэнгэ	Хүний нөөцийн менежмент Санхүү/Нягтлан Маркетинг/Бизнес төлөвлөгөө
9	Сэтэби ХХК	7	Малын тэжээл үйлдвэрлэл	Сэлэнгэ	Хүний нөөцийн менежмент Маркетинг/Олон нийтийн түгээлт
10	Дэвжих Дөл ХМЭ	3	Мал эмнэлгийн үйлчилгээ	Сэлэнгэ	Хүний нөөцийн менежмент Санхүү/Нягтлан Маркетинг/Олон нийтийн түгээлт
11	Арт Маргад ХХК	4	Малын тэжээл үйлдвэрлэл	Хэнтий	Хүний нөөцийн менежмент Санхүү/Нягтлан Маркетинг/Олон нийтийн түгээлт
12	Дээдсийн Сүрэг ХХК	13	Мах боловсруулалт	Хэнтий	Хүний нөөцийн менежмент Маркетинг/Бизнес хөгжил
13	Гурван Борхууд ХХК	9	Малын тэжээл үйлдвэрлэл	Булган	Маркетинг төлөвлөгөө Бүтээгдэхүүн хөгжил
14	Мандалхаан Сүрэг ХМЭ	2	Мал эмнэлгийн лаборатори	Хэнтий	Санхүү/Нягтлан Маркетинг/Олон нийтийн түгээлт Хүний нөөцийн менежмент
15	Хушаатын Хоршоо	25	Үржлийн нэгж	Сэлэнгэ	Хүний нөөцийн менежмент Санхүү/Нягтлан Засаглал
16	Сац Манал ХМЭ	2	Мал эмнэлгийн лаборатори	Хэнтий	Санхүү/Нягтлан Маркетинг/Олон нийтийн түгээлт

Хавсралт 2: Бизнесийн зөвлөх төлөвлөгөөний загвар

Бизнесийн зөвлөх төлөвлөгөө

Доорх хүснэгтэд тодорхой, ойлгомжтой, зорилтот үзүүлэлт болон үйл ажиллагааг тодорхойлсон Бизнесийн зөвлөх үйлчилгээний төлөвлөгөөний жишээг харуулж байна.

Түншлэгч байгууллагын мэдээлэл				
Байгууллагын нэр				
Төслийн байршил				
Төслийн хугацаа				
Чиглэл 1				
Бизнесийн зөвлөх үйлчилгээний чиглэл 1				
Одоогийн байдал				
Эцсийн зорилго				
Түлхүүр алхмууд	Хүрэх үр дүн	Үүрэг	Зорилтот чиглэлд хүрэх явц	Хугацаа
Суурь байдлаас эцсийн зорилгод хүрэхийн тулд хийх ёстой алхам бүрийг тодорхой бичих. Хийх алхмууд нь бүх талуудад ойлгомжтой, тодорхой байх шаардлагатай. Алхам 1: Алхам 2: Алхам 3:	Түншлэгч байгууллага: Түншлэгч байгууллагын бүтээх/ хөгжүүлэх үр дүнг тодорхойлох Зөвлөхүүд: Зөвлөхийн талаас алхмуудыг амжилттай гүйцэтгэхэд түншлэгч байгууллагад хүлээлгэн өгөх шаардлагатай баримт/материалыг тодорхойлох	Түншлэгч байгууллага: Эдгээр алхмуудыг гүйцэтгэхэд түншлэгч байгууллагын талаас юу хийсэн байх вэ? Тэд хэрхэн манлайлж ажиллах вэ? Хэр оролцох ёстой вэ? Мерси Кор: Мерси Корын талаас ямар зохицуулалт хийх вэ? Хэрхэн тусалж, дэвжих вэ? Зөвлөх: Аль зөвлөх энэ чиглэлийн үйлчилгээг хариуцаж ажиллах вэ? Хэрэгжилтийг дэмжихийн тулд юу хийх вэ?	Амжилттай хэрэгжсэн алхмууд ямар байх вэ? Түншлэгч байгууллагын гүйцэтгэлийг хэрхэн хэмжих вэ? Зорилгодоо амжилттай хүрсэн гэдэг нь юу вэ?	Эдгээр алхмуудыг гүйцэтгэхэд хэдэн өдөр/цаг шаардлагатай вэ? Үүнд түншлэгч байгууллага болон Кинг Консалтинг хамтын ажиллагааны цаг хугацаа болон зөвлөх үйлчилгээний дундуур түншлэгч байгууллага өөрсдөө гүйцэтгэж байгаа хугацааг хоёуланг нь оролцуулна.
Чиглэл 2				

Бизнесийн зөвлөх үйлчилгээний чиглэл 2				
Одоогийн байдал				
Эцсийн зорилго				
Түлхүүр алхмууд	Хүрэх үр дүн	Үүрэг	Зорилтот чиглэлд хүрэх явц	Хугацаа
Чиглэл 3				
Бизнесийн зөвлөх үйлчилгээний чиглэл 3				
Одоогийн байдал				
Эцсийн зорилго				
Түлхүүр алхмууд	Хүрэх үр дүн	Үүрэг	Зорилтот чиглэлд хүрэх явц	Хугацаа

Хавсралт 3: Зөвлөхийн хуудасны загвар

Зөвлөхийн хуудас				
Зөвлөхийн нэр болон хариуцсан чиглэл				
Байгууллагын нэр				
Оролцогчдын нэр				
Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн огноо (1-дэх эсвэл 2-дох)				
БЗТ-ийн чиглэл				
Одоогийн байдал				
Эцсийн зорилго				
Түлхүүр алхмууд	Үйл ажиллагаа	Ахиц дэвшил	Тайлбар	Хугацаа
Дүн шинжилгээ, Зөвлөхийн тайлбар, Зайнаас зөвлөх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө				

Амжилтын түүх

БЭЛЧЭЭРИЙН ДЭД БҮТЦИЙГ САЙЖРУУЛАХ ЖИЖИГ ТӨСЛҮҮД

Түншлэгчийн нэр: Зорилтот 8 сумын ЗДТГ

Төслийн байршил: Ховд, Увс, Баян-Өлгий, Хэнтий аймгийн 8 сум

Хугацаа: 2020 оны 4 сар-7 сар

Төслийн танилцуулга

“Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь – 3” (LTS3) төсөл нь гамшгийн эрсдэлийн бэлэн байдал болон бэлчээрийн менежментийг сайжруулах замаар малчин өрхүүдийн эмзэг байдлыг бууруулах зорилготой. LTS3 төсөл Ховд, Увс, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар зэрэг таван аймагт амжилттай хэрэгжиж дууссан. Эдгээр таван аймагт 10 сумыг сонгож, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө (БМТ)-нд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд нь зориулж техникийн туслалцаа үзүүлсэн.

2019 оны 11-р сараас эхлэн Мерси Кор сонгогдсон 10 сумын удирдлагатай хамтран сумын бэлчээрийн менежментийг сайжруулах тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон. Эдгээр чиглэлүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорлгоор Мерси Кор 2020 оны

2-р сарын 13-нд зорилтот 10 суманд жижиг дэд бүтцийг сайжруулах төсөл сонгон шалгаруулах нээлттэй уралдаан зарласан. Мерси Корын батлагдсан загварыг ашиглан зорилтот сумдууд төслийн санал хүргүүлсэн бөгөөд үүнд: ерөнхий мэдээлэл, төсөв, гүйцэтгэх ажлын техникийн үзүүлэлтүүд багтсан билээ.

Таван аймгийн 10 сумаас 10 төслийн санал хүлээж авсан. 3 төрлийн санал ирсэн: худаг сэргээн засварлах, булгийн эх хашиж хамгаалах, өвс тэжээлийн агуулах сэргээн засварлах. Зөвхөн батлагдсан загвараар боловсруулсан, цаг хугацаанд нь илгээсэн саналыг дараачийн сонгон шалгаруулалтанд оруулсан билээ.

Төсөл хэрэгжих үйл явц Нээлттэй сонгон шалгаруулалт

Бүх 10 төслийн саналыг хяналтын шат руу шилжүүлсэн. Төсөл бүр монгол хэл дээр бичигдэж, төслийн хураангуйг англи хэл рүү орчуулж, сонгон шалгаруулах хороонд танилцуулсан. Сонгон шалгаруулах баг дараах шалгуурын дагуу саналуудыг үнэлсэн:

- Мерси Корын тусламжтайгаар сумын ажилтнууд хэрэгжүүлэх боломжтой байх
- Орон нутгийн иргэдийн оролцоог хангасан байх
- LTS3 төслийн хугацаанд хэрэгжүүлж дуусгах боломжтой байх
- Төслийн зорилготой нийцсэн байх
- Хандивлагчийн дүрэм журамд нийцсэн байх – тухайлбал шинээр барилга барих биш, хуучин объектыг сэргээн засварлах гэх мэт

Сонгон шалгаруулах баг дээрх шалгуураар төслийн дараах хэсгүүдийг үнэлсэн:

- Тулгарч буй асуудлын танилцуулга: доройтож буй бэлчээрийн талбай (га), малын тоо толгой, хүн амын тодорхой мэдээлэл агуулсан ерөнхий мэдээлэл
- Санал болгож байгаа шийдэл, үйл ажиллагаа
- Хүлээгдэж буй үр дүн: хэдэн хүн, мал, бэлчээрийн талбай үр шимээ хүртэх
- Орон нутгаас оруулах хувь нэмэр, иргэдийн оролцоо
- Сэргээн засварлах ажлын техникийн үзүүлэлтүүд
- Төслийн нийт төсөв

Мерси Корын санхүү, захиргаа, хөтөлбөрийн баг, удирдах багийн гишүүдээс бүрдсэн сонгон шалгаруулах баг 2020 оны 4-р сарын 3-нд уулзаж, төслийн саналуудыг хэлэлцсэн. Уулзалтанд 8 хүн оролцсон бөгөөд сонгон шалгаруулах багийн 5 гишүүн санал өгөх эрхтэй, 3 ажилтан техникийн тайлбар, тодруулга өгөх үүрэгтэй оролцсон. 8 төслийн санал шууд шалгарсан. Төслийн 2 саналд нэмэлт тодруулга авах шаардлагатай гэж үзсэн. Сумдаас нэмэлт мэдээлэл авсны дараа дээрх хоёр төсөл 4-р сарын 14-нд амжилттай шалгарсан.

Үйл ажиллагаа

LTS3 төслийн хандивлагчийн дүрэм журмын дагуу төрийн аль нэгэн байгууллага руу мөнгө шилжүүлэхийг хориглодог. Үүний оронд Мерси Кор үйлчилгээ үзүүлэх техникийн чадвартай, мэргэжлийн аж ахуй нэгж (ААН)-ийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулсан. Сонгогдсон ААН нь сумын удирдлага, иргэдтэй хамтран ажиллах шаардлагатай байдаг, учир нь сумын түншүүд ажиллах хүчин, тээвэрлэлт зэргийг хариуцдаг.

Худалдан авалтын ажиллагаа эхлэхээс өмнө Мерси Кор сумын захиргаанаас дэд бүтцийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг аймгаас авч өгөхийг хүссэн. Ялангуяа худаг сэргээн засварлах нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд амаргүй байдаг учир сумдаас дараах зүйлсийг хүссэн:

- Худаг өмчилж байгаа эсэхээ батлах, худагтай холбоотой ямар нэг зөрчил, маргаан байхгүй гэдгээ мэдэгдэх;
- Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд худаг засварлах ажил тусгагдаж, түүнийг малчид зөвшөөрсөн байхыг батлах;
- Усны төлбөрөө төлөх журам боловсруулж, зардлаа төлөвлөсөн байх;
- Сэргээн засварласан худгийг арчлан, засвар үйлчилгээ хийх төлөвлөгөө гаргаж, сумын малчидтай хамтран ажиллах гэрээ байгуулах;

Шаардлагатай баримт бичгээ хүлээж авсны дараа Мерси Кор нь булгийн эх хаших, өвс тэжээлийн байрыг засварлах барилгын материал худалдаж авах ажлаа эхлүүлж, худаг засварлах гүйцэтгэгчээ сонгохоо зарласан. Харамсалтай нь Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Эрдэнэцагаан суманд худаг сэргээн засварлах төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон нь тодорхой болсон. Санал болгосон үйл ажиллагааны төсөв нь сумдаас гаргасан тооцооноос 2-4 дахин их байсан. Үүний нэг шалтгаан нь сумын өгсөн тооцоонд худаг засварлахад шаардлагатай нарийн тоног төхөөрөмжийн зардал ороогүй байсан. Мөн худаг маш их элэгдсэн байсан тул аль ч компанид үүнийг гар аргаар ухаж, эрсдэлд орох хүсэл байгаагүй. Үүнтэй адил Мерси Кор ч ийм аюултай төслийг дэмжээгүй. Түүнчлэн, мэргэжлийн тоног төхөөрөмж, техникийн туршлагатай байсан ч усны чанарт баталгаа байхгүй гэдгийг гүйцэтгэгч компаниуд илэрхийлж байв.

Ийнхүү үлдсэн найман төсөл цаашид хэрэгжих болсон.

Төслүүдээ сонгон шалгаруулсны дараа Мерси Кор зорилтот сумдын засаг дарга болон малчдын бүлгүүдтэй Хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав. Санамж бичигт холбогдох талуудын үүрэг хариуцлага, оруулах санхүүгийн хувь нэмрийг тусгажээ. Төсөл эхлэх үед сонгогдсон гүйцэтгэгч компани нь сумын захиргаа, малчдын бүлэгтэй хамтран ажиллахаас жаахан эргэлзэж байсан боловч Мерси Корын ажилтнууд хоёр талын харилцааг гайхамшигтай зохицуулж, Санамж бичигт оролцогч талуудын үүрэг хариуцлагыг маш тодорхой оруулж, өгч, талуудад сайн таниулж чадсан. Энэ нь төслүүдээ ил тод, ямар нэгэн саадгүй хэрэгжүүлэхэд нэмэр болсон.

Бүх төслүүд 2020 оны 7-р сард хэрэгжиж дууссан. Нийт дөрвөн булгийн эхийг хашиж, нэг өвс тэжээлийн агуулахыг өргөтгөж, таван худаг бүрэн сэргээн засварласан. Мэргэжлийн хяналтын алба бүх худгийн усны чанарыг шалгаж, ундны усанд хэрэглэх боломжтойг тодорхойлсоны дараа сумын захиргаанд хүлээлгэн өгсөн. Монгол Улсын хуулийн дагуу хашаа, өвс тэжээлийн агуулах гардуулах ёслолд ийм үйл явц шаардагдахгүй.

Арга зүй

Хонин толгой

- 1 тэмээ = 5 хонин толгой 1 морь = 7 хонин толгой
- 1 үхэр = 6 хонин толгой
- 1 ямаа = 0.9 хонин толгой

Жишээ: Малчин 10 үхэр, 5 морь, 20 ямаа, 30 хоньтой. Дээрх аргачлалаар малыг хонин толгойд шилжүүлбэл малчин 143 хонин толгойтой гэсэн үг юм.

Бэлчээр хамгаалах арга зүй

Худаг сэргээн засварласан Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын жишээ. Энэ сум тал хээрийн бүсд оршдог. Сэргээгдсэн худаг нь эргэн тойрон 5.2 км радиустай бэлчээрийн ашиглалтыг сайжруулсан гэж үздэг. Сайжруулсан бэлчээр нь 8328 га талбай эзэлж байгаа.

Үр нөлөө

Бэлчээрийн дэд бүтцийг сайжруулах төслүүд зорилтот дөрвөн аймгийн 8 суманд амжилттай хэрэгжиж дууссан. Таван худаг сэргээн засварлагдаж, дөрвөн булгийн эхийг хашиж хамгаалж, өвсний нэг агуулахыг өргөтгөсөн. Мерси Кор нийт санхүүжилтийн 78%-ийг (68.9 сая төгрөг) гаргасан бол үлдсэн 22%-ийг (19.8 сая төгрөг) сум, малчид өөрсдөөсөө санхүүжүүлсэн. Түүнчлэн нийт 8 төсөл дээр 47 малчин ойролцоогоор 20 өдөр ажилласан. Төслүүд дараах үр дүнд хүрсэн бөгөөд монголын бэлчээрийн менежментийг сайжруулахад чухал хувь нэмрээ оруулсан. Үүнд:

- **Малчин өрх:** 348 өрхийн 980 малчин уг төслөөс шууд үр шим хүртсэн
- **Бэлчээр:** 85970 га бэлчээрийн ашиглалтыг сайжруулж, ижил хэмжээний талбайтай бэлчээрийн ачаалал буурсан.
- **Мал:** ус тэжээлийн хангамж сайжирсаны улмаас хонин толгойд шилжүүлсэн 157 964 толгой мал үр шим хүртсэн.

Төсөлд идэвхтэй оролцсон сумын засаг дарга, малчид Мерси Кор, USAID/OFDA-гийн тусламжгүйгээр эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх ямар ч боломжгүй байсан гэдгээ илэрхийлсэн. Зарим суманд дэд бүтцийн төслийн хаалтыг орон нутгийн ТВ-ээр дамжуулсан. Тухайлбал, Баян-Өлгий аймагт нэг малчин тэдний сумын худаг нь хуучирсан тул хэн ч түүнийг засах сонирхолгүй байсан гэж телевизэд ярьсан.

Азаар Мерси Кор, USAID/OFDA тусламжийн гараа сунгасан тул тэд одоо усны найдвартай эх үүсвэртэй болж, нутагтаа малаа бэлчээх боломжтой болсон гээд талархлаа илэрхийлсэн.

Сумын засаг дарга, орлогч дарга нар Мерси Корт баярласнаа илэрхийлж, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд орсон уг ажлуудыг гүйцэтгэх хөрөнгө нөөцгүй байсан гэдгээ хэлж байсан.

Худаг маань засварлагдаж устай болсондоо маш их баярлаж байна. Казахууд “усгүй байх хамгийн муу зовлон” гэж ярьдаг. Энд 30 гаруй малчин байдаг. Мөн энэ нутаг буянт сумтай хил залгаа учраас буянт сумын малчид бас ашиг хүртэх боломжтой. Бид голын уснаас 8-9 км хол байдаг. Биднийг цэвэр усар хангаж өгсөн мерси кор болон худаг засварласан нармаржан компанид малчдынхаа өмнөөс хамгийн сайн сайхан бүхнийг хүсье

- Баян-өлгий аймаг, алтай сумын малчин с.Айтуган

Дараах хүснэгтэд жижиг дэд бүтэц сайжруулах төслүүдийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

“Төслийн өмнөх ба дараах” фото зургууд



Зураг 2. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, – худгийн өмнөх байдал



Зураг 3. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, – Төсөл хэрэгжсэний дараах худаг



Зураг 4. Ховд аймгийн Ховд сум- худгийн өмнөх байдал



Зураг 5. Ховд аймгийн Ховд сум- төсөл хэрэгжсэний дараах худаг

Хүснэгт 4: Худаг сэргээн засварлалт

Сум / Аймаг	Үр дүн	Мерси Корын зардал хуваалт	Сумын зардал хуваалт	Үр нөлөө
Увс аймаг, Наранбулаг сум	<p>Ерөнхий мэдээлэл: “Тариаланчдын худаг” хэмээх уг худаг нь 60 метрийн гүнтэй, Гүнбүрд багт байрладаг. Худгийг социализмын үед нэгдлийн талбайд барьсан. Одоо тариалангийн талбайг сум эзэмшдэг. Сэргээн засварлахаас өмнө цохилгаан үүсгүүр, насос, цэвэр усны хоолой, үндсэн хоолой, худгийн байшин, мал услах онгоц нь бүгд эвдэрсэн байсан. Дээр нь худгийн хоолой шавраар бөглөрсөн байсан.</p> <p>Засварын ажил: Засварлах үйлчилгээ үзүүлдэг компани хоолойн бөглөрлийг арилгаж, шинэ насос залгаж, цохилгаан үүсгүүр ажиллуулсан. Сумын удирдлага, малчид худгийн барилга, мал услах онгоцыг засахад тусалсан.</p> <p>Бэрхшээл: Худгийн хоолой бөглөрснөөс болж ус урсаж байгаа эсэх нь харагдахгүй байсан учир уг худагаас ус гарах нь анх эргэлзээтэй байсан. Шавар, хог хаягдлыг цэвэрлээд хоёр хоногийн дараа ус урсаж эхэлсэн.</p> <p>Техникийн үзүүлэлтүүд: худаг нь 1 л/сек хүчин чадалтай, 19 м статистик түвшин, 25 м динамик түвшин засварлагдаж, цохилгаан худаг болгон засаж, суманд хүлээлгэж өгсөн</p>	<p>10 029 816 төгрөг Гүйцэтгэгч компани, QJ1.5 KB насос, 6.5KB цохилгаан үүсгүүр</p>	<p>4 080 000 төгрөг Худгийн байшинг засварлах барилгын материалы, тээврийн зардал, ажиллах хүч</p>	<p>16 886 га бэлчээрийн ашиглалт сайжирч, доройтол нь багассан 55 малчин өрхийн 171 малчин, 13750 гаруй хонин толгой мал цэвэр усны хангамжтай болсон.</p>
Увс аймгийн, Давст сум	<p>Ерөнхий мэдээлэл: Давст сумын Хандгайт багт байрладаг, Хар дэл нэртэй 50 метр гүн худаг. Худаг 2013 онд баригдсан. Сэргээн засварлахаас өмнө мотор, насос, худгийн барилга эвдэрч, хэмхэрсэн байсан.</p> <p>Засварын ажил: Худгийн хоолойг цэвэрлэж, засаж, нарны эрчим хүчээр ажилладаг ухаалаг систем бүхий хувиргагчтай хяналтын самбар, нарны хавтан худалдаж авсан ба энэ нь усны урсгалыг хянаж, насосыг ажиллуулна.</p> <p>Бэрхшээл: Ажлын үед худаг 50 метр гүнтэй гэж засварын компани тодорхойлсон. Төслийн санал дээр 70 метрийн гүнтэй гэж бичиж байсан. Тиймээс мэргэжлийн компаниар судалгаа хийлгэж засварлуулах нь ямар чухал болохыг харуулав.</p> <p>Техникийн үзүүлэлтүүд: 50м гүнтэй, шахах хүчин чадал 0.18 л/сек, нарны эрчим хүчээр ажилладаг бүрэн автомат худаг суманд хүлээлгэн өгсөн.</p>	<p>10 205 000 төгрөг Шинээр нарны хавтан, цохилгаан хувиргагч, нарны эрчим хүчээр ажилладаг насос, мотор суурилуулах</p>	<p>2 100 000 төгрөг Хашаа босгох, тээврийн зардал, ажиллах хүч</p>	<p>16 800 га бэлчээрийн ашиглалт сайжирч, доройтол нь багассан. 18 малчин өрхийн 65 малчин, 12 мянган хонин толгой мал цэвэр усны эх үүсвэртэй болсон.</p>

<p>Ховд аймаг, Ховд сум</p>	<p>Ерөнхий мэдээлэл: Намарзон багт байрладаг Шар харгана нэртэй худаг. Хүдгийн социализмын үед барьсан бөгөөд 2004 онд 95 метр хүртэл гүнзгийрүүлсэн. Засварлахаас өмнө генератор, насос, хүдгийн байшин эвдэрч, хэмхэрсэн байсан. Засварын ажил: Хүдгийн компани цооногийг цэвэрлэж, шинэ насос, цахилгаан үүсгүүр суурилуулсан. Сум хүдгийн байшин, мал услах онгоцыг засаж янзлав. Техникийн үзүүлэлтүүд: 110м гүнтэй, 1.1 л/сек гаргах хүчин чадалтай, 25 м статистикийн түвшин, 85м динамик түвшин засагдсан.</p>	<p>10 325 208 төгрөг Гүйцэтгэгч компани, насос, цахилгаан үүсгүүр</p>	<p>1 705 000 төгрөг Тээврийн кардал, хөдөлмөрийн хөлс, худаг засварлах материал</p>	<p>8 382 га бэлчээрийн ашиглалт сайжирч, доройтол нь багассан. 15 малчин өрхийн 60 малчин, 14900 хонин толгой мал ундны усны эх үүсвэртэй болсон.</p>
<p>Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум</p>	<p>Ерөнхий мэдээлэл: Ховд сумын төвөөс 25 км зайд Баянбулаг багт байрладаг Улааны ар нэртэй худаг. Социализмын үед барьсан. Хүдгийн насосыг 2018 онд засварласан боловч насос 110 метрийн гүнээс ус шахах боломжгүй тул дахин эвдэрсэн. Засварын ажил: Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд хүдгийн гүйцэтгэгч цооногийг цэвэрлэж, хүдгийн гүнд тохирсон шинэ насос, шинэ цахилгаан үүсгүүр суурилуулсан. Хүдгийн байшинг сумын захиргаа, иргэд засварласан. Техникийн үзүүлэлтүүд: 95 м гүн, 2.6 л/сек гаргах хүчин чадалтай, 70м статистик түвшин, 25м динамик түвшинг нөхөн сэргээв.</p>	<p>10 333 566 төгрөг Гүйцэтгэгч компани, насос, цахилгаан үүсгүүр</p>	<p>3 080 000 төгрөг Тээврийн зардал, ажиллах хүч, хүдгийн байшин барих материал</p>	<p>8 380 га бэлчээрийн ашиглалт сайжирч, ачасалал нь багассан. 21 малчин өрхийн 15660 хонин толгой мал ундны устай болсон.</p>
<p>Баян-Өлгий аймаг, Алтай сум</p>	<p>Ерөнхий мэдээлэл: Энэ худаг нь Түнхээт нэртэй, Харнуур багт байрладаг. 1988 онд социализмын үед баригдсан, 30 метрийн гүнтэй. Генератор, насос, хүдгийн барилга нь эвдэрсэн байсан. Засварын ажил: хүдгийн цооногийг цэвэрлэж, шинэ насос, генератор, усны хоолой суурилуулсан. Техникийн үзүүлэлтүүд: 159 мм насос, QJ-0.5-50 загвар насос, LEROBS- 3500 загвар генератор</p>	<p>9 126 000 төгрөг Гүйцэтгэгч компани, насос, генератор</p>	<p>1 300 000 төгрөг Хүдгийн барилгын материал, ажиллах хүч</p>	<p>Хүдгийн усны урсац сайжирч, 5451 га бэлчээрийн ашиглалт сайжирч, ачасалал нь багассан. 8 малчин өрхийн 50 малчин, 1200 хонин толгой мал ундны устай болсон.</p>

<p>Хэнтий аймгийн Баянмөнх сум</p>	<p>Ерөнхий мэдээлэл: Хэнтий аймгийн Баянмөнх сум хоёр булгийн эх хаших хүсэлт тавьсан. Ус урсахад малын хөдөлгөөн саад болж, усны чанар нь малын баас, хөрсний элэгдлээс болж муудсан байсан. Засварын ажил: Хоёр булгийн эхийг төмөр хашаагаар хашсан. Ингэснээр усны чанар нь сайжирч, ус хурдан урсах боломжтой болж, бод мал ус урсахад саад болохоо больсон тул усны урсгал нэмэгдсэн. Техникийн үзүүлэлтүүд: Төмөр хашааг Мерси Корын “Даван туулах, дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрийн түнш байгууллагаас худалдан авсан. Хашааг малчны хоёр бүлэг компанийн тусламжтайгаар угсарсан. Засварын компани сандал, хогийн сав сайн дураараа бэлэглэсэн өгсөн.</p>	<p>4 680 000 төгрөг Төмөр хашаа, цемент худалдан авах</p>	<p>1 970 880 төгрөг Хашаа угсрах, ажилчдын хоолны зардал, хашааны материал тээвэрлэх зардал</p>	<p>14000 га бэлчээрийн ашиглалтыг сайжруулах замаар доройтлоос хамгаалсан. 19 малчин өрхийн 72 малчин, 24000 хонин толгой мал ундны устай болсон.</p>
<p>Хэнтий аймгийн Дархан сум</p>	<p>Ерөнхий мэдээлэл: Найдвартай цэвэр усны эх үүсвэртэй байхын тулд булгийн эхийг хашиж хамгаалдаг. Сумын захиргаа модон хашаа илүү удаан эдэлгээтэй, байгаль орчинд хор нөлөөгүй, олноо ихтэй, боловсруулахад амар хамгийн боломжийн материал гэж үзсэн тул модоор хашаа барихаар шийдсэн. Засварын ажил: Булаг бүрийг 160 м модон хашаагаар хашсан. Хөрс нь чулуулаг байсан учир хоёр талдаа тулгууртай хашаа барьсан. Тулгуурыг хадсаа шуруп хэрэглээгүй угсарсан. Бэрхшээл: хашааны мод нийлүүлэх үед бага эргийн бэрхшээл учирсан. Хашааны мод нийлүүлэх гэрээ байгуулсан компани ажлаа гүйцэтгэж чадаагүй учир өөр компанитай тохирч мод нийлүүлж, илүү гарсан тээврийн зардал, хашааны 3 нэмэлт хэсгийн төлбөрийн төлсөн.</p>	<p>8 030 000 төгрөг Хашааны материал худалдаж авсан</p>	<p>2 570 160 төгрөг Хашааг угсрах ажиллах хүч</p>	<p>7600 га бэлчээрийн ашиглалтыг сайжруулах замаар доройтлоос хамгаалсан. 25 малчин өрхийн 125 малчин, 14650 хонин толгой мал ундны устай болсон.</p>
<p>Баян-Өлгий аймгийн Толбо сум</p>	<p>Ерөнхий мэдээлэл: Толбо суманд өвс тэжээлийн агуулах зассан. Агуулахад хадгалж буй өвсөөр өвлийн улиралд онцгой үед мал тэжээдэг. Өмнө нь зөвхөн 40 тонн өвс тэжээл хадгалах хүчин чадалтай байсан. Засварын ажил: Төслийн хүрээнд уг агуулахыг өргөтгөж (16 м урт х 6 м өргөн талбайгаар), дээврийг нь зассан. Өргөтгөсний улмаас агуулахын хүчин чадал нь 40 тонноор нэмэгдэж, нийт 80 тонн өвс тэжээл хадгалах хүчин чадалтай болсон. Дүрэм журам: малчин фермерүүдэд зориулж агуулах ашиглах журмыг боловсруулах шийдвэр сумын захиргаа гаргасан. Энэхүү журамд агуулах ашигласны үнэ төлбөр, агуулах орлогыг засвар үйлчилгээ хийх төлөвлөгөө, агуулахын түрээсийн орлогыг хэрхэн ашиглах төлөвлөгөө зэрэг зүйлүүд орно. Сумын ИТХ агуулах түрээслэхийг албан ёсоор зөвшөөрөх ёстой. Мөн ИТХ нь агуулахын засвар үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулна.</p>	<p>6 174 727 төгрөг Өргөтгөл барих материал худалдаж авсан</p>	<p>3 000 000 төгрөг Өргөтгөл дээр ажиллах ажилчдын зардал</p>	<p>Өргөтгөсөн агуулах нь жил бүр 80 тонн өвс тэжээл хадгалах хүчин чадалтай бөгөөд өвлийг давах малчдын чадварыг бэхжүүлнэ. Үр дүнд нь 187 малчин өрх онцгой байдлын үед өвс тэжээл авах боломжтой болсон.</p>

сумдын эрсдэлийн үнэлгээ хийх, үнэлгээн дээр үндэслэн сумын ГХТ-г сайжруулах ажилд туслалцаа үзүүлсэн.

“Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” сургалт

2020 оны 6, 8-р сард Мерси Кор аймгийн ОБГ-тай хамтран зорилтот таван аймгийн арван суманд хоёр өдрийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө сайжруулах” сургалтыг амжилттай зохион байгууллаа. Аймгуудын ОБГ болон Мерси Корын туршлагатай 16 багш сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар “Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь – 3” (LTS2) төслийн хүрээнд LEGS буюу “Онцгой байдлын үед мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар стандарт”-ын аргачлалыг ашиглан зудаас бусад төрлийн аюулт үзэгдлээс хамгаалах төлөвлөгөөг шинэчлэхийг зорьсон. Урьд нь сумын захиргаа болон аймгийн ОБГ-ууд LEGS аргачлалыг сурч, сургагч багш болж байсан учир энэхүү сургалтанд LEGS-ийн арга зүйг ашиглахаар болсон. Монголд мал аж ахуйн салбарт олон хүн ажилладаг тул LEGS нь Монголын нөхцөл байдалд тохирсон аргачлал юм.

Сургалтын үеэр сургагч багш нар Онцгой комиссын гишүүдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, гамшгийн төлөвлөгөөг боловсруулахыг зааж өгч, гамшгийн менежменттэй холбоотой Монгол Улсын хууль, баримталж буй бодлогын талаарх мэдээллээр хангасан. Сургалт дараах сэдвийн хүрээнд явагдсан:

1. Гамшгаас хамгаалах хууль
2. Аймгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүн
3. Сумын гамшгийн эрсдэлийг үнэлэх аргачлал
4. ГХТ-ний хөгжлийн стратеги
5. Сумын түвшний гамшгийн эрсдэлийн үнэлгээний ерөнхий аргачлал
6. Эрсдэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлаж сумын ГХТ-г шинэчлэх

Мерси Кор анх сум бүрээс 10 хүн, нийт 100 хүнийг сургах төлөвлөгөөтэй байсан. Харин сумдын ЗДТГ уг сургалтыг олон хүн сургах сайхан боломж гэж үзэж, Онцгой комиссын гишүүдийн тоог нэмэхийг хүссэн. Иймд оролцогчдын тоо төлөвлөж байснаас илүү их гарсан. Нийт 146 (74 эрэгтэй, 72 эмэгтэй) гишүүн сургалтанд ороцсон бөгөөд үүнд сумын засаг дарга, төрийн албан хаагчид, малын эмч, байгаль орчны байцаагч, сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, багийн дарга, багш, цагдаагийн ажилтан, төрийн сангийн ажилтан, хүний эмч нар багтсан.

Оролцогчид бүлэг болж хуваагдан, дараах даалгаврыг гүйцэтгэсэн:

- 1) Олон нийтийн оролцоотой хариу арга хэмжээг тодорхойлох матрицын аргыг ашиглан сумынхаа гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн;
- 2) LEGS аргачлалыг ашиглаж, ОБЕГ-ын баталсан заавар, загвар дээр тулгуурлаж хамгийн өндөр эрсдэлтэй 2-3 аюулт үзэгдэлээс хамгаалах төлөвлөгөө шинэчилсэн.



Амжилтын түүх

“ГАМШГААС ХАМГААЛАХ СУМЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ САЙЖРУУЛАХ” СУРГАЛТ

Түншлэгчийн нэр: Зорилтот аймаг сумдын ОБГ, ЗДТГ, онцгой комиссын гишүүд

Төслийн байршил: Ховд, Увс, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар аймгийн 10 сум

Хугацаа: 2020 оны 6 сар- 8 сар

Төслийн танилцуулга

Сумын Онцгой комиссын гишүүд Гамшгаас хамгаалах төлөвлөгөө (ГХТ)-г боловсруулах, хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. ГХТ-г тодорхой арга зүй ашиглан Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) болон Шадар сайдын баталсан нэгдсэн загвар зааварын (анх Мерси Корын боловсруулсан) дагуу боловсруулсан байх ёстой. Орон нутгийн Онцгой комиссын гишүүдийн ур чадвар, мэдлэг нь янз бүр байдаг нь ГХТ-ний чанарт нөлөөлдөг. Тиймээс уг төлөвлөгөөг тогтмол сайжруулан, шинэчилж, арга зүйн дагуу боловсруулах, гамшгийн эрсдэл өөрчлөгдөхөд дагаж өөрчдөгддөг байх шаардлагатай.

Иймд орон нутгийн оролцоог хангах зорилгоор Мерси Кор нь аймгийн Онцгой байдлын газар (ОБГ)-тай хамтран сумдын Онцгой комиссын гишүүдэд дэмлэг үзүүлж,


Сургалтын төгсгөлд ОБГ болон Мерси Кор сумын ГХТ-г хянаж, саналаа өгсөн. Онцгой комиссын гишүүд ГХТ-г эцэслэн баталж, сумын засаг дарга, дараа нь ОБГ-т хүргүүлнэ.



Зураг 6. Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд эрсдэлийн үнэлгээ хийж байна



Зураг 6. Хэнтий аймгийн Дархан суманд LEGS аргачлалыг танилцуулж байна



Зураг 7. Ховд аймгийн, Эрдэнэбүрэн сумын эрсдэлийн матрикс



Зураг 8. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын ГХТ



Зураг 9. Баян-Өлгий аймгийн Толбо суманд сургалтыг танилцуулж байна



Зураг 10. Увс аймгийн Наранбулаг сумын ГХТ

Эрсдэлийн үнэлгээ

Дараах хүснэгтэд хамгийн өндөр эрсдэлтэй аюулт үзэгдлийг тогтоосон эрсдэлийн ерөнхий үнэлгээний үр дүнг танилцуулж байна. Үнэлгээнд оролцогчид ОБЕГ-аас баталсан хоёр төрлийн аргачлалыг агшигласан: индикаторыг хянах аргачлал (эрсдэл тус бүрийн магадлалыг харгалзан үзэх) болон олон нийтэд суурилсан гамшгийн эрсдэлийг үнэлэх аргачлал.

Хүснэгт 5: Гамшигийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө

	Сум	Оролцогчид		Хамгийн өндөр эрсдэлүүд / эрсдэлийн сөрөг нөлөө	Тодорхойлсон эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөгөө
		Эр	Эм		
1	Наранбулаг	6	4	Үер: өндөр эрсдэлтэй Ахуйн гал түймэр: дунд эрсдэлтэй	- Үерийн далан барих - Гал унтраагчийг олон нийтийн газар/төрийн байгууллагуудад байрлуулах
2	Давст	5	4	Үер: өндөр эрсдэлтэй Ахуйн гал түймэр: дунд эрсдэлтэй	- Үерийн далан барих - Гал унтраагчийг олон нийтийн газар/төрийн байгууллагуудад байрлуулах
3	Алтай	8	2	Үер: өндөр эрсдэлтэй Малын халдварт өвчин: өндөр эрсдэлтэй	- Үерийн далан барих эсвэл засварлах - Хүмүүсийг сэрэмжлүүлэх/ дохио өгөх

4	Толбо	8	2	Үер: өндөр эрсдэлтэй Малын халдварт өвчин: өндөр эрсдэлтэй	- Үерийн далан барих эсвэл засварлах - Хүмүүсийг сэрэмжлүүлэх/ дохио өгөх
5	Эрдэнэбүрэн	10	7	Үер: өндөр эрсдэлтэй Малын халдварт өвчин: өндөр эрсдэлтэй	- Хонгио баг дахь Улаан үзүүр гүүрийг засварлах - Шураг багийн мал угаах ванныг засах - Малын баас цэвэрлэх, мал шүршиж ариутгах усны насос, автомакс худалдаж авах
6	Ховд	4	7	Салхи шуурга: дунд эрсдэлтэй Малын халдварт өвчин: дунд эрсдэлтэй	- Шураг багийн мал угаах ванныг засах - Малын баас цэвэрлэх, мал шүршиж ариутгах усны насос, автомакс худалдаж авах
7	Баянмөнх	4	6	Үер: өндөр эрсдэлтэй Хээрийн гал түймэр: өндөр эрсдэлтэй	- Гүнзгий устай, живж осолддог голын хажууд анхааруулах тэмдэг байрлуулах - Гамшгаас хамгаалах сайн дурын бүлгийн гишүүд морьт эргүүл ажиллуулах, эргүүл хийх хуваарь гаргана
8	Дархан	9	3	Малын халдварт өвчин: өндөр эрсдэлтэй Үер: өндөр эрсдэлтэй	- Халдвараас хамгаалах хувцас, автомакс, усны насос шаардлагатай - Хүмүүсийн тамхи, шүдэнзнээс гал гарах эрсдэл өндөр тул замын хажууд анхааруулах самбар байрлуулах
9	Эрдэнэцагаан	12	22	Малын халдварт өвчин: дунд эрсдэлтэй Үер: өндөр эрсдэлтэй	- “Чоно гол” гарцыг сайжруулах, барих шаардлагатай - Гамшгаас (үер, хээрийн гал түймэр) сэрэмжлүүлэх самбар (2x3 хэмжээтэй) сумдад байрлуулах - Мал, амьтны гоц халдварт өвчний үед ариутгалын автомакс, мал угаах насос шаардлагатай.
10	Баяндэлгэр	8	15	Малын халдварт өвчин: 71% 2010, 2014, 2016 онд шүлхий, 2015 онд хонины цэцэг өвчин гарч, 200-300 сая төгрөгийн эдийн засгийн хохирол учирсан.	- Малын гоц халдварт өвчний үед ариутгалын автомакс, мал угаах насос шаардлагатай - Үер, хээрийн гал түймрээс сэрэмжлүүлэх 2x3 хэмжээтэй самбар байрлуулах - Тал хээр, ахуйн гал түймрээс хамгаалах 25 гал унтраагч, 50 гар үлээгч шаардлагатай.
Нийт		74	72		

Сургалтын үр дүнд сумын онцгой комиссийн гишүүд LEGS аргачлалыг ашиглан сумынхаа гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө шинэчилсэн. Мөн ГХТ-ний эрсдлийг бууруулах хэсэг нь улам тодорхой болж, гамшгийн үед сумаас хэрэгжүүлэх системтэй ажлын төлөвлөгөө болж хувирсан.



Амжилтын түүх

“БЭЛЭН БАЙ” СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ СУРГАЛТ

Түншлэгчийн нэр: Зорилтот аймаг сумдын ОБГ, ЗДТГ,

Төслийн байршил: Ховд, Увс, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар аймгийн 10 сум

Хугацаа: 2020 оны 6 сар- 8 сар

“Бэлэн бай” сургалтын модуль

“Бэлэн бай” сургалтын модуль нь Дэлхийн Зөн, Улаан Загалмай, Ус цаг уур орчны шинжилгээний газар, Жайка, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Багш нарын мэргэжлийн хөгжлийн институт гэх зэрэг зарим төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран Онцгой Байдлын Ерөнхий Газрын (ОБЕГ) боловсруулсан сургалтын хөтөлбөр юм. Энэхүү модуль нь ОБЕГ-ын гамшгаас хамгаалах иж бүрэн стратегийн талаар иргэд, олон нийтэд мэдлэг олгох зорилготой юм.

ОБЕГ-ын даргын 2016 оны А130-р тушаалын дагуу боловсруулсан уг 10 цагийн сургалтын хөтөлбөр нь сургагч багшийн гарын авлага, сургалтын багц, дохионы хэлтэй видео хичээл, танилцуулга хичээл, мэдлэг сорих тестийг агуулсан.

Сургагч багш бэлтгэх сургалт

“Бэлэн бай” модулийг ашиглан Мерси Кор 5 аймгийн Онцгой Байдлын газар (ОБГ)-тай хамтран 2020 оны 6 болон 8-р сард “Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь – 3” (LTS3) төслийн зорилтот таван аймгийн арван суманд сургагч багш бэлтгэх Гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтыг зохион байгуулсан. Нийт 121 төрийн албан хаагч (71 эрэгтэй, 50 эмэгтэй) уг сургалтад хамрагдаж, орон нутгийн “Сургагч багш” гэрчилгээ авсан.

Сургалтаар сумын төрийн албан хаагчид мэргэшсэн сургагч багш болж, малчин өрх, сургууль, төрийн байгууллага, орон нутгийн иргэдэд “Бэлэн бай” сургалтыг зохион байгуулах чадвартай болж сумдын гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бүх түвшинд бэхжүүлэх юм.

Сургалтын хөтөлбөрийн дагуу газар хөдлөлт, гал түймэр, уур амьсгалын өөрчлөлт, ой хээрийн түймэр, хүн, малын гоц халдварт өвчин, үер, аянга, салхи шуурга, ахуйн хэрэглээний бодисын зохистой хэрэглээ, өрхийн бэлэн байдлын төлөвлөгөө сэдвээр хичээлүүд орсон.

“Бэлэн бай” модуль нь өрхийн хэмжээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулт үзэгдлийн эсрэг хариу арга хэмжээ авах иргэдийн чадварыг дээшлүүлэх зорилготой гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг өрхийн түвшинд боловсруулах дээр анхаарлаа хандуулсан. Ингэснээр сургагч багш нар өрхийн эрсдэлийг үнэлэх, иргэдтэй хамтран эрсдэлийг бууруулах, хамгаалахыг төлөвлөх чадвартай болсон. Оролцогчид иргэдэд зориулж сургалт явуулахад шаардлагатай интерактив програм суулгасан flash бүхий “Бэлэн бай” сургалтын багц, багшийн гарын авлага гардан авлаа.

Сургалтын төгсгөлд сургагч багш нар нэг сэдэв сонгон авч сургалтын хэрэглэгдхүүн ашиглан сургалт явуулах дадлага хийсэнээрээ онцлог боллоо. 121 оролцогч, 29 ОБГ-ын ажилтнууд (нийт 150 хүн) сургагч багшийн гэрчилгээ гардан авсан. Улмаар уг сургалтыг орон нутгийн иргэд, малчдад үр дүнтэй зохион байгуулахын тулд сумдын засаг дарга нартай хамтран олон нийтэд сургалт хийх багуудыг байгуулсан. Сургалтын багууд сумаар аялж малчид, иргэдийн дунд сургалтаа хүргэсэн.



Зураг 11. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, “Бэлэн бай” сургалт



Зураг 12. Увс аймгийн Наранбулаг сум, “Бэлэн бай” сургалт



Зураг 13. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, “Бэлэн бай” сургалт



Зураг 14. Увс аймгийн Давст сум, “Бэлэн бай” сургалт



Зураг 15. Баян-Өлгий аймгийн Толбо сум, мессеж системийн туршилт, “Бэлэн бай” сургалт



Зураг 16. Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум, “Бэлэн бай” сургалт

Олон нийтэд зориулсан “Бэлэн бай” сургалт

Мэргэшсэн 150 сургагч багш 7-р сарын 5-наас 9-р сарын 20-ны хооронд хөдөө орон нутгаар аялж, малчид, ахлах ангийн сурагчид, сумын бусад иргэдийн дунд сургалт зохион байгуулсан. Сургалтанд 10-н сумын 52 багийн 3,849 (1,979 өрх) иргэд хамрагдсан. Олон нийтэд зориулсан сургалт нь ерөнхий боловсролын сургууль дотор, малчин айлд гэх мэт илүү албан бус орчинд явагдсан учир сургагч багш бэлтгэх сургалтаас ялгаатай байсан. Амьдарч буй газрын онцлог, тухайн өрхөд тохиолдож болзошгүй эрсдэл зэргээс хамааран, иргэдийн мэдээлэл дээр үндэслэн сургагч багш нар заах хичээлийн сэдэв, зөвлөмжийг өөрсдөө сонгосон.

Зуд, үер, гал түймэр, ой хээрийн түймэр, химийн бодисын зохистой хэрэглээ зэрэг сэдвээр голлон сургалт хийсэн. Сэдвээ сонгосны дараа сургагч багш нар гэр ахуйд учирч болзошгүй аюулт үзэгдлийн талаар мэдээлэл өгсөн. Эдгээр аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх нь амархан боловч нэгэнт тохиолдсон бол гэр бүлийг сүйрэлд хүргэдэг. Үүнд: пийшин зуухны ойр орчимд гал гарах, яндангийн залгаа буруу залгагдсан, цогтой үнс нурамыг хийх зориулалтын савгүй эсвэл сав нь таггүй байх, үерийн амны ойр буусан, голын гүүр, зам нь үерт эвтэрсэн, хадлан авах хугацаа оройтож өвөлжилтийн бэлтгэлээ цаг тухайд нь хангаж амжихгүй зэрэг аюулт үзэгдлүүд багтсан.

Мөн цаг үеийн холбоотой өвөлжилтийн бэлтгэл ажил, хээрийн түймэрээс сэргийлэх зэрэг зөвлөгөө өгч ажилласан. Мөн сургалт хийхээс гадна тухай өрхийн эрсдэлийг өрхийн гишүүдийн оролцоотой үнэлж, эрсдэлийг хэрхэн бууруулах зөвлөмж өгснөөрөө онцлогтой болсон. Гамшгийг эрсдэлийг бууруулж, хариу арга хэмжээ авах өрхийн гишүүдийн чадварыг бэхжүүлэх нь иргэдийн аюулгүй байдлыг хангах, сумын хэмжээнд гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Сургагч багш нар малчин өрх бүрт эрсдэлийн үнэлгээ хийсэн. Үнэлгээ хийх явцын оноо 25-45 хооронд гарсан нь тус багт эрсдэл өндөр, цаашид анхаарал хандуулан илүү эрчимтэй ажиллах шаардлагатайг харуулж байна. Өрхийн эрсдэлийн үнэлгээний аргачлал нь “Бэлэн бай” сургалтын модулийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд оролцогчдын эрсдэлийг үнэлэх зорилготой юм. Байршлаас хамааран малчин айл, гэр хороолол, орон сууц гэсэн гурван ангилалтай бөгөөд нийт 20

асуулттай. Асуултанд хэрхэн хариулснаас хамааран эрсдэлийн түвшинг оноогоор үнэлнэ. Асуулгын үр дүнг төрийн албаныхан гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаандаа ашиглана.

Сургалтад хамрагдсан иргэд олж авсан мэдлэгийнхээ талаар дараах санал хүсэлтээ илэрхийлсэн:

- Өрх бүр өөрсдийн боломжийн хэрэгцээнд гал түймрийн багаж хэрэгсэлтэй болох
- Малчид ард иргэд олон зүйлийг мэдэж авсан, цаашид ч ийнхүү сургалтыг илүү олноор зохион байгуулах
- Малчид гар утсаараа дамжуулж цаг агаарын мэдээ болон бэлчээрийн даац, бэлчээрийн ургамлын мэдээлэл, зуншлага, ган цас, зуд, зудын эрсдэлийн мэдээлэл зэрэг өөрт хэрэгтэй 12 төрлийн мэдээллийн хурдан шуурхай авч сурлаа
- Заасан хичээл иргэдэд илүү ойр ойлгомжтой энгийн хэрнээ мэдэхгүй зүйл шинэ санаа ихтэй сонирхолтой байсан
- Өвлийн улирал ойртож, гамшгийн эрсдэл нэмэгдэж буй энэ үед энэхүү сургалт мэдээлэлийг цаг үеэ олсон арга хэмжээ болсон.
- Өвөл ойртож, гамшгийн эрсдэл нэмэгдэж байгаа тул сургалтыг зөв цагт зохион байгууллаа гэж дүгнэсэн.

Дүгнэлт

“Бэлэн бай” сургагч багш бэлтгэх сургалт болон сумын иргэдэд чиглэсэн сургалтууд сумын болон иргэдийн аюулгүй байдалд чухал ач холбогдолтой юм. Орон нутгийн төрийн байгууллагууд болон ОБГ иргэдэд гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт явуулах мэдлэг, үр чадвартай болсон нь айл өрхүүдийг аюулт үзэгдлээс хамгаалах ажилд нь томоохон дэмжлэг үзүүлж байгаа. Энэхүү цуврал сургалтууд гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцоог байгуулах, гамшгийн хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан.



Амжилтын түүх

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ХЭРЭГСЭЛ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ГАРДУУЛСАН НЬ

Түншлэгчийн нэр: Зорилтот аймгуудын ОБГ

Төслийн байршил: Ховд, Увс, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар аймгууд

Хугацаа: 2020 оны 11 сар

Төслийн танилцуулга

“Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны аргыг ашиглах нь – 3” (LTS3) төслийн хүрээнд 5 аймгийн Онцгой Байдлын Газар (ОБГ)-тай хамтран Баян-Өлгий, Ховд, Увс, Сүхбаатар, Хэнтий аймгийн арван суманд “LEGS аргачлалыг ашиглан гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулах” сургалтыг 2020 оны 6-8-р сард зохион байгууллаа. Үг сургалтад сумдын Онцгой комиссын 146 гишүүн хамрагдсан: сумын засаг дарга, төрийн албан хаагчид, малын эмч, байгаль орчны байцаагчид, сургууль, цэцэрлэгийн эрхлэгчид, цагдаагийн ажилтнууд, төрийн сангийн ажилтнууд, эмч. Оролцогчид LEGS аргачлалыг ашиглан эрсдэлийн үнэлгээ хийж, хамгийн өндөр эрсдэлтэй 2-3 аюулт үзэгдэлээс хамгаалах төлөвлөгөө шинэчилсэн. Шинэчлэгдсэн гамшгийн төлөвлөгөө бүрт аюулт үзэгдлээс хамгаалах

ажлуудаа бичиж, зайлшгүй хэрэгцээтэй хэрэгсэл, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргасан.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөн дээр үндэслэн зорилтот сумдын засаг дарга, аймгуудын ОБГ-ууд гамшгийн эрсдэлийг бууруулах хэрэгсэл, тоног төхөөрөмж авах хүсэлтээ Мерси Корын боловсруулсан өргөдлийн маягтыг ашиглаж илгээсэн. Өргөдлийн маягтанд энэхүү хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хэн эзэмших, ямар зорилгоор хэрхэн ашиглах талаар асуултууд орсон байсан.

Бүх өргөдлийг LTS3 төслийн сонгон шалгаруулалтын баг хянасан. Арван сумын захиргааны санал болон таван аймгийн ОБГ-аас ирүүлсэн хүсэлт өмнөх гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтанд тодорхойлогдсон нэн тэргүүнд гүйцэтгэх ажилтай нийцэж байсан тул бүх хүсэлтийг санхүүжүүлэх шийдвэр гаргасан юм. Жич: Мерси Кор орон нутгийн захиргаа эсвэл онцгой комисс руу хөрөнгө мөнгө шилжүүлээгүй; Мерси Кор бүх бараа, материалаа өөрөө худалдан авч, зорилтот аймаг суманд төсөл дуусахаас өмнө хүргүүлсэн.

Хандивласан хэрэгсэл, тоног төхөөрөмж

Мерси Кор 20 530 400 төгрөгний үнэ бүхий гамшгийн эрсдлийг бууруулах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг таван аймгийн арван суманд, 18 719 900 төгрөгний үнэтэй хэрэгсэл, тоног төхөөрөмжийг таван аймгийн ОБГ-т хүлээлгэн өглөө. Сумын гамшгийн төлөвлөгөө сайжруулах ажлын хүрээнд тодорхойлогдсон нэн тэргүүнд хэрэгцээтэй хэрэгсэл, тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн. Үүнд гал унтраах багаж, анхааруулах самбар, шүршигч, дуут дохио, усан насос, сургалтын маникен, сургалтын ширээ, сандал зэрэг төхөөрөмж орсон. Доорх хүснэгтээс дэлгэрэнгүй мэдээлэл харна уу.

Хүснэгт 6: Сумдад хандивласан хэрэгслийн тоо, төрөл

Аймаг	Хүлээн авагч	Хандивласан тоног төхөөрөмж
Увс	Наранбулаг	35 галын хор, 2 гал унтраах багаж
	Давст	35 галын хор, 2 гал унтраах багаж
	ОБГ	20 сургалтын ширээ, 40 сургалтын сандал
Хэнтий	Баянмөнх	10 анхааруулах самбар
	Дархан	4 анхааруулах самбар, 1 усан шахуургын багц (насос, хоолой, хошуу), 2 автомакс
	ОБГ	1 сургалтын проектор
Баян-Өлгий	Толбо	1 иргэний хамгаалах дуут дохио (сирен)
	Алтай	1 иргэний хамгаалах дуут дохио (сирен)
	ОБГ	2 иргэний хамгаалах дуут дохио (сирен)
Ховд	Erdeneburen	2 усан шахуургын багц, 4 автомакс
	Khovd	2 усан шахуургын багц, 4 автомакс
	LEMA	4 анхны тусламжийн сургалтын маникен

Сүхбаатар	Эрдэнэцагаан	4 анхааруулах самбар, 1 усан шахуургын багц 2 шүршигч
	Баяндэлгэр	2 усан шахуургын багц 4 автомакс
	ОБГ	"Бэлэн бай" сургалтын 10000 ширхэг брошүр

Увс аймаг

Наранбулаг, Давст сумын эрсдлийн үнэлгээгээр үер, хээрийн болон ахуйн гал түймэр хамгийн өндөр эрсдэлтэй аюулт үзэгдэл гэж тодорхойлсон. Эдгээр хоёр суманд гал унтраах анги байдаггүй бөгөөд хамгийн ойр байрлах анги нь сумаас 100 км-ийн зайд байрладаг.

Мерси Кор сумын захиргаатай хамтран хамгийн олон хүн ирж үйлчлүүлдэг, хөл ихтэй таван байгууллагыг сонгож гал унтраах багаж хандивласан. Үүнд, сумын төрийн захиргаа, эмнэлэг, цэцэрлэг, сургууль, соёлын ордон зэрэг байгууллагууд орсон. Улсын галаас хамгаалах стандартын дагуу барилгын 20 м² тутамд нэг галын хор байрлуулахаар заасан байдаг – энэ нь таван байгууллагад дунджаар 70 ширхэг галын хор хэрэгтэй гэсэн үг юм. Мерси Кор нийт шаардлагатай гал хорын 50%-ийг буюу 35 галын хор хандивласан- нэг байгууллагад 7 ширхэг ноогдсон.

Наранбулаг сум ирэх жилийн төсөвтөө үлдсэн 35 ширхэг галын хорын зардлыг тусгаж, галаас хамгаалах стандартыг дагаж, мөрдөхөө амласан. Наранбулаг сумын засаг дарга "Бид Мерси Корын тусламжтайгаар галаас хамгаалах стандартыг нэвтрүүлсэндээ баяртай байна. Бид ирэх жил галын хор авах зардлыг төсөвтөө заавал суулгах болно. Мөн бид галын стандартыг мөрдөхийг бусад байгууллагуудаас шаардах болно." гэлээ.

Түүнчлэн Мерси Кор сум бүрт гал унтраах багаж хандивласан. Багажинд дараах хэрэгслүүд орсон: галын хөнжил, анхны тусламжийн иж бүрдэл, хорт утааны маск, жижиг хадаасны лоом, галын хор. Наранбулаг сумын эмнэлэг, сургууль гал унтраах багаж хүлээн авсал бол Давст суманд захиргааны байр, сургууль гал унтраах багаж авсан. Тусламжийн хэрэгсэл гардуулах арга хэмжээ 2020 оны 11-р сарын эхээр болж, Мерси Кор хэрэгслүүдийг хэрхэн ашиглах, арчлах талаар зааварчилгаа өгсөн.

11-р сарын 7-нд Мерси Кор Увс аймгийн ОБГ-т 40 сандал, 20 ширээг хандивласан. ОБГ нь эдгээр сандал ширээг Хяргас нуурын ойр байрладаг ОБГ-ын харьяа Сургалт, хяналтын төвд зохион байгуулах гамшгаас хамгаалах сургалтанд ашиглахыг зорьж байгаа. Уг төвд сургалтад нэг жилийн хугацаанд сумын албан хаагчид, нутгийн иргэд, жуулчид зэрэг 2000-3000 хүн хамрагдана гэсэн төлөвлөгөө байгаа.

Хэнтий аймаг

Гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр Баянмөнх сумын хамгийн эрсдэл өндөртэй аюулт үзэгдлээр үер болон хээрийн түймэр тодорсон. Сумаар дайрч урсдаг Хэрлэн голд жил бүр 3-4 хүн живдэг. Энэ жил хүмүүсийн хариуцлагагүй байдлаас болж ассан

хээрийн түймрийг хяналтаас гарч амжаагүй байхад нь арай гэж унтраажээ. Иймээс сумын удирдлагууд гамшгаас хамгаалах гөө шинэчилж, иргэдийг ой хээрийн түймэр, үер усны ослоос сэрэмжлүүлсэн арван самбар босгох үйл ажиллагаа шинээр оруулсан.

Мерси Кор 2020 оны 11-р сарын 9-ний өдөр Баянмөнх суманд очиж, гэрлийн тусгалтай арван самбарыг ЗДТГ-д болон байгаль орчны байцаагчдад гардуулж өглөө. Дөрвөн самбар нь ой хээрийн түймрээс, зургаа нь үер усны ослоос иргэдийг сэрэмжлүүлсэн. Сумын Онцгой комисс самбараа аймгийн төв рүү болон Дархан сум руу явж буй зам дагуу босгосон. Дархан сум нь Хэнтий аймгийн төвийг Төв, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай аймагтай холбосон төв зам дээр байрладаг. Эдгээр аймаг сумдын малчид ихэвчлэн Дархан сумаар дайрч оторлодог. Олон удаа нүүж, оторлох нь малын халдварт өвчин тараах, ой хээрийн түймэр гарах эрсдэлийг нэмэгдүүлдэг.



Зураг 17. Хэнтий аймгийн Баянмөнх суман дахь анхааруулах самбар

Сумын удирдлага Мерси Корт хандаж, нутгийн иргэд, отроор явж байгаа малчдыг ой хээрийн түймэр, халдварт өвчнөөс сэрэмжлүүлж анхааруулсан 4 самбар хандивлах хүсэлт тавьсан. Түүнчлэн Мерси Кор сумын захиргаанд ариутгал халдваргүйжүүлэлт хийх зориулалттай усны иж бүрэн насос, хоёр автомакс хандивлалаа.

Ховд аймаг

Гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр үер болон малын халдварт өвчин Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн суманд хамгийн их эрсдэлтэй аюулт үзэгдлээр тодорхойлогдсон. Сумдад гүүр, үерийн далан засах төсөвтэй учир Мерси Короос малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлтийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангахыг хүссэн.

2020 оны 11-р сарын 11-нд Мерси Кор Ховд сумын захиргаанд усны насос бүхий хоёр иж бүрдэл, дөрвөн автомакс хандивлалаа. Ховд сум бол Ховд аймгийн төв юм. Хамгийн олон хүн амтай тул төрийн бүх гол байгууллага, хувийн бизнес, үйлдвэрүүд энд үйл ажиллагаагаа явуулдаг. Энд халдварт өвчин тарвал тус аймгийн эрүүл мэнд, эдийн засагт ноцтой нөлөө үзүүлнэ гэж орон нутгийн удирдлага үзэж байсан.

Хил дамнасан халдварт өвчний тархалтаас урьдчилан сэргийлэхийн тулд сумын малын эмнэлэг ариутгал, халдваргүйжүүлэлтийн гурван томоохон аян жил бүр зохион байгуулдаг. Хавар, намар бүр малын хашаа саравчийг ариутгаж, зун бүр бүх малыг угаалганд хамруулдаг. Энэ нь ойролцоогоор 411 малчин өрхийн 180 мянган толгой мал ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээнд хамрагддаг

гэсэн үг юм. LTS3 төслийн хүрээнд хандивласан тоног төхөөрөмжөөр жил бүрийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийх бөгөөд мал эмч нар халдварын голомт руу явахдаа уг төхөөрөмжийг ашиглах боломжтой.

Эрдэнэбүрэн сум 405 малчин өрхийн 175 мянган толгой малтай бөгөөд малын халдварт өвчин тархах өндөр эрсдэлтэй сум. Тухайлбал, тус суманд 2010 онд боом, 2016 бог малын мялзан өвчин, цэцэг, галзуу өвчин сүүлчийн гурван жил дараалан дэгдэж, 18.5 сая төгрөгний хохирол учруулсан.

Шинээр худалдаж авсан тоног төхөөрөмжийг улсын малын эмч нар онцгой байдлын үед болон улирлын чанартай ариутгал, халдваргүйжүүлэлтэнд ашиглана: хавар намар малын хашаа хороонд ариутгал хийж, 7-8-р сард малыг халдваргүйжүүлнэ.



Зураг 18. Ховд аймгийн ОБГ

Түүнчлэн 2020 оны 11-р сарын 18-нд Мерси Кор анхны тусламжийн дөрвөн маникенийг Ховд аймгийн ОБГ-т хандивлалаа. ОБГ одоогийн байдлаар видео үзүүлж, уулзалт зохион байгуулдаг сургалтын энгийн өрөөтэй юм байна. Тэд энэ өрөөгөө засварлаж, яаралтай тусламжийн дадлага хийдэг өрөө болгохыг зорьж байгаа. Тэдний сургалтад ОБГ-ын ажилтнууд, аврах багийн

гишүүд, энгийн иргэд, оюутнууд оролцож аврах болон онцгой байдлын үед анхны тусламж үзүүлэх дадлага хийнэ. ОБГ нь дадлага хийх маникен нь тэдний сургалтыг илүү үр дүнтэй, бодитой, амьдралд ойрхон болгоход тус дэмтэй гэж үзэж байна. Баян-Өлгий аймаг

2020 оны 7-р сард Баян-Өлгий аймгийн Толбо, Алтай суманд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж өндөр эрсдэлтэй аюулт үзэгдлээр үер, гал түймэр, зудыг тодорхойлсон. Сургалтын үеэр оролцогчид энэ хоёр сумын үерийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулсан юм. Алтай, Толбо сум нь өндөр уулсаар хүрээлэгдсэн, уулын цас хайлах, бороо ороход гол үерлэх эрсдэл өндөртэй газар байрладаг. Оролцогчид аврах баг, онцгой комиссын гишүүд, иргэдэд үерийн аюулын сэрэмжлүүлэг өгөх нь хамгийн чухал алхам гэж үзсэн.

Сумдад бага оврын, гар ажиллагаатай дуут дохио бий. Гэвч уг дохио нь хүчин чадал муутай, бүх иргэнд хүрдэггүй учир Мерси Короос илүү хүчтэй, цахилгаан сирен дохио нийлүүлэхийг хүссэн. Үүнийг нь Мерси Кор 11-р сарын эхээр сумын захиргаанд гардуулж өгсөн.

Мөн Баян-Өлгийн аймгийн ОБГ хоёр дуут дохиог хүлээн авсан. Аймгийн төв 2016, 2018 онд үерт автаж байсан. Энэ үед айл өрхийн байшин гэр нь эвдэрч, 530 өрхийн 2512 хүн өртөж, 10 тэрбум орчим төгрөгийн хохирол учирсан. ОБГ аймгийн төвд дуут дохио ажиллуулдаг ч тэр нь нийт хүн амын зөвхөн 10%-д л хүрсэн. Мерси Корын хандивласан шинэ дуут дохио нь үерт нэрвэгдэх хамгийн их магадлалтай

голын хоёр талд амьдардаг 14 мянган иргэнд хүрэх чадалтай хэрэгсэл юм. Дуут дохиог зуны улиралд байнга үерт автдаг газар барьсан арван жилийн сургуулийн дээвэр дээр байрлуусан.

Сүхбаатар аймаг



Зураг 19. Сүхбаатар аймаг, Эрдэнэцагаан сум

Гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хамгийн өндөр эрсдэлтэй аюулт үзэгдлээр үер, малын халдварт өвчин, ой хээрийн гал түймэр гэж тодорхойлогдсон. Сумын гамшгийн төлөвлөгөөнд хүмүүсийг усанд живэхээс урьдчилан сэргийлэх, малын халдварт өвчний тархалтыг зогсоох арга хэмжээнүүд тусгагдсан. Сумын төвөөр

гол урсдаг бөгөөд 1996 оноос хойш нийт 10 удаа томоохон үер болж, иргэд живж, амь насаа алдаж байсан тохиолдол гарч байсан. Түүнчлэн, малын халдварт өвчин энэ суманд маш элбэг тохиолддог. Тухайлбал: шүлхий өвчин (2014, 2015, 2017, 2018), ямааны цэцэг өвчин (2012) нь малчдын амьжиргаанд хүндээр тусаж, 20 сая хүртэлх төгрөгийн хохирол учруулсан. 2020 оны 11-р сарын 24-нд Мерси Кор анхааруулах самбар 4 ширхэг, усан насос бүхий нэг иж бүрдэл, хоёр автомаксыг сумын захиргаанд хандивласан. Самбарыг Чоно голын эрэг дагуу байрлуулж, үертэй үед усанд живэх аюулыг иргэдэд сануулна. Усан насос, автомаксыг ашиглан сумын 200 мянган толгой малыг ариутгаж, халдваргүйжүүлнэ. Эдгээр тоног төхөөрөмжийг онцгой байдлын үед болон улирлын ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд ашиглана. Тухайлбал, хавар, намар малын хашаа хороог, зуны улиралд мал ариутгаж, халдваргүйжүүлэхэд зориулна.

Баяндэлгэр сум нь тал хээрийн бүсэд байрладаг бөгөөд малын халдварт өвчин болон ахуйн гал түймэр гарах өндөр эрсдэлтэй. Суманд гал унтраах багаж хэрэгсэл байдаг боловч малын халдварт өвчнийг хязгаарлах хэрэгсэл байдаггүй. Тиймээс 11-р сарын 25-нд Мерси Кор сумын захиргаанд усан насос бүхий хоёр ширхэг иж бүрдэл, дөрвөн ширхэг автомакс хандивласан. Эдгээр тоног төхөөрөмжийг малын ариутгал, халдваргүйжүүлэлтэд зориулагдана. Суманд галзуу, шүлхий, ямааны цэцэг зэрэг өвчин зонхилдог бөгөөд энэ нь малчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал, малчин өрхүүдэд 2015 оны байдлаар 300 сая төгрөгийн хохирол учирсан.

Аймгийн ОБГ “Бэлэн бай” сургалтын брошүраас 10 мянган хувь хэвлүүлэн авах хүсэлтэй байгаагаа Мерси Корт уламжилсан. Ингэснээр Сүхбаатар аймгийн ОБГ “Бэлэн бай” сургалтыг сумын иргэд, аврах баг, оюутнуудад зориулан зохион байгуулах боломжтой болно. Төсөв хүрэлцдэггүй учир ОБГ өнгөрсөн сургалтын оролцогчдод сурталчилгааны материал тараах боломж байгаагүй. ОБГ

“Бэлэн бай” сургалтын брошүрууд нь аймаг дахь гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын үр дүнг сайжруулах боломжийг ОБГ-т олгож байгаа юм.

Үр нөлөө

Гамшгийн эрсдэлийг бууруулах хэрэгсэл, тоног төхөрөөмж нь таван аймгийн ОБГ, арван сумын чадавхийг бэхжүүлэхэд чухал үр нөлөө үзүүлсэн.

Хандивласан хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглан ОБГ орон нутгийн иргэд, аврах ангиудад гамшгийн сургалт зохион байгуулах, үер болон гал түймрийн аюулаас иргэдийг сэрэмжлүүлэх, малыг ариутгаж, халдваргүйжүүлэх боломжтой боллоо. Үүнээс гадна тус хандив нь орон нутгийн удирдлагуудыг иргэдтэйгээ хамтран ажиллах сонирхолыг нэмэгдүүлж, гамшгийн хор уршгийг арилгах, гамшгийн эрсдэлийг бууруулах, байгалийн болон хүний гараар бий болсон гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх замаар аюулгүй, эрүүл нийгмийг байгуулахад хувь нэмрээ оруулна.

Мерси Кор 39.25 сая төгрөгийн үнэтэй, найман төрлийн хэрэгсэл, тоног төхөөрөмж хандивласан. Ойролцоогоор 54 мянган хүн үр шимийг нь хүртсэн. Доорхи хүснэгтийг үзнэ үү. Үр шим хүртэгсдийн тоонд малын хашаа хороо, малаа ариутгаж халдваргүйжүүлсэн малчид; сургууль эмнэлэг дотор галын хор авч суурилуулсан сурагчид, эмнэлгийн ажилтнууд; маникен, сандал, ширээ, проектор ашиглан сургалтаа илүү үр дүнтэй зохион байгуулах боломжтой болсон ОБГ-ын ажилтнууд; гэнэтийн үер, гал түймэр гарахад цаг алдалгүй дуут дохиогоор сэрэмжлүүлэг авах боломжтой болсон гал түймэр, үерийн аюултай бүсэд амьдардаг иргэд; ой хээрийн түймэр, үер усны ослоос урьдчилан сэргийлэх мэдээлэл авч буй бусад сум, аймгийн иргэд багтаж байна.

Хүснэгт 7: Үр шимт хүртэгсдийн тоо, хандивласан эд зүйлсийн үнийн дүн

Аймаг	Хандивласан хэрэгслийн үнэ өртөг (төгрөгөөр)	Үр шим хүртэгсдийн тоо
Баян-Өлгий	5 280 000	17 100
Ховд	10 269 200	4 500
Увс	10 732 000	9 800
Хэнтий	6 267 200	7 400
Сүхбаатар	6 701 900	16 000
Нийт	39 250 300	54 800

Аймаг, сумын захиргаа, ОБГ, сургууль, эмнэлгийн ажилтнууд Мерси Кор, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагт талархлаа илэрхийлэхээс гадна хандивласан тоног төхөөрөмжийг гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглахаа амласан. Малын халдварт өвчин, гал түймэр, үер зэрэг гамшигт үзэгдлийн хэмжээ хор уршиг нь байнга нэмэгдэж байгаа өнөө

үед энэхүү нэн шаардлагатай хэрэгсэл, тоног төхөөрөмж нь орон нутгийн засаг захиргаа, иргэдийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд туслах нь дамжиггүй.

Б. Тойлат, Ховд сумын мал эмнэлгийн дарга, эпидиологи

Бид сумынхаа хамгийн өндөр эрсдэлийг үер болон халдварт өвчин гэж тодорхойлсон. Бид Мерси Короос халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмж хүлээн авсандаа маш их баяртай байна. Үүгээр бид 406 малчны 166 мянган малыг халдваргүйжүүлэхээр төлөвлөж байна.

А. Озат, Баян-Өлгий аймгийн Алтай сумын ЗДТГ-ын дарга:

2014 онд сургуулийн нийтийн байранд гал гарч, барилга тэр чигтээ шатсан. Бидэнд сурагчдад анхааруулах ямар ч боломж байгаагүй. 2015 онд бороо тасралтгүй орсоны улмаас үер бууж, хоёр барилга эвдэрч сүйдсэн. Бид мөн л иргэдэд анхааруулж чадаагүй. Мерси Кор бидэнд бүх хүмүүст хүрэх хүчин чадалтай цахилгаан дуут дохио хандивласан.

Ш. Отгонжаргал, Хэнтий аймгийн Дархан сумын ЗДТГ-ын дарга

Манай сум 255 мянга гаруй малтай, 346 малчин өрхтэй. 2018, 2019 онуудад манайд галзуу өвчин гарсан. Засаг даргын тамгын газар, малчид, хувийн малын эмч нар хандивласан ариутгалын багаж хэрэгслээр үхсэн малыг устгаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ.



Амжилтын түүх

**PDS АРГАЧЛАЛЫГ
МОНГОЛД
НУТАГШУУЛАХ
СУРГАЛТУУД**

Түншлэгчийн нэр: МЭЕГ, аймгийн Мал эмнэлгийн газрууд

Төслийн байршил: Ховд, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар аймгууд

Хугацаа: 2019-2020 он

Ерөнхий мэдээлэл

“Гамшгийн эрсдэлийг бууруулахад уламжлалт болон шинжлэх ухааны арга ашиглах нь” (LTS3) төсөл нь гамшгийн эрсдэлийн бэлэн байдал болон бэлчээрийн менежментийг сайжруулах, хил дамнан халдварладаг малын өвчний эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх замаар малчин өрхүүдийн эмзэг байдлыг бууруулах зорилготой байсан. LTS3 төсөл Ховд, Увс, Баян-Өлгий, Хэнтий, Сүхбаатар аймгуудад хэрэгжсэн боловч, Увс аймагт мал амьтны өвчнийг оролцооны аргаар тандан судлах аргачлал нь хэрэгжээгүй юм.

Төслийн гол үйл ажиллагааны нэг нь малын эмч нарын малын гоц халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, яаралтай арга хэмжээ авах, өвчний тархалтыг хянах чадавхыг бэхжүүлэхийн тулд одоо хэрэгжүүлж буй тандалтын аргачлалыг Халдварт өвчнийг оролцооны аргаар тандан судлах (PDS) аргачлалтай нэгтгэх явдал

байлаа. 2001 оноос хойш хил дамнан халдварладаг малын өвчний тоо нэмэгдэж, малчдын амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд аюул учруулж эхэлсэн. Одоогоор Монголд халдварт өвчнийг тандан судалж, эрт илрүүлдэг тогтолцоо байхгүй. Бидний нэвтрүүлж буй PDS аргачлал нь малын халдварт өвчнийг тодорхойлох, эрт илрүүлэх, эрсдлийг нь бууруулах, хамгаалах хамгийн амжилттай аргачлал нь батлагдсан билээ.

PDS нь орон нутгийн түншлэгч нар тухайлбал, малын эмч, малчдыг эрүүл мэндийн тандалт, судалгаанд шууд оролцуулдаг, уламжлалт эпидемиологийн аргаас ондоо, илүү оновчтой арга гэдэг нь батлагдсан. Энэхүү аргачлалыг анх малын эрүүл мэндийн жижиг төсөл, хөтөлбөрүүдэд ашиглаж байсан бол одоо олон улсын түвшинд малын өвчинтэй тэмцэхэд PENAPH (Мал амьтан, нийтийн эрүүл мэндийн оролцоот эпидемиологийн сүлжээ) ашиглаж байна.

Өмнөх төслийн хүрээнд Мерси Кор Мал эмнэлгийн ерөнхий газар (МЭЕГ)-тай хамтран PDS аргачлалыг Монголд нэвтрүүлэх ажлыг эхлүүлж байсан. LTS3 төсөл 2019 оны 9-р сард эхлэхэд талууд Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, PDS аргачлалыг нутагшуулах ажлаа үргэлжлүүлсэн.

Төслийн хүрээнд талууд дотоод түншүүдтэй хамтран цуврал сургалт, уулзалтыг зохион байгуулахаар тохиролцсон юм. 2019, 2020 онд Мерси Кор, МЭЕГ Улаанбаатарт 3 сургалт, аймгуудад 6 сургалт зохион байгуулсан. Сургалтанд улсын болон хувийн малын эмч нар, судлаачид, төрийн албан хаагчид зэрэг 257 хүн хамрагдаж, PDS-ийн аргачлал, PDS-ийн гэрчилгээжүүлэх үйл явц, LTS3 төслийн PDS бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтийн талаар мэдлэгээ дээшлүүлсэн.

Улсын хэмжээний уулзалт, сургалтууд

Улсын хэмжээний уулзалтууд

LTS3 төслийн хүрээнд PDS-ийн бүх үйл ажиллагааг МЭЕГ-тай хамтран төлөвлөж, хэрэгжүүлсэн. Мерси Кор нь шийдвэр гаргагч нар болон PDS-ийн сургагч багш нартай байнгын харилцаа холбоотой ажилласан. Түүнчлэн төслийн үйл ажиллагаагаа төр засгийн бодлого, стратегитэй уялдуулахын тулд хоёр тал тогтмол уулзаж байлаа. Мерси Кор, МЭЕГ, PDS-ийн гол түншлэгч нарын хооронд зохион байгуулагдсан зарим чухал уулзалтуудын талаар та бүхэнд товчлон хүргэж байна.

МЭЕГ, PENAPH, “Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг”-тэй хийсэн уулзалтууд

МЭЕГ-ын урилгаар PENAPH-ын Ерөнхий зохицуулагч Жеф Маринер “Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг” (WCS)-ийн хэрэгжүүлж буй “Шинжлэх ухаанд суурилсан байгаль орчин ба хүний харилцаа” (SNAPP) төслийн хүрээнд Монголд мялзан, бог малын цэцэг өвчнийг устгах ажилд дэмжлэг үзүүлэхээр 2019 оны 8-р сарын 5-21-нд Монголд ирж ажилласан. Монголд дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн:

- Дөрвөн сургагч багш нарт PDS хэрэгжүүлэгчийн сертификат гардуулсан;
- PDS-ийн судалгаа, тайлан, судалгааны үр дүнд зөвлөгөө өгсөн;
- Өнөөгийн тандалтын үйл ажиллагаа, Монголд PDS-ийг нэвтрүүлэх асуудлыг МЭЕГ-тэй ярилцаж, PDS аргачлалыг бусад төсөлд ашиглах боломжийн талаар санал бодлоо солилцов;

Мал эмнэлгийн тандан судлах тогтолцоонд PDS аргачлалыг ашиглах, малын өвчин тандах үйл ажиллагаанд түнш талуудаа оролцуулах, оролцооны аргаар тандан судлах чадавхыг бэхжүүлэх ажлыг улсаас зохион байгуулж буй шүлхий, бог малын мялзан өвчнийг устгах үйл ажиллагаатай уялдуулах тухай ярилцах гэж МЭЕГ-ын байранд 2019 оны 8-р сарын 12-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Уулзалтад Мерси Корын Суурин төлөөлөгч, Хөтөлбөрийн менежер, PENAPH-ийн зохицуулагч, WCS-ын Суурин төлөөлөгч, МЭЕГ-ын дэд дарга, МЭЕГ-ын Мал амьтны эрүүл мэндийн газрын дарга, малын халдварт өвчний мэргэжилтэн, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний мэргэжилтэн, Монголын мал эмнэлгийн эпидемиологчдийн холбооны гүйцэтгэх захирал, Улсын мал эмнэлгийн төв лабораторийн захирал, судлаачид зэрэг 10 хүн оролцсон.

Уулзалтын үеэр оролцогчид дараах сэдвээр ярилцсан:

- Эпидемиологич, малын эмч нарт зориулсан чадавхи бэхжүүлэх сургалтын ач холбогдол
- PDS гэрчилгээжүүлэх үйл явцад оролцогч талуудын хамтын ажиллагаа
- PDS аргачлалыг цаашид нутагшуулахын ач холбогдол
- Монгол улсад серо-эпидемиологийн болон өвчний дэгдэлтийн судалгааг зохион байгуулахын ач холбогдол

PENAPH-ийн захирал доктор Маринер одоогийн тандан судлах ажлыг сайжруулах, PDS-ийг нутагшуулахад түншлэгч талуудын хамтын ажиллагаа, малын халдварт өвчнийг устгах, хяналтандаа оруулах үйл явцад PDS аргачлалыг ашиглах зэрэг сэдвээр зөвлөмж, бодлоо хуваалцлаа. Тэрээр мөн Ховдод хийсэн аяллын үеэр Мерси Кор, WCS, аймгийн мал эмнэлгийн мэргэжилтнүүд хамтран орон нутгийн малчидтай фокус бүлгийн ярилцлага зохион байгуулах замаар орон нутагт дахь малын эрүүл мэндийн байдлыг судлах, бог малын мялзан, шүлхий өвчний голомтыг тодорхойлох, сум, аймгийн түвшинд оролцоот аргаар малын өвчний эрсдэлтэй бүсийн зураглалын талаар өөрийн дүгнэлтээ танилцуулсан. Үүний дараа дээрх хамтарсан баг оролцоот аргаар тандан судлах чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааг шүлхий, мялзан өвчнийг хянах төрийн үйл ажиллагаатай нэгтгэх ажилд дэмжлэг үзүүлэх үүднээс зөвлөмж боловсруулсан.

Уулзалтын үеэр доктор Жефф Маринер PDS-ийн дөрвөн шинэ сургагч багш нарт гэрчилгээ гардуулсан бөгөөд түүний дотор Мерси Корын төслийн менежер Энхтуяа багтсан билээ. Гэрчилгээ нь сургалт, судалгаа, судалгааны тайлан бичих, сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдах, сургалт зохион байгуулах, бусад

хэрэгжүүлэгчдийн судалгааны ажлыг хянах гээд 6-8 сар үргэлжилсэн сургалтын үйл явцыг амжилттай хэрэгжүүлж дуусгасныг баталж байгаа юм.

Уулзалтын үр дүнд Мерси Кор МЭЕГ-тай хамтран PDS аргачлалыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулахыг тохиролцож, WSC нийгэмлэгийн “Бөхөнгийн эрүүл мэнд хамгаалах” төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлсэн.

МЭЕГ-тэй байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичиг

Хил дамжин халдварладаг мал, амьтны өвчнийг тандах, урьдчилан сэргийлэх, хянах төрийн тогтолцоонд PDS аргачлалыг нэвтрүүлэх, орон нутгийн малын эмч нарыг PDS аргачлалд сургах, холбогдох төрийн байгууллагад PDS-ийн талаарх мэдээ хүргэж, орон нутгийн малын эмч нарт олон улсын PDS гэрчилгээ авахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 2019 оны 12-р сард Мерси Кор МЭЕГ-тай “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулсан. Санамж бичгийн хүрээнд МЭЕГ PDS аргачлалыг нэвтрүүлэх ажлыг хариуцах мэргэжилтэн томилж, төслийн хугацаанд орон нутгийн иргэд, малчид, мал эмч, удирдлагад PDS аргачлалыг сурталчлахаар тохиролцов.

МЭЕГ болон PDS мастер сургагч багш нарын уулзалт

Мерси Кор болон PDS-ийн мастер сургагч багш (Монгол дахь PDS-ын сургалтыг удирдан чиглүүлж, ажиглах үүрэгтэй) нар хамтран МЭЕГ-ын албаны хүмүүстэй 2020 оны 2-р сарын 13-нд уулзсан. Уг уулзалтаар PDS арга зүйг нэвтрүүлэх талаар МЭЕГ-ын баримталж байгаа бодлого, 2020 оны МЭЕГ-ын ажлын ерөнхий төлөвлөгөө, стратегид PDS-ийг нутагшуулах ажлыг хэрхэн тусгасан тухай ярилцсан. Уулзалтын үеэр талууд PDS-ийн сургалт, судалгаа, уулзалт зэрэг үйл ажиллагаа багтаасан төлөвлөгөөг ярилцаж, харилцан зөвшөөрсөн.

МЭЕГ-ын мэргэжилтэн МЭЕГ-ын ажиллуулдаг мэдээллийн менежментийн систем/мэдээллийн санг танилцууллаа. Уг мэдээллийн системд Монголын мал эмнэлгийн салбартай холбоотой бүх мэдээлэл байдаг бөгөөд үүнд: МЭЕГ-ын үндэсний болон орон нутгийн салбаруудын төлөвлөгөө, үйл ажиллагаа, мал эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүсэлт, үзүүлсэн үйлчилгээ, мал эмнэлгийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн тоо, төрөл, махны импорт, экспорт, малын өвчин, малын тоо, малчин өрхийн тоо, хувийн мал эмнэлгийн мэдээлэл, мал эмнэлгийн эмийн худалдаа, нөөц зэрэг мэдээлэл ордог. Сумын малын эмч уг мэдээллийг мэдээллийн системд шивж оруулах үүрэгтэй байдаг. Жишээлбэл, малчнаас мал эмнэлгийн тусламж хүссэн огноо, тухайн малын эмчийн үзүүлж буй үйлчилгээний төрөл, худалдан авсан эм тариа, оношлогооны үр дүн, бусад мэдээллийг энэ мэдээллийн санд оруулдаг. Эцэст нь түншүүд PDS аргачлалыг засгийн газрын одоогийн тандалтын үйл ажиллагаатай хэрхэн уялдуулж болох талаар ярилцсан.

Үндэсний хэмжээний уулзалтууд

Дээр дурдсан уулзалтуудаас гадна Мерси Кор МЭЕГ-тай хамтран 2019, 2020 онд үндэсний хэмжээнд гурван сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулав. Эдгээр сургалтуудын гол зорилго нь PDS аргачлалыг төрийн гол шийдвэр гаргагчдад танилцуулах, PDS-ыг одоогийн тандан судлах системтэй холбох арга замыг судлах, МЭЕГ-ын үйл ажиллагаанд PDS-ыг нэвтрүүлэхэд цаашид дэмжлэг үзүүлэхэд оршиж байсан.

1. PDS-ыг танилцуулах уулзалт

Эхний уулзалтыг 2019 оны 12-р сарын 17-ны өдөр зохион байгуулав. Үүнд МЭЕГ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ), Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Хөдөө аж ахуйн их сургууль (ХААИС), Нийслэлийн мал эмнэлгийн газар, МХЕГ, Хил хамгаалах ерөнхий газар, ОБЕГ болон Эпидемиологийн холбоо зэрэг байгууллагуудыг төлөөлж 25 хүн оролцлоо. Оролцогчид PDS аргачлалын ач холбогдлыг ярилцаж, LTS3 төслийн тухай мэдээлэл авч, PDS аргачлалыг малын өвчин тандах тогтолцоонд хэрхэн нэвтрүүлж, малын эмч нарыг энэ аргад хэрхэн сургах талаар санал бодлоо солилцлоо. Түүнчлэн PDS-ийн сургагч багш нар судалгааны ажлын тайлангаа танилцуулж, оролцогчдын дунд идэвхтэй мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэв. Уулзалтын төгсгөлд ихэнх оролцогчид PDS нь тандан судлах үйл явцад олон хүмүүсийг хамруулах боломжтой, маш үр дүнтэй, зардал багатай арга хэрэгсэл мөн гэдэг дээр санал нэгдлээ. Тиймээс COVID-19 цар тахлын улмаас бэрхшээл тулгарч байгаа ч МЭЕГ нь улсын болон орон нутгийн түвшинд PDS-ын бүх үйл ажиллагааг дэмжиж ирсэн.

2. Малын өвчний тухай гарын авлагыг хэлэлцэх уулзалт

Дараачийн уулзалт нь 2020 оны 6-р сарын 18-нд зохион байгуулагдсан. Мерси Кор “Малын зарим өвчнүүд” хэмээх гарын авлагын талаар ярилцахын тулд МЭЕГ-ын мэргэжилтнүүдийг уулзалтанд урьсан. Энэхүү гарын авлагад хамгийн түгээмэл тохиолддог, малчдын хувьд мэдэж байх шаардлагатай 25 малын өвчний шинж тэмдэг, өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвараас хамгаалах аргачлалыг өнгөт фото зурагтай, энгийн үг хэллэгээр тайлбарлаж бичсэн бөгөөд малчдад шууд хамааралтай Малын эрүүл мэндийн тухай хуулийн зарим хэсгийг оруулсан болно.

Энэхүү гарын авлагыг PDS-ийн судалгааны үр дүнг ашиглан Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн мэргэжилтнүүд боловсруулсан. МЭЕГ-ын 12 мэргэжилтэн, PDS-ийн хоёр сургагч багш, малын эрүүл мэндийн зөвлөх багийн гурван гишүүн, Мерси Корын гурван мэргэжилтэн зэрэг нийт 20 хүн гарын авлагыг үзэж, хэлэлцэв.

Гарын авлагыг хэлэлцэх үеэр Мерси Кор PDS-ын хүрээнд хэрэгжүүлсэн үндсэн ажлуудаа ярьж, PDS-ын судалгааны үр дүнгээ танилцуулав. Энэхүү уулзалт нь малын өвчнөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажилд малчдаас өгч буй мэдээллийн

үнэ цэнийг оролцогчдод ойлгуулах сайхан боломжийг олгов. Мэргэжилтнүүд гарын авлагын сайтар хянаж үзээд малчдад малын өвчин тус бүрээр ямар мэдээлэл өгөх талаар ярилцав. Зөвлөгөөний төгсгөлд гарын авлагын агуулгыг эцэслэн баталгаажуулж, 2020 оны 9-р сард 17500 ширхэг “Малын зарим өвчнүүд” гарын авлагыг хэвлүүлж, 2020 оны 10-11-р саруудад зорилтот таван аймгийн малчдад тараав.

3. PDS аргачлалыг танилцуулах уулзалт

LTS3 төслийг хаах ажлын хүрээнд Мерси Кор МЭЕГ-тай хамтран PDS аргачлалыг танилцуулах гурав дахь уулзалтыг 2020 оны 10-р сарын 14-нд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус уулзалт нь PDS төслийн үр дүн, хүрсэн амжилтыг танилцуулах, үндэсний гол шийдвэр гаргагч нартай PDS-ийн аргачлалыг тогтолцоондоо нэвтрүүлэх цаашдын төлөвлөгөөг хэлэлцэхийг зорьсон.

Арга хэмжээнд МЭЕГ, УМЭАЦТЛ, ХААИС, Малын эмийн судалгааны хүрээлэн, PDS-ийн зөвлөх компани, Монголын эпидемиологчдын холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, 30 малын мэргэжилтэн оролцов.



Зураг 20. МЭЕГ-ын удирдлагуудтай хийсэн PDS аргачлалыг танилцуулах уулзалт, 2020 оны 10-р сар

Уулзалтаар дараах сэдвээр ярилцсан:

1. PDS систем, PDS аргачлалын талаарх танилцуулга
2. Судалгааны тайлангийн танилцуулга
3. Малын өвчнийг эрт илрүүлэх, тандахад PDS/PE аргачлалын ач холбогдол
4. Малчдад зориулсан “Малын зарим өвчнүүд” гарын авлагын танилцуулга

МЭЕГ-ын мэргэжилтнүүд Монголд PDS-ийн аргачлалыг нутагшуулах үйл явц, хүрсэн үр дүнд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байлаа. Төсөл хаагдсан ч МЭЕГ үлдсэн 17 аймагт PDS-ийг нэвтрүүлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэхээ мэдэгдсэн. МЭЕГ Дэлхийн банкны санхүүжилтээр Дэлхийн Зөнгийн 2021 онд хэрэгжүүлэх

шинэ төслийн хүрээнд PDS сургалтыг таван шинэ аймагт зохион байгуулахаар төлөвлөжээ.

Аймгийн түвшний уулзалтууд

Мерси Кор нь МЭЕГ болон аймгийн Мал эмнэлгийн газруудтай хамтран 2020 оны 10, 11-р сард Ховд, Баян-Өлгий, Хэнтий аймагт LTS3 төслийн хаалтын уулзалтуудыг амжилттай зохион байгуулав. COVID19-ийн улмаас улсын хэмжээнд хөл хорио тогтоосон учир 2020 оны 12-р сарын 17-нд Сүхбаатар аймгийн малын эмч нартай онлайн хэлбэрээр уулзалт зохион байгуулсан.

Эдгээр дөрвөн уулзалтанд зорилтот аймаг сумдын улсын болон хувийн малын эмч, шинээр гэрчилгээ авсан PDS хэрэгжүүлэгч, тархвар зүйч гээд нийт 221 хүн оролцсон.

Аймгийн уулзалтын гол зорилго нь:

- PDS арга зүй, PENAPH-ийн гэрчилгээжүүлэх үйл явцыг малын эмч нарт танилцуулах
- LTS2 ба LTS3 төслийн хүрээнд хийгдсэн PDS үйл ажиллагааны үр дүнг танилцуулах
- Зорилтот аймгуудад хийгдсэн судалгааны үр дүнг танилцуулж, мал эмнэлгийн ажлыг төлөвлөхдөө хэрхэн ашиглах талаар ярилцах
- PDS хэрэгжүүлэгч нар өөрсдийн аймагтаа PDS аргачлалыг нэвтрүүлэх нэг жилийн төлөвлөгөө боловсруулах
- PDS-ын сургалтын хөтөлбөрийг амжилттай төгссөн 37 малын эмчээс 28-д нь “PDS хэрэгжүүлэгчийн гэрчилгээ”-г гардуулах

Уулзалтын үеэр оролцогчдод “Малын зарим өвчнүүд” шинэ гарын авлагыг танилцуулав. Энэхүү гарын авлага нь малчдад малын өвчний шинж тэмдгийг илүү сайн ойлгож, танихад туслах зорилготой бөгөөд уулзалтанд оролцсон сумдын малын эмч зорилтот аймгуудын бүх сумдын малчдад 17500 ширхэг гарын авлага түгээсэн.

Хэнтий аймаг дахь PDS уулзалт

Мерси Кор аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран PDS уулзалтыг 2020 оны 11-р сарын 10-ны өдөр Хэнтий аймагт зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд төрийн болон хувийн 42 малын эмч, аймаг, сумын тархвар зүйч, аймгийн Мал эмнэлгийн газрын дарга нар оролцов.

Мерси Кор ба МЭЕГ-ын сонгосон Хэнтий аймгийн 10 сумын малын эмч, эпидемиологч PDS-ын сургалтанд амжилттай оролцож, PDS хэрэгжүүлэгчийн гэрчилгээг гардаж авлаа. Уулзалтын үеэр эдгээр PDS хэрэгжүүлэгч нар Хэнтий аймгийн гурван суманд (Баян-Адарга, Норовлин, Биндэр) хийсэн судалгааны үр дүнгээ танилцуулж, мал эмнэлгийн үйл ажиллагаагаа төлөвлөхдөө олсон мэдлэгээ бусад малын эмч нартай хэрхэн хамтран ашиглах талаар ярилцав.

Хэнтий аймаг дахь PDS-ын судалгааны зарим гол үр дүнг танилцуулбал:

- Шүлхий, гуур, боом өвчин Баян-Адарга, Норовлин сумдын малын хорогдлын тэргүүлэх шалтгаан болж байна
- Баян-Адарга, Норовлин сумдад үхрийн өвчин гарч буй гол шалтгаан нь шилжилт хөдөлгөөн, мал эмнэлгийн үйлчилгээний чанар муу, халдварын бүсд ойрхон амьдрах зэрэг нөлөөлсөн
- Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмж муу байгаа нь Биндэр сумын малын эрүүл мэндэд нөлөөлж байна
- Эргүүтэх, хамуу, балцруу, булчин цайх, нүдний өвчин зэрэг цаг уурын хүнд нөхцөлөөс үүдэлтэй паразит болон бусад өвчнүүд зонхилдог
- Одоогоор Монголд эргүүтэх өвчин эмчлэх малын эмч байхгүй тул эргүүтсэн мал амьтан үхэх магадлал өндөр байна
- Малчид өөр газар нүүж очиход дөнгөж 61% нь малын бүртгэлийн гэрчилгээ (мал эмнэлгийн гэрчилгээ) авдаг
- Оролцож буй малчдын 84% нь малаа бруцеллёзын шинжилгээнд хамруулахыг хүсч, үйлчилгээний төлбөрийг төлөхөд бэлэн гэдгээ илэрхийлсэн байна.

МЭЭГ-ийн төлөөлөгч МЭЭГ-ын шинэ онлайн мэдээллийн систем, малын өвчин тандан судлах үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулсан.

PDS-ыг хэрэгжүүлэгч нарын удирдлаган дор бусад малын эмч нар сумандаа PDS аргачлалыг ашиглан хамгийн их тархсан, хор нөлөө ихтэй малын өвчлөлийг тодорхойлож, малын өвчлөл, хорогдлын түвшин тогтоож, малчдын амьжиргаанд хэрхэн нөлөөлж буйг тооцоолов.

Зөвлөгөөний төгсгөлд PDS хэрэгжүүлэгч нар Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газарт зориулж малын эрүүл мэндийг сайжруулах 2021 оны аймгийн ажлын төлөвлөгөөг боловсруулж өгсөн. Санал болгож буй ажлуудыг аймгийн Мал эмнэлгийн газраас бүрэн санхүүжүүлж, дэмжиж ажиллах юм. Доорх хүснэгтийг үзнэ үү.

Хүснэгт 8: Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр

#	Үйл ажиллагаа	Байршил	Огноо
1	Мал эмнэлгийн үйлчилгээний талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг орон нутгийн иргэдтэй хуваалцах	Бүх сум	2020-2021
2	Төрийн болон хувийн малын эмч нарын тайлан тавих, харилцаа, эпидемиологийн судалгааны үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт явуулах	Аймаг, сумын төв	2021
3	Үхрийн бруцеллёз өвчний тандалт судалгаа хийх	Дадал, Биндэр сум	2021 оны 5-6-р сар
4	PDS судалгаа хийх	Өмнөдэлгэр, Дэлгэрхаан сум	2021
5	Малын ховор өвчний шинж тэмдгийг судлах: үс унах, чацга алдах, уушгины үрэвсэл	Аймгийн мал эмнэлгийн лаборатори	2021 оны 1 болон 2-р улирал

Баян-Өлгий аймгийн PDS уулзалт

Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран Мерси Кор 2020 оны 10-р сарын 20-нд Баян-Өлгий аймагт PDS уулзалт зохион байгуулав. Уулзалтанд аймгийн Мал эмнэлгийн газар болон 13 сумын хувийн болон улсын малын эмч, дөрвөн PDS-ийн хэрэгжүүлэгч зэрэг нийт 36 малын эмч оролцов.

Уулзалтын үеэр оролцогчид PDS-ийн мэргэжилтнээр удирдуулан бүлгийн хэлэлцүүлгийг хийв. PDS-ийн хэрэгжүүлэгч нар Баян-Өлгий аймгийн Алтай, Сагсай, Цэнгэл, Булган, Улаанхус гэсэн дөрвөн суманд хийсэн судалгааны үр дүнг танилцууллаа.

Судалгааны үр дүнд:

- Малд нөлөөлж буй паразит өвчнүүдээс хамгийн өргөн тархсан нь цагаан хорхой, шимэгч хорхой, хамуу юм;
- Булчин цайх өвчнийг Баян-Өлгий аймагт хамгийн их тархсан эндемик өвчин гэж малчид тодорхойлж байв;
- Мал угаах ванн байдаггүй, ариутгал тотмол хийдэггүй, ариутгалын бодис шүршигч хүрэлцээ муутай, вакцины хангамж тааруу, малын эмийн чанар муу зэрэг гол шалтгаанууд эдгээр өвчин тусахад нөлөөлдөг. Булчин цайх нь голдуу амин дэм, эрдсийн дутагдлаас үүсдэг.

Уулзалтын төгсгөлд PDS хэрэгжүүлэгч нар Баян-Өлгий аймагт 2021 онд малын эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, аймгийн Мал эмнэлгийн газар энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлэхээ илэрхийлэв.

Хүснэгт 9: Баян-Өлгий аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр:

#	Үйл ажиллагаа	Байршил	Огноо
1	Малын хамгийн түгээмэл өвчлөлийн талаар зорилтот бүлгийн малчидтай PDS ярилцлага хийх	Бугат, Өлгий, Баяннуур, Алтанцөгц, Ногооннуур сумууд	2020 оны 11-12-р сар
2	Улсын болон хувийн малын эмч нарт судалгааны үр дүн болон PDS аргачлалыг танилцуулах	Баян-Өлгий аймгийн бүх сумдууд	2020 оны 12-р сар
3	PDS хэрэгслийг ашиглан орон нутгийн эпидемиологичдыг сургах: зорилтот бүлгийн ярилцлага, өгөгдлийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх	Аймгийн төв	2021 оны 2-р сар
4	PDS-ын судалгаа явуулах	Улаанхус, Дэлүүн, Алтай, Толбо сумууд	2021 оны 3-4-р сар
5	PDS аргачлалыг ашиглан халдварт болон халдварт бус, эндемик өвчнийг судлах	Аймгийн мал эмнэлгийн газар	2021 оны 229 6-р сар

Ховд аймгийн PDS-ын уулзалт

Мерси Кор, Ховд аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран аймгийн төвд 2020 оны 10-р сарын 23-нд PDS уулзалтыг зохион байгууллаа. Аймгийн Мал эмнэлгийн газрын төлөөлөгчид, Аймгийн төрийн байгууллагын албаныхан, 17 сумын улсын болон хувийн малын эмч нараас бүрдсэн 96 хүн уг уулзалтанд оролцсон. Мөн уулзалтанд Ховд аймгийн 14 PDS хэрэгжүүлэгч, МЭЕГ-ын Малын эрүүл мэндийн хэлтсийн дарга, Ховд аймгийн Засаг Дарга, Ховд аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн зэрэг хүмүүс оролцсон.

Уулзалтын үеэр МЭЕГ малын эмнэлгийн салбарт хийж буй ажлууд, ахиц дэвшил, хүрсэн үр дүнгийнхээ талаар мэдээлэл өгч, оролцогчид орон нутгийн малын эмч нарт тулгарч буй бэрхшээлүүдийн талаар ярилцлаа. PDS хэрэгжүүлэгч нар Ховд аймгийн 13 суманд зохион байгуулсан 6 судалгааны үр дүнг танилцуулсан.

Судалгааны үр дүнгий товч хураангуй:

- Ховд аймагт хамгийн өргөн тархсан малын өвчинд сахуу, шимэгч хорхой, хамуу орно. Сүүлийн жилүүдэд мал эргүүтэх тохиолдол нэмэгдэж, үүнд өсвөр насны мал илүү их өвчилж, халдвараа тараадаг болсон
- Сүүлийн жилүүдэд хорт ургамал идэж хордсон малын тоо өсөж, улмаар үхэл өндөр байгаа талаар малчид мэдээлэв
- Зорилтот бүх сумдад угаалт, туулгалт зэрэг паразитын эсрэг үйлчилгээний чанар муу байна
- Малын тоо толгой хяналтгүй өсөж, бэлчээрийн менежмент муу байгаа нь бэлчээрийн даац хэтрэх, бэлчээр талхлагдахад хүргэж байна. Хоол тэжээлийн дутагдлаас болж амьтад бүх төрлийн өвчинд нэрвэгдэх шалтгаан болж байна
- Халдваргүйжүүлэлт хийгээгүй, вакцины нийлүүлэлт тогтмол бус, хангалтгүй байгаагаас бог малын сохор догол өвчин үүсэх магадлал өндөр хэвээр байна



Зураг 21. PDS-ийн гэрчилгээгээ авсан малын эмч нар 2020 оны 10-р сар, Ховд аймагт

Уулзалтын төгсгөлд PDS хэрэгжүүлэгч нар Ховд аймаг дахь малын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах нэг жилийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Хүснэгт 10: 2021 оны Ховд аймгийн Мал эмнэлгийн газрын хийх ажлын төлөвлөгөө

#	Үйл ажиллагаа	Байршил	Огноо
1	Манхан, Эрдэнэбүрэн, Буянт суманд хийсэн орон нутгийн судалгааны тайланг Аймгийн мал эмнэлгийн газарт танилцуулах	Манхан, Эрдэнэбүрэн, Буянт сум	2021
2	PDS судалгааг зохион байгуулах	Цэцэг, Дарви, Зэрэг, Дөргөн сум	2021
3	Малчдын мэдлэгийг дээшлүүлэх үүднээс тэдэнд мал эмнэлгийн тухай хууль тогтоомж, дүрэм журам, мал эмнэлгийн үйлчилгээ, малын эмийн талаар мэдлэг олгох	Бүх сум	2021
4	PDS аргачлалыг ашиглан ховор эндемик өвчний судалгааг зохион байгуулах	Алтай, Үенч, Мөст, Мөнххайрхан сум	2021
5	Адууны томууг адууны сахуугаас ялгах буюу адууны сахуугийн судалгаа хийх	Алтай сум	2021
6	Ховд аймагт паразитын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, батлуулах	Аймгийн мал эмнэлгийн хэлтэс	2021
7	Гудамжны нохойн тоог хянах, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх	Жаргалант, Буянт сум	2021 оны 3-4-р сар
8	Ranunculus, oxyporis зэрэг хортой ургамалд хордсон малыг эмчлэх зааварчилгааг боловсруулж, малчдад өгөх	Бүх сум	2021 оны 3-р улирал
9	Дэвшилтэт технологийг нэвтрүүлж, малын угаалгын чанарыг сайжруулах	Аймгийн мал эмнэлгийн хэлтэс	2021
10	Булчин цайх, хаг саатах, фторын хордлого, өсвөр малын эрдсийн дутагдал гэх зэрэг орон нутгийн эндемик өвчний судалгааг зохион байгуулах	Бүх сум	2021

Сүхбаатар аймгийн PDS уулзалт

Мерси Кор, аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран Сүхбаатар аймгийн төвд 2020 оны 12-р сарын 17-нд PDS уулзалт зохион байгууллаа. Уулзалтыг 11-р сард хийхээр анх төлөвлөсөн байсан боловч COVID-19-ийн хөл хорионоос болж хойшилж, 12-р сард цахим хэлбэрээр зохион байгуулсан.

Ховд аймгийн PDS хэрэгжүүлэгч нар, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, МЭЕГ, аймгийн Мал эмнэлгийн газар, 14 сумын улсын болон хувийн малын эмч нар гээд 47 хүн уулзалтанд оролцлоо.

Уулзалтын үеэр зохион байгуулагчид PDS-ийг нутагшуулах ажлын талаар мэдээлэл өгч, дөрвөн PDS хэрэгжүүлэгч Сүхбаатар аймгийн 4-н суманд зохион байгуулсан судалгааны тайлан, үр дүнгийн талаар танилцуулсан.

Судалгааны товч хураангуй:

- Халзан суманд адууны нийлүүлэг өвчин (Equine Dourine) харьцангуй бага (0.012%) хувьтай байна. Тус аймаг нь адуугаараа алдартай учир худалдаа их явагдаж, халдвар авах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тиймээс морины худалдаачид, мэргэжилтэн, малын эмч нарын дунд адууны өвчний талаар уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, Халзан сумын бүх үржлийн адуунд мал эмнэлгийн үнэлгээ хийх шаардлагатай байна.
- Түвшинширээ сумын хамгийн их тархсан малын өвчлөл нь шүлхий болон хамуу байна. Малчид 2010, 2014, 2017 онд шүлхий өвчний дэгдэлт гарч, зарим сум тархалт нэмэгдсэний улмаас 1-2 сарын хугацаанд бүтэн хөл хорио тогтоож байсан учир энэ өвчний талаарх мэдлэг, туршлагатай байсан. Дарьганга сумын малчид малын эрдсийн дутагдал, яс сөнөрөх өвчлөлд санаа их зовж байна.
- Эргүүг эмчилж чадах малын эмч байхгүй, хамуу болон бусад паразитын эмчилгээ Дарьганга суманд үнэтэй байна.
- 2017 онд Дарьганга суманд мялзан өвчний дэгдэлт болж байсан боловч малчид уг өвчний нөлөө, эрсдэлийн талаар ямар ч мэдээлэлгүй байсан.
- Сүхбаатар суманд халдварт бус өвчний тохиолдол нэмэгдэж, малаас авах ашиг шимд нөлөөлж байна. Мал, амьтад усны хомсдолоос үүдэн уурхайн ойролцоох бохирдсон усыг ууж байна. Малчид уурхайгаас үүдсэн бохирдол, түүний аюулын талаар мэдлэг муутай байна.

Аймгийн Мал эмнэлгийн газар хээрийн судалгааны үр дүнг нэгтгээд дараах 3-н зүйлийг гаргаж ирсэн:

1. Судалгаагаар малын өвчин малчин өрхийн орлого, амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байгааг харууллаа.
2. Орон нутгийн малчдын тусламжтайгаар PDS хэрэгжүүлэгч нар хамгийн нийтлэг малын өвчнийг олж тогтоосон: адууны томуу, сахуу, ходоодны шимэгч хорхой, цагаан хорхой, хэл татах; адууны нийлүүлэг өвчин. Халзан суманд адууны нийлүүлэг өвчин хамгийн өндөр эрсдэлтэй бөгөөд малчид үүний талаарх мэдлэгээ нэмэгдүүлсэн байна.
3. Урьдчилан сэргийлэлт, вакцинжуулалтын ажлыг төлөвлөхдөө судалгааны үр дүн болон лабораторийн шинжилгээний хариуг ашиглах шаардлагатай байна.

Уулзалтын төгсгөлд PDS хэрэгжүүлэгчдийн боловсруулсан Сүхбаатар аймгийн малын эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах нэг жилийн ажлын төлөвлөгөөг аймгийн Мал эмнэлгийн газрын дарга танилцуулсан.

Хүснэгт 11: 2021 оны Сүхбаатар аймгийн Мал эмнэлгийн газрын хийх ажлын төлөвлөгөө

Но	Үйл ажиллагаа	Байршил	Огноо
1	Халзан сумыг халдваргүй сум болгох	Халзан сум	2021
2	Хилтэй залгаа таван суман дахь хил дамнасан малын өвчний тархалтанд нөлөөлж байгаа хүчин зүйлийг олж тогтоох	Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр сумд	2021
3	Түмэнцогт сумыг бруцеллэзгүй сумаар бүртгэх	Түмэнцогт сум	2021
4	Халдварт бус өвчний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох	Баруун-Урт, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Асгат сум	2021
5	Паразитын өвчний тохиолдлыг бууруулах эпидемиологийн судалгааг зохион байгуулах	Бүх сум	2021

Үр нөлөө

Улсын болон аймгийн хэмжээний уулзалтууд амжилттай зохиогдож өнгөрлөө. 250 гаруй малын эмч, төрийн албан хаагчид эдгээр арга хэмжээнд оролцож, PDS аргачлалтай танилцаж, PDS-ийн арга зүйг ашиглаж, PDS системийг цаашид нутагшуулах алхмуудын талаар ярилцаж, судалгааны үр дүнг хуваалцлаа.

Аймгийн уулзалтын үеэр PDS хэрэгжүүлэгчид аймгийнхаа нэг жилийн ажлын төлөвлөгөөг боловсрууллаа. Эдгээр төлөвлөгөө нь PDS-ийн арга зүйн тусламжтайгаар аймаг бүрт малын эрүүл мэндийг сайжруулахыг зорьж байгаа бөгөөд аймгуудын Мал эмнэлгийн газрууд ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг хариуцах болно.

Мөн зорилтот аймгуудад улсын болон хувийн малын эмч нар PDS талаарх ойлголтоо нэмэгдүүлж чадсан бөгөөд PDS хэрэгжүүлэгч нар орон нутгийн малын эмч нартай хамтран ажиллаж, PDS аргачлалыг ашиглах, орон нутгийн судалгаа хийх чадавхийг нь бэхжүүлэх ажлаа үргэлжлүүлнэ.

LTS3 төсөл 2020 оны 11-р сарын 30-нд дууссан билээ. Гэвч МЭЕГ Дэлхийн банк, Дэлхийн зөн гэх мэт олон улсын байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэй PDS аргачлалыг үлдсэн 17 аймагт нутагшуулах ажлаа үргэлжлүүлнэ. МЭЕГ-ын мэргэжилтнүүд Монголд анх удаагаа PDS аргачлалыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн Мерси Кор болон LTS3 төсөлд талархлаа илэрхийлсэн.

Бодит байдал дээр PDS аргачлал, орон нутгийн судалгааны үр дүнг аль хэдийн бусад төсөлд ашиглаад эхэлчихсэн. Жишээлбэл,НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын санаачилгын хүрээнд PDS-ийн 2 сургагч багшийг багтаасан үндэсний эпидемиологчдын баг шүлхий өвчний эрсдэлийн үнэлгээг Дорнод аймгийн Матад сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд гүйцэтгэлээ. Тус баг уламжлалт болон оролцоот эпидемиологийн аргыг хослуулан дээрх хоёр суманд шүлхийн эрсдэлийг үнэлсэн билээ.

Түүнчлэн WCS нийгэмлэг “Бөхөнгийн эрүүл мэндийн хамгаалах” төслийг саяхан эхлүүлсэн. Төсөл эхлэх үед PDS сургагч багш нарын нэг нь PDS-ийн аргачлалыг орон нутгийн судалгаанд хэрхэн ашиглах талаар сургалтыг (WCS нийгэмлэг, Дэлхийн байгалт хамгаалах сан, эпидемиологичдын багтай хамтран) орон нутгийн мэргэжилтнүүдэд зориулж зохион байгууллаа. Мөн Ховд аймгийн таван PDS хэрэгжүүлэгч орон нутгийг судалгаанд оролцож, PDS аргачлалыг ашиглаж бөхөн болон бусад малын эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлыг судалсан.

Эцэст нь OFDA-гийн санхүүжилтгүйгээр, аймгийн Мал эмнэлгийн газрын хүсэлтийн дагуу Ховд аймгийн Мөст сумын PDS хэрэгжүүлэгч орон нутгийн хувийн малын эмч нартай хамтран PDS аргачлаар судалгаа хийлээ. Энэ нь сумын малын эмч нар хоорондын хамтын ажиллагааны сайхан жишээ болсон.

Х. Бодьсайхан, МЭЕГ-ын Малын халдварт өвчний мэргэжилтэн

Мал эмнэлгийн тандалтын тогтолцоонд PDS аргачлалыг тасралтгүй шингээх нь бидний ойрын зорилт юм. PDS аргачлал нь малын эмч, малчдын хоорондын харилцаа холбоог сайжруулах бөгөөд Монголд малын өвчнийг илүү найдвартай тодорхойлоход нарийвчилсан мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийхэд тус болно.

Малын өвчний тандан судлах, орон нутгийн судалгаанд ялам олон малын эмч оролцуулахын тулд бид нийслэл, 21 аймаг, 331 сумын малын эмч нарыг PDS аргачлалд сургахаар төлөвлөж байгаа билээ. Бид МЭЕГ-ын жилийн төлөвлөгөөнд чадавхи бэхжүүлэх сургалтуудыг тусгаж, бусад төсөл хөтөлбөртэй хамтарч малын эмч нарт PDS гэрчилгээ олгох хөтөлбөрт хамруулах ажлыг үргэлжлүүлнэ.

Мерси Корын тухай

Мерси Кор нь хамгийн их бэрхшээл зовлон тулгарсан улс оронд хүмүүсийн амьдралыг дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг олон улсын тэргүүний хүмүүнлэгийн байгууллага юм. Бид 40 гаруй улс оронд бусадтай түншилж, зоригтой шийдлүүдийг хэрэгжүүлснээр хүмүүст саад бэрхшээлийг даван туулах, хөгжин цэцэглэхэд нь тусалдаг.



45 SW Ankeny Street Portland,
Oregon 97204 888.842.0842
info@mercvcorps.org
mercvcorps.org

